



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР
БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН



**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ АРИУТГАХ
ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/ ХУУЛЬ**

**ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВАРТ ХИЙСЭН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ЗАХИАЛАГЧ БАЙГУУЛЛАГА



БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ



ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ,
АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ,
ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГА

ХУУЛЬ  ЭРХ ЗҮЙН
ХӨГЖЛИЙН  ХҮРЭЭЛЭН

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН.

Судалгааг гүйцэтгэсэн

Д.Басандорж	Техникийн ухааны доктор /Ph.D. Russia/, дэд профессор
Ж.Бариширсүрэн	Хууль зүйн магистр /LLM Hungary/, бодлогын судлаач
Б.Доржпагма	Социологийн магистр, /MA Mongolia/, социологич судлаач

Барилга, хот байгуулалтын яамны БХБЯ-2018-РЗҮ-002 дугаартай “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах” зөвлөх үйлчилгээний хүрээнд гүйцэтгэв.

2018 он

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	6
ЗУРГИЙН ЖАГСААЛТ	7
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	8
НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ.....	9
1.1. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үндэслэл, шаардлага.	9
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	11
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгох, шалгуур үзүүлэлтийг томьёолох	12
1.3.1. “Зорилгод хүрсэн төвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл.....	12
1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл	13
1.3.3. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	14
1.4. Үнэлгээний арга зүй	15
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	16
2.1. Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал	16
1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын хэрэгжилт.....	16
6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын хэрэгжилт	24
7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.2, 17.4, 17.5, 17.6, 17.7, 17.8.2, 17.8.4 дэх заалтуудын хэрэгжилт.....	33
7 дугаар зүйлийн 11 дэх заалтын хэрэгжилт	48
7 дугаар зүйлийн 13 дахь заалтын хэрэгжилт	57
19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалтын хэрэгжилт	71
23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын хэрэгжилт.....	82
23 дугаар зүйлийн 23.2 дэх заалтын хэрэгжилт.....	86
2.2. Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	93
5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтын хэрэгжилт	93
6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын хэрэгжилт	103
9 дүгээр зүйлийн 9.11 дэх заалтын хэрэгжилт	106
10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалтын хэрэгжилт	110
12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтын хэрэгжилт.....	112
15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтын хэрэгжилт	118
18 дугаар зүйлийн 18.2 дэх заалтын хэрэгжилт.....	123
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	137
Зарчмын өөрчлөлтийн хүрээнд хөндөгдөх асуудал.....	139
Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм, түүний хэрэгжилтийн тухайд.....	139

<i>Өмчлөл, ашиглалт, үйлчилгээ, түүний хэрэгжилтийн тухайд</i>	142
<i>Тусгай зөвшөөрөл, түүнд холбогдох эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн тухайд</i>	144
<i>Хяналт, шалгалт, хариуцлага, түүний хэрэгжилтийн тухайд</i>	145
<i>УХАТ—ын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын тогтолцооны тухайд</i>	147
<i>Иргэдийн хувийн хэрэгцээндээ зориулан гаргасан усны эх үүсвэрийн тухайд</i>	150
<i>Технологийн хэрэглээний усыг дахин ашиглах тухайд</i>	152
<i>Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээн зохицуулах зөвлөлийн тухайд</i>	154
<i>Хэрэглэгчийн эрх, үүрэгтэй холбогдох зохицуулалт, түүний хэрэгжилт</i>	155
<i>Цэвэрлэх байгууламж, түүний үйл ажиллагааны тухайд</i>	156
ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ	159
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	164
Хууль тогтоомж	164
Стандарт, дүрэм, журам	165
Ном, гарын авлага	165
Нийтлэл	165
Судалгааны тайлан, экспертийн ярилцлага	166
Цахим эх сурвалж	167
Мэдээллийн сан	167
ХАВСРАЛТ	168
Хавсралт 1. Зөрчлийн тухай хуульд тусгагдсан УХАТ-ын барилга, байгууламж, үйл ажиллагаа, ашиглалт, хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс зэрэг асуудалд холбогдох зөрчлүүд	168
Хавсралт 2. Удирдамж	172
Хавсралт 3. УХАТ, ЦБ-д хамааралтай стандартын жагсаалт	176
Хавсралт 4. Төлөвлөгөө	181
Хавсралт 5. Үнэлгээнд ашиглах асуумжийн маягт №1	183
Хавсралт 6. Үнэлгээнд ашиглах асуумжийн маягт №2	185
Хавсралт 6. Үнэлгээний хүрээнд хийсэн уулзалт, ярилцлагын жагсаалт	189

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж
АХБ	Азийн хөгжлийн банк
БНФУ	Бүгд Найрамдах Франц Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХБСайд	Барилга хот байгуулалтын сайд
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
БХТ	Барилгын хөгжлийн төв
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗГ	Засгийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МоМо төсөл	Усны нөөцийн нэгдсэн менежмент МоМо (Төв Азийн Усны Нөөцийн Нэгдсэн Менежмент: Загвар бүс нутаг Монгол) төсөл
МУЗЗНДНТУтХ	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
МХБ	Мэргэжлийн хяналтын байгууллага
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НААБХЗГ	Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
ОНТҮГ	Орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар
ОСНАУГ	Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар
ОУ	Олон улс
ТЗЭ	Тусгай зөвшөөрөл эзэмшигч
ТӨААҮГ	Төрийн өмчит аж ахуйн үйлдвэрийн газар
УБ	Улаанбаатар
УИХ	Улсын их хурал
УСУГ	Ус сувгийн удирдах газар
УСУГ	Ус сувгийн удирдах газар
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХК	Хувьцаат компани
ХСУХАТАтХ	Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хууль
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМСайд	Эрүүл мэндийн сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
УСУГ	Ус сувгийн удирдах газар
УБАТ	Усны аюулгүй байдлын төлөвлөгөө

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт № 1 “Зорилгод хүрэх төвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх зүйл, заалтууд	13
Хүснэгт № 2 “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх зүйл, заалтууд	14
Хүснэгт № 3 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын хэрэгжилт	16
Хүснэгт № 4 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт	24
Хүснэгт № 5 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын хэрэгжилт	33
Хүснэгт № 6 Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн хязгаар заасан зохицуулалтууд ..	38
Хүснэгт № 7 7 дугаар зүйлийн 11 дэх заалтын хэрэгжилт	48
Хүснэгт № 8 МУ-ын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ	49
Хүснэгт № 9 МУ хэмжээнд худгийн тоо	51
Хүснэгт № 10 7 дугаар зүйлийн 13 дахь заалтын хэрэгжилт	57
Хүснэгт № 11 Уул уурхайн компаниудын усыг эргүүлэн ашиглаж буй байдалд хийсэн түүвэр судалгаа	61
Хүснэгт № 12 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалтын хэрэгжилт	71
Хүснэгт № 13 УХАТ-ын шугам сүлжээний өмчлөлийн хэлбэр, хэмжээ 2018 он.	75
Хүснэгт № 14 УХАТ-ын ТЗЭ-ийн орлого, зардал, ашиг, алдагдал 2012-2016 онд	78
Хүснэгт № 15 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын хэрэгжилт	82
Хүснэгт № 16 23 дугаар зүйлийн 23.2 дэх заалтын хэрэгжилт	86
Хүснэгт № 17 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтын хэрэгжилт	93
Хүснэгт № 18 Барилга, хот байгуулалтын яамны өөрчлөлт	94
Хүснэгт № 19 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт	103
Хүснэгт № 20 9 дүгээр зүйлийн 9.11 дэх заалт	106
Хүснэгт № 21 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт	110
Хүснэгт № 22 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт	112
Хүснэгт № 23 ТЗЭ-ийн төрөл, тоо	114
Хүснэгт № 24 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт	118
Хүснэгт № 25 УСУГ, Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн өр авлагын жагсаалт	120
Хүснэгт № 27 18 дугаар зүйлийн 18.2 дэх заалтын хэрэгжилт	123

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

<i>Зураг № 1 Улсын хэмжээнд Ундны усны эх үүсвэр: шаардлага хангасан, шаардлага хангаагүй байдал.....</i>	<i>18</i>
<i>Зураг № 2 БОАЖСайд, БХБСайдын хамтарсан А/02/01 дугаар тушаалын хавсралтууд ..</i>	<i>41</i>
<i>Зураг № 3 Нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийт худгийн тоо.....</i>	<i>51</i>
<i>Зураг № 4 МУ-ын усны нийт хэрэглээний төлөв.....</i>	<i>60</i>
<i>Зураг № 5 Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо.....</i>	<i>61</i>
<i>Зураг № 6 Уул уурхайн салбарын усны хэрэгцээний хэтийн төлөв таамаглал.</i>	<i>65</i>
<i>Зураг № 7 Ашиглах боломжтой усны нөөц болон говийн бүсийн уул уурхайн усны хэрэгцээний хэтийн төлвийн харьцаа.....</i>	<i>65</i>
<i>Зураг № 8 Барилга, хот байгуулалтын яамны бүтэц.....</i>	<i>95</i>
<i>Зураг № 9 Усны салбарын байгууллагууд.....</i>	<i>97</i>
<i>Зураг № 10 ХСУХАТАҮЗЗ-ийн цахим хуудас дахь шилэн дансны цэс.....</i>	<i>108</i>
<i>Зураг № 11 ХСУХАТАҮЗЗ-ийн 2015 оны санхүүгийн байдлын аудитын гэрчилгээ.....</i>	<i>109</i>
<i>Зураг № 12 Цэвэрлэх байгууламжийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөр.....</i>	<i>126</i>
<i>Зураг № 13 Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй өрх.....</i>	<i>129</i>
<i>Зураг № 14 Бохир усны цооног.....</i>	<i>129</i>
<i>Зураг № 15 УСУГ-ын бүтэц.....</i>	<i>130</i>

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График № 1 Монгол Улсын хүн ам, бүсээр	18
График № 2 Монгол Улсын хотын хүн амын тоо. 2017 он.....	19
График № 3 Монгол Улсын хүн ам, хот, хөдөөгөөр	19
График № 4 гадаргын болон газрын доорх усны ашиглалт	59
График № 5 УХАТ-ын өр төлбөр 2017 он.....	77
График № 6 Салбарын өр төлбөрийн хэмжээ	78
График № 7 УХАТ-ын үйл ажиллагаа	78
График № 8 Зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллахад асуудал тулгарч байсан эсэх..	107
График № 9 Тусгай зөвшөөрлийг багцлах хэрэгцээ, шаардлага бий эсэх.....	114
График № 10 Тусгай зөвшөөрлийн жилийн хураамжийн хэмжээ тохиромжтой эсэх.....	116
График № 11 Тусгай зөвшөөрлийг сунгаж буй хугацаа тохиромжтой эсэх.....	116
График № 12 ХСУХАТAmX-иар ТЗЭ-д үүрэг болгосон заалтын хэрэгжилтийн байдал	116
График № 13 ТЗЭ байгууллагаар үйлчлүүлж буй орон сууцны айл өрхийн тоо	119
График № 14 Хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, учирсан хохирлоо төлүүлэхийг шаардах ТЗЭ-ийн эрхийн хэрэгжилт	121
График № 15 Цэвэр усны төлбөр, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөр зохистой эсэх	121
График № 16 Цэвэрлэх байгууламжийн ажиллагаа.....	125

НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд хууль тогтоомжид үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох, үнэлгээ хийх хүрээг тогтоох, шалгуур үзүүлэлтийг сонгох, харьцуулах хэлбэрийг сонгох, шалгуур үзүүлэлтийг томъёолох, мэдээлэл цуглуулах аргыг сонгох ажиллагаа хийгдсэн.

1.1. Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх үндэслэл, шаардлага.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 2-т хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж тус тус заасан байдаг.

Дээрх Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг хангах, мөн улс орны үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, орчны бохирдлоос хамгаалахад чиглэгдсэн суурь зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлэх онцгой үйл ажиллагааны нэг бол хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ юм.

Монгол Улсын Их хурлаас анх 2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуулийг баталснаар хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн үндэс бүрдсэн.

УХАТ-ын ашиглалтын тухай анхдагч хуулийн зохицуулалт бий болсноор хот, суурин газар оршин суугаа иргэдийг цэвэр усаар хангах, хэрэглээний бохир усыг стандартад нийцүүлэн зайлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хангагч, хэрэглэгч хоорондын харилцааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдсэн нь хотжилт, үйлдвэржилт, хүн амын төвлөрөл эрчимжсэн өнөө цагийн эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн алхам болсон. Гэвч энэхүү хуулийн зохицуулалт нь нийгэм, эдийн засгийн хөгжил, хотжилт, үйлдвэржилтийн үйл явцтай хөл нийлүүлж, тэдгээрээс урган гарч буй нийгмийн харилцаанд тулгарч буй асуудлыг бүрэн зохицуулах чадваргүй, тухайлбал, хариуцлагын тогтолцоо бүрэлдээгүй, инженерийн барилга, байгууламжийн ашиглалт, хэрэглэгч, түгээгчийн хоорондын харилцаа тодорхойгүй, мөн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах байгууллагуудын чиг үүргийн асуудлыг цэгцлэх шаардлагатай байсан тул Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуулийн /цаашид ХСУХАТАтХ гэх/ шинэчилсэн найруулгын төслийг 2011 онд баталсан ба өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна.

2011 онд ХСУХАТАтХ-ийн шинэчилсэн найруулгыг баталснаас хойш хуульд нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан ба эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь гол төлөв шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжтой холбоотой байсан бөгөөд үндсэн асуудлыг хөндөөгүй орхисон байна.

Түүнчлэн ХСУХАТАтХ-ийн хүрээнд төрийн захиргааны, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, Иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг байгууллагуудын чиг үүрэг, бүрэн эрх, хариуцлагын асуудал өнөөг хүртэл тодорхой зохицуулагдаагүй, хуулийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Хот суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн /цаашид ХСУХАТАУ33 гэх/ үйл ажиллагаа нь техникийн нөхцөл,

тусгай зөвшөөрөл олгох, усны үйлчилгээний төлбөр, УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний тариф тогтоох, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа болон тусгай зөвшөөрлийг нөхцөл, шаардлагын биелэлтэд хяналт тавьж, санал дүгнэлт гаргах төдийгөөр хязгаарлагдаж байгаа зэрэг нь уг хуулийн хэрэгжилт хангалтгүй байх үндэслэл болж байна.

Тухайлбал, ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын бүсэд хууль бусаар барилга байгууламж барих, аж ахуйн үйл ажиллагааг зөвшөөрөлгүй эрхлэх, байгаль орчин, усны эх үүсвэрийг бохирдуулах зэрэг зөрчил газар авч байгаа боловч түүнийг таслан зогсооход чиглэсэн эрх зүйн зохицуулалт хүчгүйдэж байгаа бол шинээр баригдаж байгаа орон сууцны хороолол, барилга байгууламжийн инженерийн шугам, сүлжээний ашиглалт, өмчлөлтэй холбоотой эрх зүйн зохицуулалт энэ төрлийн харилцааг бүрэн зохицуулах чадваргүй, инженерийн шугам, сүлжээний ашиглалт, үйлчилгээ хариуцсан төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын үүнд холбогдох санал, бодол хоорондоо зөрчилтэй байна.

Иймд Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, гаргаж буй шийдвэр, тэдгээрийг хүчгүйдүүлж буй сул орон зай, хариуцлагын тогтолцоо зэрэг хуулийн хэрэгжилтийн явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэх зорилгоор 2011 онд батлагдсан “Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай” хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх практик шаардлага үүссэн гэж үзсэн.

Харин хууль зүйн үндэслэлийг *нэгдүгээрт*, УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.90-д “Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлнэ.” гэж 2.94-д “Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг саарал усны стандартын шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.” гэж, 2.96-д “Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.” гэж, 4.2.3-т Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ.” гэж, *хоёрдугаарт*, УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 44-т “Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах”-аар тусгасан, *гуравдугаарт*, Хууль тогтоомжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-д “Үндсэн чиглэлийн төсөлд санал өгөх байгууллага нь нийгмийн тухайн харилцааг зохицуулж байгаа хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсний үндсэн дээр уг асуудлаар шинээр хууль гаргах, эсхүл хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэл, шаардлагыг тодорхойлно.” гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1-д “энэ хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах, эсхүл энэ хуулийн 51 дүгээр зүйлд заасны дагуу тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн

хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх” замаар хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах тухай тус тус заасан нь уг хуулийг шинэчлэн найруулах хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийснээр уг хуулийг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэх, тулгамдаж буй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөг тогтоох, мөн хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийн өмчлөл, ашиглалтын нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн, ашиглаж болохуйц шийдлийн хувилбаруудыг дэвшүүлнэ.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Засгийн газрын /цаашид ЗГ гэх/ Аргачлал батлах тухай 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-д ¹ зааснаар Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлохдоо хэрэгжилтийг нь шалгаж үнэлгээ хийх гэж буй хууль тогтоомжийн бүтэц, агуулга, зохицуулалтын шинж чанар, онцлогоос хамааран аль тохиромжтой буюу түүгээр хэрэгжилтийн үр нөлөө, үр дагавар нь гарч ирэх шалгуур үзүүлэлтийг сонгох² боломжтой байдаг.

Иймээс Улсын Их хурал /цаашид УИХ гэх/-аас 2011 онд баталсан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо уг хуулийг хэрэгжүүлэхэд агуулгын хувьд чухал ач холбогдолтой гэж үзсэн хуулийн дараахь зүйл заалтыг сонгосон. Үүнд:

1. *Хуулийн зорилтын хүрээнд*: 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтыг,
2. *Хуулийн нэр томъёоны хүрээнд*: 3 дугаар зүйлийн 3.1.12, 3.1.4 зэрэг заалтыг,
3. *Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн байгууллагуудын бүрэн эрхийн асуудлын хүрээнд*: 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтыг, 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтыг, 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтыг, 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтыг, 9 дүгээр зүйлийн 9.2, 9.3, 9.10 дахь заалтыг, 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтыг,
4. *Тусгай зөвшөөрөлд холбогдох асуудлын хүрээнд*: 12 дугаар зүйлийг,
5. *Хангагч, хэрэглэгчийн харилцааны асуудлын хүрээнд*: 13 дугаар зүйлийн 13.1, 13.4 дэх заалтыг, 14 дүгээр зүйлийн 14.1.2, 14.2.1 дэх заалтыг, 15 дугаар зүйлийн 15.1.8, 15.1.13 дахь заалтыг, 16 дугаар зүйлийн 16.2.6 дахь заалтыг, 18 дугаар зүйлийн 18.6 дахь заалтыг,
6. *УХАТ-ын барилга байгууламж, шугам сүлжээний ашиглалт, өмчлөлд холбогдох асуудлын хүрээнд*: 17 дугаар зүйлийг, 19 дүгээр зүйлийн 19.1-19.2 дахь заалтыг,
7. *Хяналт, харууцлагын асуудлын хүрээнд*: 22, 23 дугаар зүйлд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийхээр судалгааны хүрээг тогтоосон болно.

¹ Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. Эх сурвалж: <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

² ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.6.2 дахь заалт. <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгох, шалгуур үзүүлэлтийг томъёолох

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.1.3-т заасан шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох ажлын хүрээнд ХСУХАТAtX-ийн зорилгод хүрсэн төвшин, практикт нийцэж байгаа байдал гэсэн шалгуур үзүүлэлтийн дагуу хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр сонгосон.

1.3.1. “Зорилгод хүрсэн төвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалд заасан “зорилгод хүрсэн төвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойшхи хугацаанд хуулийн зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тодорхой таамаглал дэвшүүлэх, асуулт тавих замаар тогтоохыг зорьдог³

ХСУХАТtX-иар улсын хэмжээнд хот, суурин газрын оршин суугчдыг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэрлэх зориулалттай барилга байгууламжийн өмчлөлийн болон ашиглалт, үйлчилгээний суудлыг цогцоор нь шийдвэрлэх эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорьсон бөгөөд уг хуулийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор ЗГ-т үйл ажиллагаагаа тайлагнадаг, бие даасан, хараат бус хамтын удирдлагын байгууллага болох УХАТАУ33-ийг шинээр үүсгэн байгуулжээ.⁴

Өнөөгийн байдлаар иргэд, хэрэглэгчдийг чанар, стандартын шаардлагад нийцсэн унд, ахуйн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх үйлчилгээг улсын хэмжээнд УХАТ-ын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий 180 гаруй аж ахуйн нэгжээр⁵ дамжуулан хүргэж байна.

Харин хот, суурин газрын оршин суугчдыг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай барилга байгууламжийн өмчлөлийн болон ашиглалтын талаарх бодлого тодорхойлох, норм, дүрэм, нийтлэг мөрдөх журам, заавар батлах, барилга байгууламжийн захиалагчийн үүргийг хэрэгжүүлэх, ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох, биелэлтэд хяналт тавих эрхийг төрийн захиргааны байгууллага, Иргэдийн төлөөлөгчдийн хурал /цаашид ИТХ гэх/, аймаг, нийслэлийн засаг даргын, тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүргийг ХСУХАТАУ33-ийн эрхийн хүрээнд зохицуулжээ. Иймд энэхүү үнэлгээний хүрээнд улсын хэмжээнд хот, суурин газар УХАТ-ын өмчлөл, ашиглалттай холбогдох харилцааг төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн засаг дарга, ИТХ, УХАТАУ33 хуулиар олгогдсон эрхийн хүрээнд бүрэн хэрэгжүүлэх эрх зүйн зохицуулалт зорилгодоо хүрч байгаа эсэхэд үнэлэлт өгнө.

³ ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.4.1 дэх заалт. Эх сурвалж: <http://legalinfo.mn/annex/details/7338?lawid=11993>

⁴ Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 02 сарын 15-ны өдрийн 46 дугаар тогтоолоор УХАТАУ33-ийн дүрмийг, 2012 оны 05 сарын 30-ны өдрийн 183 дугаар тогтоолоор УХАТАУ33-ийн бүтэц, орон тоог баталсан.

⁵ УХАТАУ33-ийн танилцуулгаас. Эх сурвалж: <http://www.wsrc.mn/new/mn/introduction>

ХСУХАТТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын хүрээнд зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтээр дараахь зүйл, заалтыг үнэлнэ. Үүнд:

Хүснэгт № 1 “Зорилгод хүрэх төвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх зүйл, заалтууд.

№	Сонгосон зүйл, заалт
1	1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт: Хуулийн зорилт
	6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт: Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх
2	7 дугаар зүйлийн 7.1.2, 7.11, 7.13 дахь заалт: Аймаг, нийслэлийн ИТХ-ын бүрэн эрх.
3	17 дугаар зүйлийн 17.4, 17.5, 17.6, 17.8.2, 17.8.4, дэх заалт: Ус хангамж, ариутгах татуурга
	19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалт: Барилга байгууламж, шугам сүлжээний өмчлөл
4	21 дүгээр зүйлийн 21.1-21.2 дахь заалт: Хууль тогтоомжийн биелэлт, түүнд тавих хяналт
5	23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь заалт: Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтээр хуулийн зохицуулалт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний зэрэг болон сөрөг үр дагавар, хуулийг хэрэгжүүлэхэд ямар хүндрэл гарч байгаа зэрэг асуудлыг тодорхойлохыг зорино.

Монгол Улсын хүн ам өсөн нэмэгдэж, хотжилт, уул уурхай, эдийн засаг өргөжин тэлж, малын тоо өсч бэлчээр хомсдохын хэрээр усны хэрэглээ, бохир усны хэмжээ болон усны бохирдлын хэмжээ эрс нэмэгдэх хандлагатай байна.

Усны салбар нь өөрийн онцлог байдлаасаа шалтгаалан бараг бүхий л салбарын асуудалд харьяалагддаг тул хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн уялдаа холбоо, хэрэгжилт, үр дүнд тавих хяналт, хүлээлгэх хариуцлагын асуудал цалгардаж, хариуцах эзэнгүйдэж байгаа болохыг Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн “Усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар” хийсэн мэдээллээс харж болох юм. Үүнд дурдсанаар “усны асуудал нь Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд тодорхой хэсэг нь хамаарч байгаагаас гадна бусад 10 яам, 2 агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд хуваагдсан нь төрөөс усны талаар баримтлах бодлогыг зөв оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй болсныг харуулж байна”⁶ гэжээ.

Монгол Улсын хувьд баталгаатай цэвэр усаар хангагдсан хүн амын эзлэх хувь 2015 оны байдлаар 65 хувьтай байсан. Өөрөөр хэлбэл манай улсын 1.0 сая орчим хүн баталгаагүй, ил задгай болон зөөврийн усыг унд, ахуйдаа хэрэглэсээр байгаа нь иргэдийн эрүүл мэнд тодорхой хэмжээнд өвчлөлд өртөх эрсдэлийг бий болгож байгаагаас гадна манай орны усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн байдал, ялангуяа хүн амын талаас илүү хувь нь амьдарч буй нийслэл хотын усан хангамж, ариутгах татуурга ноцтой байдалд хүрсэн,

⁶ МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийлээ. Өдрийн сонин. 2018.05.05. Эх сурвалж: <https://dnn.mn/у-хүрэлсүх-усны-нөөц-ус-ашиглалтын-өнөөгийн-байдал-тулгамдаж-буй-асуудал-хэрэгжүүлэх-арга-хэмжээний-талаар-мэдээлэл-хийлээ/>

түүнээс бохирдож буй газар нутгийн хэмжээ улам өсөн нэмэгдэж байгаа нь ноцтой үр дагавар учруулахаар байна.⁷

Хэдийгээр сүүлийн жилүүдэд олон улсын болон гадаадын донор орнуудын тусламж, дэмжлэгээр хот, суурины УХАТ-ын барилга байгууламжийг сайжруулах, чанар, хүртээмжийг дээшлүүлэх цөөнгүй ажил хийгдэж байгаа боловч тэдгээрийг нэгтгэн дүгнэсэн явдал одоо хэр байхгүй байгаа нь нийтийн аж ахуйн /цаашид НАА гэх/ салбарын нэгдмэл бус байдлыг буюу өмчлөл, ашиглалт, үйлчилгээний олон талт оролцоонд түшиглэсэн байдлаас хамааралтай байж болох байна. Тухайлбал, хот, суурины иргэд, аж ахуйн нэгжийг стандартын шаардлага хангасан усаар хангах, бохир усыг татан зайлуулах үйл ажиллагааг манай улсад ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний чиглэлээр ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий нийт 180 гаруй аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг⁸ бөгөөд тусгай зөвшөөрлийг ХСУХАТАУ33 олгодог боловч тэдгээрийн үйл ажиллагаанд тавих хяналт зөвхөн хэрэглэгчийн санал, гомдлийн мөрөөр гаргаж буй мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж, шаардлагын хүрээнд хэрэгждэг нь учир дутагдалтай байна. Энэ болон бусад хуулийг хэрэгжүүлэх явцад үүсч буй нөхцөл байдал, хүндрэл бэрхшээлийн илрүүлэх зорилгоор ХСУХАТАтХ-ийн дараахь зүйл заалтад Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжих боломж, хэрэгжиж буй байдлын үнэлгээ хийнэ. Үүнд:

Хүснэгт № 2 “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлэх зүйл, заалтууд.

№	Сонгосон зүйл, заалт
1	5 дугаар зүйл: Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх
2	6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт: Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх
3	9 дүгээр зүйлийн 9.11 дэх заалт: Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн бүтэц
4	10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт: Зохицуулах зөвлөлийн бүрэн эрх
5	12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт: Тусгай зөвшөөрөл, түүний ангилал
7	15 дугаар зүйл 15.1.3 дахь заалт: Хэрэглэгчийн эрх, үүрэг
8	18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт: Цэвэрлэх байгууламж

1.3.3. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

ХСУХАТАтХ-ийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээллийг аргачлалын 3.7.3.1-т заасан бэлэн байгаа мэдээлэл цуглуулах арга буюу холбогдох ном, товхимол, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, Барилга, хот байгуулалтын яам /цаашид БХБЯ гэх/, ХСУХАТАУ33, Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар /цаашид ОСНАУГ гэх/, Ус сувгийн удирдах газар /цаашид УСУГ гэх/ зэрэг холбогдох байгууллагаас гаргасан статистик тоо мэдээ зэргээс, мөн аргачлалын 3.7.3.2-т заасан холбогдох субъектээс судалгаа авах аргын дагуу тухайн хууль тогтоомжийн

⁷ МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийлээ. Өдрийн сонин. 2018.05.05. Эх сурвалж: <https://dnn.mn/у-хүрэлсүх-усны-нөөц-ус-ашиглалтын-өнөөгийн-байдал-тулгамдаж-буй-асуудал-хэрэгжүүлэх-арга-хэмжээний-талаар-мэдээлэл-хийлээ/>

⁸ ХСУХАТАУ33 –ийн Даргын мэндчилгээ. Эх сурвалж: <http://www.wsrc.mn/new/mn/news/168>

хэрэгжилтийг хариуцан зохион байгуулж буй ХСУХАТАҮЗЗ-ийн ажлын алба, БХБЯ-ны Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газар /цаашид НААБХЗГ гэх/, тусгай зөвшөөрөл эзэмшигч /цаашид ТЗЭ гэх/-дээс шаардлагатай мэдээ, мэдээллийг нарийвчлан гаргуулах зэргээр бүрдүүлсэн болно.

1.4. Үнэлгээний арга зүй

Энэхүү үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан хийж, гүйцэтгэв. Түүнчлэн ХСУХАТАтХ-ийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг судлахдаа харьцуулах, түүхчлэх, задлан шинжлэх (анализ), баримт бичигт дүн шинжилгээ хийх гэсэн хууль зүйн судалгааны үндсэн арга зүйг ашигласан.

Үүнээс гадна хот, суурины УХАТ-ын барилга байгууламжийн өмчлөл, ашиглалт, үйлчилгээнд холбогдох асуудлуудаар салбарын мэргэжилтэн, хангагч, хэрэглэгчдийн дунд анкетын болон чанарын судалгаа авах замаар хуулийн ч хуулийн холбогдох заалтуудын хэрэгжилтийг хэрхэн үнэлж буйг тогтоосон, мөн өмнө хийгдсэн ус хангамж, бохир ус зайлуулах системийн талаар хийгдсэн судалгааны ажлуудыг ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэрэгжүүлэх үе шатанд төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон үнэлгээ хийх хүрээнд багтсан зүйл заалтын хэрэгжилтэд дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл буюу хууль тогтоомж, илтгэл, нийтлэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, ном, эмхэтгэл зэрэг олон нийтийн хүртээл болгосон бүтээлүүд болон холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ХСУХАТАТХ-ийн сонгогдсон заалтууд тухайн асуудлыг хангалттай зохицуулж чадаж байгаа эсэх, хэрэв хангалтгүй бол ямар шалтгаан байгааг тодорхойлох ажиллагаа хийгдсэн.

2.1. ЗОРИЛГОД ХҮРЭХ ТӨВШИН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын хэрэгжилт

Хүснэгт № 3 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
1	1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт: Хуулийн зорилт	1.1.Энэ хуулийн зорилт нь хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино	Хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцаа зохицуулагдсан байна.

Судалсан байдал

Ус бол өдөр тутмын зайлшгүй хэрэгцээ учраас усгүй орон хөгжих нь бүү хэл оршин тогтнох ч боломжгүй юм. Иймээс өнөөдөр дэлхийн улс орнууд усны нөөцөө нэмэгдүүлэх, усыг ариг гамтай ашиглах талаарх төрийн бодлого боловсруулах ажлыг чухалчилж байна.

Аливаа улс өөрийн орны нийгэм, эдийн засгийн хөгжлийг төлөвлөн зохион байгуулахдаа ирээдүй хойч үедээ байгалийн нөөц баялаг, байгалийн аливаа сайхан нөхцөл бүрийг зөв зохистой хэмжээгээр эдэлж хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх нь улс үндэстэн оршин тогтнох, тогтвортой хөгжих эх үндэс болдог. Иймээс ч дэлхийн нийтийн хэмжээнд тогтвортой хөгжлийн хүрээнд 1/нөхөн сэргээгдэхгүй нөөц баялаг болон нефть, нүүрс, хүнд металлын хэрэглээг багасгах 2/синтетик аргаар аргаар гарган авсан байгальд хортой химийн бүтээгдэхүүний хэрэглээг багасгах 3/байгалийн нөөц, хөрс, ургамал, ан амьтан, газар, усыг хамгаалах менежментийг сайжруулж, нөөцийг зүй бусаар ашиглах, доройтуулахыг бууруулах, зогсоох; 4/хүмүүсийн хэрэгцээгээ хангах эрхийг

хязгаарлахгүйгээр байгалийн нөөцийг зөв зохистой хямгатай ашиглах боломжуудыг бүрдүүлэх гэх дөрвөн зарчмыг мөрдөх шаардлагатай гэж үздэг.⁹

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2-т заасан хүний “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрх”-ийг хангах, мөн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тодорхойлсон иргэдийн амьдрах, ажиллах орчны аюулгүй байдлыг хангах, асуудлын хүрээнд хөндөгдөх чухал асуудлын нэг бол иргэдийг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах үйл ажиллагаа юм. Энэ нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн асуудал төдийгүй үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн эрх зүйн зохицуулалтын салшгүй нэг хэсэг юм. Иймээс өнгөрсөн жилүүдэд төр, засгаас ус хангамж, ариутгах татуургад холбогдох зорилго, зорилт агуулсан үндэсний хэмжээнд хэрэгжүүлж буй бодлогын баримт бичгүүд болон түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой олон тооны тогтоол, шийдвэр баталсан байдаг. Тухайлбал, МУ-ын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Үндэсний хөгжлийн цогц бодлого, Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, “Ус” үндэсний хөтөлбөр, Ногоон хөгжлийн бодлого, Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл баримтлал-2030, Монгол орны Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө зэрэг үндэсний хэмжээний бодлогын баримт бичгүүдэд эл асуудлыг тусгажээ.

Ус хангамж, ариутгах татуургад хамаарах харилцааг зохицуулж буй гол хууль болох ХСУХАТАТХ-ийн зорилт нь хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах явдал юм.

Дээр дурдсанчлан иргэний баталгаатай эдлэх эрхийн нэг хэсэг болох амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах зорилгоор төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцдаг¹⁰.

Гэтэл иргэдийг стандартын шаардлага хангасан унд, ахуйн хэрэглээний усаар хангах, хэрэглээнээс гарсан усыг татан зайлуулах асуудлыг зохицуулж буй гол хууль болох ХСУХАТАТХ-иар зөвхөн суурин газрын буюу 500-аас дээш хүн амтай суурин газар оршин суугаа иргэдийн, тэр дундаа зөвхөн УХАТ-ын инженерийн төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон иргэдийн УХАТ-ын асуудлыг шийдвэрлэж байгаа нь учир дутагдалтай байна.

Энэ нь суурин газар оршин суугаа хэдий ч төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй гэр хорооллын иргэд, хөдөө орон нутагт хүн амын тоогоор суурин газарт тооцогдохгүй хэдий ч аялал жуулчлал, ажлын байрны хангамжаас шалтгаалан хүн амын тоо 500-аас дээш гардаг газрууд, суурин газар биш хэдий ч УХАТ-ын барилга, байгууламж,


⁹ <https://asmhub.mn/uploads/files/5-togtvortoy-khgzhil-ba-baygaliyn-ntsiyn-khariutslagatay-ashiglalt.pdf>

¹⁰ Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

инженерийн шугам сүлжээ бүхий газруудад энэ хууль хүрч үйлчлэх боломжгүй байдлыг бий болгожээ.

Манай орны нийт усны нөөцийн 98.1 хувийг гадаргын ус эзэлдэг бөгөөд нөөц нь 554 сая м3/жил, түүнээс ашиглах боломжит нөөц 4.96 сая м3/жил байна.¹¹ Харин 1.96 хувийг эзлэх газрын доорх усны нөөцөөс төв суурин газрын усны хэрэглээний 80-90 хувийг хангаж байна.

Зураг № 1 Улсын хэмжээнд Ундны усны эх үүсвэр: шаардлага хангасан, шаардлага хангаагүй байдал




Хотын ундны усны нөөцийг тогтоох ажил үргэлж анхаарлын төвд байсаар ирсэн бөгөөд анх 1980 оны Монгол, Зөвлөлтийн ашигт малтмалын нөөцийн комиссын хамтарсан хуралдаанаар УБ хотын ундны усны нөөцийг 4 эх үүсвэрээс нийт 215900 м³/хоног гэж баталгаажуулсан бөгөөд 175 худгаас 248000

м³ /хоногийн нөөцтэй гэж тодотгожээ. Харин Монгол Улс болон Япон Улсын ЗГ хоорондын хамтын ажиллагааны хүрээнд ЖАЙКА-ийн судалгааны баг УБ хотын ерөнхий төлөвлөгөөнд зориулан 2008 онд хийсэн судалгаагаар УБ хотын цэвэр усны хэрэглээг 2 хувилбараар¹² тооцсон бөгөөд 2015 онд усны хомсдолд орж болзошгүй гэсэн дүгнэлт хийж¹³ байсан. Хамгийн сүүлд 2018 онд Мянганы Сорилтын Корпорацид танилцуулсан мэдээлэлд УБ хотын хүн амын нэг жилийн усны хэрэгцээ 77 сая м³ бол өсөн нэмэгдэж буй хүн ам, үйлдвэр, аж ахуйн хэрэгцээг одоогийн нөөцөөр хангах боломжгүй, усны хязгаарлалтад орохуйц байдалд хүрсэн¹⁴ тухай дурджээ.

2017 оны байдлаар Монгол Улсын нийт хүн амын 46% буюу 1462716 хүн УБ хотод оршин суугаа бол нийт хүн амын 67,5% буюу 2146716 хүн суурин газар амьдарч байна.

Үүнээс харахад ХСУХАТАТХ-ийн үйлчлэх хүрээ нь суурин газар амьдарч буй нийт хүн амын 67 гаруй хувьд хүрч үйлчлэх мэт боловч үүнээс зөвхөн инженерийн

График № 1 Монгол Улсын хүн ам, бүсээр



¹¹ Гадаргын усны нөөц ба уул уурхайн ус ашиглалт. Эх сурвалж: <http://www.mmhi.gov.mn/public/more/id/618>

¹² Өндөр хувилбараар тооцвол 2020 онд 351300 м³/хоног, 2030 он гэхэд 510700 м³/хоног болох ба бага хувилбараар тооцвол 2020 онд 294900 м³/хоног, 2030 онд 367700 м³/хоног болно


¹³ <http://audit.gov.mn/files/report/performance/2011/2011-PA-BOA1-Water.pdf>

¹⁴ Улаанбаатар хотын ус хангамжийн асуудлыг таван жилийн хугацаанд иж бүрэн шийднэ. Эх сурвалж: <http://vip76.mn/content/55125>

шугам сүлжээнд холбогдсон иргэдийн стандартын шаардлагад нийцсэн, баталгаат УХАТ-ын үйлчилгээнд хамаарах юм. Тухайлбал, манай улсын хүн амын 46% нь оршин суугаа УБ хотын иргэдийн 60 гаруй хувьд буюу гэр хорооллын иргэдийн УХАТ-ын ашиглалт энэ хууль хамаарахгүй буюу зөвхөн цэвэр ус түгээх, бохир ус соруулах машинд тусгай зөвшөөрөл олгох төвшинд хэрэгжиж байгаа бөгөөд бусад хууль тогтоомжид энэ асуудлыг тусгаагүй нь хийдэл үүсгэж, хүний эрх, эрх ашиг хохирох эрсдэлийг үүсгэж байна.


График № 2 Монгол Улсын хүн ам, хот, хөдөөгөөр

Хүн бүрийн амин чухал хэрэглээний нэг бол ус юм. Иймээс хүн амд үзүүлэх суурь үйлчилгээний нэг болох стандартын шаардлага хангасан, баталгаат усаар тасралтгүй, тэгш, хүртээмжтэй хангах, хэрэглээнээс гарсан



бохир усыг татан зайлуулах, стандартад нийцүүлэн байгальд эргүүлэн нийлүүлэх үйл ажиллагааг “хүнийг ... нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажлаар... нь ялгаварлан гадуурхалгүйгээр” хүргэх нь төрийн үүрэг, хариуцлага юм. Гэтэл ХСУХАТАТХ-иар хот, суурин газрын УХАТ-ын инженерийн барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээтэй холбоотой асуудлыг 500-аас дээш хүн амтай¹⁵ суурин газрын хэмжээнд зохицуулахаар тусгасан нь төрийн үйл ажиллагааны тэгш, хүртээмжтэй байдлын зарчим алдагдах, зөвхөн хүн амын төвлөрөл тогтоосон хэмжээнд үүссэн суурин газарт оршин суугаа иргэдийн эрхийн асуудал болгожээ гэж үзэж болох байна.

График № 3 Монгол Улсын хотын хүн амын тоо. 2017 он



Графикаас харахад манай улсын суурин газар оршин суугаа иргэдийн тоо 2146716 байгаа бөгөөд үүний 68,1% нь УБ хотод амьдарч байна. УБ хотын нийт иргэдийн 56,7% нь гэр хороололд, 43,3% нь орон сууцны хороололд¹⁶ буюу инженерийн шугам сүлжээнд холбогдсон орон сууцанд амьдардаг байна. Суурин газрын хүн амын дийлэнх хувь нь амьдардаг УБ хотын орон сууцны хорооллын өрх жилд дунджаар

6600 орчим өрхөөр нэмэгдэж, 2016 оны эцэст 164.8 мянгад хүрсэн байхад гэр хорооллын өрх жилд дунджаар 8000 орчим өрхөөр нэмэгдэж, 2016 оны эцэст 216.0 мянга болжээ.

¹⁵ Хот, тосгоны эрх зүйн байдлыг тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар Суурин г

¹⁶ Монгол Улсын нийслэлийн нийгэм, эдийн засгийн байдал 2016 он. Нийслэлийн ЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг, Статистикийн газар.

Иргэдийн хэрэгцээг хангахын тулд нийслэлийн хэмжээнд 4938.3 сая квт.цаг цахилгаан, 7.8 сая гкал дулаан, 44.8 сая метр куб ус түгээж 776.3 тэрбум төгрөгөөр борлуулснаас ус ариутгал, усан хангамж 44 509.1 сая төгрөг болсон байна. Харин нийслэлийн хэмжээнд 2016 онд хийгдсэн нийт барилга угсралтын ажлын 11,3%-ийн инженерийн барилга байгууламж эзэлж байгаагаас 20% нь далан, суваг, шугам, сүлжээ байсан ба өмчийн хэлбэрийг харвал 98,9% нь хувийн, 1,1% нь төрийн өмчийн байгууллагынх байна. Мөн нийслэлд 2016 оны байдлаар цахилгаан, хий үйлдвэрлэл, усан хангамжийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах бүртгэлтэй ААН байгууллага 136 байснаас 57 ААН байгууллага үйл ажиллагаа явуулжээ.¹⁷ Үүнээс харахад УХАТ-ын инженерийн барилга, байгууламжийн өмчийн хэлбэрт сүүлийн жилүүдэд өөрчлөлт орж хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт эрс нэмэгдсэн байна. Үүнээс харахад ХСУХАТАТХ-д хувийн хэвшлийн ААН, иргэдийн УХАТ-ын өмчлөл, ашиглалт, үйлчилгээнд хамаарах эрх, үүрэг, хариуцлагын асуудлыг тусгах шаарлага үүссэнийг харуулж байна.

Ус хангамжийг тэгш, хүртээмжтэй байлгах, мөн усны аюулгүй байдлыг хангах, иргэд, ААН-ийг стандартын шаардлагад нийцсэн хэрэглээний усаар хангахад төр голлох үүргийг гүйцэтгэдэг бол, харин бодлогын хэрэгжилтэд төрийн болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоо чухал. Ус хангамж, бохир ус татан зайлуулах асуудлын хүрээнд яригдах дэд бүтцийн хөгжил дэвшил, усны нөөцийн хамгаалал, усны чанарын менежмент, усны түгээлт, усны үнэлгээ, эдийн засгийн үзүүлэлт, усны бохирдлын хяналт, ариутгах үйлчилгээ, усны менежментийн системийн үйл ажиллагаа, ус ашиглалт, устай холбоотой бодлого боловсруулах үйл ажиллагаан дахь иргэд олон нийт, хувийн хэвшлийн болон орон нутгийн өмчийн НАА байгууллагуудын оролцоо нь хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, төрөөс нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангах төрийн үүргийг гүйцэлдүүлэхэд нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг. Гэвч ХСУХАТАТХ-д иргэд, хувийн хэвшлийн байгууллагуудын эрх үүрэг, оролцоо, хариуцлагын асуудлыг зохицуулалтгүй үлдээсэн нь УХАТ-ын салбарын хөгжил, дэвшлийн хүрээнд шинэ тутам үүсэж буй харилцааг зохицуулах эрх зүйн орчинд хийдэл үүсгэжээ. Иймээс ХСУХАТАТХ-д хувийн өмчийн инженерийн барилга, байгууламж, шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээ, өмчийн хэлбэр, өмчлөгч, ашиглагчийн эрх, үүргийг тодорхой тусгаагүй нь цаг үеийн шаардлагыг хангахгүй байна гэж үзлээ.

ХСУХАТАТХ нь Монгол Улсын бусад олон хуулиудтай хамааралтай боловч нэгдсэн эрх зүйн зохицуулалтад ороогүй байна. Ялангуяа устай холбоотой голлох хууль болох Усны тухай хууль, Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль болон бусад Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Барилгын тухай, Компаний тухай, Төсвийн тухай, Монополийн өмчийн тухай, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай, Засгийн газрын бүтцийн тухай, Засгийн газрын агентлагийн тухай, Хот төлөвлөлтийн тухай зэрэг хуулиудтай уялдаа холбоо муутай байна.¹⁸

¹⁷ Монгол Улсын нийслэлийн нийгэм, эдийн засгийн байдал 2016 он. Нийслэлийн ЗД-ын хэрэгжүүлэгч агентлаг, Статистикийн газар.

¹⁸ Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын хууль, эрх зүйн орчин ба тогтолцоо, өнөөгийн байдал” судалгаа. БХБЯ, НҮБХХ, КОЙКА. 2015 он.

Монгол Улсын хэмжээнд УХАТ-ын инженерийн дэд бүтцийг хөгжүүлэх, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, НАА салбарыг бэхжүүлэх замаар хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь ханган баталгаажуулахад чиглэсэн дотоодын болон олон улсын байгууллага, гадаад орны дэмжлэгтэй төсөл хөтөлбөр тогтмол хэрэгжиж ирсэн боловч үр дүн нь хүсэн хүлээсэн төвшинд хүрч хараахан чадахгүй байна. Тухайлбал, УИХ-ын 2010 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 36 дугаар тогтоолоор “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөр, Нийслэлийн НАА салбарыг бэхжүүлэх төсөл, НҮБХХ-ийн “Мянганы хөгжлийн зорилтод хүрэх, орон нутгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад үзүүлж буй дэмжлэгийг өргөжүүлэх нь. Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламж МОН/13/302” төсөл хөтөлбөрүүдийг дурдаж болох бөгөөд төсөл, хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа тухайн үйл ажиллагааг цааш үргэлжлүүлэх төрийн болон орон нутгийн мэргэжлийн байгууллага дутагдаж байна. Ялангуяа төсөл хөтөлбөрийн хүрээнд суурилуулсан тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээний чиглэлээр мэргэшүүлсэн ажилтныг тогтвортой ажиллуулах бодлого, хөшүүрэг дутагдаж байна. Иймээс аливаа нэг төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн бүтээн байгуулалт, тухайлбал, инженерийн шугам сүлжээ, худаг, ус цэвэршүүлэх болон бохир ус цэвэрлэх байгууламж зэргийг тухайн орон нутгийн НААБ-д хариуцуулдаг, ингэхдээ тухайн байгууллагын хүний нөөцийн, материаллаг болон санхүүгийн чадавхыг харгалзаж үзэхгүй байх нь түгээмэл байна.

Ус, ус хангамжийн барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээнд хамаарах хяналт, шалгалтын асуудал бас төдийлөн сайн биш байна. Манай улсын усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээнд УИХ, ЗГ, Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Баг, хорооны иргэдийн нийтийн хурал, Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, Сав газрын захиргаа, Аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн байгаль хамгаалагч, Сав газрын зөвлөл, Усны мэргэжлийн байгууллага багтдаг. Харин УХАТ-ын үйлчилгээ, ашиглалтад холбоотой хяналт, шинжилгээг УИХ, ЗГ, БХБЯ, Хот, суурины УХАТ-ын ашиглалт үйлчилгээг зохицуулах зөвлөл /цаашид ХСУХАТАҮЗЗ гэх/, Барилгын хөгжлийн төв, Мэргэжлийн хяналтын байгууллага, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга зэрэг байгууллагууд гүйцэтгэдэг. Гэтэл Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр УХАТ-ын ашиглалт үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын мөрөөр БХТ, ХСУХАТАҮЗЗ-д УХАТ-ын улсын байцаагч ажиллах боломжгүй болж, зөрчилд арга хэмжээ авах эрх зөвхөн МХБ-ын улсын байцаагчид үлдсэн нь хүн амын эрүүл мэнд, үндэсний аюулгүй байдлын төвшинд хөндөгдөх унд, ахуйн хэрэглээний ус хангамжтай холбоотой зөрчил, дутагдлыг цаг тухайд нь таслан зогсоох, хууль тогтоомж зөрчсөн үйлдэлтэй үр дүнтэй тэмцэхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулагдаагүй, төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа газруудад УХАТ-ын асуудал хариуцсан хүний нөөцийн дутагдалтай, ХСУХАТАТХ-ийн хүрээнд үүсгэн байгуулагдаж, УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, тэдэнд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах, усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэг бүхий ХСУХАТАҮЗЗ-ийн статус, эрх зүйн байдал тодорхойгүй зэрэг шалтгаанаас үүдэн УХАТ-ын бодлого төлөвлөлт, хууль

тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, салбар дундын зохицуулалтыг сайжруулах зэрэг олон ажил хариуцах эзэнгүй хаягдсан шинжтэй байгаа нь энэ салбар уналтад орох, хууль хэрэгжихгүй байх бас нэг шалтгаан юм.

Түүнчлэн хуулийн нэр “Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хууль” гэж томъёологдсон нь УИХ-аас 1993 онд баталсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд заасан хот, тосгоныг суурин газар гэж үзнэ гэх хуулийн тодорхойлолттой зөрчилдөж байна. Уг хуулийн 3 дугаар зүйлийн 1-д Хот нь 15000-аас доошгүй оршин суугчтай ... суурин газар мөн, 2-т Тосгон нь 500-15000 оршин суугчтай ... суурин газар мөн гэж заажээ. Үүнээс харахад “хот, суурин газрын” гэж томъёолох нь хуулийн нэр томъёоны нэгдмэл байдлыг алдагдуулсан тул хуулийн нэрийг өөрчлөх шаардлагатай гэж үзлээ.

ХСУХАТАТХ-д ашиглагдаж буй нэр томъёо бусад хууль тогтоомжтой уялдах, хуулийн нэр томъёо, ойлголтын нэгдмэл байдлыг хангахгүй байна. Тухайлбал, 2012 онд батлагдсан Усны тухай хуульд олон нийтэд үзүүлэх ус хангамжтай холбоотой барилга байгууламжийн талаар “усны барилга байгууламж гэж усны түрэлт, урсцыг тохируулах, ус хуримтлуулах, хадгалах, дамжуулах, хуваарилах, түгээх, ариутгах, цэвэрлэх, түүний чанарыг сайжруулах, газрын доорх ус олборлох, усны үер, гамшгаас хамгаалах энгийн болон инженерийн хийц бүхий барилга байгууламжийг¹⁹ ойлгохоор тусгасан бол 2016 онд батлагдсан Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын²⁰ 4.1.1-д “барилга байгууламж” гэж орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, ..., ус суваг, далан хаалт зэрэг байгууламж түүний инженерийн шугам сүлжээг²¹, 4.1.35-д “инженерийн шугам сүлжээ” гэж ус хангамж, ..., ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, ...-ны төвлөрсөн байгууламжийг; 4.1.37-д “төвлөрсөн бус инженерийн шугам сүлжээ” гэж тодорхой талбай, эсхүл барилга байгууламжид ус, ...-ны үйлчилгээ нийлүүлэх зориулалт бүхий байгууламжийг; 4.1.38-д “төвлөрсөн инженерийн шугам сүлжээ” гэж төв суурин газар, түүний тодорхой хэсэгт орших барилга байгууламжийг ус, ...-ны төвлөрсөн эх үүсвэртэй холбох үндсэн байгууламжийг; 4.1.23. “бие даасан эх үүсвэр, шугам сүлжээ” гэж тухайн барилга байгууламжийн хэрэгцээг хангахад зориулан барих ус... зэрэг инженерийн хангамжийн шугам сүлжээ, байгууламжийг ойлгоно гэж тодорхой бөгөөд нарийвчлалтай зааж өгсөн байна. Иймээс ХСУХАТАТХ-ийг УХАТ-ын барилга байгууламжид хамгийн их хамаарал бүхий Усны тухай, Барилгын тухай хуулиудтай уялдуулах шаардлага үүссэн байна. Түүнчлэн ХСУХАТАТХ-иар, түүнийг батлагдсанаас хойш шинэчлэн найруулсан хууль тогтоомжуудад нийцүүлэн, хэрэглэгчийг унд, ахуйн хэрэглээний усаар хангах үйл ажиллагааны хүрээнд ус хуримтлуулах, хадгалах, дамжуулах, хуваарилах, түгээх, ариутгах, цэвэрлэх, түүний чанарыг сайжруулах, газрын доорх ус олборлох, усны үер, гамшгаас хамгаалах энгийн болон инженерийн хийц бүхий барилга байгууламжийн өмчлөл, ашиглалттай холбоотой харилцааг авч үзэх шаардлага үүссэн гэж үзэж болох юм.

¹⁹ Усны тухай хуулийн 3.1.13 дахь хэсэг

²⁰ Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2016 он. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/11705>

²¹ Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 4.1.1 дэх заалт 2016 он. <http://www.legalinfo.mn/law/details/11705>

2011 онд батлагдсан ХСУХАТтХ-ийн шинэчилсэн найруулгаар хүн амын төвлөрөл үүссэн хот, суурины иргэд, аж ахуйн нэгжид стандартын шаардлага хангасан ус нийлүүлэх, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах үйл ажиллагааны бүхий л үе шатанд ашиглагдах инженерийн барилга байгууламжийн өмчлөл, ашиглалттай холбоотой үүссэн харилцааг зохицуулах зорилготой, хуулийн хүрээнд шийдвэрлэглэх боломжгүй хэд хэдэн шинэ нөхцөл байдал үүссэн тул уг хуулийг нийгэм, эдийн засгийн хөгжил, цаг үеийн шаардлагад нийцүүлэн шинэчлэх шаардлага үүссэн байна. Тухайлбал, Барилгын тухай хуулийн 7 дугаар зүйл. Нийтийн болон гуравдагч этгээдийн эрх, ашиг сонирхол, 37 дугаар зүйл. Захиалагчийн чиг үүрэг, 46 дугаар зүйл. Барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигчийн үүрэг зэргийг энд дурдаж болох юм.

Үндсэн хуулийн 11 зүйлийн 1-д 1-д “Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” Гэж заасан байдаг. Тэгвэл иргэдийг чанарын шаардлага хангасан унд, ахуйн усаар хангах, ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалах, байгаль, экологийг хамгаалах, ус бохирдуулахаас урьдчилан сэргийлэх зэрэг асуудал нь төрийн үүрэг бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хамгаалах асуудлын хүрээнд хөндөгдөх сэдэв юм.

Гэтэл ХСУХАТАтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх явцад энэ хуулийн ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд хамаарах зохицуулалт, хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын асуудал, хэрэглээнээс гарсан усыг дахин ашиглахтай холбоотой зохицуулалтууд зэрэг олон заалт зорилгодоо хүрэхгүй, хэрэгжилт хангалтгүй байгаа нь, мөн хот, суурин газрын УХАТ-ын асуудлыг зохицуулах, ялангуяа төвлөрсөн шугам, сүлжээнд холбогдоогүй суурин газрын иргэдийн асуудлыг шийдвэрлээгүй, мөн суурин газарт тооцогдохгүй ч инженерийн шугам, сүлжээ бүхий газарт үйлчлэх чадамжгүй байна.

Үнэлсэн байдал

ХСУХАТАтХ-ийн 1 дүгээр зүйлд заасан “Энэ хуулийн зорилт нь хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэх зохицуулалт ЗОРИЛГОДОО ХҮРЭХГҮЙ БАЙНА гэж үнэллээ.

Ийнхүү үнэлэхэд дараахь хүчин зүйлс нөлөөлсөн болно. Үүнд:

1. Хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах асуудал нь ус хангамжийн эх үүсвэрийн харуул хамгаалалт, хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм хэрэгждэггүй, цэвэрлэх байгууламжаас гарч буй хаягдал усны чанар стандартын шаардлага хангадаггүй, гэр хорооллын нүхэн жорлон, хөрсний бохирдол зэргээс шалтгаалан эрсдэлд орсон байна.
2. Хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийн өмчлөл зөвхөн төрийн болон орон нутгийн байх зохицуулалт хэрэгждэг ч сүүлийн жилүүдэд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар эдгээрийг барьж байгуулах тохиолдолд элбэгшсэн. Гэвч УХАТ-ын

салбарын өмчлөлийн асуудал, хувийн хэвшлийн оролцоог зохицуулсан эрх зүйн орчин байхгүй нь маргааны гол эх үүсвэр болдог.

3. хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг ашиглах, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл /цаашид ТЗ/-ийг энэ хуулиар байгуулагдсан ХСУХАТАҮЗЗ олгож байгаа бөгөөд ТЗ эзэмшигчдэд тавих эдийн засгийн шаардлага сул, хэт олон ТЗ эзэмшигч байгаа зэрэг асуудал хөндөгддөг.
4. Нэр томъёоны зөрчил ихтэй. Тухайлбал, ХСУХАТАтХ гэж томъёологдсон нь УИХ-аас 1993 онд баталсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд заасан хот, тосгоныг суурин газар гэж үзнэ гэх хуулийн тодорхойлолттой зөрчилдөж байна. Уг хуулийн 3 дугаар зүйлийн 1-д Хот нь 15000-аас доошгүй оршин суугчтай ... суурин газар мөн, 2-т Тосгон нь 500-15000 оршин суугчтай ... суурин газар мөн гэж заажээ. Үүнээс харахад “хот, суурин газрын” гэж томъёолох нь хуулийн нэр томъёоны нэгдмэл байдлыг алдагдуулсан байна.
5. Хуулийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь, мөн хуулийг хэрэгжилтийг хангуулах, хяналт, шалгалт хийх, арга хэмжээ авах эрх бүхий этгээдийн тоо цөөн, зарим тохиолдолд ашиг сонирхлын зөрчилтэй байгаа нь энэ хууль хэрэгжихгүй байх гол шалтгаан болж байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр УХАТ-ын ашиглалт үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын мөрөөр БХТ, ХСУХАТАҮЗЗ-д УХАТ-ын улсын байцаагч ажиллах боломжгүй болж, зөрчилд арга хэмжээ авах эрх зөвхөн МХБ-ын улсын байцаагчид үлдсэн. Хэрэв МХБ байцаагч зөрчлийн хэрэг үүсгэвч тухайн хэрэг прокурорын хяналтад ордог зэрэг ойлгомжгүй, үйл ажиллагааг удаашруулсан зохицуулалтууд хэрэгжиж байна.
6. Хүн амын сандартын шаардлага хангасан, баталгаат ундны усаар хангагдах эрхийг зөвхөн хот, суурин газраар, түүн дотроо зөвхөн инженерийн шугам, сүлжээнд холбогдсон иргэдээр хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулиар баталгаажсан хүн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах, амьд явах, орчны бохирдлоос хамгаалуулах эрхийг хангах төрийн үүргийг хот, хөдөө, орон сууц, гэр хороолол зэргээр ялгаварлан гадуурхсан байдлаар хүргэх үндэс болсон байна.
7. ХСУХАТАтХ-д бүрэн эрхийг нь тодорхойлсон УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулагдаагүй, төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа газруудад УХАТ-ын асуудал хариуцсан хүний нөөцийн дутагдалтай, ХСУХАТАтХ-ийн хүрээнд үүсгэн ХСУХАТАҮЗЗ-ийн статус, эрх зүйн байдал тодорхойгүй байгаа нь УХАТ-ын бодлого төлөвлөлт, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, салбар дундын зохицуулалтыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх зэрэг олон ажил хариуцах эзэнгүй хаягдсан шинжтэй байхад нөлөөлж байна.

6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтын хэрэгжилт

Хүснэгт № 4 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
	6 дугаар зүйл. Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн	6.1.Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага	Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийнхээ хүрээнд хууль тогтоомж, төрийн

	захиргааны байгууллагын бүрэн эрх	<p>дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:</p> <p>6.1.1.хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хууль тогтоомж болон дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх;</p> <p>6.1.2.хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, өргөтгөх, төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>6.1.3.орон нутгийн УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;</p> <p>6.1.4.хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан байгуулах, түүний байнгын ажиллагааг эрхлэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;</p>	бодлогыг хэрэгжүүлэх, салбарыг нэгдсэн удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангах замаар салбарын нэгдмэл байдлыг хангаж, тухайлбал салбарын үйл ажиллагаа үр дүнтэй, мэдээ мэдээлэл, статистик бодитой болсон байна.
--	-----------------------------------	--	---

Судалсан байдал

ХСУХАТАтХ-ийн 6 дугаар зүйлд Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тодорхойлсон боловч шууд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байгаа нь хуулийн энэхүү зохицуулалт зорилгодоо хүрэхгүй байх анхдагч үндэслэл болж байна.

БХБЯ-нд Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар байгаа хэдий ч эдгээр газрууд нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд бодлого тодорхойлох үндсэн чиг үүрэгтэй ажилладаг бол Барилгын хөгжлийн төв ТӨҮГ-т Орон сууц, нийтийн аж ахуйн хэлтэс байгаа боловч түүнд салбар дундын зохицуулалт хийх эрх зүйн үндэс байхгүй, мөн төрийн захиргааны байгууллагын зохицуулалт хийх чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй, энэ талын хууль эрх зүйн орчин тодорхойгүй байна.

ХСУХАТАтХ-д УХАТ-ын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой бүрэн эрхийг нь тусгаж өгсөн байгууллага бол ХСУХАТАҮЗЗ юм. Тус зөвлөл нь хуулийн хүрээнд үнэ тариф тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй байгууллага бөгөөд статус, эрх зүйн байдал нь өнөөг хүртэл тодорхойгүй байна. Тухайлбал, УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчээс²² харахад төрийн захиргааны байгууллага биш юм.

²² УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоолоор баталсан Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч

Манай улсад ХСУХАТАУЗЗ-ийн адил хуулиар байгуулагдсан Зөвлөл хэд хэд байдаг бөгөөд, тэдгээр нь тухайн салбарын бүхий л асуудлыг шийдвэрлэх, шийдвэр гаргах эрхтэй байх нь нийтлэг байна. Тухайлбал, Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны тухай хуулиар байгуулагдсан хараат бус, бие даасан, төрийн албаны төв байгууллага²³, үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнах ба зөвлөлийн даргыг мөн адил УИХ-аас чөлөөлж, томилдог. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөл бие даасан, хараат бус, мэргэжлийн баг бүрэлдэхүүнтэй, уг зөвлөл нь шүүхийн захиргаанд хамаарах бүхий л асуудлыг шийдвэрлэдэг, даргыг нь МУ-ын ерөнхийлөгч томилж, үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнадаг.

Харин Ерөнхий сайд даргыг нь томилдог Монгол Улсын Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөл²⁴, Жижиг, дунд үйлдвэрийн үндэсний зөвлөл²⁵, Агаарын бохирдлын эсрэг сан²⁶ Аялал жуулчлалын зөвлөл²⁷, Агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг зохицуулах, үйл ажиллагааны харилцан уялдааг хангахад хяналт тавих чиг үүрэг бүхий Үндэсний хороо²⁸ Харилцаа холбооны зохицуулах хороо²⁹ зэрэг байгууллагуудын нийтлэг шинжийг ажиглахад тухайн харилцааг зохицуулж буй суурь хуулиар үүсгэн байгуулагддаг, орон тооны, эсхүл орон тооны бус гишүүдээс бүрддэг, тухайн хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлдэг байна. Эдгээр нь хуулиар олгогдсон эрхийнхээ хүрээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг сайжруулах зорилгоор тухайн салбарын асуудлыг нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүйн удирдлага, зохион байгуулалтаар хангах үндсэн чиг үүрэгтэй байх нь түгээмэл байна.

Улсын бүртгэлийн сан дахь мэдээллээс харахад манай улсад 600 орчим зөвлөл бүртгэлтэй байгаагаас дийлэнх нь төрийн бус байгууллага байгаа бол ТБАГУТҮГ /төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар/ ангилалд буюу төрийн байгууллагад хамаарах, төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий 42 зөвлөл байна Үүнд, Шүүхийн ерөнхий зөвлөл, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийгмийн даатгалын зохицуулах зөвлөл, Биржийн зохицуулах зөвлөл, Төрийн албаны зөвлөл, Хэлний бодлогын үндэсний зөвлөл, Чөлөөт бүсийн зөвлөл, сав газрын зөвлөлүүд, аймгийн зохицуулах зөвлөлүүд багтаж байна.³⁰

ХСУХАТАУЗЗ нь ХСУХАТАТХ-ийн хүрээнд зөвхөн үнэ тариф, тусгай зөвшөөрөл, маргаанд хамаарах асуудлыг шийдвэрлэж байгаа нь төрийн байгууллагын нэг газар, нэгжийн гүйцэтгэж болохуйц ажлыг бүхэл бүтэн зөвлөлийн хэмжээнд шийдвэрлэж байна гэж харагдаж байна. Хэрэв Зөвлөлийг НАА-н салбар, УХАТ-ын үйл ажиллагааг сайжруулах,

²³ Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйл.Төрийн албаны төв байгууллага

²⁴ <http://www.legalinfo.mn/annex/showPrint/932>

²⁵ Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/annex/details/2523?lawid=2358>

²⁶ <http://www.legalinfo.mn/additional/details/3283?lawid=8669>

²⁷ <http://www.legalinfo.mn/law/details/8929>

²⁸ Агаарын тухай хууль. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/8669?lawid=8669>

²⁹ Харилцаа холбооны тухай хууль. <http://www.legalinfo.mn/law/details/523>

³⁰ Улсын бүртгэлийн ерөнхий газар Эх сурвалж: <http://opendata.burtgel.gov.mn/les?condition=3&text=%D0%B7%D3%A9%D0%B2%D0%BB%D3%A9%D0%BB>

нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, удирдлага арга зүйгээр хангах зорилгоор байгуулсан бол тус зөвлөлийн хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн чиг үүргийг нэмэгдүүлэх, салбарын асуудлыг нэгдмэл байдлаар шийдвэрлэж чадахуйц төвшинд эрх хэмжээг нэмэгдүүлэх асуудлыг авч үзэх, статус, эрх зүйн байдлыг нь тодорхой болгох хэрэгтэй юм. Тухайлбал, МУ-ын ерөнхий сайдын УИХ-ын чуулганд хийсэн мэдээллээс харахад ХСУХАТАУЗЗ-ийг БХБЯ-ны харьяа гэж танилцуулсан нь, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд³¹ хуульд өөрөөр заагаагүй бол НАА-н үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг төрийн захиргааны төв байгууллага олгоно гэж заасан нь, Зөвлөлийн даргыг БХБСайдын санал болгосноор Ерөнхий сайд томилдог нь, мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлд “төрийн байгууллага, албан газар, улсын төсөвт үйлдвэрийн газар” /ТБАГУТҮГ/³² ангиллаар бүртгэгдсэн зэргээс харахад ХСУХАТАУЗЗ нь БХБЯ-ны харьяа, төрийн байгууллага байж болох юм. Гэтэл Зөвлөл нь өөрийгөө БХБЯ-нд хамааралгүй, бие даасан, хараат бус, хөндлөнгийн байгууллага гэж үзэж байгаа нь шийдвэрлэх, нэгдмэл ойлголтод хүргэх шаардлатай асуудлын нэг байна.

Ерөнхийдөө ХСУХАТАТХ-иар ХСУХАТАУЗЗ-д хариуцуулснаас бусад асуудал хариуцах эзэнгүй үлдсэн байна. Үүнээс харахад ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангах тогтолцоо бодлогоос орхигдсон шинжтэй байна. Энэ салбарыг удирдах өнөөгийн тогтолцоо нь тархай бутархай, олон яам, агентлагуудад харьяалагдаж байгаа нь энэ чиглэлээр хийж гүйцэтгэж буй ажлууд уялдаа холбоогүй, өөр хоорондоо зөрүүтэй байхаас гадна салбарын нэгдсэн мэдээлэл, тоо судалгаа гаргах боломжгүй байдалд хүргэсэн нь салбарыг удирдах, үйл ажиллагааг үнэлэхэд, хэтийн төлөвлөгөө, бодлого тодорхойлох зэрэг асуудлыг хүндрүүлж байна.


Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, хүн амын өсөлт, улс орны нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг тодорхойлох усны салбарын чиг үүргийн хуваарилалт нь Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд тодорхой хэсэг нь хамаарч байгаагаас гадна бусад 10 яам, 2 агентлагийн эрхлэх асуудлын хүрээнд хуваагдсан нь төрөөс усны талаар баримтлах бодлогыг зөв оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэхэд ихээхэн хүндрэлтэй болсныг харуулж байна.³³

³¹ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7.1. Энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрлийг хуульд өөрөөр заагаагүй бол төрийн захиргааны холбогдох төв байгууллага олгоно. 15.14.5. нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх; Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/34/>

³² Улсын бүртгэлийн ерөнхий газар. <http://opendata.burtgel.gov.mn/lesinfo/5611547>

³³ МУ-ын Ерөнхий сайд У. Хүрэлсүхийн УИХ-ын нэгдсэн хуралдаанд хийсэн мэдээллээс

Усны салбарын бүтэц, зохион байгуулалтыг дор схемлэн үзүүлэв.



Усны асуудлыг БОАЖЯ голлон хариуцаж, бүтцийн хувьд тусгайлсан нэгж ажиллаж байгаа бол бусад яамдад 1-3 мэргэжилтэн тухайн салбарын усны асуудлыг хариуцан ажиллаж байгаа нь учир дутагдалтай байна.

Судалгааны ажлын “Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Төрийн захиргааны төв байгууллагын

бүрэн эрхийн асуудлыг судалж үзсэн бөгөөд УХАТ-ын асуудлыг БХБЯ-ны төвшинд 2 газрын 3 мэргэжилтэн хариуцаж байгаа нь төрийн бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажиллагаа эрсдэлтэй байна гэж үнэлэхэд хүргэсэн.³⁴

Үүнээс харахад өнөөгийн тогтолцоо нь хүн амыг стандартын шаардлага хангасан унд, ахуйн хэрэглээний усаар хангах, орчны бохирдлоос хамгаалах чиг үүрэг НАА салбарын хувьд хэрэгжихгүй байгаа тул хуулийн энэ заалтын дагуу төрийн захиргааны байгууллагыг яаралтай байгуулах шаардлагатай байна. Судалгаанаас харахад ХСУХАТАТХ нь усны салбарын нэгдсэн бодлогод шууд хамааралтай, бөгөөд хуулийн хэрэгжүүлэгч НАА байгууллагууд нэгдсэн удирдлагагүй байна. Иймээс НАА салбарыг нэгдсэн бодлого зохицуулалтаар хангахын тулд юуны өмнө бүтэц зохион байгуулалт, БХБЯ-ны 2 газар, БХТ, ХСУХАТАУЗЗ зэрэг байгууллагуудын үйл ажиллагаа, чиг үүрэг, эрх, үүрэг, хариуцлагыг оновчтой хуваарилах, уялдаа холбоог сайжруулах шаардлагатай юм. Өөрөөр хэлбэл, тухайн байгууллагын статус, эрх зүйн байдлыг тодорхойлж, түүнд тохирсон чиг үүргийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг бий болгох нь чухал байна. Тухайлбал, салбарын бодлого, алсын хараа, стратегийг хэрэгжүүлэх асуудал БХБЯ-нд, салбарын хуулийн хэрэгжилт, норм, дүрэм, стандартыг мөрдүүлэх ажил төрийн захиргааны байгууллагад, УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг хариуцах байгууллагууд нь орон нутгийн өмчит болон хувийн хэвшлийн тусгай зөвшөөрлийн болзол хангасан ААН байх боломжтой юм.

УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний байгууллагууд буюу НАА салбарын онцлог нь нийтийн эрх, ашиг сонирхлын үүднээс ашгийн бус байх шаардлагатай онцгой объект төдийгүй ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн ба орон нутгийн өмчид байх хуулийн зохицуулалттай.³⁵ Гэтэл нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинээр баригдаж буй барилга, байгууламжийн УХАТ-ын барилга, байгууламж, төвлөрсөн болон салбар шугам сүлжээ хувийн хэвшлийн болон дундын

³⁴ Тайлангийн %%% хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

³⁵ Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын хууль, эрх зүйн орчин ба тогтолцоо, өнөөгийн байдал” судалгааны тайлангаас. 2015 он. БХБЯ, НҮБХХ-ийн “Мянганы хөгжлийн зорилгод хүрэх, орон нутгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад үзүүлж буй дэмжлэгийг өргөжүүлэх нь. Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламж” МОН/13/302 төсөл

өмчлөлийн байх тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байна. ХСУХАТАтХ-иар энэхүү харилцаа зохицуулагдаагүй нь хүндрэл учруулж байна.

Түүнчлэн НАА салбарт хийгдэж буй өргөтгөл, шинэчлэлийн ажлуудыг гол төлөв олон улсын болон гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжаар гүйцэтгэдэг бөгөөд энэ төрлийн төсөл, хөтөлбөрт хамрагдах эсэх нь орон нутгийн удирдах байгууллагуудын өөрсдийн авхаалж самбаанаас шалтгаалдаг ерөнхий байдал ажиглагдаж байгаа нь энэ салбарт нэгдсэн бодлого үгүйлэгдэж байгааг харуулж байна. Үүнийг төрийн, орон нутгийн, хувийн хэвшлийн гээд олон талт харилцаа бүхий НАА-н салбарын үйл ажиллагааг нэгтгэн барих толгой байгууллага тодорхойгүй, нэгдсэн стратеги, алсын хараатай бодлого хэрэгжээгүй олон жил болсноос энэ салбар уналтад орсон зэрэг шалтгаантай холбон тайлбарлаж болох юм. Тухайлбал, аймаг орон нутгийн хэмжээнд УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг сайжруулах чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулан худаг гаргах, бохир усны найрлагын хэмжээ тогтоох лабораторийн тоног төхөөрөмж суурилуулах, хүн амын ундны усыг дамжуулан шүүж зөөлрүүлэх, цэвэршүүлэх аппарат суурилуулах, цэвэрлэх байгууламж байгуулах зэрэг ажлыг зохион байгуулж байгаа боловч эдгээр төсөл хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа хариуцах эзэн нь тодорхойгүй үлддэг нийтлэг дутагдал байгааг салбарын мэргэжилтнүүд анхааруулж байна.

Шигтгээ:

Орон нутагт янз бүрийн төсөл хөтөлбөрийн хүрээнд хаа сайгүй худаг гаргадаг болсон нь нэг талдаа сайн боловч нөгөө талдаа орон нутгийн нийтийн аж ахуйн үйлчилгээний газруудад тодорхой хэмжээний хүндрэл үүсгэж байгаад анхаарах шаардлагатай байна. Нэг газар худаг гаргаад, тууз хайчилсны дараа хэдэн жил ажиллаад муудаад эхэлдэг, хариуцах эзэнгүй үлдэхээр нь орон нутгийн НААБ-д хүчээр шахуу хариуцуулдаг. Бас худгийг төвийн шугам сүлжээтэй холбогдсон газар гаргах зөвшөөрөл олгож байгаа нь бидний ажлыг хүндрүүлэх, алдагдалтай ажиллах бас нэг нөхцөл болдог. Тиймээс худаг гаргах асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Мөн НАА салбарт оруулж буй хөрөнгө оруулалтыг ойлгомжтой, нэгдсэн бодлоготой болгох шаардлагатай байна. Жишээ нь бид шийдвэрлэх шаардлагатай асуудлаа хүсэлт, өргөдөл, төсөл гээд бичээд өгдөг, хэзээ шийдвэрлэгдэх нь тодорхойгүй, сонгон шалгаруулалт бас тодорхойгүй байдаг. Иймээс ер нь нэг жагсаалт гаргаад энэ аймгийн ийм ажлын дараа манай аймгийн асуудал шийдэгдэх нь гэдгийг харах, төлөвлөх боломжтой болгох хэрэгтэй байна. Бид ийм хүсэлтээ яамруу, аймагруу, засагруу, АХБ-ны төсөлд бас өөр хаана өгөх боломжтой байна тэр газарт нь хүргүүлдэг нэг асуудалтай. Хэрэв 1 байгууллагад ханддаг, тэр нь ээлж дараагаар нь шийддэг бол их зүгээр байна.

Төвийн бүсийн зөвлөгөөнд оролцсон НААБ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

2015 онд гүйцэтгэсэн “НАА-н үйлчилгээний салбарын хууль эрх зүйн орчин ба тогтолцоо, өнөөгийн байдал” судалгааны дүнгээс харахад ХСУХАТАтХ-ийн хэрэгжилтэд саад болж буй хүчин зүйлсийн талаар салбарын 124 мэргэжилтнээс авсан судалгаагаар инженерийн барилга, байгууламжийн өмчлөл тодорхойгүй, ХСУХАТАтХ бусад хууль тогтоомжтой зөрчилддөг, салбарын бүтэц зохион байгуулалтын оновчгүй байдал зэрэг нь хууль хэрэгжихгүй байх үндсэн шалтгаан болдог гэж үзсэн байна.³⁶

УХАТ-ын өмчлөл, ашиглалт, үйлчилгээнд хамаарах харилцаа төрийн болон орон нутгийн өмчийн хэлбэрээс хальсан, усны асуудал нь бараг бүхий л яамдын үйл

³⁶ Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын хууль, эрх зүйн орчин ба тогтолцоо, өнөөгийн байдал” судалгааны тайлангаас. 2015 он. БХБЯ, НҮБХХ-ийн “Мянганы хөгжлийн зорилгод хүрэх, орон нутгийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад үзүүлж буй дэмжлэгийг өргөжүүлэх нь. Хөдөөгийн ус хангамж, ариун цэврийн байгууламж” МОН/13/302 төсөл

ажиллагаанд хамаарч байгаа үед энэ хуулийн хэрэгжилт, хуулийн норм, стандартыг мөрдүүлэх ажиллагааг бие даасан бүтэц, төрийн захиргааны байгууллага хариуцах асуудал тулгамдаж байна. Энэ байгууллага нь ус хангамж, усны үйлчилгээтэй холбоотой салбар дундын зохицуулалтыг тодорхой болгох үүднээс НАА-н үйлчилгээний салбарын асуудлыг хариуцсан Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байвал илүү зохимжтой юм.

2004 оны Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд³⁷ зааснаар агентлаг нь Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байх ба салбарын хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийг биелүүлэх ажлыг эрхэлсэн хүрээ, салбарын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг хангах, тэдгээрийг сурталчлах, хэрэглэж байгаа практикийг судалж, боловсронгуй болгох санал боловсруулж сайдад танилцуулах, төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд өгөх саналыг үндэслэл, тооцоотой боловсруулах, агентлагийн хэтийн болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө, үндсэн чиглэл, төсвийн төслийг хуульд заасан нөхцөл, үндэслэлээр хугацаанд нь боловсруулж, төсвийн ерөнхийлөн захирагчид оруулах, хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, нийслэлийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын бүтцийн нэгж, Засаг даргын дэргэдэх холбогдох байгууллагад эрхэлж буй ажлын чиглэлээр мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, салбарынхаа хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэшлийг нь дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг нь хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх арга хэмжээ авах, Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг тэдгээрт нийцүүлэх санал боловсруулж сайдад танилцуулах, хуулиар эрх олгосон бол захиргааны хэм хэмжээний актыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих асуудлыг хариуцах юм.

Гэтэл ХСУХАТАТХ-ийн 6 дугаар зүйлд төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг заасан боловч агентлагийг өнөө хүртэл байгуулаагүй нь УХАТ-ын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг хэнд хамааралтай болох нь тодорхойгүй, хэрэгжилтийг судлах ажиллагаа орхигдсон, энэ салбарын хөрөнгө оруулалт бусад салбарын давалгаан дор, хавсарга шинжтэй болсон, салбарт хийгдсэн, хийгдэж буй хөрөнгө оруулалт тухайн орон нутгийн удирдлагын авхаалж самбаанаас хамааралтай болсон, зээл тусламж авах, өр төлбөрийг эргэн төлөх асуудал нэгдсэн бодлого төлөвлөлтгүй болсон, УХАТ-ын үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд олон газарт буюу орон нутгийн удирдлага, ХСУХАТАҮЗЗ, сав газрын зөвлөл гээд хэд хэдэн газарт тайлан, мэдээллээ хүргүүлж төрийн хүнд суртлын дарамтад орсон, салбарын стратеги, бодлого төлөвлөлт боловсруулах, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах ажил орхигдсон нөхцөл байдалд хүргэжээ. Өөрөөр хэлбэл, НАА, УХАТ-ын салбар олон эзний нэг боол мэт ажиллаж ирсэн нь энэ салбарын хөгжил, дэвшил зогсонги байдалд орох шалтгаан болсон байна. Үүний нэг илрэл бол энэ салбарт ажиллагсдын цалин, нийгмийн баталгааны

³⁷ Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль 2004 он. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/271>

өнөөгийн байдлаас шалтгаалан энэ салбарт ажиллах мэргэшсэн боловсон хүчний дутагдал улам өсөж байгаа явдал юм.

Үнэлсэн байдал

ХСУХАТАтХ-ийн 6 зүйлд заасан Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэхээр тусгасан зохицуулалт зорилгодоо хүрч хэрэгжихгүй байна гэж үнэллээ.

Хуулийн зохицуулалтын зорилгыг хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд салбарын хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарыг нэгдсэн удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангах замаар салбарын нэгдмэл байдлыг хангаж, тухайлбал салбарын үйл ажиллагаа үр дүнтэй, мэдээ мэдээлэл, статистик бодитой болсон байна гэж тодорхойлсон.

Энэхүү зохицуулалт ЗОРИЛГОДОО ХҮРЭХГҮЙ байна гэж үнэлэхдээ дараахь нөхцөл байдлыг харгалзан үзсэн болно. Үүнд:

1. ХСУХАТАтХ-ийн 6 дугаар зүйлд Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тодорхойлсон боловч шууд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байна.
2. БХБЯ-нд Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар байгаа хэдий ч эдгээр газрууд нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд бодлого тодорхойлох үндсэн чиг үүрэгтэй ажилладаг бол Барилгын хөгжлийн төв, ХСУХАТАҮЗЗ-д салбар дундын зохицуулалт хийх эрх зүйн үндэс байхгүй, мөн төрийн захиргааны байгууллагын зохицуулалт хийх чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй, энэ талын хууль эрх зүйн орчин тодорхойгүй байна.
3. ХСУХАТАтХ-ийн хүрээнд үүсгэн байгуулагдсан ХСУХАТАҮЗЗ нь хуулийн хүрээнд хамаарах асуудлаас зөвхөн тариф тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах, сургалт зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бол БХБЯ-ны харьяа БХТ нь холбогдох норм, дүрэм, журмыг боловсруулах, мөрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.
4. ХСУХАТАтХ-иар ХСУХАТАҮЗЗ-д хариуцуулснаас бусад асуудал хариуцах эзэнгүй үлдсэн байна. Үүнээс харахад ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангах тогтолцоо бодлогоос орхигдсон шинжтэй болж энэ салбарыг удирдах өнөөгийн тогтолцоо нь тархай бутархай, олон яам, агентлагуудад харьяалагдаж байгаа нь энэ чиглэлээр хийж гүйцэтгэж буй ажлууд уялдаа холбоогүй, өөр хоорондоо зөрүүтэй, салбарын нэгдсэн мэдээлэл, тоо судалгаа гаргах боломжгүй байдалд хүргэсэн байна.
5. УХАТ-ын асуудлыг БХБЯ-ны төвшинд 2 газрын 3 мэргэжилтэн, БХТ-ийн 1 мэргэжилтэн хариуцаж байгаа нь төрийн бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг улсын хэмжээнд хэрэгжүүлэх ажиллагаа хангалтгүй байх нэг шалтгаан болж байна.
6. УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний байгууллагууд нийтийн эрх, ашиг сонирхлын үүднээс ашгийн бус байх шаардлагатай. Хуульд зааснаар ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн ба орон нутгийн өмчид байх

зохицуулалттай боловч нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинээр баригдаж буй барилга, байгууламжийн УХАТ-ын барилга, байгууламж, төвлөрсөн болон салбар шугам сүлжээ хувийн хэвшлийн болон дундын өмчлөлийн байх тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж, тэдгээрийг хариуцан ажиллаж буй хувийн хэвшлийн ААН-үүдийн үйл ажиллагааг төрийн бодлогод нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн хоорондын харилцаа зохицуулах асуудал зохицуулагдаагүй байна.

7. УХАТ-ын салбарын нэгдсэн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага байхгүйгээс шалтгаалан улсын төсөв, олон улсын болон гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжаар хийгдэж буй өргөтгөл, шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй төсөл, хөтөлбөрт хамрагдах эсэх нь орон нутгийн удирдах байгууллагуудын өөрсдийн авхаалж самбаанаас шалтгаалдаг ерөнхий байдал үүссэн байна. Энэ нь хуулийн 6.1.2-д заасан хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, өргөтгөх, төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зохицуулалт хэрэгжихгүй, чиг үүрэг эзэнгүй байгааг харуулж байна.
8. УХАТ-ын өмчлөл, ашиглалт, үйлчилгээнд хамаарах харилцаа төрийн болон орон нутгийн өмчийн хэлбэрээс хальж хувийн хэвшлийн оролцоотой болсон, усны асуудал нь бараг бүхий л яамдын үйл ажиллагаанд хамаарч байгаа үед энэ хуулийн хэрэгжилт, хуулийн норм, стандартыг мөрдүүлэх ажиллагааг хариуцах бие даасан бүтэц, төрийн захиргааны байгууллага байхгүй нь УХАТ-ын салбарыг “дайвар, хавсарга” салбар болгосон.
9. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан агентлагийн Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүргийн асуудал салбар дотроо 3 хуваагдсан байгаа нь салбарын нэгдсэн бодлого хэрэгжихгүй байх, зарим асуудал хаягдах шалтгаан болж байна. Тухайлбал, ХСУХАТАТХ-ийн 6.1.1-д заасан хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хууль тогтоомж болон дээд шатны байгууллагын шийдвэрийг хэрэгжүүлэх ажил, ялангуяа хууль тогтоомж зөрчигчдөд хариуцлага тооцох асуудал хэрэгждэггүй байх, мөн хуулийн 6.1.4-д заасан хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан байгуулах, түүний байнгын ажиллагааг эрхлэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах ажиллагаа хэрэгжихгүй байх үндэслэл болжээ.
10. Эрх бүхий байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах, нэгдсэн тооцоо судалгаа, статистиктай байх, ашиглах зорилгоор хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн санг хариуцах байгууллагагүйгээс энэ чиглэлээр хийгдсэн хоёр ч мэдээллийн санг ашиглах боломжгүй байна. ХСУХАТАУ33-д УХАТ-ын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан байх боловч түүнийг ажиллуулах, хөтлөх хүний нөөцгүй тул зөвхөн байгууллагын дотоод хэрэгцээг хангах төдийд хөтөлдөг, харин БХБЯ-ны харьяа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт төслийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн Инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн санг 2018 онд шилжүүлсэн боловч, түүнд хандах эрх БХБЯ-ны НААБЗГ, ХСУХАТАУ33, БХТ болон бусад салбарын байгууллагуудад байхгүй байна.
11. Төрийн захиргааны байгууллагагүй байгаа нь УХАТ-д хамаарах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг хэнд хамааралтай болох нь тодорхойгүй, хэрэгжилтийг судлах, үнэлэх ажиллагаа орхигдсон, энэ салбарын хөрөнгө оруулалт бусад салбарын

давалгаан дор, хавсарга шинжтэй болсон, салбарт хийгдсэн, хийгдэж буй хөрөнгө оруулалт тухайн орон нутгийн удирдлагын авхаалж самбаанаас хамааралтай болсон, зээл тусламж авах, өр төлбөрийг эргэн төлөх асуудал нэгдсэн бодлого, төлөвлөлтгүй болсон, УХАТ-ын үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд олон газарт буюу орон нутгийн удирдлага, ХСУХАТАҮЗЗ, сав газрын зөвлөл гээд хэд хэдэн газарт тайлан, мэдээллээ хүргүүлж төрийн хүнд суртлын дарамтад орсон, салбарын стратеги, бодлого төлөвлөлт боловсруулах, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах ажил орхигдсон хүргэжээ.

Зөвлөмж

1. УХАТ-ын салбарыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж буй өнөөгийн тогтолцоо нь хүн амыг стандартын шаардлага хангасан унд, ахуйн хэрэглээний усаар хангах, орчны бохирдлоос хамгаалах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх чадваргүй байгаа тул төрийн захиргааны байгууллагыг зайлшгүй байгуулах,
2. НАА, УХАТ-ын салбарын бодлого, алсын хараа, стратегийг хэрэгжүүлэх асуудал БХБЯ-нд, салбарын хуулийн хэрэгжилт, норм, дүрэм, стандартыг мөрдүүлэх ажил төрийн захиргааны байгууллагад, УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг хариуцах байгууллагууд нь орон нутгийн өмчит болон хувийн хэвшлийн тусгай зөвшөөрлийн болзол хангасан ААН байхаар зохицуулах боломжийг судлах,
3. Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн ба орон нутгийн өмчид байх хуулийн зохицуулалттай боловч сүүлийн жилүүдэд энэ салбарт хувийн хэвшлийн эзлэх хувь нэмэгдэж байгаа, цаашид УБ хот төдийгүй орон нутагт ч мөн адил энэ нөхцөл үүсэх боломжтойг харгалзан төр, хувийн хэвшлийн харилцааг зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох

7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, 17 дугаар зүйлийн 17.2, 17.4, 17.5, 17.6, 17.7, 17.8.2, 17.8.4 дэх заалтуудын хэрэгжилт

Хүснэгт № 5 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томьёолол
2	7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт: Аймаг, нийслэлийн ИТХ-ын бүрэн эрх.	7.1.2. Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох;	Ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд ахуйн болон үйлдвэрлэлийн бохирдол үүсэхгүй байна.
	17 дугаар зүйл.Ус хангамж, ариутгах татуурга	17.2.Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр нь хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй байх бөгөөд тэдгээрийн дэглэмийг Усны тухай хуулийн 31.3, 31.4-т заасны дагуу тогтооно. 17.4.Энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах байдлаар тогтоож, хэрэгжилтийг хангуулна:	

		<p>17.6.Төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш таван метрт хамгаалалтын зурвас тогтооно.</p> <p>17.7.Хотын доторх цэвэр усны дамжуулах, түгээх, бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам ашиглалтын явцад засвар, үйлчилгээ хийх хамгаалалтын зурвас газартай байна.</p> <p>17.8.Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд Усны тухай хуулийн 31.2.1-д зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:</p> <p>17.14.Бохир ус татан зайлуулах шугамын тэнхлэгээс хоёр тийш зургаан метрээс багагүй зайд барилга байгууламж, шугам сүлжээг барихыг хориглоно.</p>	
--	--	--	--

Судалсан байдал

ХСУХАТАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т зааснаар аймаг, нийслэлийн ИТХ нь Нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох эрх, үүрэгтэй байна.

ИТХ-д нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох эрх олгосон эрх зүйн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулиас эхтэй. Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр бүлэгт Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагад хамаарах асуудлыг тусгасан байдаг. Үүнд зааснаар “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ”³⁸, нутгийн өөрөө удирдах байгууллага нь “аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал...” байх³⁹ ба “... тухайн ... нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэх...⁴⁰ эрхтэй байна. Мөн ИТХ-ын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно, харин нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэх⁴¹ боломжийг Үндсэн хуулиар олгожээ. Харин ИТХ-ын тогтоол, шийдвэр нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрт нийцсэн байх ... шаардлагатай бөгөөд түүнийг тус тусын нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр дагаж мөрдөгдөх⁴² үндсэн зарчмыг тодорхой заажээ.

³⁸ Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх заалт

³⁹ Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 2 дахь заалт

⁴⁰ Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх заалт

⁴¹ Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 2 дахь заалт

⁴² Үндсэн хуулийн 63 дугаар зүйлийн 2 дахь заалт

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга /цаашид ЗД гэх/-ын УХАТ-ын өмчлөл, ашиглалттай холбогдох эрх, үүргийг юуны өмнө Усны тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /цаашид ЗЗНДНУТХ гэх/ ХСУХАТАтХ болон Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын хүрээнд авч үзье.

Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох эрх

ИТХ-ийн нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох эрхийг хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл нь Үндсэн хуулиас гадна УИХ-аас 2006 онд ЗЗНДНУТХ-д заасан тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын бүхий л асуудал, түүн дотроо ... байгаль орчныг хамгаалах арга хэмжээний хөтөлбөрийг батлах, нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах зэрэг онцгой бүрэн эрхэд нь хамаарах асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхэд суурилсан байна.⁴³

ИТХ-ын ЗЗНДНУТХ-д заасан нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах ... асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй боловч усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн тухайд Усны тухай хуульд “ЗД-ын саналыг үндэслэн усны эх үүсвэрийг орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргах, хамгаалалтын бүсийн заагийг тогтоох, хамгаалах⁴⁴ болон хот, суурины ариутгах татуургын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн заагийг тогтоох⁴⁵ эрхтэй гэж тусгасан бол ХСУХАТАтХ-ийн 17.4-т “Энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ... тогтоож, хэрэгжилтийг хангуулна” гэж тус тус заасан байна.

Дээрх зохицуулалтаас харахад ИТХ нь Усны тухай хуулиар усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг ЗД-ын саналд үндэслэн тогтоох, хамгаалах, мөн усан сан бүхий хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоохдоо хот, суурины ариутгах татуургын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт болон ЗД-ын саналд үндэслэж байхаар зохицуулжээ. Харин ХСУХАТАтХ-иар ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон

⁴³ МУ-ын ЗЗНДНУТХ-ийн 18.1.Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж хэрэгжүүлнэ: 18.1.2.нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн талаар: з/нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний цогцолбор хөтөлбөрийг батлах; к/нутаг дэвсгэрийнхээ тодорхой хэсгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай Засаг даргын саналыг хэлэлцэн шийдвэрлэх; а/нутаг дэвсгэрийн хөгжлийн дунд хугацааны бодлого болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах;

⁴⁴ Усны тухай хуулийн 11.1.3 дахь заалт

⁴⁵ Усны тухай хуулийн 11.1.4 дэх заалт

эрүүл ахуйн бүсийг ЗД-ын саналд үндэслэн тогтоож, хэрэгжилтийг хангуулах эрх, үүрэгтэй байхаар зохицуулсан нь хуулийн нэр томъёоны хувьд дээрх хуулиудад “усны эх үүсвэр”, “ус хангамжийн эх үүсвэр”, “ус хангамжийн гадаргын усны эх үүсвэр”, “ундны усны эх үүсвэр”, “усан сан бүхий газар”-ын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс зэргээр олон нэр томъёо ашигласан нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байна. Мөн санал, дүгнэлт авах асуудлын хувьд Усны тухай хуульд усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг тогтоохдоо ЗД-ын саналыг, усан сан бүхий газрын тэжээгдлийн мужийн заагийг тогтоохдоо хот, суурины ариутгах татуургын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтэд үндэслэхээр, харин ХСУХАТАТХ-ийн 17 дугаар зүйлийн 17.4.3-т мэргэжлийн хяналтын байгууллагын хот, суурины УХАТ-ын улсын байцаагчийн дүгнэлтийг, мөн “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журамд “Ус хангамжийн гадаргын усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоохдоо байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүгнэлтийг авах шаардлага тавьсан бол ХСУХАТАТХ-д аймаг, нийслэлийн ЗД-аас ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох саналыг авахаар тусгасан нь хууль хэрэглэгчдэд хуулийн зүйл заалтын дунд төөрөгдөл үүсгэх эрсдэлтэй байна. Иймээс хуулийн зохицуулалтын уялдаа холбоог сайжруулах, нэг мөр ойлгоход хялбар байдлаар зохицуулах шаардлагатай байна.

Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн хязгаар

Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн хязгаарыг тогтооход Усны тухай хуульд заасан ерөнхий зохицуулалтын дагуу “усан сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол, мөрний татамд онцгой хамгаалалтын бүсийг, харин усан сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүсийг, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүсийг тогтоох”-оор байна. ХСУХАТАТХ-ийн хот, суурины төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд⁴⁶; төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийг Усны тухай хуулийн 31.3-т заасны дагуу⁴⁷; төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт урсгал уснаас шууд тэжээгдэх худгийн усыг ашиглахдаа хамгаалалтын бүсийг мэргэжлийн хяналтын байгууллагын хот, суурины УХАТ-ын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн 500 метрээс багагүй зайд⁴⁸; урсгал усыг төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа тохиолдолд тухайн газрын хөрс, чулуулгийн тогтолцоо, голын урсацыг харгалзан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг Усны тухай хуулийн 31.4-т заасны дагуу⁴⁹ тогтоох гэсэн хуулийн заалтыг үндэслэх шаардлагатай боловч эдгээр зохицуулалтууд өөр хоорондоо зөрүүтэй, төдийгүй Усны тухай хуулийг шинэчлэн баталсантай холбоотой зарим зүйл заалтын эшлэл буруу байна.

⁴⁶ ХСУХАТАТХ-ийн 17.4.1 дэх заалт

⁴⁷ ХСУХАТАТХ-ийн 17.4.2 дахь заалт

⁴⁸ ХСУХАТАТХ-ийн 17.4.3 дахь заалт

⁴⁹ ХСУХАТАТХ-ийн 17.4.4 дэх заалт

Түүнчлэн 2009 оны 03 сарын 09 өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 51/75 дугаар тушаалаар баталсан Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг⁵⁰ 2015 оны 6 дугаар сарын 05-ны өдөр Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 дугаар хамтарсан тушаалаар “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”⁵¹ /цаашид Бүсийн дэглэм гэх/ болгон шинэчлэн баталсан байдаг.

Энэхүү Бүсийн дэглэмд онцгой хамгаалалтын бүсийг гол мөрөн, горхи, булаг, шандын эргээс 50 метрээс доошгүй зайд буюу түүнээс өргөн, намаг бүхий татамтай тохиолдолд нийт татмын хэмжээгээр өргөсгөж⁵², нуур, урсацын тохируулгатай усан сангийн эргээс 100 метрээс доошгүй зайд, гол мөрөн дээр байгуулсан усан сангийн хувьд түүний эргээс тухайн гол мөрний онцгой хамгаалалтын бүсийн өргөнтэй тэнцүү хэмжээний зайд⁵³, хот суурин газрын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 100 метрээс доошгүй, үерийн хамгаалалтын далангаас 50 метрээс доошгүй зайд⁵⁴, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд⁵⁵ тогтоох бол энгийн хамгаалалтын бүсийг усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд⁵⁶, нийслэл болон аймгийн төвийн хот суурины нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс 500 метр хүртэлх зайд⁵⁷ тогтоохоор тус тус заасан байна.

Эрүүл ахуйн бүс тогтоогоогүй, тогтоох нөхцөл боломж хангагдаагүй болон бүсийн дэглэм зөрчигдөж байгаа усны эх үүсвэрийг хүн амын ус хангамжийн зориулалтаар ашиглахыг хориглодог.⁵⁸

Хот, суурины тухайд түүний төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, ус түгээх шугам, ус түгээх цэгт эрүүл ахуйн бүс тогтоох⁵⁹ ба төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүсийг⁶⁰, төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр хөрсний ус, урсгал уснаас шууд тэжээгдэх уст үе, хөрсний уснаас хамгаалагдсан уст үе, гадаргын ус, урсгал уснаас тэжээгдэж байгаагаас хамааран доод тал нь 200 метр, дээд тал нь 50 км-ээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоохоор⁶¹ ялгамжтай зохицуулсан байна.

Бүсийн дэглэмийн 2.4-д хот суурины... ус, цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн байгууламж бүхий газарт онцгой хамгаалалтын бүс тогтоохгүй гэж,

⁵⁰ Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/7685>

⁵¹ “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам. Ух сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/11118?lawid=11118>

⁵² Бүсийн дэглэмийн 2.3.2 дахь заалт

⁵³ Бүсийн дэглэмийн 2.3.3 дахь заалт

⁵⁴ Бүсийн дэглэмийн 2.3.4 дэх заалт

⁵⁵ Бүсийн дэглэмийн 2.3.5 дахь заалт

⁵⁶ Бүсийн дэглэмийн 2.6.1 дэх заалт

⁵⁷ Бүсийн дэглэмийн 2.6.2 дахь заалт

⁵⁸ Бүсийн дэглэмийн 3.3 дахь заалт

⁵⁹ Бүсийн дэглэмийн 3.12 дахь заалт

⁶⁰ Бүсийн дэглэмийн 3.13 дахь заалт

⁶¹ Бүсийн дэглэмийн 3.15 дахь заалт

3.17-д төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугам хоолойн тэнхлэгээс хоёр тийш 5 метрт эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно гэж заасан бол мөн ХСУХАТАТХ-ийн 17.6-д төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш таван метрт хамгаалалтын зурвас тогтооно гэж заасан нь ойлгомжгүй байдал үүсгэж байна.

Мөн ХСУХАТАТХ-ийн 17.4.1-д хот, суурины төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд тогтоохоор заасан бол Бүсийн дэглэмд төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн хувьд 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүсийг, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг⁶² тогтооно гэж заасан байдал нь мөн адил хуулийг хэрэглэхэд хүндрэлтэй нөхцөл үүсгэж байна.

Хүснэгт № 6 Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн хязгаар заасан зохицуулалтууд

Бүс	ХСУХАТАТХууль	Усны тухай хууль	Бүсийн дэглэм
Эрүүл ахуйн хориглолтын бүс	50 метр ≤	100 метр ≤	<ul style="list-style-type: none"> ➤ 100 метр ≤ /төвлөрсөн ус хангамж/ ➤ 50 метр ≤ /төвлөрсөн бус ус хангамж/
Эрүүл ахуйн хязгаарлалтын бүс			<ul style="list-style-type: none"> ➤ 200 метр ≤ /уст үе, гадаргын ус/ ➤ 500 метр ≤ /урсгал ус/ ➤ /төвлөрсөн бус ус хангамж/ ➤ 50 км /урсгал усны дээд талд/ ➤ 500 метр /урсгал усны болон доод талд/ ➤ 200 метр ≤ /төвлөрсөн бус ус хангамж/ ➤ 5 метр /төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугам хоолойн тэнхлэгээс хоёр тийш/
Энгийн хамгаалалтын бүс	200 метр ≤ 500 метр ≤ /урсгал уснаас шууд тэжээгдэх худаг/	200 метр ≤	<ul style="list-style-type: none"> ➤ 200 метр ≤ / усны сан бүхий газрын эргээс/ ➤ 500 метр ≥ /нийслэл болон аймгийн төвийн хот суурины нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс/
Онцгой хамгаалалтын бүс		50 метр ≤ + гол мөрний татам	<ul style="list-style-type: none"> ➤ 100 метр ≥ /хот суурины нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газрын эргээс/ ➤ ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд; ➤ ус дамжуулах шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн байгууламж бүхий газарт онцгой хамгаалалтын бүс тогтоохгүй

Дээрх зохицуулалтаас харахад усны эх үүсвэрээс 50-100 метр ба түүнээс дээш зай онцгой хамгаалалтын бүсэд хамаарах бөгөөд уг бүсэд Усны тухай болон ХСУХАТАТХуулиудад зааснаар барилга байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал бэлтгэх болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглох үндсэн зохицуулалт хэрэгждэг. Үүнийг Бүсийн дэглэмд заасан ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд газрын өнгөн хөрсийг эвдрэл элэгдэлд оруулах, мод бут огтлох, элс хайрга чулуу олборлох; цэвэрлээгүй хаягдал бохир ус болон хог хаягдал хаях, хаягдлын сан байршуулах; орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж

⁶² Бүсийн дэглэмийн 3.18 дахь заалт

барьж ашиглах;газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгохыг хориглох ⁶³ зохицуулалтуудаар өргөжүүлж өгсөн.

Гэтэл бодит амьдралд хууль, журам хэрэгжихгүй, хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд барилга байгууламж барих, ашигт малтмал олборлох, хөрс хуулах, мод бут огтлох үзэгдэл байнга гарсаар байгаа нь эрх бүхий албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагаа, хууль хэрэгжүүлэгч байгууллагуудын эрх хэмжээ хүчгүйдэж байгааг тухайлбал, Туул голын орчимд үүссэн нөхцөл байдал тод харуулж байна.

*Кейс: УИХ-ын Өргөдлийн байнгын хорооны дарга М.Оюунчимэг: Туул голын асуудал дээр МАН, АН гэж талцах шаардлага байхгүй*⁶⁴

Туул голын сав газар, түүний ойр орчим, усны ундарга ихтэй хамгаалалтын бүсэд сүүлийн хэдэн жил янз бүрийн үйл ажиллагаа явуулж байгаа. Бүр замбараагаа алдсан. Үйл ажиллагааг нь харахад, хайрга дайрга олборлолтоос гадна барилгууд баригдаж байна. Баригдчихсан хаус хотхонууд ч их бий. Уг нь ААН-үүд аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулна гэж зөвшөөрөл авдаг. Гэтэл яг газар нь очоод, байдлыг нь ажиглахаар хаалттай хашааны цаана нэг бол хайрга олборлож байна эсвэл барилга баригдаж байх жишээтэй. Зориулалтын бусаар ашиглаад байна гэсэн үг л дээ. Барилгын ажил одоо ч үргэлжилж байна. Туул голын эргээс ердөө 10 метр хүрэхгүй газар хүртэл барилгын ажил явагдаж байгаа. Хуулиараа бол голын эргээс 50 метрээс дотогш зайд ААН үйл ажиллагаа явуулах эрхгүй. Хайрга дайрга олборлосноос болоод Туул голын урсац тасарсан. Одоо хөрсний чийгийг нь барьж буй бургасыг сүйтгэх ажиллагаа маш эрчимтэй явагдаж байна. Холбогдох албаны хүмүүсийг нь ажлаа хий гэж шаардахаар “Зөвшөөрлийг нь цуцлахаар шүүх дээр очоод бидний шийдвэр уначихдаг” гэж учирладаг. Ихэнх тохиолдолд шүүх зөвшөөрлийг нь эргүүлээд сэргээчихдэг юм байна. Тэр ч байтугай төр төлөөлөөд ажиллаж байгаа албан хаагчид ААН-үүдийн хашаанд нь ч нэвтэрч чадахгүй байдалтай ажиллаж байгаа. Төр төлөөлж буй байгууллагууд ийм нөхцөлд байхад ажил урагшаа явахгүй. Цагдаад барилгын ажил явагдаж буйг нь мэдээлж, гомдол гаргахаар олон нийтийн газар тодорхой хэв журам зөрчөөгүй учир бидэнд хамаагүй гэдэг.Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд ААН-үүд үйл ажиллагаа явуулсаар байна. Зөвшөөрлийг нь цуцалчихаад байхад л үйл ажиллагаа явуулаад байх жишээтэй..Зөвшөөрөл нь өөрөө Усны тухай болон бусад хууль тогтоомжуудыг зөрчиж байгаа. Тиймээс цуцлахаас өөр арга байхгүй

Олон нийт ч хэлж байгаа. Мөнгөтэй баян хүмүүсийн газар учраас асуудал гацна гэж тайлбарладаг. Тийм ээ, энэ асуудал яригдсаар ирсэн ч үр дүнд хүрсэн нь ховор. Бүр зарим сайдын үед “Үүнийг тань цуцалчихъя. Шүүх дээр очоод сэргээчихнэ биз” гэсэн үүднээс хүртэл асуудал хандсан гэдэг хардлага дагуулдаг. Тийм учраас бид ААН-үүдэд хууль зөрчиж, зөвшөөрөл олгосон төрийн албан хаагчдыг бас АТГ-д шалгуулах нь зүйтэй гэсэн байр суурийг гишүүд илэрхийлж байгаа. ... Мэдээж ААН-үүд шуудхан очоод газраа авчихаагүй. Бүгд л тодорхой хүрээнд төлбөр, мөнгөө төлсөн байгаа. Одоо Туул голын эрэг дагуу газрыг зарна гээд явж байгаа иргэн ч бий. Энэ нь Туул голын эрэг дагуу газар өөрөө авлигажилт, хууль бусаар мөнгөжих хэрэгсэл болж байгааг харуулж байгаа юм. Яг хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүдийг хохирлыг барагдуулах чиглэлд төрийн байгууллагууд анхаарч ажиллана.

Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг хэрэгжүүлэх

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ЗД ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох асуудлаар ЗЗНДТНУТХ- д заасны дагуу дэд бүтцэд

⁶³ Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.9.1, 3.9.3, 3.9.11, 3.9.12

⁶⁴ М.Оюунчимэг: Туул голын асуудал дээр МАН, АН гэж талцах шаардлага байхгүй. Эх сурвалж: <http://medee.mn/mobile.php?eid=105471>

хамаарах нийтлэг бүрэн эрхийн⁶⁵ хүрээнд “орон нутгийн чанартай үер усны хамгаалалт, далан суваг барих, засварлах, тэмдэгжүүлэх ажлыг зохион байгуулах;⁶⁶ нутаг дэвсгэртээ ... хот тосгоны орон сууц, нийтийн аж ахуй, үйлчилгээг хөгжүүлэх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах...”⁶⁷, Усны тухай хуульд зааснаар тухайн нутаг дэвсгэрийн усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн зааг, тэжээгдлийн мужийг тэмдэгжүүлж, бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах⁶⁸, бүсийн дэглэмийг мөрдүүлэх⁶⁹, сахиулах⁷⁰, ХСУХАТАТХ-иар “ХСУХАТАТХ тогтоомж, түүнд нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах”⁷¹ эрх эдэлж, нөгөө талаар үүрэг хүлээдэг. Харин бүсийн дэглэмийг хэрэгжүүлэх, журмын хэрэгжилтэд хяналт тавих асуудал усны сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын эрх бүхий байцаагч, байгаль хамгаалагчид хамаарах⁷² зохицуулалт хэрэгжиж байна.

Үүнээс харахад Усны тухай хууль, ХСУХАТАТХ болон Бүсийн дэглэмийг мөрдөх журмын хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд тавих хяналт, хууль сахиулах ажиллагаа аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны ЗД, усны сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын эрх бүхий байцаагч, байгаль хамгаалагчид гүйцэтгэхээр байна.

Энэ нь ЗД-ын хувьд нэг талаас ААН, иргэнд газар ашиглах, эзэмших зөвшөөрөл олгох, нөгөө талаас хуулийн хэрэгжилтийг хангах гэсэн эсрэг тэсрэг нөхцөлийг үүсгэсэн нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байх гол шалтгаан болох магадлалтай юм.

Нийслэл хотын хувьд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох асуудлаар онцлог зохицуулалт хэрэгждэг. Тухайлбал, хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох эрхийг тухайн орон нутгийн ИТХ-д Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлд ерөнхий байдлаар олгосон, гэтэл 22.5-д “нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хамтран тогтооно” гэж заасан нь нийслэлийн хувьд ойлгомжгүй байдал үүсгэж байна.

Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг тогтоох асуудлаар Усны тухай хуулийн 11 дүгээр зүйл, ХСУХАТАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дахь заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16.1.4 дэх заалтад үндэслэн нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 04 сарын 05-ны өдрийн “Улаанбаатар хотын усны эх

⁶⁵ МУ-ын ЗЗНДНТУТХ-ийн 29 дүгээр зүйл

⁶⁶ МУ-ын ЗЗНДНТУТХ-ийн 29.1.4 дэх заалт

⁶⁷ МУ-ын ЗЗНДНТУТХ-ийн 35.1.5 дахь заалт

⁶⁸ Усны тухай хуулийн 12.1.4 дэх заалт

⁶⁹ Усны тухай хуулийн 13.1.6 дахь заалт

⁷⁰ Усны тухай хуулийн 15.1.4 дэх хэсэг

⁷¹ ХСУХАТАТХ-ийн 8.1.1 дэх заалт

⁷² Бүсийн дэглэмийн 1.4 дэх заалт

үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” 50 дугаар тогтоолыг⁷³ баталсан.


Харин Усны тухай хуулийн 22.5-д үндэслэн 2018 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан “Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг тогтоох тухай” А/02/01 дугаар тушаал батлагдан, түүний хавсралтаар “Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүс, Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүс, Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн муж”-ийн зургийг тус тус баталсан⁷⁴ байна.

Дээрх хоёр тушаалаас харахад НИТХ-аас ундны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын болон хязгаарлалтын бүсийг, усан сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсийг, газрын доорх усны тэжээгдлийн мужыг тогтоосон нь БХБСайд, БОАЖСайдын хамтарсан тушаалаар УБ хотын хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын болон хязгаарлалтын бүсийг, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээгдлийн мужыг тогтоосон тушаалтай давхцаж байна.

Судалгааны ажлын хүрээнд НИТХ-ын “Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” 50 дугаар тогтоолын хавсралтуудтай танилцах боломжгүй, уг тогтоол олон нийтэд нээлттэй, ил тод бус байсан нь хоёр сайдын хамтарсан А/02/01 дугаар тушаалын хавсралтаар баталсан зурагтай харьцуулах, дүгнэлт хийх боломжгүй байдалд хүргэсэн.

Түүнчлэн эрүүл ахуйн болон хязгаарлалтын бүсийг тогтоосон зураг, төслүүд олон нийтэд нээлттэй, ил тод бус байгаа нь эдгээр бүсэд хууль тогтоомж зөрчин газар олгох, эзэмшүүлэх зэрэг хууль бус үйл ажиллагааг өөгшүүлэх нэг үндэслэл болж байна.

Зураг № 2 БОАЖСайд, БХБСайдын хамтарсан А/02/01 дугаар тушаалын хавсралтууд



⁷³ Тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Ундны эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсийн зураг”-ийг, 3 дугаар хавсралтаар “Ундны эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийн зураг”-ийг, 5 дугаар хавсралтаар “Усны сан бүхий газрын энгийн хамгаалалтын бүсийн зураг”-ийг, 7 дугаар хавсралтаар “Усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүсийн зураг”-ийг, 9 дүгээр хавсралтаар “Газрын доорх усны эх үүсвэрийн тэжээгдлийн мужийн зураг”-ийг тус тус баталсан.

⁷⁴ Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг тогтоох тухай. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/annex/details/8172?lawid=13081>

Үүнээс харахад эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоож буй хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хүрээнд усны эх үүсвэр, ус хангамжийн эх үүсвэр, ундны усны эх үүсвэр зэрэг нэр томъёог хольж ашигладаг, нэг асуудлыг хэд хэдэн байдлаар тодорхойлсон байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангалтгүй байх эрсдэлийг дагуулж байна. Түүнчлэн хууль тогтоомжид заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагууд болон ИТХ-аас эрүүл ахуйн хориглолтын болон хязгаарлалтад холбогдох тушаал, шийдвэрүүдийг гаргасан нь давхардал үүсгэсэн байна.

Усны сан, усны барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн зааг тогтоосон хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий этгээдийн тоо олон хэдий ч тэдгээрийн үйл ажиллагаа уялдаа холбоогүй, хууль тогтоомж зөрчигчид авах арга хэмжээ нь хүчгүй, тухайлбал ЗД нэг гараараа зөвшөөрөл олгож, нөгөө гараараа хяналт тавьж буй байдал зэрэг нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байх гол шалтгаан болж байна. Тухайлбал, МУ-ын нийт хүн амын талаас илүү хувь нь оршин суугаа УБ хотын усны эх үүсвэр болсон Туул голын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй хэд хэдэн асуудал тулгамддаг. Нэг талаас газрын болон үйл ажиллагааны зөвшөөрлийг хэд хэдэн субъект олгох эрхтэй, нөгөө талаас бүсийн дэглэм мөрдөгдөж буй эсэхэд хяналт тавих эрх бүхий субъект, түүний үйл ажиллагааг, эрх хэмжээ тодорхойгүй, хангалтгүй байгаа зэргийг онцолж болох байна.

Кейс А.Сүхбат: Туул голыг гольдролоор нь улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай⁷⁵

УИХ-ын даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдаад 1 жил болсон байна. Энэ хугацаанд Туул голын дээд эх үүсвэрээс Заамар сум хүртэл гольдролын дагуу явж, асуудлыг нь судалсан бөгөөд Туул голын бохирдол зөвхөн Сонгины орчмоор ч биш голын дээд эх үүсвэр нь хүртэл бохирдох нөхцөл бий болсныг тогтоосон. Туул, Тэрэлжийн голын гольдирол ойр орчимд нь газар авсан айлууд, аж ахуйн нэгжүүд газар ухаж, бие засах газраа хүртэл байгуулчихсан байгаа юм. Энэ нь бие засах газрын бохир нь шууд гол руу цутгаж байгаа гэсэн үг. 2012 онд баталсан Усны тухай хуулиар голын эргээс 50 метр хүртэлх зайг онцгой хамгаалалтын, 200 метр хүртэлхийг энгийн хамгаалалтын бүс гэж заагаад тэнд газар олгохыг хориглосон байдаг. Гэтэл Засаг даргын захирамж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар Гачуурт, Тэрэлж, Налайх зэрэг бүх хэсэгт газар олгосон, Туул голын гольдролын дагуу тав, арван жилээр газар эзэмшүүлсэн, мөн Туул гол руу цутгадаг голуудын гольдролд ч эзэмших эрх олгочихсон байгаа. Тухайлбал, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд харъяалагддаг Горхи Тэрэлжийн тусгай хамгаалалттай газар нутагт Эрдэнэ сумын Засаг дарга 1000 гаруй хүнд газар өмчлүүлчихсэн байна.

2018 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Улсын Их Хурлын Өргөдлийн байнгын хорооны хуралд танилцуулсан мэдээллээс харахад Туул голын энгийн болон онцгой хамгаалалтын бүсэд үе үеийн нийслэл, дүүргийн удирдлагуудаас нийтдээ 14 мянга гаруй нэгж талбарын зөвшөөрөл олгосноос онцгой хамгаалалтын бүсэд 894 объект, энгийн хамгаалалтын бүсэд 500 орчим барилга байгууламж байдаг⁷⁶ ба эдгээр нь хэд хэдэн хууль дүрэм зөрчиж байгааг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч С.Батболд “Туул голын хамгаалалтын зурвасыг маш сайн баримтлах хэрэгтэй. Холбогдох яамтай ярилцаад, Туул гол дагуу олгогдсон газруудын эрхийг цуцалж, дахин

⁷⁵ А.Сүхбат: Туул голыг гольдролоор нь улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай. Эх сурвалж: <http://vip76.mn/content/52147>

⁷⁶ Туул гол дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах зөвшөөрөл олгосон асуудлаар хэлэлцүүлэг зохион байгууллаа. УИХ-ын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс. 2018.04.10. Эх сурвалж: <http://www.parliament.mn/n/wpey>

барилга бариулахгүй байх тал дээр онцгой анхаарал хандуулж ажиллах шаардлагатай” гэж мэдэгдсэнээс харж болох юм⁷⁷

Кейс: Туулыг цэвэрлэхэд 1,7 тэрбумыг зарцуулсан ч бохир хэвээрээ⁷⁸

Туул голын эрэг дагуу хязгаарлалтын бүс дотор 312 ах ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байсан. Дээрх аж ахуй нэгжүүд голын эрэг дагуу барилга барих, үйл ажиллагаа явуулахдаа тодорхой заасан хэмжээ хязгаарыг зөрчсөн байсан. Ер нь Туул голын эрэг дагуу зөвшөөрөлгүй аж ахуй нэгж үйл ажиллагаа явуулж байгаа нь зөвшөөрөл олгосон хүмүүстэй холбоотой гэж бодож байна. Хан-Уул дүүргийн Засаг дарга Сонсголонгийн гүүрний баруун талд нөхөн сэргээлт хийх газрыг барилгын хог хаягдлаар дүүргэж дээр нь барилга барьсан зөрчил ч илэрсэн. Сонсголонгийн гүүрний дэргэд “Пума” констракшн 54 га газарт шинэ гэр хороолол барьж байгаа. Гэтэл энэ нь үйл ажиллагаа явуулах зөвшөөрөлгүй. Мөн зөвшөөрөлгүй барилга барьж байсан “Суруго Монгол” ХХК үйл ажиллагааг зогсоосон байна. Эдгээр аж ахуй нэгжид Эрдэс баялаг эрчим хүчний яам, Байгаль орчин аялал жуулчлалын яам, Барилга хот байгуулалтын яам гээд холбогдох яамдууд зөвшөөрлийг нь олгодог. Ер нь бол зөвшөөрлийг дарга нар өгдөг. Цуцлах эрхийг нь ч бас тэд өгнө. Ямар нэг байгууллагыг торгоод, хаагаад өнгөрөхдөө биш харин үр дүнд хүрэх хэрэгтэй байна. Зарим нь зөвшөөрөл өгч байхад зарим нь аврах гээд явж байна. Энэ байдлыг өөрчилж бодлоготой шийдвэр гаргах хэрэгтэй байна.

МХЕГ-ын Байгаль орчин, аялал жуулчлал, геологи, уул уурхайн хяналтын газрын улсын ахлах байцаагч Б.Чинзоригийн Ардын эрх сонинд өгсөн ярилцлагаас

Хот, суурин төлөвлөлт ба хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс

Ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох асуудал нь тухайн хот, суурины төлөвлөлт, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй салшгүй холбоотой байна.

Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд тусгасан зорилтод нийцсэн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил сүүлийн жилүүдэд эрчимтэй хийгдэж эхэлсэн боловч батлагдсан нь цөөн байна.

Нийслэлийн хувьд 2002 оноос хойш Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байгаа бол аймгуудын хувьд дийлэнх нь ерөнхий төлөвлөгөөгөө батлуулаагүй байна.⁷⁹ Шалтгааныг нь гол төлөв төсөв мөнгөний асуудалтай холбон тайлбарласан байх боловч гадаад, дотоодын компаниудаар хөрөнгө зарж зураг төслөө боловсруулсан ч батлагдаагүй хүлээгдэж буй нь бас цөөнгүй байна.

УБ хотын хувьд “Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө /цаашид ЕТ гэх/”-г анх ЗГ-ын 2002 оны 28 дугаар тогтоолоор баталсан бол “Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага” баримт бичгийг УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоол⁸⁰-оор баталсан байна. ЕТ-нд өөрчлөлт оруулахад

⁷⁷ С.Батболд: Туул гол дагуу олгогдсон газруудын зөвшөөрлийг цуцлах шаардлагатай. Эх сурвалж <https://dnn.mn/c-батболд-туул-гол-дагуу-олгогдсон-газрын-зөвшөөрлийг-цуцлах-шаардлагатай/>

⁷⁸ Туулыг цэвэрлэхэд 1,7 тэрбумыг зарцуулсан ч бохир хэвээрээ. Эх сурвалж: <https://news.mn/г/68984/>

⁷⁹ Ерөнхий төлөвлөгөөтэй холбогдуулан Чойбалсан, Даланзадгад, Дархан, Улаанбаатар хот, Өвөрхангай, Ховд, Орхон, Хөвсгөл, Сүхбаатар, Төв зэрэг аймгуудын мэдээллийг судаллаа.

⁸⁰ “Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага” баримт бичиг. УИХ-ын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоол. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/9196>

Улаанбаатар хотын хүн амын тоо сүүлийн 10 гаруй жилийн дотор механик болон ердийн өсөлтөөс шалтгаалан эрчимтэй нэмэгдсэн⁸¹, зохион байгуулалт, төлөвлөлтгүй газар олголт зэрэг гол шалтгаан болжээ.

Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд ерөнхийдөө тухайн орон нутагт ногоон байгууламжийг ихээр байгуулах, гэр хорооллыг орон сууцны хороолол болгох, инженерийн шугам сүлжээнд хамрагдах байдлыг нэмэгдүүлэх асуудлуудыг тусгадаг боловч эдгээр зорилтууд нь хэтэрхий ерөнхий лоозонгийн шинжтэй байх эрсдэлтэй байна. Тухайлбал төлөвлөсөн арга хэмжээнүүдэд шаардагдах санхүүжилтийн хэмжээ тодорхойгүй, ямар эх үүсвэрээс санхүүжүүлэх талаар тодорхой тусгадаггүй Ерөнхий төлөвлөгөөг гардан хэрэгжүүлэх институци, удирдлага менежментийн бүтэц, тогтолцоог гүйцэт төлөвлөдөггүй, асуудлуудыг хариуцах эзэн, хяналт тавих тогтолцоогүй үлдээдэг нийтлэг сул талтай гэж үзэж болохоор байна. Үүнээс үүдэн хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй холбоотой гарч буй гол зөрчлүүд болох эрх бүхий албан тушаалтан дур мэдэн газар олгох, улмаар эмх замбараагүй, хууль тогтоомж зөрчин баригдсан барилга байгууламжийн тоо нэмэгдэх, суурьшсан бүсэд шинээр тавигдах инженерийн шугам сүлжээнд шаардлагатай газар чөлөөлөх зэрэг асуудлууд байнга гарсаар байна.

Үнэлсэн байдал

МУ-ын Үндсэн хууль, ЗЗНДНУТХ, Усны тухай хууль, ХСУХАТАТХ болон Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам, бусад холбогдох тогтоол, шийдвэрийн хүрээнд ХСУХАТАТХ-ийн 7.1.2-т заасан аймаг, нийслэлийн ИТХ-ын нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох үйл ажиллагааг ЗОРИЛГОДОО ХҮРЭХГҮЙ байна гэж үнэллээ.

Ийнхүү үнэлэх үндэслэлийг дараахь нөхцөл байдалд тулгуурласан болно:

1. ХСУХАТАТХ-ийн 7.1.2-т заасан "... ундны усны эх үүсвэр" гэх хуулийн нэр томъёо холбогдох хууль тогтоомжид байхгүй байна. Усны тухай хуулийн 3.1.6-д "усны эх үүсвэр" гэж ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа усны нөөц болон гол мөрний урсац бүрэлдэх эхийг; 3.1.15-д "ус хангамжийн эх үүсвэр" гэж худаг, татах, цуглуулах, цэвэршүүлэх байгууламж, түгээх зориулалт бүхий усны барилга байгууламжийг ойлгоно гэжээ. Үүнээс харахад ус хангамж, ариутгах татуургад хамаарах хуулийн нэр томъёоны нэгдмэл байдал хангалтгүй байна. Иймээс хуулийн нэр томъёог салбарын ерөнхий хууль болох Усны тухай хуульд нийцүүлэх замаар хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.
2. ИТХ нь хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоохдоо:
 - Усны тухай хуульд зааснаар усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийг ЗД-ын саналд, усан сан бүхий газрын

⁸¹ 2017 оны жилийн эцсийн байдлаар 1,462,973-д хүрсэн байна. ОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО, бүс, аймаг/нийслэл, хот/хөдөөгөөр. Эх сурвалж: https://www.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0300_004V1&RESIDENT_select_all=0&RESIDENTSingleSelect=_11&SOUM_select_all=0&SOUMSingleSelect=_5_511&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2017&viewtype=table

тэжээгдлийн мужийн заагийг хот, суурины ариутгах татуургын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтэд үндэслэхээр,

- ХУХАТАТХ-д зааснаар ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг аймаг, нийслэлийн ЗД-ын саналд, ус хангамжийн эх үүсвэрт урсгал уснаас шууд тэжээгдэх худгийн усыг ашиглахдаа хамгаалалтын бүсийг мэргэжлийн хяналтын байгууллагын хот, суурины УХАТ-ын улсын байцаагчийн дүгнэлтэд үндэслэхээр,
- Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журамд зааснаар ус хангамжийн гадаргын усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийг тогтоохдоо байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан дүгнэлтийг авах шаардлагыг тус тус тавьсан байна.

Үүнээс харахад ИТХ-аас ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоохдоо санал, дүгнэлтийг нь авах зайлшгүй шаардлагатай байгууллага, албан тушаалтанд холбогдох эрх зүйн зохицуулалтууд хууль хэрэглэгчдэд, ялангуяа 4 жил тутамд шинээр сонгогддог, мэргэжлийн гэхээс илүүтэй улс төрийн нөлөө бүхий хүмүүсээс бүрддэг байгууллага болох ИТХ-ын хувьд хуулийн зүйл заалтын дунд төөрөгдөл үүсгэх эрсдэлтэй байна. Иймд хуулийн зохицуулалтуудын уялдаа холбоог сайжруулах, нэг мөр ойлгоход хялбар байдлаар томъёолох шаардлагатай байна.

3. Ус хангамжийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох орон зайн хэмжээ, хязгаар хууль тогтоомжуудад адил төстэй байгаа хэдий ч ашиглагдаж буй нэр томъёоны хувьд “усны эх үүсвэр”, “ус хангамжийн эх үүсвэр”, “ус хангамжийн гадаргын усны эх үүсвэр”, “ундны усны эх үүсвэр”, “усан сан бүхий газар”-ын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс зэрэг олон хэлбэрээр ашиглагдаж байгаа нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж байгаа тул нэр томъёог цэгцлэх, хууль хэрэглэгчдэд аль болох ойлгомжтой болгох шаардлагатай байна.
4. Усны болон ус хангамжийн эх үүсвэр, усан сан бүхий газрын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчих явдал нь хэвийн үзэгдэл мэт болж, улмаар хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэгчдийн эрх мэдэл, үйл ажиллагаа хүчгүйдэж байна. Үүний тод жишээ бол Туул гол орчимд баригдаж буй барилгын талбайд мэргэжлийн хяналтын байгууллага бүү хэл УИХ-ын гишүүн өргөдөл, гомдлын мөрөөр хяналт, шалгалт хийх боломжгүй байгаа байдал юм.
5. Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох тухай зохицуулалт агуулсан Усны тухай хууль, ХСУХАТАТХ дахь зарим заалтууд ойлгомжгүй, өөр өөрийн өнцгөөс тайлбарласан байдалтай байгаа нь хууль хэрэглэгчдийг төөрөгдүүлэх эрсдэлтэй байна. Тухайлбал, Усны тухай хуульд зааснаар хамгаалалтын бүс нь онцгой болон энгийн, эрүүл ахуйн бүс нь хязгаарлалтын болон хориглолтын гэсэн ялгаатай байхаар зохицуулсан атал ХСУХАТАТХ-д энэ тухай огт тусгаагүй, зөвхөн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй байх ерөнхий зохицуулалт хэрэгжиж байна.
6. Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоосон ИТХ-ын тогтоол, шийдвэр тогтворгүй байна. Энэ нь тухайн орон нутагт хөрөнгө оруулалт татах горьдлого, сонгуульд ялалт байгуулсан намын бодлого, иргэд, ААН-ийн эсэргүүцлээс эмээх, хөрөнгө мөнгө, эрх мэдэл бүхий этгээдийн нөлөөнд автах зэрэг байдлаас ихээхэн

хамаарч байна. Хэдийгээр УИХ-аас 2015 онд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай⁸², Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай⁸³, 2008 онд Хот байгуулалтын тухай⁸⁴ зэрэг хуулиудыг баталсан ч хэрэгжилт хангалтгүй байгаа нь ялангуяа хот, суурин доторх ус хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийн хамгаалалтын бүсийг тогтооход хүндрэл учруулж байна.

7. Аймаг, нийслэлийн ЗД нь нэг талаас ИТХ-аас хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй холбогдуулан гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэгч, нөгөө талаас орон нутагтаа газар эзэмшүүлэх, өмчлүүлэх шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан байгаа нь бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах, эсхүл түүнийг зөрчих асуудлыг тухайн хүнд даатгаад үлдээсэнтэй адил байна. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан⁸⁵-д хийсэн хайлтын үр дүнд бүсийн дэглэм зөрчиж газар олгосон асуудлаар албан тушаалтныг шийтгэсэн тогтоол, шийдвэр олдоогүй, мөн иргэн, ААН-д хууль зөрчиж олгосон тусгай зөвшөөрөл олгосон шийдвэрийн шүүхээс хүчингүй болгож шийдвэрлэдэг талаарх мэдээллүүд нь энэхүү таамаглалыг бататгаж байна.
8. Газар эзэмших, тодорхой үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг олон байгууллагаас олгодог, бие биенээсээ санал авдаггүй байдал нь хуулийн хэрэгжилтийг хангалтгүй байлгах бас нэг шалтгаан болж байна.
9. ИТХ нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ус хангамж, ариутгах татуургыг хөгжүүлэх бодлого боловсруулан, биелэлтэд хяналт тавих, энэ талаар Засаг даргын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх⁸⁶ эрхтэй боловч энэ эрхээ бүрэн хэрэгжүүлдэггүй, зарим тохиолдолд эс үйлдэхүйгээр хандаж байгаа зэрэг нь ИТХ-ын гишүүдийн энэ асуудалд өгч буй ач холбогдол, үзэмжээс хамаарч хууль хэрэгжих боломжтой байдлыг бий болгосон байна.
10. Бүсийн дэглэмийн 2.4-д хот суурины... ус, цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн байгууламж бүхий газарт онцгой хамгаалалтын бүс тогтоохгүй гэж, 3.17-д төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугам хоолойн тэнхлэгээс хоёр тийш 5 метрт эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно гэж заасан бол ХСУХАТАТХ-ийн 17.6-д төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш таван метрт хамгаалалтын зурвас тогтооно гэх зөрүүтэй зохицуулалт хэрэгжиж байна. Мөн ХСУХАТАТХ-ийн 17.4.1-д хот, суурины төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд тогтоохоор заасан бол Бүсийн дэглэмд төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн хувьд 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүсийг, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг⁸⁷ тогтооно гэж янз бүрээр томъёолсон нь хуулийг хэрэглэхэд хүндрэлтэй нөхцөл үүсгэх эрсдэлтэй байна. Түүнчлэн эдгээр зохицуулалт хэрэгжихгүй байгааг гэр хорооллын ус түгээх төвлөрсөн болон төвлөрсөн бус худгийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм хэрхэн хэрэгжиж байгаагаас харж болох юм.

⁸² Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/11484>

⁸³ Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль 2015. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/11219>

⁸⁴ Хот байгуулалтын тухай хууль 2015 Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/530>

⁸⁵ <http://www.shuukh.mn/>

⁸⁶ ХСУХАТАТХ-ийн 7.1.1 дэх заалт

⁸⁷ Бүсийн дэглэмийн 3.18 дахь заалт

11. ИТХ-аас тогтоосон хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг хамгаалах үйл ажиллагаа, эрх зүйн орчин сул байна. Усны тухай хууль, ХСУХАТАтХ болон Бүсийн дэглэмийг мөрдөх журмын хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд тавих хяналт, хууль сахиулах ажиллагаа аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны ЗД, усны сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын эрх бүхий байцаагч, байгаль хамгаалагчид гүйцэтгэхээр байгаа хэдий ч Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш зөвхөн мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын /цаашид МХБ гэх/ улсын байцаагчид арга хэмжээ авах эрхийг үлдээсэн нь МХБ-ын хүн хүч дутмаг, зөвхөн төлөвлөгөөний дагуу хяналт хийдэг байдлаас шалтгаалан зөрчлийг цаг тухайд нь таслан зогсоох боломжгүй байдалд хүргэжээ. Мөн мэргэжлийн байгууллагуудын хяналт, шалгалт хийх боломж хумигдсан, зөрчлийг илрүүлэх процесс удаашралтай болсон, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах үндсэн чиг үүрэг бүхий байгууллагуудад арга хэмжээ авах, хариуцлага тооцох эрхгүй болсон, Зөрчлийн тухай хуулийн хүрээнд хүлээлгэж буй торгуулийн арга хэмжээний хэмжээ бага байгаа зэрэг хүчин зүйлсээс хамааралтай байна.
12. Нийслэл хотын хувьд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох асуудлаар онцлог зохицуулалт хэрэгждэг бөгөөд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох эрхийг тухайн орон нутгийн ИТХ-д Усны тухай хууль болон ХСУХАТАтХ-иар олгосон, гэтэл Усны тухай хуулийн 22.5-д “нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хамтран тогтооно” гэж заасан нь нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох асуудлаар 2016 оны “Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” НИТХ-ын 50 дугаар тогтоол, 2018 оны “Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг тогтоох тухай” БХБСайд, БОАЖСайдын хамтарсан А/02/01 дугаар тушаал гэсэн баримт бичиг гаргах үндэслэл болсон байна. НИТХ-ын 50 дугаар тогтоолын хавсралтуудтай танилцах боломжгүй, тэдгээр нь олон нийтэд нээлттэй, ил тод бус байсан байгаа нь бүсийн дэглэмийг зөрчих эрсдэлийг нэмэгдүүлж байна.
13. Газрын тухай хуулийн 13.1-д зам, шугам сүлжээний газарт ... ус хангамж, ариутгах татуурга, ... зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна гэж заасан бөгөөд үүнд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг оруулалгүй орхигдуулсан. Иймээс хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоож, кадасрт хийлгэсэн цагаас эхлэн газрын төлбөрийн асуудал хөндөгддөг. Орон нутгийн төсөвт энэ чиглэлээр зарцуулах санхүүжилт тусгагддаггүй, ус хангамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын дийлэнх нь эдийн засгийн чадамжгүй, алдагдалтай ажилладаг тул ус хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн газрын төлбөрийг төлөх төлбөрийн чадваргүй байна. Үүнээс шалтгаалан кадастрын зураглал хийлгэдэггүй, улмаар кадастрын зураглалын мэдээллийн санд болон газрын мэдээллийн санд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн тухай мэдээллийг оруулдаггүй байдал нь энэ бүсэд газар олгох асуудлыг даамжруулж байна.
14. ХСУХАТАтХ-ийн “17.2.Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр нь хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй байх бөгөөд тэдгээрийн дэглэмийг Усны тухай хуулийн 31.3, 31.4-т заасны дагуу тогтооно., 17.4.2.төвлөрсөн ус хангамжийн эх

үүсвэрийн энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийг Усны тухай хуулийн 31.3-т заасны дагуу; 17.4.4.урсгал усыг төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа тохиолдолд тухайн газрын хөрс, чулуулгийн тогтолцоо, голын урсацыг харгалзан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг Усны тухай хуулийн 31.4-т заасны дагуу., 17.7.Хотын доторх цэвэр усны дамжуулах, түгээх, бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам ашиглалтын явцад засвар, үйлчилгээ хийх хамгаалалтын зурвас газартай байна., 17.8-д Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд Усны тухай хуулийн 31.2.1-д зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:” гэх заалтуудын эшлэл буруу, 2012 онд баталсан Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцэхгүй байна.

Зөвлөмж

1. Ус хангамжийн эх үүсвэр, усны барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоож буй хуулиудын нэр томъёо, хэмжээ, хязгаар тогтоосон зүйл заалтуудын бичвэрийн уялдаа холбоог сайжруулах замаар хууль хэрэглэгчдэд ойлгомжтой болгох,
2. Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгатай уялдуулах,
3. Ус хангамжийн эх үүсвэр, усны барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг Газрын тухай хуулийн зам, шугам сүлжээний газарт хамааруулах, газрын төлбөрөөс чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох,
4. ИТХ-аас тогтоосон хамгаалалтын болон эрүүл ахуйг бүсийг хамгаалах үйл ажиллагааг үр дүнтэй байлгахын тулд МХБ-аас гадна мэргэжлийн байгууллагад хяналт, шалгалт хийх, арга хэмжээ авах эрх олгосон эрх зүйн зохицуулат бий болгох,
5. ИТХ-аас хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоохдоо санал, дүгнэлтийг нь авах зайлшгүй шаардлагатай байгууллага, албан тушаалтанд холбогдох эрх зүйн зохицуулалтуудын уялдаа холбоог сайжруулах,
6. ИХТ-ыг ЗД-ын үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, дүгнэлт өгөх ажлыг тогтмол гүйцэтгэдэг байлгахад анхаарах, ялангуяа хууль дүрэм зөрчиж газар олгодог байдлыг хязгаарлахад чиглэсэн дорвитой арга хэмжээ авдаг байх,
7. ИХТ-аас тогтоосон ус хангамжийн эх үүсвэр, усны барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулсан хэн бүхэнд заавал хариуцлага тооцдог байх, үр дүнг олон нийтэд мэдээлдэг байх,

7 дугаар зүйлийн 11 дэх заалтын хэрэгжилт

Хүснэгт № 7 7 дугаар зүйлийн 11 дэх заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
3	17 дугаар зүйлийн 17.11 дэх заалт Ус хангамж, ариутгах татуурга	17.11. Иргэн хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэрийг ашиглах болон бусад хэрэглэгчийг усаар хангах нөхцөлд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөнө.	Иргэн хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэр нь хууль тогтоомжид заасан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрддөг байна.

Судалгааны тайлангийн 7 дүгээр зүйлийн 7.1.2 дахь заалтын хэрэгжилт хэсэгт усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох, Бүсийн дэглэмийг мөрдөх асуудлыг дэлгэрэнгүй авч үзсэн тул энэ хэсэгт Үндсэн хууль, Газрын тухай, МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиуд болон МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн хүрээнд эзэмших, өмчлөх, ашиглах эрх үүссэн иргэдийн хувьд усны эх үүсвэр буюу ундны хэрэгцээнд ашиглаж буй гүний худгийн хувьд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх боломжийг судаллаа.

Судалсан байдал

Монгол Улсын 2017 оны Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны дүнгээс харахад судалгаанд хамрагдсан иргэдийн 21,7% нь ус хангамжийн шугам сүлжээнээс, 28,6% нь ус түгээх байрнаас, 22,8% нь хамгаалсан гүний худгаас, 1,3% нь хамгаалсан булгаас, 6,8% нь зөөврийн уснаас, 7% нь хамгаалаагүй гар худаг, булгаас, 10,2% нь усны ил эх үүсвэрээс, 1,6% нь ус зөөврийн ердийн хөсөг, хурын уснаас ундны усны хэрэгцээгээ хангадаг байна.⁸⁸

Иргэнд өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах эрхтэй олгох газрын хэмжээний тухайд

Газрын тухай хуульд иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0,07 га-гаас, гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар иргэнд 0,1 га-гаас илүүгүй, мөн тариалангийн газрыг газар тариалангийн салбарт олон жил тогтвортой ажилласан иргэнд 5 га хүртэлх⁸⁹ хэмжээтэй байхаар зохицуулсан. Мөн энэ хуулийн 44 дүгээр зүйлд газар ашиглуулах тухай зохицуулалтыг тусгаж өгсөн байх ба ашиглуулах газрын хэмжээ дээр дурдсан эзэмшүүлэх газрын хэмжээтэй⁹⁰ адил байна.

Түүнчлэн МУ иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлд иргэнд өмчлүүлэх газрын хэмжээг газрын байршил, зориулалтаас хамааран ялгамжтай байдлаар, нарийвчлан тогтоож өгсөн.⁹¹

Хүснэгт № 8 МУ-ын иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ

Иргэнд өмчлүүлэх газрын		
	байршил	хэмжээ /га/
1	Нийслэлд	0.07 хүртэл га
2	Аймгийн төвд	0.35 хүртэл га
3	Сумын төв, тосгонд	0.5 хүртэл га
4	Нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай авто замын дагуух газарт /сумын төвөөс бусад/	0.07 хүртэл га

⁸⁸ 2017 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа. Танай ундны усны эх үүсвэр юу вэ? ҮСХ. Эх сурвалж: <http://web.nso.mn/nadamn/index.php/catalog/247/datafile/F41/V1074>

⁸⁹ Газрын тухай хууль. 29 дүгээр зүйл. Эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил. 29.1, 29.2, 29.3 дахь заалт. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/216>

⁹⁰ Газрын тухай хуулийн 44.6-д Энэ хуулийн 44.4-т заасан иргэнд хувийн гэр, орон сууцны хашааны зориулалтаар ашиглуулах газрын хэмжээ 0,05 га-гаас, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ тарих зориулалтаар олгох газрын хэмжээ 0,1 га-гаас тус тус илүүгүй байна. Газрыг 5 жил хүртэл хугацаагаар гэрээгээр ашиглуулах бөгөөд гэрээг нэг удаад сунгах хугацаа 5 жилээс илүүгүй байна гэж заасан.

⁹¹ МУ иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг

Үүнээс харахад хот, суурин газарт 0,07-0,35 га хүртэлх хэмжээтэй газрыг иргэний өмчлөлд олгож байна. Гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлэх газрын байршил хэмжээг м2-аар илэрхийлбэл нийслэлд 0.07 хүртэл га 20х35 м2, аймгийн төвд 0.35 хүртэл га 35х100 м2, сумын төв, тосгонд 0.5 хүртэл га 50х100 м2 байна.

Газрын хэмжээ тогтоох, газар олгох асуудлыг тухайн орон нутгийн хүн амын нягтрал, өмчлүүлэх газрын нөөц зэргийг харгалзан гэр бүлийн хэрэгцээнд үнэгүй өмчлүүлэх газрын дээд хэмжээг хуульд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр тухай шатны ИТХ тогтоодог бол аймаг, нийслэлийн Засаг дарга төрийн нэгдсэн бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулахын⁹² зэрэгцээ аймгийн төвийн сумын Засаг дарга болон нийслэлийн дүүргийн Засаг даргын өргөн мэдүүлснээр иргэний газар өмчлүүлэх тухай өргөдлийг хүлээн авч, тухайн шатны ИТХ-ын саналыг үндэслэн газар өмчлүүлэх тухай шийдвэр гаргах⁹³ иргэнд газар өмчлүүлэх тухай захирамж гаргах⁹⁴ эрхийг энэ хуулиар олгосон.

ХСУХАТАТХ-ийн 17.4.1-д хот, суурины төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд тогтоохоор заасан бол Бүсийн дэглэмд төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн хувьд 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүсийг, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг⁹⁵ тогтооно гэж заасан. Үүнээс харахад иргэн өмчлөл/эзэмшлийн газартаа нүхэн жорлон, бохир усны нүхнээс дор хаяж 150-250 метрт гүний худаг гаргах зохицуулалттай байна. Гэсэн ч энэ зохицуулалт огт хэрэгжих боломжгүй зүгээр л цаасан дээрх тоо болохыг 0.7 га хүртэлх газартаа байшин, гарааш, жорлон, машин, хүнээ багтаадаг гэр хорооллынхны хувьд нүхэн жорлонтойгоо хаяа дэрлүүлэн гүний худаг гаргуулж, түүнээсээ ундны усаа авч ууж байгаа байдал юм.

Худаг гаргах, цооног өрөмдүүлэх асуудлын тухайд

УИХ-аас 2002 онд баталсан Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай⁹⁶ хуульд иргэд өмчилсөн газартаа өрхийн хэрэглээний худаг гаргах асуудалтай холбоотой хэд хэдэн заалт байна. Энэ хуулийн 27 дугаар зүйлд зааснаар газар өмчлөгч иргэн холбогдох хууль тогтоомжид заасны дагуу өмчийн газрынхаа түгээмэл тархацтай ашигт малтмалыг гэр бүлийнхээ хэрэгцээнд ашиглах, уг газарт худаг гаргаж усыг нь ашиглах⁹⁷, стандарт, дүрэм, журам, шаардлагад нийцүүлэн өмчийнхөө газарт барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ барих, ашиглах⁹⁸ эрхтэй. Мөн Усны тухай хуулийн 27 дугаар зүйлд зааснаар иргэн аймаг, нийслэлийн байгаль орчны албанаас олгосон зөвшөөрлийн⁹⁹ дагуу хувийн хэрэгцээндээ зориулан усны эх үүсвэрийг ашиглах болон

⁹² Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12.1 дэх хэсэг

⁹³ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 12.1.3 дахь заалт

⁹⁴ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 21.1 дэх хэсэг

⁹⁵ Бүсийн дэглэмийн 3.18 дахь заалт

⁹⁶ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/346>

⁹⁷ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 27.1.6 дахь заалт

⁹⁸ Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 27.1.7 дахь заалт

⁹⁹ Усны тухай хуулийн 27.1 дэх заалт

бусад хэрэглэгчийг усаар хангах зорилгоор худаг гаргах, цооног өрөмдүүлэх боломжтой байна.

Манай улсын хэмжээнд 2017 оны байдлаар тусгай зөвшөөрөл бүхий 200 гаруй ААН худаг гаргах үйлчилгээ үзүүлж байна. 2013 онд улсын хэмжээнд зохион байгуулагдсан усны тооллогын дүнгээс харахад 2013 онд 30343 худаг тоологдсон байдаг¹⁰⁰ ба Нийслэлийн 2013 оны гүний худгийн тооллогоор нийт 152 хорооны 92 хороонд нийт 5331 худаг тоолсноос хөрсний 797 болон гүний усны 4279 худаг бий¹⁰¹ гэх албан ёсны судалгаа гарчээ.

Харин Статистикийн мэдээллийн санд байршуулсан мэдээллээс харахад 2015 оны байдлаар улсын хэмжээнд 42098 худаг байгаагаас иргэдийн унд, ахуйн хэрэглээнд түгээмэл хэрэглэдэг гүний өрөмдмөл болон богино яндант худаг 10184 байна.¹⁰² Үүнээс гүний өрөмдмөл худгийг тоо 2015 оны байдлаар улсын хэмжээнд 8335 байгаагаас УБ-т 938 худаг тоологдсон байна.¹⁰³

Хүснэгт № 9 МУ хэмжээнд худгийн тоо

Баг, хороо	Худаг	2015
Улсын дүн	Худаг, бүгд	42,098
	Гүний өрөмдмөл	8,335
	Богино яндант	1,849
	Энгийн уурхайн	26,705

Нийслэлийн нутаг дэвсгэрт 2003 оноос эхлэн 4260 худгийг шинээр гаргасан байна. тодруулбал, нийт тоологдсон худгийн 80 хувийг сүүлийн 10 жилд ухаж гаргажээ. Нийслэлийн нутаг дэвсгэрт гаргасан нийт худгийн 58% буюу 3094 худаг нь албан ёсоор зөвшөөрөлтэй, 42% нь зөвшөөрөлгүй байна. Зөвшөөрөлгүй нийт худгийн 78.5 хувь нь өрхийн эзэмшилд байна. Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа нийт худгийн 50.8 хувь буюу 2709 худгийг унд, ахуйн зориулалтаар, 9.1 хувийг газар тариалан, 7.3 хувийг үйлдвэрлэл, 1.3 хувийг мал аж ахуйд зориулж дангаар нь ашиглаж байна. Харин 1680 худгийг давхар

буюу олон зориулалтаар ашигладаг судалгаа бий.

Зураг № 3 Нийслэлийн нутаг дэвсгэр дэх нийт худгийн тоо



Хамгийн сүүлд нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд худгийн тооллого судалгааг явуулахад 8700 орчим худаг бүртгэгдсэн¹⁰⁴ бөгөөд үүнээс УСУГ-ын харьяанд 670 худаг байхад хяналтаас

¹⁰⁰ Эх сурвалж: https://www.switch-asia.eu/fileadmin/user_upload/RPSC/event/23-25May16-Mongolia/24-25May/12_WaterStatistics_MEGDT_Mongolian.pdf

¹⁰¹ Нийслэлийн гүний худгийн тайлангаас. Нийслэлийн статистикийн газар. 2013 он

¹⁰² Худгийн тоо улсын хэмжээнд: Эх сурвалж: <http://www.1212.mn>

¹⁰³ Статистикийн мэдээллийн нэгдсэн сан. Худаг, усан сан, уст цэгийн тоо, төрлөөр, 1996-2015 он, улс, бүс, аймаг, нийслэл, сум, багаар, 3 жил тутам. Эх сурвалж: <http://www.1212.mn>

¹⁰⁴ Аж ахуйн нэгж байгууллагуудтай “Экологийн хариуцлагын гэрээ” байгуулж эхлэв. 2018.05.03. Эх сурвалж: <http://www.ulaanbaatar.mn/Home/newsdetail?dataID=31121>

гадуур 8,700 ундны усны худаг байгаагийн 5,000 гаруй нь унд, ахуйдаа хэрэглэдэг, ямар нэг байдлаар ашиг олох зорилгогүй хувь хүний худаг байгаа ч ундны усны эрүүл ахуйн хяналтыг хийдэг ганц байгууллага болох Мэргэжлийн хяналтын ерөнхий газар /цаашид МХЕГ гэх/ 2017 онд гүний 8700 худгаас ердөө 96-гаас нь дээж авч шинжилгээ хийсэн байна.¹⁰⁵ Үүнээс харахад үлдсэн худгуудын ус ямар ч хяналтгүйгээр хэрэглэгдэж байна.

Кейс: ХСУХАТАҮЗЗ-ийн “Ундны усны чанар, эх үүсвэрийн эрүүл ахуйн дэглэм, хамгаалалтын бүс”сэдэвт 1 сарын аяны тайлангаас¹⁰⁶

Хяналт, шалгалтын аяны хүрээнд ХУД-ийн Зайсан толгой орчмын ундны усны эх үүсвэртэй нийт 10 гаруй аж ахуй нэгж, байгууллага, орон сууцны хотхоны нийт 20 гаруй гүний худаг хамрагдав. Гэтэл хуулийн 17.4.1 дэх заалт Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Жигүүр гранд группийн “Зайсан виллаж”, Лакшири зайсан виллаж хотхоны усны эх үүсвэрийн гүний худгууд, түүнчлэн “Роял Кроун Вилла”, “Хатан туул”, “Дрийм ланд”, “Соёмбо” зэрэг орон сууцны хотхоны эх үүсвэрийн гүний худгуудад зөрчигдөж, гүний худгууд нь хүн амын ундны усны эх үүсвэрийн нийтийн эзэмшлийн зам талбайд ил задгай, ариун цэвэр, хамгаалалтын бүсийг мөрдүүлээгүй худгийн өрөөнд хог овоолсон, худгийг агуулах болгосон, хамгаалалтын ямарч барилга байгууламжгүй, бохир усны шугамын зарим нь худагтай ойрхон байгааг ажлын хэсэг илрүүлэв. Түүнчлэн аяны хүрээнд хамрагдсан нийт гүний худгуудын усанд усны чанарын шинжилгээ тогтмол хийгдэхгүй байна. Энэ нь тухайн хотхонд оршин суугчдын хэрэглэж буй ундны усны чанар ямарч хяналтгүй, усны чанар нь эрсдэлтэй төвшинд байгааг харуулж байна. Мөн Монгол Улсын Усны тухай хуулийн 26.1 дэх заалтад “Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаад улсын хуулийн этгээд нь тодорхой зориулалт, хугацаа, болзол нөхцөл заасан ус ашиглах зөвшөөрөл, гэрээний үндсэн дээр хууль тогтоомжийн дагуу ус ашиглах эрхтэй байна” гэсэн заалтыг зөрчиж ашиглаж болох эсэх нь тодорхойгүй, зөвшөөрөлгүй гүний худгаас оршин суугчдыг ундны усаар хангаж буй зөрчил Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Фүюушин ХХК, “Мозул Скай” ХХК зэрэг компаниуд болон “Цэцээ гүн”, “Сөүл роялти каунти”, “Тэргүүн чансаа” ХХК, “Зайсан виллаж”, “Хатан туул”, “Соёмбо”, “Лакшири зайсан виллаж”, “Хунгийн хотхон” зэрэг орон сууцны хотхонуудад илэрсэн байна. Усны эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээг тусгай зөвшөөрөлгүй, мэргэжлийн бус байгууллага, СӨХ эрхэлж байгаагаас дээрх зөрчил, дутагдлууд үүсч, ХУД-ийн Зайсан толгой орчмын төвлөрсөн бус усны эх үүсвэртэй хотхонуудын хүн амын өдөр тутамдаа хэрэглэж буй ундны усны чанар баталгаагүй, эрсдэлтэй төвшинд хүрсэн байна.

НАА-н салбарын мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар төвлөрсөн ус хангамжийн ус хангамжийн шугам сүлжээ бүхий газрын ойролцоо гүний худаг гаргах асуудлыг хориглох асуудлыг хуулиар шийдвэрлэх нь суурин газрын гүний усны нөөцийг хамгаалах, иргэдийг баталгаат эх үүсвэрээс стандартын шаардлага хангасан усаар хангах, ус хангамжийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үздэг байна.

Шигтгээ:

Орон нутагт УХАТ-ын төвлөрсөн шугам сүлжээний ойр орчимд гүний худаг гаргах, бие даасан ус хангамжийн бүтэцтэй болох тохиолдол сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдсэн. Үүнийг зохицуулах шаардлагатай байна. Учир нь энэ худгуудын ашиглалт, үйлчилгээ ямар ч хяналтгүй, дээрээс нь орон нутгийн хөрөнгө зарж хийсэн инженерийн шугам сүлжээний томоохон хөрөнгө оруулалтуудыг ашиглахгүй байх боломж олгоод байгаа нь НААБ-ууд алдагдалтай ажиллахад ч нөлөөлж байна. Ялангуяа хувийн болон гадаадын төсөл, хөтөлбөрийн хүрээнд гаргасан гүний худгуудыг хариуцах эзэн, хамгаалалт, үйлчилгээ зэрэг асуудал нь хүндрэлтэй байдаг.

ХСУХАТАҮЗЗ-өөс зохион байгуулсан Төвийн бүсийн уулзалт, зөвлөгөөний оролцогчидтой хийсэн ярилцлагаас. 2018.10.11

¹⁰⁵ Нүхэн жорлонгоос 150-250 метрт гүний худаг гаргах ёстой.2018.05.29. Эх сурвалж. <https://ikon.mn/n/1avg>

¹⁰⁶ Эх сурвалж: www.wsrc.mn

Хувийн хэрэгцээнд гаргасан усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн асуудлын тухайд

ХСУХАТАтХ-ийн 7.11-д иргэн хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэрийг ашиглах болон бусад хэрэглэгчийг усаар хангах нөхцөлд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх хуулийн шаардлага тавьсан.

Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох зайг ХСУХАТАтХ-д эрүүл ахуйн хориглолтын бүс 50 метр, энгийн хамгаалалтын бүс 200-500 метрт байхаар заасан, харин Бүсийн дэглэмд төвлөрсөн бус ус хангамжаас 50 метрт эрүүл ахуйн хориглолтын бүсийг, төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрээс 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг, онцгой хамгаалалтын бүсийг ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд тогтоох зэрэг нарийвчилсан зохицуулалтыг тусгаж өгсөн байдаг. Үүнээс харахад ундны хэрэгцээнд ашиглаж буй иргэдийн эзэмших/өмчлөх эрх бүхий газарт гаргасан худгийн 50 метрт эрүүл ахуйн хориглолтын болон онцгой хамгаалалтын бүсийг, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг тогтоож холбогдох дүрэм, журмыг мөрдөх шаардлага үүснэ.

Газрын тухай хууль, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай болон түүний дагаж мөрдөх журмын тухай хуулиудад зааснаар хот суурин газар амьдарч буй иргэдэд нэг удаа үнэ төлбөргүйгээр 0,07-0,35 га хүртэлх хэмжээтэй газрыг өмчлүүлэх ерөнхий зохицуулалт үйлчилж байна. Өмчлүүлэх газрын хэмжээг хот, суурины нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршлаас хамааран хууль тогтоомжид заасан ерөнхий хэмжээнээс бага хэмжээтэйгээр олгох боломж бүхий эрх зүйн орчин, түүнчлэн иргэдийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлээс худалдан авч буй газрын хэмжээ хуульд зааснаас ч бага хэмжээтэй байх нь түгээмэл байна. Тухайлбал, Улаанбаатар хотод дунджаар 0,05 га газрыг өрхийн хэрэглээнд өмчилж, эзэмшиж байгаа тохиолдолд иргэн хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэрийг ашиглах болон бусад хэрэглэгчийг усаар хангах нөхцөлд ХСУХАТАтХ-д заасан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх боломжгүй байна.

Гэтэл Усны тухай хууль, МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомжид заасан эрхийн дагуу төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр буюу худаг гарган унд, ахуйн хэрэглээний усаар хангагдаж байгаа иргэдэд ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм мөрдөхтэй холбоотой дараахь хариуцлагыг тооцох боломжтой байна. Үүнд: ус хэрэглэгч худгийн ашиглалтын зориулалтыг өөрчлөх, зөвшөөрөлгүйгээр цооног өрөмдөх, худаг гаргах, суваг шуудуу татахгүй байх бол тусгай зөвшөөрөл эзэмшигч ой, усны сан бүхий газар, ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд усны хайгуул судалгаа хийх, цооног өрөмдөж худаг гаргахгүй байх үүрэгтэй. Нийслэлийн Байгаль орчны газраас өгсөн мэдээлэлд зөвшөөрөлгүй худаг гаргасан тохиолдолд иргэнийг 1200000-3600000 төгрөгөөр, ААН байгууллагыг

4800000-12000000 төгрөгөөр торгож, учирсан хохирлыг төлүүлэх зохицуулалттай¹⁰⁷ байна.

Харин иргэн хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэрийг ашиглах болон бусад хэрэглэгчийг усаар хангах нөхцөлд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх эрх зүйн зохицуулалтын хүрээнд Зөрчлийн тухай хуулийн 6.1-д заасан Хог хаягдлын тухай хууль зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно¹⁰⁸, 6.2-д заасан Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хууль зөрчин УХАТ-ын барилга байгууламжийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, УХАТ-ын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын, эсхүл эрүүл ахуйн бүсийн заагт зөвшөөрөлгүй нэвтэрч хохирол учруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг зургаан зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, УХАТ-ын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсэд зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж, шугам сүлжээ барьсан бол түүнийг буулгаж, үйл ажиллагааг зогсоож учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг найман зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, УХАТ-ын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсэд байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөөгүй бордоо ашиглан таримал ургамал тарьсан, эсхүл бодис, арга технологи хэрэглэн хөнөөлт шавж, мэрэгчийг устгасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох арга хэмжээг¹⁰⁹ хэрхэн хэрэгжүүлэх нь ойлгомжгүй, шийдвэрлэгдээгүй үлджээ. Түүнчлэн иргэн өөрийн эзэмшил, өмчлөлийн газартаа барилга байгууламж барих, 7.15 дугаар зүйлд заасан Усны тухай хууль зөрчин усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн¹¹⁰ бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх нь тодорхойгүй байна

Дээрхээс харахад ХСУХАТатХ, Усны тухай, Газрын тухай, МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиуд болон Бүсийн дэглэм дэх худагтай холбоотой эрх зүйн зохицуулалтууд нь иргэнийг гарцаагүй хууль тогтоомж зөрчих байдалд хүргэж байна гэж үзэж болох юм.

¹⁰⁷ Зөвшөөрөлгүй худаг гаргавал 12 сая хүртэлх төгрөгөөр торгоно. 2017 он. Эх сурвалж: <http://www.control.mn/i/8562/#.W84OXHszaM8>

¹⁰⁸ 6.1 дүгээр зүйл.Хог хаягдлын тухай хууль зөрчих 3.Хүн амын төвлөрсөн суурьшлын бүс, усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүс, ашигт малтмалын нөөц тогтоогдсон газарт зөвшөөрөлгүйгээр, эсхүл хуулиар хориглосон бусад газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹⁰⁹Зөрчлийн тухай хуулийн 6.2 дугаар зүйлийн 4,5,6,8 дугаар хэсэг./Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль зөрчих/ Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/12695>

¹¹⁰ Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлийн 1.5,

Үнэлсэн байдал

ХСУХАТАтХ-ийн 7.11-д иргэн хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэрийг ашиглах болон бусад хэрэглэгчийг усаар хангах нөхцөлд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх эрх зүйн зохицуулалт ЗОРИЛГОДОО ХҮРЭХГҮЙ байна гэж үнэллээ.

Хуулийн зохицуулалтын зорилгыг хууль тогтоомжид заасан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг иргэний хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэрт мөн адил хэрэгжүүлснээр усны чанар, стандартад нийцсэн ус хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, мөн ус хангамжийн эх үүсвэрийг бохирдлоос хамгаалахад чиглэгдсэн гэж үзсэн.

Ийнхүү үнэлэх үндэслэлийг дараахь нөхцөл байдалд тулгуурласан болно:

1. МУ иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу хот, суурин газарт 0,07-0,35 га хүртэлх хэмжээтэй газрыг иргэний өмчлөлд олгож байна. Гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлэх газрын байршил хэмжээг м²-аар илэрхийлбэл нийслэлд 0.07 хүртэл га 20x35 м², аймгийн төвд 0.35 хүртэл га 35x100 м², сумын төв, тосгонд 0.5 хүртэл га 50x100 м² байгаа нь ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох наад захын зай хэмжээг хангахгүй байгаа нь иргэд хууль тогтоомж зөрчигч болох нөхцөлийг бүрдүүлсэн байна.
2. Гэр бүлийн хэрэгцээнд зориулан иргэнд олгох хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0,1 га-гаас илүүгүй, мөн тариалангийн газрыг 5 га хүртэлх¹¹¹ хэмжээтэй олгох тохиолдолд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг тухайн газар мөрдөх боломжтой боловч уг газарт ямар бордоо, химийн бодис ашиглаж буйг бүрэн хянах боломжгүй байна.
3. Усны тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудад иргэн аймаг, нийслэлийн байгаль орчны албанаас олгосон зөвшөөрлийн дагуу гэр бүлийнхээ хэрэгцээнд ашиглах, уг газарт худаг гаргаж усыг нь ашиглах боломж олгосон зохицуулалт нь ХСУХАТАтХ болон Бүсийн дэглэмд заасан хамгаалалтын болон эрүүл ахуйн дэглэм дэх хуулийн шаардлагыг хангах боломжгүй байдлыг харгалзаагүй, уялдаа холбоогүй байна. Тухайлбал, гэр хорооллын бохир усны шугам сүлжээнд холбогдоогүй айл өрхүүд нүхэн жорлон ашиглаж байгаа нь 0,07 га газарт худаг, жорлон, байшин, гарааш зэрэгцэн байрлах нөхцөлийг бүрдүүлж байгаа нь хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм хэрэгжих боломжгүй байдлыг үүсгэж байна.
4. Ус хангамжийн эх үүсвэр, түүний хамгаалалтын асуудал нь газрын харилцааны асуудалтай салшгүй холбоотой байх тул газар, хөрсний бохирдлоос хамгаалах, газар төлөвлөлт, хот төлөвлөлт, УХАТ-ын асуудлын уялдаа холбоог сайжруулах шаардлага байна.
5. Практикт тулгамдаж буй асуудлаас гадна хууль тогтоомжийн төвшинд зөрүүтэй зохицуулалт бас байна. Тухайлбал, ХСУХАТАтХ-ийн 17.4.1-д хот, суурины төвлөрсөн

¹¹¹ Газрын тухай хууль. 29 дүгээр зүйл. Эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлэх газрын хэмжээ, байршил. 29.1, 29.2, 29.3 дахь заалт. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/216>

бус ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд тогтоохоор заасан бол Бүсийн дэглэмд төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн хувьд 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүсийг, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг¹¹², онцгой хамгаалалтын бүсийг ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд тогтооно гэж зөрүүтэй байдлаар зохицуулжээ.

6. Манай Улсын хэмжээнд 2017 оны байдлаар тусгай зөвшөөрөл бүхий 200 гаруй ААН худаг гаргах үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд худаг гаргах үйлчилгээний хөлс хотод 110000-160000 төгрөг/метр, хөдөө орон нутагт байршлаас хамааран үнэ тарифаа харилцан тохиролцох байдлаар тогтоодог байна. Иргэдийн зүгээс худаг гаргуулах эрэлт хэрэгцээ нэмэгдсэн нь эдгээр ААН-ийн тоо өсөхөд нөлөөлсөн байх магадлалтай. Харин тусгай зөвшөөрөл бүхий ААН-үүдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах хэрэгцээ шаардлага өндөр байгааг сүүлийн жилүүдэд зөвшөөрөлгүй гаргасан худгийн тоо эрс нэмэгдэж байгаа судалгаа харуулж байна.
7. Худгийн тоо мэдээллүүд зөрүүтэй байна. Тухайлбал, 2013 онд улсын хэмжээнд хийсэн, мөн онд нийслэлээс хийсэн худгийн тооллогын дүнгүүд ихээхэн зөрүүтэй байна. Энэ нь худгийн тооллогын дүн нэгдсэн байдлаар гарах боломжгүй байгаа тохиолдолд тэдгээрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж буй байдлыг тогтоох, хууль дүрэм зөрчигчид хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдээгүй байгааг харуулж байна. Түүнчлэн худгийн тоо мэдээлэл хоорондоо ихээхэн зөрүүтэй гарч байгаа нь зөвшөөрөлгүй худгийн тоо их байгааг илэрхийлж байна.
8. Зөрчлийн тухай хуулийн Усны тухай хууль зөрчих, ХСУХУТАтХ зөрчих, Хог хаягдлын тухай хууль зөрчих хэсэгт хариуцлага хүлээлгэхээр тусгасан үйлдэл, үйл ажиллагаа нь МУ-ын иргэнд газар өмчлүүлэх болон Газрын тухай хуулийн дагуу газар өмчилж, эзэмшиж буй иргэдийн хувьд байнга хууль зөрчигч байх үндэслэл болсон байна.

Зөвлөмж

1. Газрын тухай, МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээнд зориулан өмчлүүлж буй газрын хэмжээ, Газрын тухай, Усны тухай хуулиар олгогдсон худаг гаргаж ашиглах эрх, Усны тухай хууль, ХСУХАТАтХ, Бүсийн дэглэмд заасан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоосон зохицуулалтуудыг уялдуулах,
2. ХСУХАТАтХ-ийн 17.4.1-д хот, суурины төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд тогтоохоор заасан бол Бүсийн дэглэмд төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн хувьд 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүсийг, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг¹¹³, онцгой хамгаалалтын бүсийг ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд тогтооно гэж зөрүүтэй байдлаар томъёолсныг өөрчлөх,

¹¹² Бүсийн дэглэмийн 3.18 дахь заалт

¹¹³ Бүсийн дэглэмийн 3.18 дахь заалт

3. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу байнга хууль зөрчигч болсон өөрийн эзэмшлийн худаг бүхий иргэдийн бодит нөхцөл байдалд илүү тохирсон, хэрэгжүүлэх боломжтой зохицуулалт бий болгох.

7 дугаар зүйлийн 13 дахь заалтын хэрэгжилт

Хүснэгт № 10 7 дугаар зүйлийн 13 дахь заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
4	17 дугаар зүйлийн 17.13 дахь заалт Ус хангамж, ариутгах татуурга	17.13. Уул уурхай, эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглана.	Уул уурхай, эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашигладаг байна.

Судалсан байдал

Дэлхийн ихэнх улс орнууд ус хэрэглээнийхээ 80 орчим хувийг гадаргын усны эх үүсвэрээс хангадаг бол манай орны хувьд ус хангамжийн 10 орчим хувийг нь гадаргын ус эзэлдэг бөгөөд гадаргын усны хэрэглээний бүтцийг ерөнхийлөн авч үзвэл газар тариалан, бэлчээрийн мал аж ахуй, усан цахилгаан станц, уул уурхайн салбар голлон эзэлж байна.

Газрын доорх ус нь экологийн нэн эмзэг тогтоцтой, нөхөн сэргээх хугацаа нь хэдэн хэдэн зуун жилээр тооцогддог учраас газрын доорхи усыг онцгой хамгаалалтад авч, нөхөн сэлбэгдэх хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр ашиглах шаардлагатай байдаг. Иймд усаа хэмнэх нэгэн чухал алхам бол уул уурхайд усыг дахин ашиглах, хэмнэх технологийг түлхүү нэвтрүүлэхэд чиглэгддэг. Тухайлбал усыг дахин ашиглавал ус бохирдуулсны төлбөрөөс тодорхой хувь хэмжээгээр хөнгөлөх зэргээр түүнийг хөхиүлэн дэмждэг. Харин манай улсын хувьд технологийн хэрэглээний усаа дахин ашиглах асуудал дөнгөж ойлголтын төвшинд байна. Саарал усыг ашиглахгүй байх гол шалтгаанд усыг эргүүлэн ашиглахад гарах зардал цэвэр усыг ашиглахаас илүү үнэтэй байгаад оршино.

Уул уурхайн салбарын технологийн усыг эргүүлэн ашиглаж буй байдал

Уул уурхайн салбар нь тоосжилт дарах, зүлэг, мод услах, тоног төхөөрөмжийн хөргөлт, угаалга цэвэрлэгээ, гал түймэр унтраах зэрэг ажлууд болон баяжуулах, боловсруулах технологид усыг усыг ихээхэн хэмжээгээр ашигладаг онцлог бүхий салбар бөгөөд өнөөгийн байдлаар уул уурхайн ус хэрэглээний 6.9 хувийг гадаргын ус эзэлж байна.¹¹⁴

Уул уурхайн салбарт гадаргын усыг ашиглах орчин нөхцөлийг дээшлүүлэх зорилго бүхий эрх зүйн зохицуулалтууд цөөнгүй боловч хэрэгжилт хангалтгүй, удаашралтай байдаг. Тухайлбал, Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний

¹¹⁴ Гадаргын усны нөөц ба уул уурхайн ус ашиглалт. Эх сурвалж: <http://www.mmhi.gov.mn/public/more/id/618>

хөгжлийн цогц бодлого¹¹⁵, “Ус” үндэсний хөтөлбөр¹¹⁶ Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал¹¹⁷, Усны тухай хууль¹¹⁸, Ногоон хөгжлийн бодлого¹¹⁹, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030¹²⁰ ЗГ-ын Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр ¹²¹, Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө¹²² зэрэг бодлогын баримт бичгүүдийг энд дурдаж болох юм.

Уул уурхайн салбарт ашигт малтмал олборлох явцад ашиглагдах усны хэмжээ буюу уурхайн ус хэрэглээний нормд зааснаар нүүрснээс шингэн түлш гаргахад 9800 л/ тн, жоншны уурхайд 1800л/тн, цайрын уурхайд 1 тоннд 16000л/тн, зэсийн хүдрийн уурхайд 4900л/тн, алт, цагаан тугалга олборлолт 1м3 элс угаахад 4100л, хүдэр боловсруулахад 4600л/тн ус хэрэглэгддэг байна.¹²³

Хэдийгээр ХСУХАТАТХ-ийн 17.13-д Уул уурхай, эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглана гэж үүрэгжүүлсэн заалт оруулж өгсөн боловч уул уурхайн салбарт үйлдвэрлэл эрхлэгчдийн хувьд энэ асуудал зөвхөн нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжиж байна. Тухайлбал, уул уурхайн нийгмийн хариуцлагыг 1/байгаль орчны нөхөн сэргээлт, 2/усны хэмнэлттэй, дахин ашиглах компаний бодлого, 3/орон нутгийн иргэд, төр захиргааны байгууллагатай харилцаа тогтоох гэсэн гурван үндсэн хүрээнд тогтоосноос¹²⁴ харж болох юм.

¹¹⁵ УИХ-ын 2008 оны 12 тоот тогтоолоор баталсан “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын 5 дугаар тэргүүлэх чиглэлийн хүрээний стратегийн Зорилт 3-д: Гадаргын усны тодорхой хэсгийг аж ахуйн эргэлтэд оруулан арвижуулах замаар хүн ам, үйлдвэрлэлийн ус хангамжийг шийдвэрлэх

¹¹⁶ УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Ус” үндэсний хөтөлбөрийн 2.2.4.усны нөөцийг зүй зохистой ашиглах, хэмнэх, хаягдал бохир усыг эргүүлэн ашиглах, цэвэрлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үерийн аюулаас сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх, үүнд чиглэсэн аливаа үйл ажиллагаа, санал санаачилгыг хууль тогтоомжийн хүрээнд дэмжих;% 3.3.2-д: Орхон, Сэлэнгэ, Хэрлэн, Туул, Ховд, Булган, Халх, Онон, Эг, Хархираа, Түргэн, Шишхэд, Ерөө, Хараа, Тамир, Богдын голууд дээр урсцын тохируулга хийж, усан сан байгуулах, шилжүүлэн ашиглах боломжийн талаар судалгаа хийж, боломжтой газруудад зураг төсөл зохиох, бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх

¹¹⁷ УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.5.1.7-д: Гадаргын усны ашиглалтыг сайжруулах үүднээс томоохон гол, мөрөнд урсцын тохируулга хийж, бороо, цас, мөсний усыг хуримтлуулж нөөцлөх усан санг ууршил багатай, эрчим хүчний нөөц ихтэй бүс нутагт байгуулж, говь, тал хээрийн ууршил ихтэй бүсэд усыг нөөцлөх, дамжуулах далд систем барьж байгуулна;

¹¹⁸ Усны тухай хуулийн: 4 дүгээр зүйл. Усны нөөцийн нэгдсэн менежмент;

¹¹⁹ УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлого”-ын 3.2.11-д: Хур бороо, цас, үерийн усыг хуримтлуулан ашиглах санаачилга, гадаргын усны хуримтлал бий болгон ашиглах төсөл, газрын доорх усыг нөхөн сэргээх, нөөцийг нэмэгдүүлэх туршилт, судалгааг хөхүүлэн дэмжих;

¹²⁰ УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.1.4-т: “Эрдэс баялгийн салбар”: II үе шат (2021-2025 он): Ус хангамжийн найдвартай эх үүсвэрийн төслүүдийг хэрэгжүүлж, уул уурхайн томоохон төслүүдийн үйлдвэрлэлийн бүрэн хүчин чадлыг эзэмших;

¹²¹ “Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийн 3.1.3.3: Усны хэрэгцээг газрын доорх болон гадаргын усаар, хосолмол аргаар хангах бодлого барьж ирээдүйд өсөн нэмэгдэх усны хэрэгцээг “Хэрлэн-Говь” төслийг хэрэгжүүлж хангах хувилбар боловсруулж шийдвэрлэх;

¹²² Засгийн газрын 2013 оны 389 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”-ний 4.6-д: Боомт, усан сан байгуулах боломжит газруудад хайгуул, судалгаа хийж, ТЭЗҮ болон зураг төсөл боловсруулна;


¹²³ <https://asmhub.mn/uploads/files/5-togtvortoy-khgzhil-ba-baygaliyn-ntsiyn-khariutslagatay-ashiglalt.pdf>

¹²⁴ 2011 оны 12 дугаар сард “Уул уурхайн үйлдвэрлэлийн нийгмийн хариуцлага” сэдэвт зөвлөгөөнөөр үндсэн ийг Уул уурхайн яамтай хамтран зохион байгуулсан. Зөвлөгөөнд 150 гаруй хүн оролцож, уул уурхайн компани, орон нутгийн төр захиргааны байгууллагын төлөөлөгчид оролцсон.

Гадаад орнуудын туршлагаас харахад уул уурхай, хүнд үйлдвэр, эрчим хүчний үйлдвэрлэлээс гарсан усыг эргүүлэн ашиглах асуудлыг чухалчилж, тодорхой зорилт тавин ажиллаж байна. Тухайлбал, Хятадын Эрчим хүчний газраас “2015-2020 онуудад авч хэрэгжүүлэх нүүрсний цэвэр, үр ашигтай хэрэглээний арга хэмжээнүүдийн төлөвлөгөө”-г нийтэд зарласан байна. Уг төлөвлөгөөнд усны нөөц хомс бүс нутгуудад уурхайн усны 95%-ийг, усны хангамж хэвийн газруудад уурхайн усны 80%-ийг, усны нөөцөөр баялаг газруудад уурхайн усны 75 хувийг тус тус эргүүлэн ашиглана¹²⁵ гэж тусгасан байна.

Манай улсын нийт усны нөөц 609,5 км³ бөгөөд үүнээс ашиглах боломжтой нь усны нөөц нь 10,56 км³ байх ба үүний 4,96 км³ нь гадаргын, 5,6 км³ нь газрын доорх ус юм.¹²⁶ Үндэсний статистикийн хорооноос 2017 оны эхний улиралд нийтэлсэн мэдээллээс харахад гадаргын усны ашиглалт хүн амын унд, ахуйн хэрэглээнд 0,4%, үйлдвэрлэл үйлчилгээнд 99,6%, газрын доорх усны ашиглалт хүн амын унд, ахуйн хэрэглээнд 0,8%, үйлдвэрлэл үйлчилгээнд 99,2%-тай байна.

График № 4 гадаргын болон газрын доорх усны ашиглалт



ҮСХ-оос гаргаж буй аж үйлдвэрийн салбарын статистикийн ерөнхий мэдээллийг 1/уул, уурхайн олборлолт, 2/боловсруулах үйлдвэрлэл, 3/цахилгаан, хий, уур, агааржуулалт, 4/усан хангамж гэсэн үндсэн 4 хэсгээс бүрдүүлдэг байна.¹²⁷

Дээр дурдсан үйлдвэрлэл үйлчилгээний дотроос судалгааны сэдэвт хамаарах төрлийг үзвэл 2015 онд уул уурхайд 81,1 сая м³, цахилгаан станцууд 44,7 сая м³ ус хэрэглэж байсан бөгөөд энэ хэмжээ тогтмол нэмэгдэж 2021 онд уул уурхайд 111,1 сая м³, цахилгаан станцууд 63,5 сая м³ ус хэрэглэнэ гэх таамаглал дэвшүүлсэн байдаг.¹²⁸

2012 онд батлагдсан Усны тухай хуулийн 4.1-д “Монгол улсын нутаг дэвсгэр дэх усны нөөц нь стратегийн үнэт баялаг мөн” гэж, 4.3-т “Усыг ашиглах боломжит нөөцийн хүрээнд үр ашигтай, хэмнэлттэй байдлаар ашиглах зарчим баримтална.” гэж тус тус заасан нь усны тухай хуульд оруулсан томоохон дэвшил юм. Стратегийн үнэт баялаг болох ус нь шавхагддаг, сэргээгдэхгүй байгалийн нөөцийн ангилалд хамаардаг бөгөөд

125 БНХАУ-ын 2015-2020 онуудад “Цэвэр нүүрс”-ний талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай. Эх сурвалж: <https://mrpam.gov.mn/news/706/>

126 Усны статистикийн өнөөгийн байдал. Эх сурвалж: https://www.switch-asia.eu/fileadmin/user_upload/RPSC/event/23-25May16-Mongolia/24-25May/12_WaterStatistics_MEGDT_Mongolian.pdf

127 Аж үйлдвэрийн салбарын статистикийн ерөнхий мэдээлэл. ҮСХ. Эх сурвалж: http://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Аж_үйлдвэрийн_статистикийн_мэдээний_тухай_тооцох_а_рга_зүй.pdf&ln=Mn

128 Усны статистикийн өнөөгийн байдал. Эх сурвалж: https://www.switch-asia.eu/fileadmin/user_upload/RPSC/event/23-25May16-Mongolia/24-25May/12_WaterStatistics_MEGDT_Mongolian.pdf

гүний ус нь тодорхойлолтоороо нөхөн сэргээгдэшгүй баялаг гэсэн ойлголтод багтдаг.¹²⁹

Зураг № 4 МУ-ын усны нийт хэрэглээний төлөв

Салбар	дэд салбар	Усны нийт хэрэглээ-ашиглалт, хэрэгцээ, сая.м3/жил	
		2015 он	2021 он
Унд ахуй	Хот	70.9	72.9
	Хөдөө	4.0	6.0
Хөдөө аж ахуй	Мал аж ахуй	94.9	108.6
	Усалгаатай тариалан	169.8	260.8
Үйлдвэрлэл	Уул уурхай	81.1	111.1
	Хүнд үйлдвэр	1.8	2.7
Эрчим хүч	Хөнгөн үйлдвэр	5.1	7.6
	Барилга	2.0	3.2
Нийтийн ус хэрэглээ	Цахилгаан станцууд	44.7	63.5
	Нийгмийн үйлчилгээ	5.9	6.5
Аялал жуулчлал	Ахуйн үйлчилгээ	5.6	8.7
	Ногоон хэрэм	2.6	2.9
Зам тээвэр		1.4	3.4
Нийт		493.4	662.4

Манай улсын хувьд ашигт малтмалын орд газруудын байршил нь усны нөөц хомс говийн бүсэд төвлөрч байгаагаас шалтгаалан уул уурхайн салбарт усны хэрэгцээ хамгийн их анхаарал татдаг. Уул уурхай эрчимтэй өсөхийн хэрээр усны эрэлт хэрэгцээ үлэмж нэмэгдэж төлөвтэй байгааг салбарын мэргэжилтнүүдийн судалгаа, тооцоолол харуулсаар байгаа.

Усны тухай хуульд усны барилга байгууламжийг эзэмших, ашиглах эрхийг 5 жилийн хугацаатай олгож, хариуцлагатай ашигласан тохиолдолд эрхийг дахин 5 жилийн хугацаатай сунгаж байхаар заасан, харин стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах зориулалт бүхий ус ашиглах зөвшөөрлийн хугацаа нь ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацаатай нэгэн адил¹³⁰ 30 жилийн хугацаатай олгогдохоор тусгагдсан байна. Түүнчлэн уул уурхайн салбарын үйл ажиллагаатай холбоотой чухал заалт бол хот, суурины унд ахуйн төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээнээс үйлдвэрлэлийн зориулалттай усны эх үүсвэр, шугам сүлжээг тусгаарлах, мөн уул уурхайн олборлолтод ус ашиглах аж ахуйн нэгж, байгууллага ашигт малтмал баяжуулах усаа голын эрэг, голдирлыг үл хөндөн шахуурга, яндан хоолойгоор дамжуулан авах¹³¹ тухай, байгальд халтай технологи бүхий үйлдвэр, үйлчилгээний газарт ус ашиглуулах дүгнэлт гаргахыг хориглосон¹³², мөн ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон журмын дагуу ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулсан байна¹³³, хэрэв хаягдал ус зайлуулах зөвшөөрөлд заасан хэмжээнээс болон хаягдал усны стандартаас хэтэрсэн бохир усыг удаа дараа хаясан бол ус ашиглах эрхийг цуцлах¹³⁴ тухай зохицуулалтуудыг оруулсан нь

¹²⁹ https://mn.wikipedia.org/wiki/Байгалийн_нөөц

¹³⁰ Усны тухай хуулийн 28.9 дэх заалт

¹³¹ Усны тухай хуулийн 30.4, 60.6 дахь заалт

¹³² Усны тухай хуулийн 28.19 дэх заалт


¹³³ Усны тухай хуулийн 24.4, -д Ус

¹³⁴ Усны тухай хуулийн 24.6 дахь заалт

энэ салбарын усны хэрэглээг хүн амын ундны усны эх үүсвэрт сөргөөр нөлөөлөхгүй байх, зохистой байлгахад чиглэсэн гэж үзэж болох юм.

Гэхдээ уул уурхайн компаниудын ус ашиглалт, ус дахин ашиглалттай холбоотой зарим зохицуулалтууд нь тодорхойгүй хэвээр байна. Тухайлбал, ус тусгаарлагч гэдэг нь хөрсөнд бохир ус нэвчихээс хамгаалсан тусгаарлагч байх уу, эсвэл зөвхөн цэгийг тойруулсан тусгаарлагч байх уу, байгальд халтай технологийг хэрхэн тогтоох¹³⁵, уурхайн хаягдал уснаас хамгийн багадаа хэдэн хувийг дахин ашиглах шаардлагатай зэрэг асуудал тодорхойгүй, журамлагдаагүй хийдэл үүсгэсэн нь энэхүү үйл ажиллагаа нийгмийн хариуцлагын хүрээнд, сайн дурын үндсэн дээр хэрэгжих асуудал болж хувирчээ.

Зураг № 5 Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо



Уул уурхайн яам, Ашигт малтмал, газрын тосны газраас гаргасан “Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ”-нд дурдсанаар 2017оны 11 дүгээр сарын 06-ны байдлаар 3184 хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл байгаагаас ашиглалтын тусгай зөвшөөрөл 1399, хайгуулын тусгай зөвшөөрөл 1785 байна.¹³⁶

Хүснэгт № 11 Уул уурхайн компанудын усыг эргүүлэн ашиглаж буй байдалд хийсэн түүвэр судалгаа

Уул уурхайн компани	Тайлбар	Эргүүлэн ашиглаж буй усны хэмжээ %
Цайртминерал ХХК	Далд уурхайн усгүйжүүлэн савлах цехэд баяжмалыг усгүйжүүлж, ялган авсан усыг эргүүлэн үйлдвэрлэлд ашигладаг.	Ус дахин ашиглалтын хэмжээ 75%
Цахим хуудас: http://www.tsairt.mn	Ил уурхайн ус ашиглалтын талаар мэдээлэл байхгүй	
Оюутолгой ХХК Цахим http://ot.mn/	Хэрэгжүүлж буй арга хэмжээ: Хаягдлын сангийн усыг хэмнэлттэй ашиглах; Хөргөлтийн усыг 100% дахин ашиглах; Уурхайн гүний усыг 100% дахин ашиглах; Ахуйн хэрэглээний хаягдал усыг цэвэрлэж 100% дахин ашиглах; Машин механизмын цэвэрлэгээний усыг 100% дахин ашиглах; Усыг ууршихаас хамгаалсан арга хэмжээ авах; Усыг ариг гамтай ашиглах.	“Оюу толгой” нэг тонн хүдэр боловсруулахдаа ердөө 0.35 шоо метр буюу дэлхийн ижил үйл ажиллагаатай бусад уурхайн хэрэглэдгээс даруй гурав дахин бага ус ашигладаг Ус дахин ашиглалтын төвшин 2016 онд 89%, 2017 оны 1 улиралд 88,7%

¹³⁵ Ус стратегийн үнэт баялаг. 2012 он. Эх сурвалж: <http://www.mongolianminingjournal.com/content/34609.shtml>

¹³⁶ Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ. 2017 он. Эх сурвалж: <https://www.mrpm.gov.mn/public/pages/83/monthly%20report%20201710%20new.pdf>

	бохир усыг байгальд шууд хаяхгүй байх бодлого баримталдаг.	
Эрдэнэс таван толгой ХК http://erdenestt.mn	<p>ЭТТ ХК нь нийт 6 гүний худгаас уурхайн усны хэрэглээг хангадаг. Жилд дунджаар 103,7 мянган м3 ус ашигладаг, үүний 86%-ийг уурхайн тоосжилт дарах, машин угаахад зарцуулдаг байна. Тухайлбал 2017 онд 147000 м3 ус ашиглахаар төлөвлөсний 95000 м3-ийг гүний худгаас, 2000 м3-ийг саарал уснаас, 20000 м3-ийг шүүрлийн уснаас ашиглана гэж тооцсон байна.</p> <p>ЭТТ ХК-ийн хувьд уурхайн ус ашиглалтыг хэмнэх бодлого барьж байгаа боловч хэрэглээний усны 81%-ийг гүний, 1,7%-ийг саарал уснаас хангахаар төлөвлөсөн байна.</p> <p>ЭТТ ХК нь 2011 оноос олборлолтын үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Олон нийтэд нээлттэй байршуулсан мэдээллээс харахад 2015 оноос БОМТ боловсруулан ажиллаж байна.</p> <p>Тус ХК-ий БОМТ-өөс харахад унд ахуйн усны чанар, төвшинд анхаарах, газрын доорх усны түвшний өөрчлөлтөнд хяналт тавих, саарал усыг дахин ашиглах зорилтыг тогтмол тавьж иржээ. Энэ чиглэлээр гүйцэтгэж буй ажлууд нь тодорхой хэмжээнд ахиц гаргасан байна. Үүнд ХСУХАТАТХ-д хамаарах уурхайн хотхонуудын бохир усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэршүүлэх, саарал усыг дахин ашиглах зэрэг асуудлыг дурдаж болох юм.</p> <p>Тухайлбал, 2016 оны БОМТ-ий Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөнд саарал усыг ногоон байгууламжийн усалгаа болон зам талбайн усалгаанд ашиглах, БУЦБ-ын хаягдал усны стандартанд нийцүүлэх арга хэмжээг авахаар тусгажээ.</p> <p>ЭТТ ХК нь механик болон биологи цэвэрлэгээний 3 цэвэрлэх байгууламжтай, “бохир усыг 97,5 % хүртэл цэвэрлэх боломжтой. Цэвэрлэгдсэн усыг хөрсөнд нь шингээх зориулалттай шүүх сувгуудыг төлөвлөж өгсөн бөгөөд эдгээр шүүх сувгуудад дахин усны гүн цэвэрлэгээ явагдах учраас цэвэрлэгээний үр дүн 99% хүрнэ гэж тооцдог. ОХШХ –ийн дагуу цэвэрлэх байгууламжийн хаягдал усны чанарт улирал тутам шинжилгээ хийлгэж тогтмол хяналт явуулж, гарсан үр дүнгээр мэдээллийн сан бүрдүүлнэ.” гэж төлөвлөсөн боловч хэрэгжилт ямар шатанд байгаа талаар мэдээлэлгүй байна.¹³⁷</p> <p>2017 оны БОМТ-нд саарал усыг ашиглах, бохир ус ЦБ-ийн хаягдал усыг стандартанд нийцүүлэх арга хэмжээг авах, Ногоон байгууламжийн усалгаанд саарал усыг ашиглах, Усны хэрэглээг хамгийн бага төвшинд барих, усыг ариг гамтай хэрэглэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг зорилт</p>	Ус дахин ашиглалтын төвшин 1,7%

¹³⁷ Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал, шоо м/хоног, төрөл, байгуулагдсан оноор: 1. Цанхи хотхон: 25 шоо м/хоног, механик болон биологийн, 2013 он, 2.Эрдэнэс хотхон: 40 шоо м/хоног, механик болон биологийн, 2011 он, 3.Уурхайн оффис: 20 шоо м/хоног, механик болон биологийн, 2011 он, Эх сурвалж: http://erdenestt.mn/uploads/files/2017-08/1503042670_ett_emp_2016.pdfhttp://erdenestt.mn/uploads/files/2017-08/1503042670_ett_emp_2016.pdf

	тавьсан боловч хэрэгжилтийн талаар мөн адил мэдээлэлгүй байна. ¹³⁸	
Тавантолгой ХК http://tavantolgoi.mn/ орон нутгийн өмчит хувьцаат компани	2013 онд нийтэлсэн мэдээллээс харахад уурхайн ус ашиглалтыг сайжруулах үүднээс уурхайгаас гарч буй гүний усыг тунгаагуур үүсгэн дахин уурхайн зам усалгаанд болон усны шаардлагатай газруудад ашигладаг. Мөн уурхайн тосгоноос гарч байгаа бохир усыг цэвэрлэх төхөөрөмж суурьлуулсан. ¹³⁹	Усны хэрэглээ, ус ашиглалтын талаар үйл ажиллагааны тайландаа тусгадаггүй. Ус дахин ашиглаж буй талаар мэдээлэл үйл ажиллагааны тайлангуудад байхгүй
Алтайн хүдэр	Уурхайн үйл ажиллагааны талаарх мэдээлэл олон нийтэд ил тод байршуулагдаагүй. Иймээс олон нийтийн хяналт тавих боломжгүй.	Усны хэрэглээ, ус ашиглалтын талаар үйл ажиллагааны тайландаа тусгадаггүй. Ус дахин ашиглаж буй талаар мэдээлэл үйл ажиллагааны тайлангуудад байхгүй
Энержи Ресурс ХХК http://www.energyresources.mn	Ухаа худаг уурхайн цогцолборын үйлдвэрлэлийн ба ахуйн хэрэглээний ус хангамжийн боловсронгуй системийг бий болгох ажил 2008 оноос эхэлж 2011 онд ашиглалтад орсон. Ингэхдээ цэвэр усны нөөцөөр хомс говь нутгийн онцлогийг дээд зэргээр харгалзсан, усыг 100 хүртэлх хувь дахин ашиглах, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилтэт технологиудыг нэвтрүүлж ажилласан. Ус хангамжийн цогц систем нь уурхайн цогцолборын усны хэрэгцээг хангаад зогсохгүй Өмнөговь аймгийн Цогтцэций сумыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэршүүлсэн усаар хангадаг. Системийн бүх бүрэлдэхүүн хэсгүүд ус хэмнэлтийг дээд зэргээр хангах технологийн горимд суурилсан гэжээ.	Усыг 98 хувь хүртэл дахин ашиглах орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн. 2013 онд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийг шинээр барьж, ашиглалтад оруулснаар үйлдвэрлэлд дахин ашиглах усны хэмжээг өмнөхөөс 60-70% нэмэгдүүлсэн.
Эрдэнэт үйлдвэр	Эрдэнэтийн уулын баяжуулах үйлдвэрийг усаар хангахын тулд Сэлэнгэ мөрнөөс 60 км урт хоолойгоор 60 гаруй сая м3 усыг технологийн зориулалтаар хэрэглэдэг. Баяжуулах үйлдвэрт хэрэглэсэн усыг эргүүлэн ашигладаг. Хоногт 200,0 орчим м3 усыг Хаягдлын аж ахуйгаас авч ашиглаж байна. Сүүлийн үед үйлдвэрийн шинэчлэлд ус бага ашигладаг технологи сонгож байгаа. Баяжуулах фабрикийн өргөтгөл, ус өргөх станцуудад тавьж буй технологийг нэрлэж болно. Үйлдвэр хүчин чадлаа нэмэгдүүлж байгаа ч, хэрэглэж буй усны хэмжээ эрс нэмэгдэхгүй байгаа. Үүнд усны тоолуур өргөн ашигласан нь бас нөлөөлж байгаа. ¹⁴⁰	Усны 80 гаруй %-ийг эргүүлэн ашигладаг
Алтан Дорнод Монгол ХХК http://www.adm.mn	Алтан Дорнод Монгол ХХК-ий байгаль орчин, ус дахин ашиглалттай холбоотой ямар нэг мэдээлэл олон нийтэд нээлттэй эх сурвалжаас олдоогүй	

Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн компаниудын үйл ажиллагаандаа дахин ашиглаж буй усны хувь хэмжээг тогтоох зорилгоор санамсаргүй түүврийн аргаар дээрх 7 ААН-ын олон нийтэд ил тод байршуулсан мэдээллийг судалж үзэхэд уурхайн үйл ажиллагааны усны нийт хэрэглээний хэдэн

¹³⁸ http://erdenestt.mn/uploads/files/2017-08/1503042719_ett_emp_2017.pdf

¹³⁹ <http://tavantolgoi.mn/news/43#.W9WRRnszaM8>

¹⁴⁰ Т.Батсүх: “Эрдэнэт” үйлдвэр усыг зохистой ашигладаг.Эх сурвалж: <http://mongolcom.mn/read/29622>

хувийг дахин ашигласан усаар хангаж байгаа талаар тоо мэдээлэл гаргасан компани ховор байна. Харин “Өмнийн говь дахь уул, уурхайн компаниудын усны удирдлагын сайн дурын кодекс”-т нэгдэн орсон 10 компани усны талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тодорхой хэмжээнд мэдээллээ ил тод байршуулдаг бол дийлэнх компаниудын хувьд цахим хуудасгүй, цахим хуудастай нь зөвхөн компаний танилцуулга төдийхнөөр хязгаарлагдсан мэдээлэлтэй байна.

2016 оны байдлаар Өмнийн говь дахь уул, уурхайн компаниудын дундаас “Уул уурхайн салбарын үйл ажиллагааны сайн дурын Кодекс”¹⁴¹-т нэгдэн орсон 10 компаний хувьд нийт ашигласан ус 17,072,030м /жил /6 компаний дундаж/, газрын доорх ус: 99.5%, дахин ашигласан ус: 79% /3компани/ байсан гэж мэдээлжээ. Харин уул уурхайд дахин ашигласан усны хэмжээг тогтоохдоо энэ чиглэлээр харьцангуй сайн ажиллаж байгаа компаниудыг сонгон авч дундажыг гаргасан байна.¹⁴²

ХСУХАТАТХ-ийн 17.13-д уул уурхай ... нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглана гэж үүрэгжүүлсэн зохицуулалт оруулж өгсөн боловч уг заалтын хэрэгжилтийг тайлагнадаг уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй ААН огт байхгүй байгаа нь хуулийн энэ заалт зорилгодоо хүрэхгүй, хэрэгжихгүй байна гэх дүгнэлтэд хүргэж байна.

Уул уурхайн компаниуд үйл ажиллагаандаа хэрэглэж буй усны талаарх мэдээллийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” боловсруулах, биелэлтийг тайлагнах ажлын хүрээнд БОАЖЯ, АМГ зэрэг байгууллагуудад мэдээлэл хүргүүлдэг бол ХСУХАТАТХ-ийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий БХБЯ-нд энэ талаар мэдээлэл хүргүүлдэггүй, яам энэ талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс мэдээлэл авдаггүй байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар дахь усны хэрэглээний өнөөгийн байдал, хэтийн төлөв, төлөвлөлт¹⁴³-өөс харахад ирээдүйд хэрэгжих томоохон төслүүд болох Сайншанд дахь Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөлд 2,1 сая м3, Багануур дүүрэг, Дундговь аймагт хэрэгжих Нүүрс хийжүүлэх үйлдвэрүүдэд 9,9 сая м3, Зэс баяжуулах, хайлуулах,

¹⁴¹Уул уурхай ба газрын доорх усны менежмент, хяналт шинжилгээ сургалт – 2017. Нэмэлт материал. Эх сурвалж: https://www.commddev.org/wp-content/uploads/2015/05/ifc008_additional-materials.pdf

¹⁴²Энэхүү кодекс 6 зүйл 19 заалттай бөгөөд 4 дүгээр зүйлд Усны нөөцийн үр дүнтэй менежмент ба хамгаалал агуулгын хүрээнд Уурхайн үйл ажиллагаан дахь ус ашиглалтыг үр ашигтай хэрэглээ, хэмнэлттэй болгон сайжруулах, мөн ус хаягдлыг багасгах/ус хэмнэх тухай дурджээ. Энэхүү Кодекс-т нэгдэн орсноор сайн дурын үндсэн дээр усны менежментийн хариуцлагатай, үр ашигтай тогтолцоог бий болгохын зэрэгцээ өөрсдийн усны хэрэглээны талаар ил тод мэдээлэл тайлан гаргах, орон нутгийн иргэдтэй усны хяналт шинжилгээг хамтран хийх, усан хангамжийн хүртээмжтэй байдлыг дээшлүүлэхэд орон нутагт дэмжлэг үзүүлэх зэрэг амлалтуудыг компаниуд авч байгаа болно. Уг кодекст 2017 оны 5 сарын байдлаар Энержи Ресурс, Говь Коал энд Энержи, Эрдэнэс Монгол, Эрдэнэс Таван Толгой, Оюу Толгой, Терра Энержи, Эрдэнэ Ресурс Девелопмент, Саус Гоби Сэндс, Баян Айраг, Монголын Алт Корпораци гэсэн 10 компани нэгдсэн байна. Кодексийн эрхэм зорилгыг “Усаар хангагдах нь хүний үндсэн эрх гэдгийг хүлээн зөвшөөрч, усыг хариуцлагатай, хууль журмын дагуу тогтвортой ашиглах талаар сайн дурын үүрэг, амлалт авч байна. Бид усыг үр ашигтай ашиглан, усны мониторинг шинжилгээг ил тод хийж, усны чанарыг хадгалж, усны менежментийг өргөн хүрээний оролцоонд суурилан хийх болно. Уул уурхайн компаниуд Уул уурхайн салбарын үйл ажиллагааны сайн дурын Кодекс-д нэгдэн орох байдлаар хариуцлагатай уул уурхайг дэмжиж байна.” Гэж тодорхойлсон байна.

¹⁴³ Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар дахь усны хэрэглээний өнөөгийн байдал, хэтийн төлөв, төлөвлөлт илтгэл.Эх сурвалж: C:/Users/Dell/Downloads/06_Mining%20and%20heavy%20industry%20ITGEE.pdf

цэвэршүүлэх үйлдвэрүүдэд 8,6 сая м3, Төмөрлөгийн үйлдвэрүүдэд 9,2 сая м3 гээд эдгээр хэдэн төлийн хувьд 30 орчим сая м3 технологийн усны хэрэгцээ үүсэх судалгаа гарчээ.

“Орхон гол дээрх урсацын тохируулга бүхий ус хуримтлуулах сан байгуулах” төслийн ТЭЗҮ-ийн ажлын даалгаврын судалгааны тайланд томоохон үйлдвэр, уурхайн усны хэрэглээг 2010 оны усны хэрэглээний байдалд үндэслэн 5 жил тутмаар тооцсон байдлаас харахад нэг хоногийн дундаж усны хэрэглээ дараахь байдлаар өснө гэсэн үзүүлэлттэй байна.

Зураг № 6 Уул уурхайн салбарын усны хэрэгцээний хэтийн төлөв таамаглал.¹⁴⁴



Зураг № 7 Ашиглах боломжтой усны нөөц болон говийн бүсийн уул уурхайн усны хэрэгцээний хэтийн төлвийн харьцаа¹⁴⁵



Дээр дурдсан болон бусад хүчин зүйлсээс шалтгаалан уул уурхайн усны хэрэгцээ өсөхийн хэрээр усны нөөцийн асуудал ялангуяа эрдэс баялгийн орд ихтэй боловч ус багатай говийн аймгуудад тулгарах талаар ус, усны нөөц, усны хэрэглээтэй холбоотой бүхий л судалгааны тайлангуудад дурдсан байгаа боловч уурхайн усыг эргүүлэн ашиглах технологийг бүрэн хэрэгжүүлж байгаа компани ховор байна.

Усны хэрэглээний өсөлтийн талаар болон ХСУХАТАТХ-ийн 17.13-д заасан хэрэглээний усыг дахин ашиглах асуудлыг дотоод, гадаадын судалгааны байгууллагаас хийсэн судалгааны ажлуудад, мөн олон улсын байгууллагуудаас энэ талаар анхаарч ажиллахыг

¹⁴⁴ Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар дахь усны хэрэглээний өнөөгийн байдал, хэтийн төлөв, төлөвлөлт илтгэл.Эх сурвалж: C:/Users/Dell/Downloads/06_Mining%20and%20heavy%20industry%20ITGEE.pdf

¹⁴⁵ Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар дахь усны хэрэглээний өнөөгийн байдал, хэтийн төлөв, төлөвлөлт илтгэл.Эх сурвалж: C:/Users/Dell/Downloads/06_Mining%20and%20heavy%20industry%20ITGEE.pdf

зөвлөж ирсэн. Тухайлбал, Стокхольм хотноо зохиогдсон Дэлхийн усны долоо хоногийн үйл ажиллагааны үеэр “Цөл нутаг дахь эрэлт хэрэгцээ” судалгааг танилцуулсан байдаг. Тус судалгаагаар ус, эрчим хүчний одоогийн төлөв байдлыг Монгол Улсын үндэсний төвшинд болон Туул голын сав газар, говийн бүсийн Галба-Ууш Долоодын сав газарт нарийвчлан судалсны дүнд “Уул уурхайн салбар, дулааны цахилгаан станцуудад Монгол Улсын хувьд улам ихээр хомсдож буй усны нөөцийг улам ихээр ашиглахаар зэхэж байна”, “Монгол Улсын хувьд бусад улс орны адил ус, эрчим хүчний хэрэглээг хамтад нь төлөвлөх асуудал туйлын чухал болж байна.” зэрэг дүгнэлтүүдэд үндэслэн АХБ, Монгол Улсын Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны судалгаагаар Монгол Улсад усны нөөцийн хомсдол нүүрлэж буй тул эрчим хүч, уул уурхайн хөгжлийн төлөвлөгөөндөө усны асуудлыг тусгах зайлшгүй хэрэгцээ бий гэж үзжээ. Иймээс эрчим хүч, уул уурхайн хөгжлийн төлөвлөгөөнд усны нөөцийн асуудлыг тусгахыг чухалчлахаас гадна орон сууц, үйлдвэрлэлийн салбарт эрчим хүчний ашиглалтыг сайжруулах, борооны усыг ашиглах, хаягдал усыг дахин ашиглахыг уриалан эрчим хүчний шинэ байгууламжуудыг аль болох бага ус хэрэглэдэг байхаар төлөвлөж, ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийн тогтолцоог сайжруулснаар эрчим хүч, усны ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх боломжтой бөгөөд эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд усны менежментийн байгууллагууд ч өөрсдийн үйл ажиллагаагаа сайжруулж, дэмжлэг үзүүлж байх шаардлагатай гэж зөвлөсөн байдаг.¹⁴⁶

Иймээс ХСУХАТАТХ-ийн 17.13-д заасан технологийн хэрэглээний усыг дахин ашиглах асуудлыг эрчимжүүлэх, үр дүнд хүргэх зорилгоор Ус бохирдуулсны төлбөрийн тухай, Усны тухай, Ашигт малтмалын тухай зэрэг хууль тогтоомжуудад энэхүү үйл ажиллагааг үүрэгжүүлсэн, үнэлэх, дүгнэх, тайлагнах зэргээр хариуцлагажуулж, эзэнжүүлсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж үзлээ.

Эрчим хүчний салбарын технологийн усыг эргүүлэн ашиглаж буй байдал

Эрчим хүчний салбар нь манай улсын хувьд хамгийн их ус ашигладаг салбар юм. БОНХЯ-наас 2014 онд гаргасан судалгаанаас харахад нийт усны хэрэглээний хамгийн өндөр хувийг буюу 25%-ийг эрчим хүчний салбар дангаараа ашигладаг бол хүн амын унд ахуйд 16%-ийг ашигладаг байна. Одоогоор унданд хэрэглэж болох цэвэр усыг цамхаг хөргөх, үнс зайлуулах, угаалга хийхийн тулд ашиглаж байгаа нь харамсалтай боловч өөр сонголт байхгүй боловч энэ их хэмжээний цэвэр усыг дахин боловсруулсан усаар солих асуудал тулгамдаж, шийдлээ хүлээж байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 35 дугаар зүйлд заасан мэдээллийн сангийн бүрдлийн дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Байгаль орчны мэдээллийн төвөөс уг мэдээллийн санг хөтлөн нийт 32 төрлийн мэдээллийн сан үүсгэснээс 21 төрлийн мэдээлэл тодорхой хэмжээнд олон нийтэд ил тод байршсан байна. Уг мэдээллийн санд оруулсан тоо мэдээлэл нь 2013-2014 онд хийгдсэн бүртгэл, тооллогын дүн байна. Энэхүү мэдээллийн сан дахь Усны мэдээллийн санд¹⁴⁷ 10 дэд мэдээллийн сан байх ба үүнээс судалгааны ажилд холбогдох Ус ашиглалтын мэдээллийн сан¹⁴⁸, Ус

¹⁴⁶ <https://www.adb.org/mn/news/mongolia-needs-integrate-water-energy-and-mining-development-plans>

¹⁴⁷ Ус, рашааны мэдээллийн сан. <http://www.eic.mn/water/>

¹⁴⁸ <http://eic.mn/wateruse/>

бохирдуулагчийн мэдээллийн санг¹⁴⁹ ашиглах боломжгүй байсан бол харин Усны барилга байгууламжийн мэдээллийн сан¹⁵⁰ -гийн ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, дулааны цахилгаан станцуудын худаг, Худгийн мэдээлэлд ХСУХАТАТХ-ийн хүрээнд хамаарах асуудлаар дүн шинжилгээ хийлээ.

Дулааны цахилгаан станцуудын /цаашид ДЦС гэх/ худгийн тооллогод зөвхөн Улаанбаатар хотын 2, 3, 4 дүгээр ДЦС-ын ашиглалтад байгаа худгуудыг хамруулсан байна. Үүнээс харахад 2 дугаар ДЦС-д 1957-1999 онд гаргасан 38-45 метрийн гүнтэй 4 ширхэг худгийг, 3 дугаар ДЦС-д 1974-2001 онд гаргасан 33-47 метрийн гүнтэй 13 ширхэг худгийг, 4 дүгээр ДЦС-д 1983-2008 онд гаргасан 24-70 метрийн гүнтэй 19 ширхэг худгийг, нийт 35 гүний худгийн сайн чанарын буюу унд, ахуйн хэрэглээнд хэрэглэж болох усыг нийслэл хотын ДЦС-ын дотоод хэрэгцээнд турбин цехийн техникийн усан хангамж, техникийн усаар хангах зорилгоор ашиглаж байна.¹⁵¹

Орон нутгийн ДЦС-уудын ус ашиглалтын мэдээлэл олдохгүй байсан нь эрчим хүчний салбарын усны хэрэглээнд хамаарах зохицуулалтын хэрэгжилтийг УБ хотоор хязгаарлахад хүргэсэн болно. УБ хотын хувьд нүүрсний хэрэглээгээрээ хамгийн өндөр 4-р цахилгаан станц нь хоногт дунджаар 9.0 мянган тонн нүүрс хэрэглэж байгаа ба цагт 1100тн ус хэрэглэдэг¹⁵² гэх судалгаа бий. Харин бусад эрчим хүчний үйлдвэрүүдийн /ДЦС-уудын/ тухайд ус ашиглалттай холбоотой ямар нэг тоо баримт нийтлэгдээгүй байна.

Эрчим хүчний салбарт хэрэгжиж буй үйл ажиллагааны талаарх нарийн мэдээ, мэдээлэл олон нийтэд ил тод бус, олон нийтийн зүгээс мэдээлэл авах боломжтой эх сурвалжуудад цахилгааны үнэ тариф, тус салбарт оруулах хөрөнгө оруулалт зэрэг хэдэн сэдвээр тогтмол мэдээлэл түгээгддэг бол ус ашиглалтын талаар албан ёсны мэдээлэл байршуулдаггүй нийтлэг төрхтэй байна.

Харин салбарын асуудлаар зохион байгуулагдсан хурал, зөвлөгөөний үеэр энэ төрлийн мэдээллийг салбарынхандаа хүргэдэг гэж үзэж болох байна. Тухайлбал, “Ус ба эрчим хүч” хэлэлцүүлгээр эрчим хүчний үйлдвэр, компаниуд усыг хэмнэх зорилгоор олон ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байгаа, ДЦС-ууд усны хэрэглээнд хяналт тавихын тулд цех бүрт хэмжүүр байрлуулж, зуухны үнс барих төхөөрөмжид үнсэн сангийн тунгаагдсан усыг дахин ашиглах, цацруулах бассейныг алдагдал багатай хөргөх цамхагаар солих, хөргөх цамхагуудад засвар шинэчлэлтийг хийж усны зарцуулалтыг бууруулах зэрэг арга хэмжээ авч байгаа, Дарханы дулааны шугам сүлжээ ХК болон Багануурын дулааны станц нь дулаан хангамжийн нээлттэй системийг хаалттай системд шилжүүлсэн, “Дорнод бүсийн эрчим хүчний систем”, “Даланзадгадын дулааны цахилгаан станц”, “ДЦС-4” ХК-иуд ус бэлтгэхдээ эсрэг осмосын төхөөрөмжийг суурилуулсан зэрэг бодит хэмнэлт байгааг усны мэргэжилтнүүд онцолжээ.¹⁵³ Гэвч эдгээр нь хэрхэн хэрэгжиж, ус хэмнэх,

¹⁴⁹ <http://eic.mn/waterpollution/>

¹⁵⁰ <http://eic.mn/waterconstruction/>

¹⁵¹ Усны барилга байгууламжийн мэдээллийн сан. Дулааны цахилгаан станцуудын худаг. Эх сурвалж: <http://www.eic.mn/waterconstruction/index.php?id=8&page=4>

¹⁵² Цахилгаан станцын бүртгэл, тооллого. Нийтлэгдсэн 2014 он. Эх сурвалж: <http://agaar.mn/article-view/306>

¹⁵³ Ус ба эрчим хүч” хэлэлцүүлэг боллоо. Эх сурвалж: <https://news.mn/r/659523/>

усыг дахин ашиглах тухайд ямар бодит үр дүнд хүрсэн талаар тодорхой мэдээлэл үгүй байна.

ХСУХАТАтХ-ийн 17.13-д заасан эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглах зохицуулалтын хэрэгжилт хангалгүй, зорилгодоо хүрэхгүй байна.

Гэхдээ энэ салбарын усны хэрэглээг саарал усаар нөхөх, усыг хэмнэлттэй ашиглах тал дээр Монгол Улс 2018 онд Мянганы Сорилтын Корпорацитай байгуулсан гэрээний үр дүнд томоохон ахиц гарна гэх хүээлт үүсээд байна. Мянганы Сорилтын Корпорациас Улаанбаатар хотын усан хангамжийг сайжруулах чиглэлээр олгох буцалтгүй тусламжийн хүрээнд 350 сая ам.долларын буцалтгүй тусламж олгоно. Уг тусламжаар хэрэгжих хөтөлбөрийн хүрээнд үндсэн хоёр том төсөл хэрэгжих бөгөөд үүний нэг нь Төв цэвэрлэх байгууламжаас цэвэрлэгдээд гарч буй бохир усыг дахин боловсруулах үйлдвэр барих, цэвэршүүлсэн усыг III, IV цахилгаан станцуудад нийлүүлэх асуудал юм.

Эрчим хүчний үйлдвэрүүд нь Эрчим хүчний яаманд харьяалагдан үйл ажиллагаагаа тайлагнадаг бөгөөд тайлангуудад нь ХСУХАТАтХ-ийн 17.13-д заасан эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглах үүргийн биелэлтийг тусгайлан гаргадаггүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг үнэлэх нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

Үнэлсэн байдал

ХСУХАТАтХ-ийн 17.13-ын “Уул уурхай, эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглана” гэх зохицуулалт **ЗОРИЛГОДОО ХҮРЭХГҮЙ** байна гэж үнэллээ.

Хуулийн зохицуулалтын зорилгыг хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүргийн дагуу уул уурхай, эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашигласнаар усны нөөц, ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалах, үйлдвэрлэлд усны зохистой хэрэглээг бий болгох, ус хэмнэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн гэж үзсэн.

Ийнхүү үнэлэх үндэслэлийг дараахь нөхцөл байдалд тулгуурласан болно:

1. ХСУХАТАтХ-ийн 17.13-д “Уул уурхай, эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглана” гэж заасан нь уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүдэд хэрэглээний усаа эргүүлэх ашиглах үүрэг хүлээлгэжээ.
2. Усыг хэмнэлттэй ашиглах, саарал усыг дахин ашиглах асуудлыг Монгол Улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, “Ус” үндэсний хөтөлбөр Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Усны тухай хууль, Ногоон хөгжлийн бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, ЗГ-ын Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр, Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд тусгасан байх боловч хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэж болох байна.
3. ҮСХ-оос гаргасан мэдээллээс харахад манай улс 2015 онд нийт 493,4 сая м³ ус ашигласнаас уул уурхайд 81,1 сая м³, цахилгаан станцууд 44,7 сая м³ ус хэрэглэсэн нь нийт усны хэрэглээний 25 гаруй хувийг дангаараа эзэлжээ. Мөн 2017 оны эхний

улиралд газрын доорх усны 0,8%-ийг хүн амын унд, ахуйн хэрэглээнд, 99,2%-ийг үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглажээ.

4. Манай улсад ашигт малтмал ашиглалтын 1676 хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл эзэмшигч бий. Эдгээр ТЗЭ нь Усны тухай хуулийн дагуу ус ашиглах гэрээ байгуулан, уг хуульд заасан шаардлага ханган ажиллах үүрэг хүлээдэг боловч шинэчлэн батлагдсан Усны тухай хуульд ус ашиглалт, ус дахин ашиглалттай холбоотой зохицуулалтууд нь тодорхойгүй хэвээр байгааг анхаарах шаардлагатай байна.
5. Өнөөгийн байдлаар ХСУХАТАТХ-д заасан технологийн хэрэглээний усыг дахин ашиглах үүргийг уул уурхайн компаниуд зөвхөн нийгмийн хариуцлагын хүрээнд, сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлж байна.
6. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн компаниуд ус ашиглалт, дахин ашиглаж буй усны хувь хэмжээний талаар мэдээллээ ил тод байршуулахгүй байгаа нь олон нийтийн болон төрийн хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй байдлыг бий болгосон гэж үзэж болох юм. Судалгааны ажлын хүрээнд санамсаргүй түүврийн аргаар 7 ААН-ын олон нийтэд ил тод байршуулсан мэдээллийг судалж үзэхэд уурхайн үйл ажиллагааны усны нийт хэрэглээний хэдэн хувийг дахин ашигласан усаар хангаж байгаа талаар тоо мэдээлэл гаргасан компани ховор байна. Харин “Өмнийн говь дахь уул, уурхайн компаниудын усны удирдлагын сайн дурын кодекс”-т нэгдэн орсон 10 компани усны талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тодорхой хэмжээнд мэдээллээ ил тод байршуулдаг бол дийлэнх компаниудын хувьд цахим хуудасгүй, байгаа нь зөвхөн компаний танилцуулга төдийхнөөр хязгаарлагдсан мэдээлэлтэй байна.
7. Түүнчлэн ХСУХАТАТХ-ийн 17.13-д уул уурхай ... нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглана гэсэн заалтын хэрэгжилтийг тайлагнадаг уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН огт байхгүй байна. Энэ нь хуулийг хэрэгжүүлэгч БХБЯ энэ асуудалд төдийлөн ахнаарал хандуулдаагүй учраас уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүд тайлангаа ирүүлдэггүй, түүнийг нэгтгэх, дүгнэх ажиллагаа хийгдэдгүй. Түүнчлэн энэ асуудал БАОЖЯ, БХБЯ-ны чиг үүрэгт давхцсан байдлаар орсон нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.
8. Үүнээс харахад уул уурхайн компаниуд үйл ажиллагаандаа хэрэглэж буй усны талаарх мэдээллийг “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” боловсруулах, биелэлтийг тайлагнах ажлын хүрээнд БОАЖЯ, АМГ, УУЯ зэрэг байгууллагуудад мэдээлэл хүргүүлдэг бол ХСУХАТАТХ-ийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий БХБЯ-нд энэ талаар мэдээлэл хүргүүлдэггүй, яам энэ талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс мэдээлэл авдаггүй байна.
9. ХСУХАТАТХ-ийн 17.13-д заасан хэрэглээний усаа эргүүлэн ашиглахтай холбоотой харилцаа, хэмжээ, хязгаарыг нарийвчлан зохицуулсан дүрэм, журам боловсруулагдаагүй, хуулийн хэрэгжилтийг хариуцах байгууллага, нэгж тодорхойгүй, хуулийн хэрэгжилтийн талаар тайлан мэдээ авдаггүйтэй холбоотой байна. Энэ нь уул уурхайн компаниудын дахин ашигласан усны талаар нэгдсэн тоо, статистик байхгүй, энэ чиглэлээр ямар ахиц гарсныг тодорхойлох боломжгүй байдалд хүргэсэн байна.
10. Уул уурхай, эрчим хүчний салбарт усыг дахин ашиглах, хэмнэх технологийг түлхүү нэвтрүүлэх, түүнийг хөхиүлэн дэмжих эрх зүйн зохицуулалтуудыг бий болгох шаардлага үүссэн байна. Манайд технологийн хэрэглээний ус, хэрэглээнээс гарсан

ус, саарал ус, хаягдал ус гэж хэд хэдэн янзаар нэрлэгддэг усыг ашиглахгүй байх гол шалтгаанд усыг эргүүлэн ашиглахад гаргах зардал цэвэр усыг ашиглахаас илүү үнэтэй, мөн дээрх салбаруудад ашиглагдаж буй худгууд бүрэн тоолууржаагүй, технологийн хэрэглээний усаа ашиглаж буй байдлын талаар тайлан мэдээллийг авах, нэгтгэх эзэнгүй, БОАЖЯ, УУЯ, ЭХЯ, Ашигт малтмалын газар зэрэг байгууллагууд ХСУХАТАТХ-ийн 17.13-д заасан үүргийн хэрэгжилтийг дүгнэдэггүй зэрэгтэй шууд холбоотой байна.

11. Иймээс МУ-ын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээнд дурдсан усны үр ашигтай хэрэглээ, дахин ашиглах технологийг дэмжиж, санхүүгийн урамшуулал нэвтрүүлэх, бүх уурхайд усны тоолуур ашиглуулдаг болгох /худаг тус бүрт/, усны хяналт шинжилгээнд иргэдийг оролцуулах зэрэг арга хэмжээ авах замаар дахин ашиглах усны хэмжээг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. .

Уул уурхайн салбарт технологийн хэрэглээний усыг дахин ашиглах асуудал хэдийгээр хангалтгүй, тодорхойгүй байгаа ч эрчим хүчний байгууллагуудаас харьцангуй дээр байна гэж үнэлж болох юм.

12. Эрчим хүчний салбар нь нийт усны хэрэглээний хамгийн өндөр хувийг буюу 25%-ийг дангаараа хэрэглэж, гүний усыг станцуудын цамхаг хөргөх, үнс зайлуулах, угаалга хийхийн ашигладаг буюу хамгийн өндөр усны хэрэглээтэй салбар юм.
13. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Байгаль орчны мэдээллийн төвөөс хөтөлдөг Мэдээллийн санд байршуулсан тооллогын мэдээллээс харахад УБ хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 4 ДЦС-д нийт 35 гүний худгийн сайн чанарын буюу унд, ахуйн хэрэглээнд хэрэглэж болох усыг нийслэл хотын ДЦС-ын дотоод хэрэгцээнд турбин цехийн техникийн усан хангамж, техникийн усаар хангах зорилгоор ашигладаг бол орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ДЦС-уудын мэдээлэл байхгүй байна.
14. Эрчим хүчний салбарт хэрэгжиж буй үйл ажиллагааны талаарх нарийн мэдээ, мэдээлэл олон нийтэд ил тод бус, олон нийтийн зүгээс мэдээлэл авах боломжтой эх сурвалжуудад цахилгааны үнэ тариф, тус салбарт оруулах хөрөнгө оруулалт зэрэг хэдэн ерөнхий сэдвээр мэдээлэл түгээгддэг бол ус ашиглалтын талаар албан ёсны мэдээлэл байршуулдаггүй нийтлэг дутагдал байна.
15. ХСУХАТАТХ-ийн 17.13-д заасан хэрэглээний усаа эргүүлэн ашиглахтай холбоотой харилцаа, хэмжээ, хязгаарыг нарийвчлан зохицуулсан дүрэм, журам боловсруулагдаагүй, хуулийн хэрэгжилтийг хариуцах байгууллага, нэгж тодорхойгүй, хуулийн хэрэгжилтийн талаар тайлан мэдээ авдаггүй байдал нь мөн адил эрчим хүчний байгууллагуудын дахин ашигласан усны талаар нэгдсэн тоо, статистик байхгүй, энэ чиглэлээр ямар ахиц гарсныг тодорхойлох боломжгүй байдалд хүргэсэн байна.

Зөвлөмж

1. ХСУХАТАТХ-ийн 17.13-ын “Уул уурхай, эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглана” гэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглахтай холбоотой харилцаа, хэмжээ,

- хязгаарыг нарийвчлан зохицуулсан болон хэрэгжилтийн тайлан мэдээ гаргах жишиг баримт зэрэгт холбогдох дүрэм, журмыг боловсруулах,
2. Уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүдийн БОНМТ болон ус ашиглалтын тайланд технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашигласан талаар тусгадаг байх, өмнөх онтой харьцуулан дүгнэдэг байх,
 3. Уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүдийн технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглаж буй байдалд хяналт, шалгалт хийх байгууллага, олон нийтийн оролцоог тодорхойлох
 4. Уул уурхай, эрчим хүчний төдийгүй хүнд үйлдвэрүүдийн хувьд хэрэглээний усаа эргүүлэн ашиглахтай холбоотой улсын хэмжээнд нэгдсэн тоо, статистик гаргадаг байх, улмаар энэ чиглэлээр ямар ахиц гарсныг тодорхойлох шалгуурт үзүүлэлттэй байх,
 5. Технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглаж буй хувь хэмжээнээс хамааран татварын болон бусад хөнгөлөлт, урамшууллын тогтолцоог бий болгох замаар энэхүү үйл ажиллагааг хөхиүлэн дэмждэг тогтолцоог бий болгох.
 6. Хүн амыг унд, ахуйн хэрэглээний усаар хангах, хэрэглээнээс гарах бохир усыг татан зайлуулах байрилга байгууламжийн өмчлөл, ашиглалт, үйлчилгээнд үүсэх харилцааг зохицуулах үндсэн зорилготой энэ хуульд уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүдийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглахтай холбоотой зохицуулалт байх нь оновчтой эсэхийг судлах.

19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалтын хэрэгжилт

Хүснэгт № 12 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн томьёолол
5	19 дүгээр зүйл.Барилга байгууламж,шугам сүлжээний өмчлөл	19.1.Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байна.	Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байснаар түүний засвар, үйлчилгээ, хэвийн ажиллагаа баталгаатай, тасралтгүй болно.
		19.2.Энэ хуулийн 19.1-д заасан барилга байгууламж, шугам сүлжээ, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг зохих тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж болно.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд төрөөс хувийн хэвшилтэй дэд бүтцийн салбарын түншлэл, түүн дотроо усан хангамж, ариутгах татуургаын дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

Судалсан байдал

ХСУХАТАтХ-ийн 19 дүгээр зүйлд зааснаар Хот, суурины 1/ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, 2/цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, 3/цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байх бөгөөд

эдгээр барилга байгууламж, шугам сүлжээ, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг зохих тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж болно гэж заасан. Үүнээс харахад УХАТ-ын барилга байгууламж бүхэлдээ төрийн болон орон нутгийн өмчид байхаар байна. Гэтэл амьдралд хэрэгжихдээ тухайлбал, бие даасан ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ бүхий орон сууцны хотхон, хороолол баригдсан, үйлдвэр, ААН-үүд өөрийн бага оврын цэвэрлэх байгууламжийг ашиглах тохиолдол гарч байна.

Ялангуяа магистрал шугам сүлжээнээс салаалсан УХАТ-ын салбар шугам сүлжээний хувьд иргэн, ААН, орон сууцны контор, СӨХ-ийн эзэмшил, өмчлөлийн асуудал хөндөгдөж байна.

Шигтгээ:

ОСНААҮГ-ын харьяа конторууд үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэл үүсгэдэг хэд хэдэн асуудал байдаг. Тухайлбал УХАТ-ын шугам сүлжээ сууц өмчлөгч, СӨХ гээд хэд хэдэн газрын өмчлөл, эзэмшилд байдаг. Шугам сүлжээнд гарсан эвдрэл гэмтлийг засах, шаардлагатай ажиллагааг хийхэд эдгээрээс зөвшөөрөл авах хэрэг гардаг, зарим тохиолдолд хамтарч ажиллахгүй байх явдал бий, ялангуяа тоолууртай холбоотой асуудал дээр. Тэр бүү хэл СӨХ манай конторуудаас дундын эзэмшлийн шугам, сүлжээ ашигласан учраас СӨХ-д төлбөр төл гэж шаарддаг, бас хуучирсан болон шаардлага хангахгүй шугам сүлжээг засах, солих шаардлагыг хүлээж авахгүй байх, төлбөр тооцоогоо барагдуулахгүй байх зэрэг асуудал нь инженерийн шугам, сүлжээний өмчлөлийн асуудлыг шийдвэрлэх шаардлагыг бий болгож байна.

Ерөнхийдөө хувийн орон сууцны конторууд шинээр ашиглалтад орсон барилгын цэвэр, бохир усны шугам, сүлжээг хариуцдаг, хуучныг бол тоодоггүй. Харин хуучны орон сууцыг алдагдлыг нь хүлээгээд орон нутгийн өмчит ОСК-ууд хариуцдаг. Нийслэлд 20 гаруй хуучны барилга СӨХ-гүй, ОСК-д харьяалахгүй байдаг, нэг идэвхтэй оршин суугч нь энэ 2 байгууллагын ажлыг хийгээд явж байх жишээтэй. Ингээд харахад ус хангамжийн шугам, сүлжээ хуучраад, алдагдал ихсээд, их засвар дөхөөд ирэхээр эзэнгүйдэх эрсдэл ихтэй гэж харагддаг. Тиймээс эртхэн орон нутгийн эсхүл төрийн өмчид авч, шугам сүлжээний элэгдэл хорогдол, их засвар хийх хугацаа, хөрөнгийг тооцож байхгүй бол нэг л өдөр том асуудал үүснэ.

УБ хотын ОСНААҮГ-ын мэргэжилтнүүдтэй хийсэн хэлэлцүүлэг, уулзалтаас

2003 онд батлагдсан Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай¹⁵⁴ хуулиар ус, дулаан хангамжийн нэгдсэн системийг хэсэгчлэн хувааж, олон эзэнтэй болгосноос сууц өмчлөгчид инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг дур мэдэн өөрчлөх асуудал хяналтгүй болж, нэгдсэн горим тохируулга хийх боломжгүй болсноос хангагч байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа алдагдах, хэрэглэгчдийг найдвартай ус, дулаанаар хангахад сөргөөр нөлөөлж байна. Мөн тус хуулийн 15.6-д “сууц өмчлөгчид нь орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийг дундаа хамтран өмчлөх, орон сууцны байшингийн дэвсгэр болон орчны газрыг эзэмших, ашиглах эрхээ хэрэгжүүлэхдээ инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар, үйлчилгээ эрхэлж буй мэргэжлийн байгууллагад саад учруулахыг хориглоно” гэж заасан байтал энэ заалт одоог хүртэл зөрчигдсөөр байгаа нь нийслэлийн ОСНААҮГ-ын албан

¹⁵⁴ Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль 2003 он.

хаагчидтай хийсэн уулзалт, хэлэлцүүлгээс харагдаж байлаа. Тухайлбал, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөөх газарт ирүүлсэн нийт гомдлын 37%-ийн СӨХ, ус, дулаан, цахилгаан зэрэг нийтийн үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдол эзэлдэг байна.¹⁵⁵

СӨХ-д хамаарах асуудлаар шүүхэд хандах тохиолдол цөөнгүй гардаг бөгөөд Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийг хэрэглэж байгаа шүүхийн практикийн тухайд Монгол Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимаас 2011 онд зөвлөмж гаргасан байдаг.¹⁵⁶ Уг зөвлөмжид “СӨХ нь хуулийн этгээдийн эрхгүй бөгөөд орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгө болон орчны газрын ашиглалтын хэвийн байдлыг хангах, хамгаалах, оршин суугчдад үйлчлэх тэдний ая тухтай байдлыг хангах, үйлчлэх үүрэгтэйн хувьд нэлээд хязгаарлагдмал эрх, үүрэгтэйгээр ажиллана. Тухайлбал: Хуулийн 3 дугаар зүйлийн “өмчлөх” гэсэн ойлголт нь Иргэний хуулийн 142¹⁵⁷, 146¹⁵⁸, 148¹⁵⁹ дугаар зүйл болон бусад заалтуудаар, “эзэмших” гэсэн ойлголт нь мөн хуулийн 89-97 дугаар зүйлд зааснаар, “ашиглах” гэсэн ойлголт нь Барилгын тухай хуулийн 20¹⁶⁰, Газрын тухай хуулийн 441 дүгээр зүйлд зааснаар тус тус зохицуулагдахын дээр Газрын тухай хуулийн 441 дүгээр зүйлд зааснаас бусад газар эзэмших, ашиглахтай холбоотой заалтууд СӨХ-д хамаарч үйлчлэхгүй. ... СӨХ дундын өмчлөлийн эд хөрөнгийг бүртгэнэ, бүртгүүлнэ гэдэг нь өмчлөгч, эзэмшигч өөрийн хөрөнгө, өмчийн зүйлийг эрх бүхий байгууллагад бүртгүүлнэ гэсэн ойлголтоос өөр ойлголт юм. Сууцны байшин болон ямар хэмжээтэй, юунд зориулагдсан хичнээн тооны, ямар үнэлгээтэй хөрөнгө СӨХ-ны хамгаалалтанд байна вэ гэдгийг харуулах, улсын нэгдсэн тоо бүртгэлд зориулагдсан тооцоо судалгааг СӨХ-ны хөрөнгийн бүртгэл гэж үзэх нь зүйтэй. ... Гэтэл зарим СӨХ-ны гүйцэтгэх захирал дундын өмчлөлийн эд хөрөнгө, орчны газрыг эзэмшдэг мэтээр ойлгож ... байгаа нь хууль бус юм. Өөрөөр хэлбэл өөрийн холбооныхоо гишүүн төдийгүй сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч буюу үйлчлүүлэгчийнхээ эсрэг эрх хэмжээгээ хэтрүүлж байгаа үйлдэл гэж үзэхээр байна.” гэжээ. Үүнээс харахад СӨХ нь оршин суугчдын дундын өмчлөлийн эд хөрөнгийн ашиглалтын хэвийн байдлыг хангах, хамгаалах үүрэгтэй бөгөөд дундын өмчлөлийн эд хөрөнгө, орчны газрыг

¹⁵⁵ ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах газрын дарга Ц.Лхагвасүрэнгийн илтгэлээс. 2018.10.10

¹⁵⁶ МУ-ын Дээд шүүхийн 2011 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн №1 зөвлөмж. Эх сурвалж: <http://www.supremecourt.mn/act/4>

¹⁵⁷ Иргэний хуулийн 142 дугаар зүйл. Нийтийн зориулалттай орон сууц өмчлөх

¹⁵⁸ 146 дугаар зүйл. Орон сууцны дангаар өмчлөх болон дундын өмчлөлийн зүйл

¹⁵⁹ 148 дугаар зүйл. Орон сууц өмчлөгчийн эрх, үүрэг

¹⁶⁰ Барилгын тухай хууль. 2008 он. 20 дугаар зүйл. Барилга байгууламжийг ашиглах

20.1.Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь барилга байгууламжийг ус, агаар, хөрсний бохирдлоос сэргийлэх, хот байгуулалт, ашиглалтын дүрмийн шаардлагын дагуу ашиглана.

20.2.Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учруулах, зохих мэргэжлийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүтээц, төлөвлөлт, зориулалтыг өөрчлөх, тухайн барилга байгууламж дотор байгаль орчин, хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж ашиглалтын хэвийн нөхцөлийг алдагдуулж болзошгүй үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

20.3.Өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь ашиглалтын дүрэмд заасан хугацаанд барилга байгууламжид үзлэг, шалгалт явуулж, илэрсэн зөрчлийг арилгах, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэх зэрэг арга хэмжээ авч, ашиглалтын хэвийн нөхцөл, аюулгүй байдлыг хангуулж ажиллана.

20.4.Ашиглалтын явцад барилга байгууламжид эвдрэл, гэмтэл учрах, нурах тохиолдолд гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч, өмчлөгч, эзэмшигч, ашиглагч, материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн хэн буруутай нь хариуцлага хүлээнэ.

эзэмших эрхгүй, харин орон сууц өмчлөгч нь сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн өмчлөгч, эзэмшигч байх юм.

СӨХ-д холбогдох асуудалтай нэгэн адил яригдах зүйл бол хувийн хэвшлийн ОСК-уудын өмчлөл, эзэмшилд байх УХАТ-ын шугам, сүлжээ юм. Хэдийгээр орон сууцны барилга захиалагч байгууллага тухайн ОСК-д эрх шилжүүлэн өгснөөр эзэмших, өмчлөх эрх үүсч байгаа боловч бодит байдлын мөн чанарыг харвал тухайн орон сууц баригдахад шаардагдсан нийт хөрөнгө оруулалтын зардал орон сууцыг борлуулж буй үнэд шингэсэн байдгийг харгалзан үзэж шаардлагатай юм. Харин дан ганц шугам, сүлжээ барих хөрөнгө оруулалт хийсэн тохиолдлыг ялгаж үзэх шаардлагатай юм.

Үүнээс харахад орон сууцны хотхон, хорооллын ус хангамжийн шугам, сүлжээ нь тухайн хороололд оршин суугаа иргэдийн дундын өмч болох бөгөөд ОСК-т СӨХ-ийн нэгэн адил ашиглалтын хэвийн байдлыг хангах, хамгаалах асуудал хамаарахаар харагдаж байна.

Кейс: “Б.Д” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргад холбогдох захиргааны хэргийн тухай УДШ-ийн тогтоолоос¹⁶¹

Нэхэмжлэгч “Б.д” ХХК-ийн хувьд “М.И” ХХК-ийн барьж ашиглалтад оруулсан Ивээл хотхоны 41 а, б, в байрны нийт 243 айлын цэвэр бохир ус хангамж болон гадна инженерийн шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээг хариуцахаар тус компанитай“Хамтран ажиллах гэрээ” байгуулан ажиллаж байжээ гэжээ. Давж заалдах шатны шүүх хэрэгт авагдсан “Б.Д” ХХК болон “М.И” ХХК-ийн хооронд ... “Ивээл” хотхоны 41а, 41б, 41в байрны инженерийн шугам сүлжээ, хоолойн гадна, дотор шугам, узелийн тоног төхөөрөмжийг “Б.д” ХХК-д шилжүүлэх” зорилгоор “Орон сууцны ашиглалтыг шилжүүлэх гэрээ”, 2016 оны 5 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан “Хамтран ажиллах гэрээ” зэрэг 2 гэрээг, Хэрэгт авагдсан бичгийн баримтаар “М.И” ХХК болон нэхэмжлэгч компанийн хооронд 2015 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр байгуулагдсан “Орон сууцны ашиглалтыг шилжүүлэх гэрээ”-ний 1.2-д “М.И” ХХК нь орон сууцны барилгын ил далд инженерийн шугам, засварын ажлыг барилгын баталгаат 3 жилийн хугацаанд бүрэн хариуцан ажиллана гэсэн үүрэг хүлээсэн, барилгын баталгаат хугацаа 2018 оны 4 дүгээр сарын 28-ны өдөр дуусахаар гэрээнд заасан байдаг. ...

б. Нийтийн орон сууцны инженерийн байгууламж болох цэвэр, бохир усны шугам сүлжээ, холбогдох байгууламжийг нэхэмжлэгч болон гуравдагч этгээдийн аль нь байхаас үл хамаарах үндсэн хөрөнгийн балансад бүртгэсэн ч гэсэн энэ нь захиран зарцуулах эрхтэйгээр өмчлөх үр дагаврыг бий болгохгүй, өөрөөр хэлбэл уг байгууламжийг ашиглаж орон сууцны айл өрхөд үйлчилгээ үзүүлэх, улмаар түүний засвар үйлчилгээг хариуцан эрхэлж буй Зохицуулах зөвлөлөөс олгосон тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь үйл ажиллагаа эрхлэн явуулах зорилгоор уг байгууламжийн ашиглалтыг хариуцахаар байна.

Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын 2018 оны 10 сарын 18-ны шүүх хуралдааны тогтоолоос харахад нийтийн орон сууцны инженерийн байгууламж болох цэвэр, бохир усны шугам сүлжээ, холбогдох байгууламжийг нэхэмжлэгч болон гуравдагч этгээдийн аль нь байхаас үл хамаарах үндсэн хөрөнгийн балансад бүртгэсэн ч гэсэн энэ нь захиран зарцуулах эрхтэйгээр өмчлөх үр дагаврыг бий болгохгүй, өөрөөр хэлбэл уг байгууламжийг ашиглаж орон сууцны айл өрхөд үйлчилгээ үзүүлэх, улмаар түүний засвар үйлчилгээг хариуцан эрхэлж буй Зохицуулах зөвлөлөөс олгосон тусгай зөвшөөрөл бүхий этгээд нь үйл ажиллагаа эрхлэн явуулах зорилгоор уг байгууламжийн ашиглалтыг хариуцахаар байна. Үүнээс харахад тухайн орон сууцны инженерийн байгууламж болох цэвэр, бохир усны шугам сүлжээ, холбогдох байгууламжийн

¹⁶¹ Улсын Дээд шүүхийн цахим хуудас: <http://www.supremecourt.mn/zahirгаа/view?id=1526>

өмчлөгчид буюу орон сууцны оршин суугчдын саналд үндэслэн эдгийг орон нутгийн өмчид шилжүүлэх боломжийг судлах боломжтой юм.

Хүснэгт № 13 УХАТ-ын шугам сүлжээний өмчлөлийн хэлбэр, хэмжээ 2018 он.

№	Орон нутгийн харъяалал	Өмчлөлийн хэлбэр	Шугам, сүлжээ	Шугамын урт /км/		Нийт урт /км/
1	Улаанбаатар хот	Хувийн хэвшлийн ОСАБ	Бохир усны шугам, сүлжээ	534		817
2		Нийслэлийн өмчит ОСАБ		136		
3		УСУГ		147		
4	Улаанбаатар хот	Хувийн хэвшлийн ОСАБ	Цэвэр усны шугам, сүлжээ	220		1068
5		Нийслэлийн өмчит ОСАБ		288		
6		УСУГ		560		
7	Аймаг, орон нутаг		Бохир усны шугам, сүлжээ	382		382
8			Цэвэр усны шугам, сүлжээ	Эх үүсвэр	500	1482
9				Дамжуулах	578	
10				Түгээх	402	

ХСУХАТАУ33-өөс гаргасан орон сууц ашиглалтын байгууллагуудын шугам, сүлжээний мэдээллээс харахад УХАТ-ын шугам сүлжээний өмчлөлийн асуудал аймаг, орон нутагт ХСУХАТАТХ-ийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжиж 100% орон нутгийн өмчид байна. Харин эл асуудал УБ хотод хуулийн зохицуулалтаас хальсан шинжтэй болжээ. Тухайлбал, УБ хотод 817 км бохир усны шугам, сүлжээ байгаагаас 534 км буюу 65,6% нь цэвэр усны шугам, сүлжээ 1068 км байгаагаас 220 км буюу 20,5% нь хувийн хэвшлийн өмчид байна.

Хуулийн 19.1-д заасан “Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байна” гэх зохицуулалтаас гадуур хувийн хэвшлийн өмчит шугам, сүлжээ бий болох эрх зүйн үндэслэл нь 2008 оны Барилгын тухай хуульд барилгын чанарын баталгаат хугацааг 3 жил байхаар тогтоож өгснөөс үүдэлтэй гэж үзэж болохоор байна. Барилгын захиалагч, гүйцэтгэгч компаниуд барилгын чанарын баталгаат хугацаандаа тухайн барилгын инженерийн дэд бүтцийн асуудлыг хариуцах шаардлагад нийцүүлэн ашиглалт, үйлчилгээг хариуцсан хувийн хэвшлийн орон сууцны конторуудыг байгуулж, УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг хариуцуулдаг, хожим нь тухайн ААН-д эдгээр шугам, сүлжээний эзэмших, өмчлөх эрхийг шилжүүлдэг зэрэг нь хувийн өмчийн хэлбэрийг бий болгоход нөлөөлжээ.

Мөн 2016 оны Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 14.3 дугаар хэсэгт тусгайлан барилга байгууламжийг ашиглалтын гэрчилгээ авсны дараа ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа буюу барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтэц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын нөхцөлийг

бүрдүүлэх 1 жилийн хугацаа олгосон байна. Мөн энэхүү хугацаа нь дуусгавар болсноос хойш дээр дурдсан нөхцөлийн хэвийн ашиглалтын хугацаа нь 3-аас доошгүй жил байхаар тусгажээ. Энэ хугацаанд гарсан зөрчлийг захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч, материал ханган нийлүүлэгч, эзэмшигчийн аль буруутай этгээд арилгаж, хохирлыг барагдуулахаар зохицуулж өгсөн нь “цэвэр, бохир усны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын нөхцөлийг” наад зах нь 4 жил хариуцахаар зохицуулжээ. Хэрэв барилгын захиалагч тухайн шугам, сүлжээг сайн дураараа төр, орон нутгийн өмчид шилжүүлэхгүй тохиолдолд шинээр баригдсан барилга байгууламжийн УХАТ-ын шугам, сүлжээний ашиглалт, үйлчилгээг хувийн хэвшил хариуцах боломжийг эдгээр зохицуулалттай холбон ойлгож болохоор байна.

Кейс. Хувийн орон сууцанд байгаа дундын өмчлөлийн өмч хөрөнгийг засварлах, ашиглах боломж бололцоо нээгдэнэ¹⁶²

Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/914 дүгээр захирамжаар байгуулагдсан Хувийн хэвшлийн хөрөнгөөр барьж ашиглалтад оруулсан орон сууцны барилгын нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжин ирж байгаа нийтийн эзэмшлийн эд хөрөнгө (инженерийн байгууламж)-ийн чанар, өмчлөлтэй холбогдох асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий байнгын Хотын Ерөнхий менежерээр ахлуулсан ажлын хэсгийн хурлаар 2016, 2017 онуудад шинээр ашиглалтад орсон 1,9 тэрбум төгрөгийн өртөг бүхий 39 орон сууцны инженерийн шугам сүлжээг нийслэлийн өмчид бүртгэх тухай саналыг авч хэлэлцлээ¹⁶³.

Өнөөдрийн байдлаар дахин үнэлгээнд хамрагдаагүй 491 орон сууцны инженерийн шугам сүлжээ байна. Эдгээрээс 39 орон сууц нь 2016-2017 онд ашиглалтад орсон буюу шинэ гэж үзэж байгаа тул тус тооллого дахин үнэлгээнд хамрагдахгүйгээр шууд бүртгүүлэх саналыг НИТХ-ын тэргүүлэгчдийн хуралдаанд өргөн барихаар шийдвэрлэв.

Цаашид үлдсэн бүх орон сууцнуудын шугам сүлжээг үе шаттайгаар хэсэгчлэн хамруулахаар төлөвлөж байна. Бүртгэж авснаар орон сууцанд байгаа дундын өмчлөлийн өмч хөрөнгийг засварлах, ашиглах боломж бололцоо нээгдэж өмч хөрөнгө эзэнжих юм.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны мэдээлэл

Дээрх жишээнээс харахад Нийслэлийн зүгээс орон сууцны инженерийн шугам, сүлжээг нийслэлийн өмчид бүртгэх асуудлыг хүндрүүлдэггүй, харин ч орон сууцнуудын шугам сүлжээг нийслэлийн өмчид бүртгэж авснаар орон сууцанд байгаа дундын өмчлөлийн өмч хөрөнгийг засварлах, ашиглах боломж бололцоог нээх, улмаар нийтийн эзэмшлийн өмч хөрөнгө эзэмших нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажилладаг болох нь харагдаж байна. Орон сууцны инженерийн шугам, сүлжээг сүлжээг нийслэлийн өмчид бүртгэх асуудлыг НИТХ-ын 2014 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчид үнэ төлбөргүйгээр шилжин ирж буй нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авах тухай журам”-ын дагуу хэрэгжүүлдэг.

Гэхдээ Нийслэлийн өмчийн харилцааны газраас¹⁶⁴ нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлж авах ажиллагаа нь хувийн хөрөнгөөр

¹⁶² Хувийн орон сууцанд байгаа дундын өмчлөлийн өмч хөрөнгийг засварлах, ашиглах боломж бололцоо нээгдэнэ 2018.09.07. Эх сурвалж: <https://news.mn/r/1999400/>


¹⁶³ Засгийн газраас 2018 онд Тооллого дахин үнэлгээ хийх тогтоол гарсны дагуу дундын өмчлөлийн өмч хөрөнгөд бүртгэгдээгүй орон сууцыг бүртгэлжүүлэхээр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Сангийн яам хамтран Төрийн өмчийг тооллого дахин үнэлгээний аргачлалыг боловсруулж байна.

¹⁶⁴ Нийслэлийн өмчид үнэ төлбөргүйгээр шилжин ирж буй нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авах тухай журам 2014 он. Эх сурвалж: <http://umch.ub.gov.mn/index.php/featured-item/2017-04-08-15-38-37/289-2017-08-29-05-13-05>

барьсан орон сууцны барилгын түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлэх иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтэд үндэслэдэг бөгөөд нийт 14 төрлийн баримт бичиг¹⁶⁵ бүрдүүлэх шаардлага тавьдаг.

Үүнээс харахад бүрдүүлэх материалын жагсаалтын 9-т дурдсан авлага, өглөггүй тухай тооцоо нийлсэн акт болон 14-т дурдсан элэгдлийн зардлыг буюу нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлж байгаа эд хөрөнгийн ашиглалтад орсон үеэс байгуулсан хуримтлагдсан элэгдлийн зардалыг төлөх асуудал нь хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдаж, ашиглалтад орсон барилга байгууламжийн УХАТ-ын инженерийн шугам, сүлжээг орон нутгийн өмчид үнэгүй шилжүүлэх хүсэлт гаргахгүй байх шалтгаан нөхцөл болж байх талтай. Учир нь УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ хариуцдаг ОСК-уудын орлого, зарлагын баланс алдагдаж ихэнх нь алдагдалтай ажилладаг, үндсэн хөрөнгө, хуримтлал муутайгаас үүдэн элэгдэл, хорогдлын хуримтал үүсгэдэггүй, түүнийгээ бусад зардалдаа зарцуулдаг нийтлэг төрх ажиглагддаг.

Энэ салбарын өр төлбөрийн хэмжээ¹⁶⁶ жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа нь нийслэлийн өмчид төлбөргүй шилжүүлэх нөхцөлийг хангах шугам сүлжээний тоо цөөрөх, хожим хувийн хэвшлийн өмчлөл, эзэмшилд байгаа УХАТ-ын инженерийн



шугам, сүлжээний ашиглалтын хугацаа дуусах, эвдрэл, гэмтэл гарах үед санхүүжилтийг төр, орон нутгийн төсвөөс гаргахаас өөр гарцгүй болох эрсдэлийг бий болгох магадлалтай.

¹⁶⁵ Үүнд. 1/ Иргэн бол тоног төхөөрөмж, шугам сүлжээ, ус дулаан дамжуулах төвийг үнэ төлбөргүй шилжүүлэх тухай өргөдөл, Аж ахуйн нэгж, байгууллага бол тоног төхөөрөмж, шугам сүлжээ, ус дулаан дамжуулах төвийг үнэ төлбөргүй шилжүүлэх тухай албан хүсэлт, 2/ Барилга байгууламж, тоног төхөөрөмж, шугам сүлжээг ашиглалтанд хүлээж авсан комиссын акт, 3/ Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн угсралтын ажлын гүйцэтгэлийн зураг, схем, 4/ Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн угсралтын ажлын гүйцэтгэлийн төсөв, 5/ Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн угсралтын ажлын ил, далд ажлын акт, 6/ Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн өмчлөлийн заагийг тогтоосон зураг, 7/ Ус, дулаан, цахилгаанаар хангах техникийн нөхцөл олгосон зөвшөөрөл, 6/ Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг үйлдвэрлэсэн газар техникийн үзүүлэлт, материалын сертификат зэрэг стандартын шаардлагыг хангасан болохыг тодорхойлсон баримт бичгүүд, 7/ Гадна цахилгааны шугам сүлжээний тоног төхөөрөмжийг УБЦТС ТӨХК-д хүлээлгэж өгсөн тухай акт, 8/ Цахилгааны нөөц, тэжээлтэй холбоотой баримт бичиг, 9/ Оршин суугчид болон эзэмшигч байгууллагууд ус, дулаан, цахилгаанаар хангагч байгууллагуудад авлага, өглөггүй тухай тооцоо нийлсэн акт албан бичиг, 10/ Өөрийн өмчлөлийн эд хөрөнгийг нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлэх тухай нийт оршин суугч иргэд, аж ахуйн нэгж байгууллагын хүсэлт, зөвшөөрөл, 11/ Тухайн нутаг дэвсгэрийн ашиглалт хариуцсан мэргэжлийн байгууллагын нийтийн эзэмшлийн эд хөрөнгийн ашиглалтыг хариуцахыг зөвшөөрсөн албан бичиг, 12/ Авто зам, замын байгууламжийг нийслэлийн авто замын газрын мэдээллийн санд оруулсан тухай тодорхойлолт, 13/ Тухайн нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, барилга байгууламжийн техник ашиглалтын түвшинг тогтоосон дүгнэлт, 14/ Нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлж байгаа эд хөрөнгийн ашиглалтад орсон үеэс байгуулсан хуримтлагдсан элэгдлийн зардал багтаж байна.

¹⁶⁶ ХСУХАТАУЗЗ-ийн мэдээллээс

ХСУХАТАҮЗЗ-өөс гаргаж буй тооцоо судалгаанд хувийн хэвшлийн өмчийн УХАТ-ын шугам, сүлжээ гэх нэгдсэн нэр томъёо ашиглаж байгаа нь тодорхой тоо статистик гаргах, үнэлгээ, шинжилгээ хийхэд хангалтгүй байна. Иймээс хувийн хэвшлийн өмчлөл, эзэмшилд байгаа шугам, сүлжээг орон сууцны хороолол барихад зайлшгүй шаардлагатай шугам, сүлжээ, эсхүл зөвхөн хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай шугам сүлжээ гэх зэргээр ангилах нь зүйтэй гэж үзлээ. Ийнхүү нарийвчлан ангилах нь дээр дурдсан дундын өмчийн шугам, сүлжээнд хамаарах эсэхийг тогтоох, шугам сүлжээний жинхэнэ эзэмшигч, өмчлөгчийг тогтоох, эрх, үүрэг, хариуцлага хүлээх, эрсдэл үүрэх зэрэгт чухал ач холбогдолтой юм. Учир нь инженерийн шугам, сүлжээний өмчлөгч, эзэмшигч нь хувийн хэвшлийн ААН байх тохиолдолд УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолоор баталсан Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээний асуудал эсэхийг анхаарах шаардлага үүсэх юм.

Төр, хувийн хэвшлийн түншлэл /цаашид ТХХТ гэх/¹⁶⁷-ийн гэрээнд төрийн хийх ёстой нийтийн зориулалттай ажил үйлчилгээг төрийн ба хувийн хэвшлийн ААН хамтарч хийхээр тэдгээрийн хооронд байгуулдаг удаан хугацааны гэрээг ойлгодог. Гэрээний гол асуудал нь төр, хувийн хэвшлийн хамтарч хийх ажиллагаа нь төрийн хийх ажил байх явдал юм.¹⁶⁸

Монгол Улсад ТХХТ-ийг хөгжүүлэх эрх зүйн үндэс нь ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлого болон Концессийн тухай хууль¹⁶⁹ юм. ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлого нь концессээ бодвол төр ба хувийн хэвшлийн хамтарч ажиллаж болох илүү өргөн хүрээг хамардгаараа, мөн санхүү, хөрөнгө оруулалтын тал дээр ч харьцангуй уян хатан байдгаараа концессоос давуу талтай: ТХХТ-ийн гэрээ дуусгавар болоход төслийн эд хөрөнгө нь гэрээнд заасан нөхцөл шаардлагын дагуу төрийн мэдэлд шилжинэ. Хувийн компани, Засгийн газрын хооронд байгуулах гэрээ нь ТХХТ-ийн гэрээ хэлэлцээрийн үндэс боловч хэрэгжүүлэхийн тулд тухайлбал, хувийн компани ажил үйлчилгээг хэрэглэгчдэд шууд хүргэж байгаа бол хэрэглэгчдэд үйлчлэх тухай гэрээг нэмж байгуулж болдог. ТХХТ-ийг тодорхойлох хамгийн энгийн үндсэн шинжүүд нь: 1/төрийн байгууллага болон хувийн хэвшлийн ААН-ийн хооронд байгуулах урт хугацааны гэрээгээр хувийн хэвшил нийгмийн тухайн суурь үйлчилгээг үзүүлэх эсвэл энэхүү үйлчилгээний тодорхой хэсгийг үзүүлэхэд хувь нэмэр оруулна, 2/ Хувийн компани үзүүлсэн үйлчилгээний төлбөрөө төслийн орлогоор нөхнө. Орлогын эх үүсвэр нь улс, орон нутгийн төсвөөс, эсвэл хэрэглэгчийн тарифаас санхүүжсэн эсвэл хосолсон хэлбэртэй байж болох бөгөөд орлогын хэмжээ нь үзүүлсэн үйлчилгээний чанар ба хэмжээнээс хамаардаг. Тиймээс ТХХТ-ийн гэрээгээр эрсдэлийг, үүний дотор эрэлтийн болон үйлчилгээний боломжит байдлын эрсдэлийг төрөөс хувийн хэвшилд шилжүүлдэг. Ингэснээр хувийн хэвшил илүү их орлого олохын тулд өмнө нь төрийн үзүүлж байсан үйлчилгээний тоо хэмжээ, чанар, нь илүү сайн болох бололцоо олгодгоороо давуу талтай. ТХХТ-ийн талаар төрөөс баримтлах бодлогод зааснаар ТХХТ-ийг нийгмийн салбарын түншлэл, дэд бүтцийн салбарын түншлэл, төрийн тодорхой чиг

¹⁶⁷ Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлага 2013 он. Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газар Эдийн засгийн хөгжлийн яам <http://nda.gov.mn/backend/f/lZA0kdjzwF.pdf>

¹⁶⁸ <http://nda.gov.mn/backend/f/lZA0kdjzwF.pdf>

¹⁶⁹ Концессийн тухай хууль. 2010 он. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/312?lawid=312>

үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх түншлэл, үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх түншлэл болон байгаль орчны салбарын түншлэл гэсэн хэлбэртэй байх бөгөөд Дэд бүтцийн салбарын түншлэлийн хүрээнд орон сууц, ус хангамж, ариутгах татуургын түншлэл хамаарахаар тусгасан байдаг.¹⁷⁰

Судалгаанаас харахад өнөөдөр НАА салбарт УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ эрхлэх ТЗ эзэмшигч хувийн хэвшлийн ААН-үүдийн хэдэн хувь нь дээрх ТХХТ-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхойгүй байна.

Үнэлсэн байдал

ХСУХАТАТХ-ийн 19.1-д заасан “Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байна.”, мөн 19.2-т заасан “Энэ хуулийн 19.1-д заасан барилга байгууламж, шугам сүлжээ, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг зохих тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж болно.” заалтууд ЗОРИЛГОДОО ХҮРЭХГҮЙ байна гэж үнэллээ.

Хуулийн зохицуулалтын зорилгыг Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байснаар түүний засвар, үйлчилгээ, хэвийн ажиллагаа баталгаатай, тасралтгүй байна. Эдгээр барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг хариуцах эрхийг зөвхөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хувийн хэвшилд шилжүүлнэ гэж тодорхойлсон болно.

Хуулийн зохицуулалт зорилгодоо хүрэхгүй байна гэж үнэлэхэд дараахь нөхцөл байдал үндэслэл болж өгсөн. Үүнд:

1. Хуульд зааснаар 1/ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, 2/цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, 3/цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байна гэж заасан. Үүнээс харахад УХАТ-ын барилга байгууламж бүхэлдээ буюу магистрал болон салбар шугам сүлжээ мөн адил төрийн болон орон нутгийн өмчид байхаар байна. Нийгмийн хөгжил, эрэлт, хэрэгцээ, зарим тохиолдолд хуулийн шаардлагаар даасан ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ бүхий орон сууцны хотхон, хороолол баригдсан, үйлдвэр, ААН-үүд өөрийн бага оврын цэвэрлэх байгууламжийг ашигладаг болсон нь ялангуяа магистрал шугам сүлжээнээс салаалсан УХАТ-ын салбар шугам сүлжээ нь иргэн, ААН, орон сууцны контор, СӨХ-ийн эзэмшил, өмчлөлд байхад нөлөөлжээ.
2. 2018 оны байдлаар ХСУХАТАУЗЗ-өөс гаргасан орон сууц ашиглалтын байгууллагуудын шугам, сүлжээний мэдээллээс харахад УХАТ-ын шугам сүлжээний өмчлөлийн асуудал аймаг, орон нутагт ХСУХАТАТХ-ийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжиж 100% орон нутгийн өмчид байгаа бол УБ хотод бохир усны шугам, сүлжээний 65,6%, цэвэр усны шугам, сүлжээний 20,5% нь хувийн хэвшлийн өмчид

¹⁷⁰Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого. УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолын хавсралт. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/annex/details/3312?lawid=6653>

байна. Үүнээс харахад хотжилтын нөлөөгөөр буюу хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрөл нэмэгдэх тусам УХАТ-ын барилга байгууламжийн өмчлөл, эзэмшлийн асуудал хурцаар хөндөгдөх, хувийн хэвшлийг оролцоо өсөх хандлагатай байна.

3. Хэдийгээр ХСУХАТАтХ-ийн 19.1-д “Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байна” гэж тодорхой хуульчилж өгсөн боловч 2003 онд батлагдсан Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай¹⁷¹ хуулиар ус, дулаан хангамжийн нэгдсэн системийг хэсэгчлэн хувааж, олон эзэнтэй болгосон, 2008 оны Барилгын тухай хуульд барилгын чанарын баталгаат хугацааг 3 жил байхаар тогтоож өгсөн нь хувийн хэвшлийн эзэмшил, өмчлөл бүхий УХАТ-ын барилга байгууламж бий болох орчинг бүрдүүлсэн бол НИТХ-ын 2014 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчид үнэ төлбөргүйгээр шилжин ирж буй нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авах тухай журам”-д хувийн хөрөнгөөр барьсан орон сууцны барилгын түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлэх иргэн, аж ахуйн нэгж нь хангагч байгууллагад авлага, өглөггүй байх, эд хөрөнгийн ашиглалтад орсон үеэс байгуулсан хуримтлагдсан элэгдлийн зардлыг төлөх зэрэг шаардлага тавьсан нь хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдаж, ашиглалтад орсон УХАТ-ын инженерийн шугам, сүлжээг орон нутгийн өмчид үнэгүй шилжүүлэх хүсэлт гаргахгүй байх шалтгаан нөхцөл болжээ гэж үзэж болохоор байна.
4. ХСУХАТАУ33-д үйл ажиллагааныхаа тайланг ирүүлсэн 104 байгууллагын дүнгээс харахад эдгээр байгууллагууд нийт үйл ажиллагаагаараа 269.7 тэрбум төгрөгийн орлого олж, 300 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан байна. Үүнээс харахад нийт дүнгээрээ 30,3 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн судалгаа гарсан нь энэ салбарын санхүү, эдийн засгийн чадамж сул, УХАТ-ын шугам, сүлжээний засвар, үйлчилгээг гүйцэтгэх хангалттай хөрөнгө, санхүүгийн нөөц хувийн хэвшлийн ОСК-уудад байхгүй болохыг харуулж байна. Энэ нь нийслэлээс тавьж буй шаардлагыг тэр бүр хангах боломжгүйг мөн адил харуулж байна.
5. УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ хариуцдаг хувийн хэвшлийн ТЗ бүхий ААН-үүдийн үйл ажиллагааны орлого, зарлагын баланс алдагдаж ихэнх нь алдагдалтай ажилладаг, үндсэн хөрөнгө, хуримтлал муутайгаас үүдэн элэгдэл, хорогдлын хуримтал үүсгэдэггүй, түүнийгээ бусад зардалдаа зарцуулдаг зэрэг нийтлэг дүр төрх нь энэ салбарын өр төлбөрийн хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэхэд нөлөөлдөг. Үүний улмаас нийслэлийн өмчид төлбөргүй шилжүүлэх нөхцөлийг хангах шугам сүлжээний тоо цөөрөх, хожим хувийн хэвшлийн өмчлөл, эзэмшилд байгаа УХАТ-ын инженерийн шугам, сүлжээний ашиглалтын хугацаа дуусах, эвдрэл, гэмтэл гарах үед санхүүжилтийг төр, орон нутгийн төсвөөс гаргах эрсдэлтэй байна.
6. ХСУХАТАтХ-ийн 19.2-т заасан барилга байгууламж, шугам сүлжээ, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг зохих ТЗ бүхий хуулийн этгээд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж болно гэж тодорхой зааж өгсөн. ХСУХАТАУ33-өөс гаргаж буй статистик, мэдээлэлд “хувийн өмчийн” гэх нэгдсэн нэр томъёо ашиглаж байгаа нь УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй ТЗ бүхий ААН-үүдийн хэд нь,

¹⁷¹ Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль 2003 он.

нийт УХАТ-ын барилга байгууламж, шугам сүлжээний хэдэн хувь нь ТХХТ-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, ашиглалт үйлчилгээ хариуцаж байгаад үнэлэлт, дүгнэлт хийх боломжгүй байдалд хүргэсэн нь ТХХТ-ийн хүрээнд хувийн хэвшлийн өмчлөл, ашиглалтад байгаа УХАТ-ын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг тусад нь бүртгэх, хөтлөх шаардлагыг тодорхойлж байна.

Зөвлөмж

1. ХСУХАТАТХ-ийн 19.1, 19.2 дахь заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах, УХАТ-ын барилга байгууламж, инженерийн шугам, сүлжээг төрийн болон орон нутгийн өмчид байлгахад анхаарах,
2. БХБЯ-ны зүгээс барьж буй “зөвхөн магистрал шугам, сүлжээ болон эх үүсвэрийн барилга байгууламж төрийн болон орон нутгийн өмчид байна” гэх бодлого, чиглэл нь энэ хуулийн “1/ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, 2/цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, 3/цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байна” гэх зохицуулалтын хүрээг хумьж, зөвхөн төв шугам сүлжээнд хамаатуулж, салбар шугам сүлжээг орхигдуулж байгаа нь алдаатай байна. Иймд энэ хуулийн заалтын зорилгод нийцсэн бодлого, үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.
3. УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ хариуцдаг ОСК-ууд УХАТ-ын барилга байгууламж, шугам, сүлжээний гамшиг, ослын улмаас үүсч болзошгүй засвар, үйлчилгээ, их засвар, ашиглалтын хугацаа дуусах тохиолдолд шугам, сүлжээг шинээр солих зэрэгт зориулсан хуримтлал үүсгэхгүй байгаа нь эрсдэлтэй байна. Иймээс хүн амыг стандартын шаардлагад нийцсэн унд, ахуйн хэрэглээний усаар тасралтгүй, баталгаатай хангах төрийн үүргийг хэрэгжүүлэх, ямарваа нэг тохиолдолд төр УХАТ-ын барилга байгууламж, шугам, сүлжээний засвар, үйлчилгээтэй холбоотой санхүүгийн дарамтад орохгүй байхын тулд хувийн хэвшлийн ААН-ийн эзэмшил, өмчлөлд байгаа УХАТ-ын барилга байгууламж, шугам, сүлжээг даатгалд хамруулах, эсхүл элэгдэл хорогдлын тусгай сантай болгох зэрэг асуудлыг судалж үзэх шаардлагатай.
4. ТХХТ болон концессын гэрээгээр баригдсанаас бусад шинээр баригдаж буй орон сууцны хороолол, хотхонуудын хэрэгцээнд зориулан барьж суурилуулсан УХАТ-ын барилга байгууламж, шугам, сүлжээний өртөг ихэнх тохиолдолд тухайн орон сууцыг борлуулах үнэд шингэсэн байдагтай холбогдуулан тухайн УХАТ-ын барилга байгууламж, шугам, сүлжээг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх асуудлыг орон сууц өмчлөгчдийн саналд үндэслэдэг байх нөхцөлийг бүрдүүлэх

23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын хэрэгжилт

Хүснэгт № 15 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
6	23 дугаар зүйлийн 23.1 дэх заалт Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	ХСУХАТАТХ-ийг зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэж байна уу?

Судалсан байдал

ХСУХАТАТХ-ийн 23 дугаар зүйлд хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаар “албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр, харин хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулахаар тусгасан байна.

Төрийн албан хаагчид хариуцлага хүлээлгэх

Захиргааны ерөнхий хуулийн¹⁷² /цаашид ЗЕХ гэх/ 105 дугаар зүйлийн 105.1-д “Захиргааны байгууллагын захиргааны шийдвэр гаргах ажиллагаа болон захиргааны акт энэ хуулийн дагуу эрх зүйн зөрчилтэйд тооцогдож эрх зүйн үр дагаваргүй болсон бол тухайн гэм буруутай албан тушаалтны санаатай болон санамсаргүй үйлдсэн зөрчилд нь тохирох шийтгэлийг оногдуулна” гэж, ЗЕХ-ийн 105.2 дахь заалт болон Төрийн албаны тухай хуулийн¹⁷³ 26 дугаар зүйлд төрийн албан хаагч, албан тушаалтанд оногдуулах /сахилгын/ шийтгэлийг тодорхойлж өгсөн бөгөөд “тухайн албан тушаалтныг томилсон болон дээд шатны байгууллагын албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хаалттай болон нээлттэй сануулах, албан тушаалын цалингийн хэмжээг бууруулах, ажлаас халах, нийтийн албанд тодорхой хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах шийтгэлийн аль нэгийг оногдуулахаар заажээ.

ХСУХАТАТХ-ийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны явцад төрийн албан тушаалтан, албан хаагчийн зүгээс гаргасан зөрчил, дутагдалд Төрийн албаны болон ЗЕХ-ийн дагуу авсан арга хэмжээний талаар тодорхой тоо баримт гаргах боломжгүй байна. Учир нь ХСУХАТАҮЗЗ, БХБЯ, нийслэл, орон нутгийн ЗДТГ зэрэг уг хуулийг хэрэгжүүлэгч байгууллагуудын цахим хуудсанд тухайн байгууллагын хүний нөөцийн холбогдолтой тушаал, шийдвэрүүдийг ил тод байршуулж, олон нийтэд танилцуулах ажиллагаа хангалттай хийгдээгүй байна.

Гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг нөхөн төлүүлэх

Албан тушаалтны гэм буруугаас үүдсэн хохирлыг барагдуулах тухайд ЗЕХ-ийн 103 дугаар зүйлд албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиргааны байгууллагад хохирол учирсан бол хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар Иргэний хуулийн 498-д заасны дагуу буцааж төлүүлэх замаар захиргааны байгууллага хохирлоо барагдуулах¹⁷⁴ хуулийн зохицуулалттай.

Гэвч ХСУХАТАТХ-ийн 23.1 дэх заалтыг үндэслэн албан тушаалтнаар төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлсэн тохиолдол гараагүй байна.¹⁷⁵ Харин Төрийн албаны тухай

¹⁷² Захиргааны ерөнхий хууль. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/11259?lawid=11259>

¹⁷³ Төрийн албаны тухай хууль. 2002 он. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/12189>

ЗЕХ-ийн 03.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлэх, 103.2.Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна, 103.3.Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна.

¹⁷⁵ “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” судалгааны тайлан. 2018 он. “Эрх зүйн боловсрол” академи Ханнс-Зайделийн сан. 132 дугаар хуудас.

болон ЗЕХ-д зааснаар албан тушаалтан, төрийн албан хаагч хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдаанаас бусдад учруулсан хохирлыг төр хариуцан нөхөн төлбөр төлөх зохицуулалтын¹⁷⁶ дагуу Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 1489 дугаар магадлалын¹⁷⁷ дагуу БХБЯ-аас 1,284,4 сая төгрөгийн нөхөн төлбөр төлөгдөхөөр байна.¹⁷⁸

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх

Албан тушаалтны санаатай болон санамсаргүй үйлдэл гэмт хэргийн шинж агуулсан бол Эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх тухай ХСУХАТАтХ-ийн 23 дугаар зүйлд тусгасан.

ХСУХАТАтХ-ийн хүрээнд хамрах асуудлаар албан тушаалтны гаргасан шийдвэр, үйлдэлд хамаарах ЭХ-ийн зохицуулалтаас 22.8 дугаар зүйлийг¹⁷⁹ сонгон судаллаа. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим санд¹⁸⁰ байршуулсан 2016 оны 5 дугаар сарын 31-ны өдрөөс хойших хугацаанд гаргасан 3 шатны шүүхийн шийдвэрээс харахад НАА салбарын оролцоотой, ЭХ-ийн 22.8.1.1-д заасан “Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэгт холбогдох нэг хэргийг хянан хэлэлцсэн байна.

*Кейс. Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2017 оны 184 дүгээр шийтгэх тогтоолоос*¹⁸¹

Дорноговь аймгийн Замын-Үүд сумын засаг даргаар ажиллаж байсан этгээд 2015 онд А/164 дугаартай захирамжаар Замын-Үүд хөгжлийн сангаас 27,000,000 төгрөгийг Замын-Үүд нийтийн аж ахуй үйлчилгээ “ОНӨ” ХХК-нд шилжүүлж НӨАТ-ын дүнг хасуулж “Петровис” ХХК-ийн Замын-Үүд салбарын ШТС-ын дансанд шилжүүлэн бэлнээр гаргуулан авч төсвийн хөрөнгийг зориулалтын зарцуулж Замын-Үүд хөгжлийн санд 27,000,000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэн болохыг тогтоосон байна

Үнэлсэн байдал

ХСУХАТАтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэх заалтын хэрэгжилтийг зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн

¹⁷⁶ Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, Иргэний хуулийн 498., 498.2, 498.4, Захиргааны ерөнхий хуулийн 101.1, 101.2 дахь заалтууд хамаарна.

¹⁷⁷ Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 1489 дугаар магадлал. Эх сурвалж: <http://new.shuukh.mn/irgendavah/5799/view>

¹⁷⁸ МУ-ын ЗГХЭГ-ын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ХЭГ/1565 тоот “Асуулгын хариухүргүүлэх тухай” албан бичиг. Эх сурвалж: www.parliament.mn/files/30376

¹⁷⁹ Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйл. Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэрэг. 1.Төсөв захирагч төрийн өмч, төсвийн хөрөнгийг: 1.1.зориулалтын бусаар зарцуулсан; 1.2.зах зээлийн дунджаас дээгүүр үнээр бараа, ажил, үйлчилгээ худалдан авсан; 1.3.нөөцлөх нэрээр хэрэгцээнээс илүү хэмжээгээр бараа, бүтээгдэхүүн худалдан авч, мөнгөний эргэлтийг саатуулсан;

1.4.зохиомол хомсдол бий болгох замаар бараа, бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх үнийг зориудаар өсгөсөн; 1.5.төрийн өмчийн, төсөвт байгууллагын эд хөрөнгийг зах зээлийн дунджаас доогуур үнээр борлуулсан; 1.6.улсын төсвийн, өөрийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга байгууламж, тоног төхөөрөмжийн угсралтад шаардлага хангаагүй бараа, бүтээгдэхүүн ашиглах замаар төсөвт өртгийг бүрдүүлж хөрөнгө завшсанаас хохирол учирсан бол нийтийн албанд томилогдох эрхийг гурван жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

¹⁸⁰Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. Эх сурвалж: <http://new.shuukh.mn/>

¹⁸¹Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан. Эх сурвалж: <http://new.shuukh.mn/>

хүрээнд үнэлэхэд шаардлагатай мэдээлэл хангалтгүй байсан судалгааны ажилд хүндрэл учруулж байна.

Гэхдээ хууль зөрчсөн албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэх замаар ХСУХАТАТХ-ийн хэрэгжүүлэгч, хэрэгжилтэд хяналт тавьж хууль сахиулах үндсэн чиг үүрэг бүхий албан хаагчдын ажлын хариуцлагыг сайжруулах зорилго бүхий энэхүү зохицуулалт ЗОРИЛГОДОО ХҮРЭХГҮЙ байна гэж үнэлж болохуйц үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлж болох юм. Тухайлбал,

1. ХСУХАТАТХ-ийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны явцад төрийн албан тушаалтан, албан хаагчийн зүгээс гаргасан зөрчил, дутагдалд Төрийн албаны болон ЗЕХ-ийн дагуу авсан арга хэмжээний талаар тодорхой тоо баримт гаргах боломжгүй байна. Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэг бүхий БХБЯ, ХСУХАТАҮЗЗ, БХТ, ОСНАҮГ зэрэг төрийн болон төрийн оролцоотой байгууллагуудын хүний нөөцөд хамаарах тушаал, шийдвэрүүдийг олон нийтэд ил тод, нээлттэй байршуулаагүй дутагдал, мөн тушаал, шийдвэрийн үндэслэл хэсэг хэт ерөнхий, тухайлбал, “ажил үүргээ хангалттай биелүүлээгүй”, “өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлээгүй” зэргээр томъёологдсон байдал зэргээс Төрийн албаны тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл хүлээж буй албан хаагч ямар үйл ажиллагаанд хамаарах ямар асуудлаар шийтгэл хүлээснийг олж тогтоох боломжгүй байна.
2. Шүүхийн шийдвэрийн санд байршуулсан, хүчинтэй шүүхийн шийдвэрээс харахад хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ хариуцсан байгууллагын албан тушаалтан, албан хаагчид ажил үүргээ гүйцэтгэх явцдаа гаргасан гэм буруутай үйлдэлд холбогдуулан эрүүгийн хэрэг үүсгэн, шүүхээр шийдвэрлэсэн тохиолдол байхгүй, харин Байгаль орчныг бохирдуулах гэмт хэрэг үүсгэн шийдвэрлэсэн хэрэг цөөн хэд байна.
3. ХСУХАТАТХ-д хамаарах асуудлаар ЗЕХ-д заасан “албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиргааны байгууллагад хохирол учирсан бол хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар Иргэний хуулийн 498-д заасны дагуу буцааж төлүүлэх замаар байгууллагад учруулсан хохирлыг барагдуулсан тохиолдол гараагүй байгаа нь хариуцлага тооцох ажил хангалтгүй байгааг илтгэж байна.
4. Харин Төрийн албаны тухай болон ЗЕХ-д зааснаар албан тушаалтан, төрийн албан хаагч хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдаанаас бусдад учруулсан хохирлыг төр хариуцан БХБЯ-аас 1,284,4 сая төгрөгийн нөхөн төлбөр төлөхөөр байна. Энэ нь албан тушаалтны буруутай үйл ажиллагааны эрсдэлийг төр хариуцдаг ойлголт бат бэх оршиж, төрөөс төлбөрийг барагдуулж байгаа нь албан тушаалтны хариуцлага, хандлага өөрчлөгдөхгүй байх эрсдэлийг дагуулж байна.
5. ХСУХАТАТХ-ийг хэрэгжүүлэгч байгууллагуудын ажилтан, албан хаагчдад Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэдэггүй байдал нь энэ салбарт зөрчил гардаггүй гэсэн агуулгаас илүүтэй салбарын үйл ажиллагаа, төсөв, санхүүжилтэд тавьж буй хяналт сул, хариуцлага тооцох үйл ажиллагаа хангалтгүй байна гэх дүгнэлтэд хүргэсэн.

Зөвлөмж

1. ХСУХАТАТХ-ийг хэрэгжүүлэгч байгууллагуудын өмчийн хэлбэр олон янз, тэдгээрийн ажилтан, албан хаагчдын эрх зүйн байдал нь харилцан адилгүй байх тул цаашид

хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх зүйлийн хэрэгжилтийн үнэлгээ хийх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор холбогдох байгууллагууд сахилгын шийтгэл оногдуулж буй тушаал шийдвэрүүддээ эрх бүхий албан тушаалтны шийдвэр гаргах эрх зүйн үндэслэлийг тодотгосон дүрэм, журмыг эшлэхээс гадна тухайн албан хаагч ямар үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөр зэрэгт холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх явцад ямар алдаа дутагдал гаргасныг дурдаж байх тал дээр анхаарах шаардлагатай байна. Ингэснээр энэ хуулийн төдийгүй бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээ хийх ажлыг хөнгөвчлөх боломжийг бүрдүүлэхэд бодит нөлөө үзүүлэх байна.

2. ХСУХАТАтХ-ийг хэрэгжүүлэгч байгууллагуудын хүний нөөцийн холбогдолтой тушаал, шийдвэрүүдийг олон нийтэд ил тод, нээлттэй байршуулахад анхаарч ажиллах, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай¹⁸² хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах,
3. Хот, суурины ус хангамж ариутгах татуургын барилга, байгууламжийн ашиглалт, өмчлөл, үйлчилгээнд төрийн байгууллагаас гадна хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байгаатай холбогдуулан УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн удирдах болон гүйэтгэх ажилтнуудын албан үүргээ гүйцэтгэх явцад хүлээх хариуцлагын асуудлыг тодорхой болгох.

23 дугаар зүйлийн 23.2 дэх заалтын хэрэгжилт

Хүснэгт № 16 23 дугаар зүйлийн 23.2 дэх заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга	Зорилгод хүрэх төвшин шалгуур үзүүлэлтийн томъёолол
7	23 дугаар зүйлийн 23.2 дахь заалт Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага	23.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	Хуулиар хүлээлгэх хариуцлагын хэмжээн нь хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, хууль зөрчсөн үйлдлийн улмаас учирсан хохирлыг барагдуулахуйц байна.

Судалсан байдал

ХСУХАТАтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.2-т хууль зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага оногдуулахаар тусгасан байна.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлын хүрээнд Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгт хамаарах Байгаль орчныг бохирдуулах гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд торгох, зорчих эрхийг хязгаарлах, хорих ял оногдуулах бол хуулийн этгээдэд эрх хасах, торгох ял оногдуулах¹⁸³ боломжтой.

Харин 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох, хохирол нөхөн төлүүлэх, эрх хасах арга хэмжээ авах боломжтой бөгөөд хуулийн Зургадугаар бүлэгт Нийтийн ёс суртахуун, хүн амын

¹⁸² Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль. 2011 он. Эх сурвалж: <http://www.legalinfo.mn/law/details/374>

¹⁸³ Эрүүгийн хуулийн 24.1 дүгээр зүйл. Байгаль орчныг бохирдуулах

эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчлүүд, түүнд хүлээлгэх хариуцлагын асуудлыг зохицуулж өгсөн. Уг хуулийн 6.2 дахь зүйлд Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг нэгдүгээрт, усны тоолуур болон шугам сүлжээнд холбох асуудалд холбогдох зөрчил гаргасан, хоёрдугаарт, УХАТ-ын барилга байгууламжийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмд холбогдох зөрчил гэж хоёр ангилж болох байна. Тухайлбал, усны тоолуурт холбогдох зөрчил гаргасан¹⁸⁴, ус хангамжийн байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд хангагчийн зөвшөөрөлгүйгээр холбосон¹⁸⁵, техникийн нөхцөл, холбогдох дүрэм, журам зөрчсөн¹⁸⁶, стандартын шаардлага хүртэл цэвэрлэгдээгүй бохир усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлсэн¹⁸⁷, УХАТ-ын барилга байгууламжийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн¹⁸⁸, түүнд зөвшөөрөлгүй нэвтэрч хохирол учруулсан¹⁸⁹, бүсэд зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж, шугам сүлжээ барьсан¹⁹⁰, газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис, цацраг идэвхт бодис хадгалсан, боловсруулсан,

¹⁸⁴ 1.Усны тоолуурын битүүмжлэл, байрлал, холболтыг дураараа өөрчилсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹⁸⁵ 2.Ус хангамжийн байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд хангагчийн зөвшөөрөлгүйгээр холбосон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹⁸⁶ 10.Хуульд заасны дагуу техникийн нөхцөлд тусгагдсан шаардлагыг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 11.Хангагч, эсхүл хэрэглэгч ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаархи хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөггүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 12.Цэвэр усны алдагдал, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн гэмтлийг тогтоосон хугацаанд засварлаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹⁸⁷ 3.Бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл урьдчилан цэвэрлээгүй бохир усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, үйл ажиллагааг зогсоож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож, хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹⁸⁸ 4.Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламжийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹⁸⁹ 5.Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламжийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн заагт зөвшөөрөлгүй нэвтэрч хохирол учруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг зургаан зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹⁹⁰ 6.Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсэд зөвшөөрөлгүйгээр барилга байгууламж, шугам сүлжээ барьсан бол түүнийг буулгаж, үйл ажиллагааг зогсоож учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг найман зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

үйлдвэрлэсэн, хориотой химийн бодис ашигласан¹⁹¹, худаг, цооног өрөмдсөн¹⁹² зэрэг үйлдэлд торгох арга хэмжээ авахаар тусгажээ.

Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын хэмжээ Зөрчлийн тухай хуулиар хувь хүнд 10 нэгжээс 1000 нэгж хүртэл, хуулийн этгээдэд 300 нэгжээс 10000 нэгж хүртэл байна. Түүнчлэн хууль зөрчсөн үйл ажиллагаагаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ойлголт нь харилцан адилгүй, тогтсон жишиггүй, хохирлын хэмжээ тогтоох ажиллагаа хэн нэгний үзэмжид суурилсан байгаа нь энэ салбар авилга, хээл хахуульд өртөх гол эрсдэлийг бий болгож байна.

Харин Эрүүгийн хуулиар хүнийг 5400 нэгжээс 27000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх, хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж 20000 нэгжээс 120000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэхээр тус тус тусгасан байна.

Гэвч УХАТ-ын ашиглалтын явцад хамгийн түгээмэл тохиолддог зөрчлүүд болох усны тоолуурыг зөвшөөрөлгүйгээр өөрчлөхөд хувь хүн 30000 төгрөгийн, хуулийн этгээд 300000 төгрөгийн, цэвэр усны алдагдал, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн гэмтлийг тогтоосон хугацаанд засварлаагүй тохиолдолд¹⁹³ хувь хүн 10000 төгрөгийн, хуулийн этгээд 200000 төгрөгийн торгууль хүлээхээр хуульчилсан нь иргэд, ААН-ийн энэ асуудалд хандах хандлагыг өөрчлөх, зөрчил гаргахгүй байлгах, гэмтлийг шуурхай арилгах арга хэмжээ авах хэмжээнд хүртэл нөлөөлөхгүй байна.

Мөн Туул голын хамгаалалтын бүсэд олон тооны орон сууцны хотхонууд баригдаж, зарим нь Туул голыг тэжээдэг гол судлуудыг дайруулсан гүний худгаас ундны болон хэрэглээний усаа татан авч хэрэглэдэг нь нийслэлийн хүн амын ундны усны нөөц бүрэлдэх асуудалд сөргөөр нөлөөлж байгаа хэдий ч эдгээр хамгаалалтын бүсэд орон сууц барих зөвшөөрөл олгох асуудал үе үеийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдэлд байна. Эдгээр шийдвэрүүдийн дунд усны, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоосон хууль тогтоомжид

¹⁹¹ 7.Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсэд газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис, цацраг идэвхт бодис: 7.1.хадгалсан; 7.2.боловсруулсан; 7.3.үйлдвэрлэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсэд байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөөгүй бордоо ашиглан таримал ургамал тарьсан, эсхүл бодис, арга технологи хэрэглэн хөнөөлт шавж, мэргэчийг устгасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹⁹² 9.Ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсэд унд, ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

¹⁹³ 12.Цэвэр усны алдагдал, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн гэмтлийг тогтоосон хугацаанд засварлаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг арван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

нийцээгүй зөвхөн тухайн цаг үед хэн нэгний ашиг сонирхолд нийцүүлэн, хууль тогтоомж зөрчиж гаргасан шийдвэр цөөнгүй байхад зөрчлийг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх асуудал төдийлөн хөндөгдөхгүй хэвээр байна.

Түүнчлэн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоох асуудал тухайн үеийн ИТХ, Засаг даргын тогтоолоор өөрчлөгддөг байдал нь эрсдэл дагуулж байна. Тухайлбал, НИТХ-ын 194 дүгээр, 289 дугаар тогтоол болон 2016 оны НИТХ-ын 50 дугаар тогтоолыг дурдаж болох юм. Ерөнхийдөө усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоосон холбогдох хууль дүрэм зөрчин олгогдсон газрын зөвшөөрлийн тоо нэмэгдэх тутамд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг шинэчлэн тогтоох асуудал үүсдэг нь ажиглагдаж байна.

Кейс: 2008 он. Ундны усны аюулгүй байдал алдагдвал хэн хариуцлагыг нь хүлээх вэ¹⁹⁴

“Нарантуул” худалдааны төвөөс урагш байрлах А станцын 44, 44Е, 45, 49 дүгээр худгаас 50 метрт барилгын ажил явагдаж байна. Уг нь Усны тухай хуулинд дээрх хориотой, хамгаалалтын бүсийн 300 метр радиуст барилга байгууламж барихыг хориглодог. Гэтэл энд өнөөдөр “Эко констракшн”, “Гольф”, “Инвэкс” компаниуд бүтээн байгуулалт хийсээр... Энэ нь ундны ус хомсдох, хүнсний аюулгүй байдал алдагдах сөрөг нөлөөтэй аж. Жишээлбэл, “Инвекс” компанид 260 га газрыг эзэмшүүлэх эрх олгосон Нийслэлийн засаг даргын 2006 оны 126 тоот захирамж 2006 оны гуравдугаар сарын 22-ны өдөр гарчээ. Мөн өдөр тус компани Нийслэлийн газрын албаны дарга Б.Төмөрхуяг, газар зохион байгуулагч С.Долгормаа нартай гэрээ байгуулсан байх юм. ... Тус компанийн барьж байгаа “Дүнжингарав” худалдааны төв хуулийн хэд хэдэн заалтыг зөрчин сүндэрлэж буй гэнэ. “Дүнжингарав”-ын барилгын ажил эхэлд УСУГ үүнийг хориглосон шийдвэр гаргахад өнөөх компанийн эзэд захирамж үзүүлээд л амыг нь тагласан байна. Улмаар Улсын мэргэжлийн хяналтын газрын дарга асан Д.Батбаатар дээрх зөрчил нь ундны ус бохирдох, хомсдох нөхцөлийг бүрдүүлж байна хэмээн хотын мэрт албан тоот хүргүүлж, энэ ажиллагааг зогсоохыг хүссэн ч бас л нэмэр болоогүй гэнэ. Үүнээс гадна дээрхи компани Төмөр замын аюулгүй байдлын бүсийг давж үйл ажиллагаагаа явуулжээ. Төмөр замаас 200 метрт барилга барихыг хориглосон байдаг. Харин “Дүнжингарав”-ын марктингийн албаны дарга М.Баярбаатарын ярьсанаар 100-гаад метрийн зайтай барьсан гэнэ. Улмаар тус компани хотын мэрийн захирамжтай болохоор хууль дүрмийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа хэмээв. Харин газрын үнэлгээг БОЯ, барилгын компаниар гаргуулсан гэдгээ онцоллоо. Гэтэл үнэлгээ хийсэн гэх “Тэкол” компани аль хэдийнэ үйл ажиллагаа явуулахаа больсон гэнэ. Хачирхалтай нь дээрхи компанид газар эзэмшүүлэх захирамж нь Нийслэлийн Засаг даргын 2003 оны гуравдугаар сарын 19-ний өдрийн “Улаанбаатарын төвлөрсөн усан хангамжийн тэжээлийн мужид хамгаалалтын бүс тогтоох тухай” 95 тоот тогтоолыг зөрчсөн хэрэг болжээ.

Кейс: 2018 он. Туул голын ай сав газрын захиргааны дарга Я.Болдбаатарын ярилцлагаас¹⁹⁵

Туул голын дагуу Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт тэр дундаа Баянзүрхийн гүүрнээс Яармагийн гүүрний гол хүртэлх хэсэгт, туул голын энгийн болон онцгой хамгаалалтын бүс байдаг. Энэ хэсгийн 14-15 километр газарт Богд хаан хамгаалалтын захиргааны бүс бас давхар явдаг. Мөн голын хойд талын эрэг 50 метр, 200 метрт энгийн болон онцгой хамгаалалтын бүсэд давхар явж байгаа. Голынхоо хойд талд нийслэлийн нутаг дэвсгэрт орж явдаг. Харин голын урд хэсэг нь Богд хаан хамгаалалтын бүсэд давхардаж харьяалагддаг. Энэ хэсэг 2013, 2014 оноос эхлээд БОАЖЯ-ны тусгай хамгаалалттай газрын даргын зөвшөөрлөөр нийтдээ 52 газар олголт аялал жуучлалын чиглэлээр хийгдсэн байгаа. Зарим хэсэг нь зориулалт нь өөрчлөгдөөд орон сууц, амралтын газар зэрэг байгуулагдаж үйл ажиллагаа явуулж байгаа газрууд байна. Үйл ажиллагаа явуулаагүй хоосон газрууд ч байгаа. Туулын голын үерийн шороон далангаар хамгаалалтын бүс тогтоогдож байсан. Харин томоохон хорооллууд үерийн далангийн урдаа орчихсон. Энэ нь хамгаалалтыг бүсийг зөрчөөд орчихсон байгаа.

¹⁹⁴ Ундны усны аюулгүй байдал алдагдвал хэн хариуцлагыг нь хүлээх вэ.2008 он. Эх сурвалж: <http://news.gogo.mn/r/19343>

¹⁹⁵ Я.Болдбаатар: Хамгаалалтын бүсэд худаг гаргахыг хориглосон байдаг. 2018.05.28 Эх сурвалж: <http://undesten.mn/47572.html>

Дээрх хоёр жишээнээс харахад 2008 онд ч, 2018 онд ч хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гарсан хэвээр байгаа нь хуулиар хүлээлгэх хариуцлагаас эмээх, хууль зөрчихөөс татгалзах нөхцөл бүрдээгүй байгааг харуулж байна. Ялангуяа ХСУХАТАТХ-ийн 17.8.3, .17.8.4 дүгээр заалтыг зөрчин баригдсан барилга, байгууламжууд хэдэн зуун сая, тэрбумын хөрөнгө оруулалт шаарддаг. Ийм хэмжээний хөрөнгө оруулж байгаа тохиолдолд ХСУХАТАТХ-иар хүлээлгэх хариуцлагын хэмжээ “өдрийн хоолны тооцооны” хэмжээнд байгаа нь дээрх үзэгдлийг өөгшүүлж байна. Мөн хууль зөрчин барилгын ажил эхэлсэн, хөрс хуулалт болон бусад ажил хийгдсэн тохиолдолд тогтоож буй хохирлын үнэлгээ байгаль орчны экологийн бодит үнэлгээнд хүрэхгүй байгаа нь нөлөөлдөг гэж үзэж болохоор байна.

Дээрхээс харахад өнөөдөр УХАТ-ын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд барилга байгууламж барьсан этгээдэд, ХСУХАТАТХ-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн хуулиар хүлээлгэх хариуцлагын хэмжээ 10 сая хүртэл төгрөг хүртэлх торгууль байгаа нь иргэд, ААН-үүд хууль тогтоомж зөрчихөөс урьдчилан сэргийлэх хэмжээнд хүрэхгүй байна.

*Кейс: Зайсанг зайдалсан “Зүүнбаян рефайнери” компанийнхан Туулыг сүйтгэж байна.*¹⁹⁶

2008 оны наймдугаар сарын 8-нд Байгаль, орчны яамны Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газраас “Зүүнбаян рефайнери” компанид 743 дугаартай Тусгай хамгаалалттай нутаг дэвсгэрт газар ашиглах ГЭРЧИЛГЭЭ-г таван жилийн хугацаатай олгожээ. Уг газрын ашиглах зориулалт нь аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулна...

“Зүүнбаян рефайнери” компани Туул голын эргээс наймхан метрийн зайд барилгынхаа суурийг тавьжээ. Тэгэхдээ ус тогтоох үүрэг бүхий хайргыг ухааж, зайлуулсан. Мөн таван га газрын бургасыг хядсан аж. Энэ нь Усны тухай хуулийн 22.2-ын “Усны сан бүхий газрын эргээс 50 метрээс доошгүй зайд болон гол мөрний татамд онцгой хамгаалалтын бүс тогтооно”, Онцгой хамгаалалтын бүсэд барилга, байгууламж барих, газар хагалах, тэсэлгээ хийх, газар тариалан эрхлэх, ашигт малтмал хайх, олборлох, зэгс, шагшуурга, мод огтлох, элс, хайрга, чулуу авах, байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар түүж бэлтгэх, мал угаах болон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх цэг байгуулахыг хориглоно” гэх заалтыг, мөн 22.3-т “Усны сан бүхий газрын эргээс 200 метрээс доошгүй зайд энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрээс 100 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн бүс тогтооно” гэж заасныг илтэд зөрчжээ. Гэвч “Зүүнбаян рефайнери” ХХК үйл ажиллагаагаа зогсоосонгүй. Туул голын эргийг сүйдэлж, усны гол тэжээл болсон бургасыг нь хядаж байгаа ч өнөөдөр тэднийг зогсоох хууль Монголд үгүй ажээ.

*Кейс: Туул голын сав газрын захиргааны дарга Г.Долгорсүрэнтэй хийсэн ярилцлагаас*¹⁹⁷

... Барьж байгаа барилгыг зогсоох эрх бүхий байгууллага нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газар. Бидэнд байцаагчийн эрх байдаггүй. Голын эрэг дээр барилга барьж буйг шалгуулахаар хүсэлт гаргахаар нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар “Бид захиалгаар шалгалт хийдэггүй. Төлөвлөгөөт шалгалтаа хийдэг” гэдэг. Барилгын ажил улирлаар явагддаг. Тэднийг оны сүүлчээр төлөвлөгөөт шалгалтаа хийх гэсээр байтал барилгын ажил нь зогсчихдог. Бид албан бичгээр шаардлага хүргүүлдэг. Шаардлагыг хүлээж авахгүй бол шүүхэд хандана. Зарим барилгын компани шаардлага тавихаар үйл ажиллагаагаа зогсоодог болоод байгаа. Гэтэл зарим нь нохойгоо тавьж, хашаа руугаа ч оруулдаггүй. Эдгээр барилгын компаниуд газрын болон барилга барих зөвшөөрлөө авчихсан байдаг.

Дээрх кейсүүдээс харахад ХСУХАТАТХ-ийг зөрчигчидтэй тэмцэх, хууль бус үйл ажиллагааг нь таслан зогсоох, шаардлагатай арга хэмжээг нэн даруй авах эрх бүхий цорын ганц бүхий байгууллага болох МХБ нь хүн хүч, ажлын ачаалал зэргээс хамааран төдийлөн үр дүнтэй ажиллаж чадахгүй байна гэж үзэж болох юм.

¹⁹⁶ Эх сурвалж: <http://www.oloo.mn/n/54512.html>

¹⁹⁷ Онцгой хамгаалалтын бүсийг 35 метр давжээ. 2014 он. Эх сурвалж: <http://unuudur.mn/index.php/article/52883>

Шүүхийн ерөнхий зөвлөлийн /цаашид ШЕЗ гэх/ Шүүн таслах ажиллагааны 2013-2017 оны тайлангаас харахад ХСУХАТАТХ-д хамаарах асуудлаар эрүүгийн хэрэгт холбогдон ял шийтгэл авсан иргэн, хуулийн этгээд байхгүй байгаа бол Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэсэн тоо, торгуулийн хэмжээ зэрэг мэдээлэл бие дааж бүртгэгдэдгүй тул дүн шинжилгээ хийх боломжгүй байна.

Иймээс УХАТ-ын барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээ, мөн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх, хохирлын үнэлгээг байгаль орчны экологийн бодит үнэлгээнд нийцүүлэх хэрэгцээ шаардлага байна. Харин Эрүүгийн хуульд заасан эрх хасах ялыг бодитойгоор хэрэгжүүлэх замаар хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай байна.

Үнэлсэн байдал

ХСУХАТАТХ-ийн 23.2-т заасан “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэх зохицуулалтын зорилгыг хуулиар хүлээлгэх хариуцлагын хэмжээ нь хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, хууль зөрчсөн үйлдлийн улмаас учирсан хохирлыг барагдуулахуйц байна гэж тодорхойлсон бөгөөд хэрэгжилтийн үнэлгээгээр хуулийн зохицуулалт ЗОРИЛГОДОО ХҮРЭХГҮЙ байна гэж үзлээ. Ийнхүү үнэлэх болсон үндэслэл нь:

1. ХСУХАТАТХ-иар зохицуулсан УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ, өмчлөлийн асуудалд холбогдуулан Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгт хамаарах Байгаль орчныг бохирдуулах гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдон эрүүгийн хариуцлага тооцсон тохиолдол 2016 оны 6 сарын 1-нээс хойшхи хугацаанд гараагүй байна. Энэ нь энэ төрлийн хэрэг маргааныг шалгах, хариуцлага тооцох ажиллагаа сул байгааг харуулж байна.
2. Зөрчлийн тухай хуулийн Зургадугаар бүлэгт Нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчлүүд, түүнд хүлээлгэх хариуцлагын асуудлыг тусгаж торгох, хохирол нөхөн төлүүлэх, эрх хасах арга хэмжээ авах боломжтой байдлаар тусгасан боловч хууль хэрэгжиж эхэлснээс хойших тоо баримт тодорхойгүй байгаа нь, энэ төрлийн зөрчлийн тусад нь бүртгэгдэггүйн улмаас мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжгүй байна.
3. Үндсэн хуулиар баталгаажсан хүний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгаа болсон стандартын шаардлага хангасан ундны усаар хангагдах эрхийг зөрчиж, цаашлаад үндэсний аюулгүй байдалд заналхийлж болзошгүй нөхцөл байдал үүсгэж, хууль тогтоомж зөрчиж буй этгээдүүдтэй хийж буй тэмцэл шат шатны хууль, хяналтын байгууллагуудын эрх хэмжээнээс хэтэрсэн, хэн нэгний эрх ашгийг хамгаалсан байдалтай байгаа нь хууль хэрэгжихгүй байх гол шалтгаан болжээ гэж үнэлж болох байна.
4. Хуулиар хүлээлгэх торгуулийн арга хэмжээ нь энэ асуудалд хандах хандлагыг өөрчлөх, зөрчил гаргахгүй байлгах, гэмтлийг шуурхай арилгах арга хэмжээ авах хэмжээнд хүртэл нөлөөлөхгүй байна. Тухайлбал, ХСУХАТАТХ-ийн 17.8.3, .17.8.4 дүгээр заалтыг зөрчин баригдсан барилга, байгууламжууд хэдэн зуун сая, тэрбумын хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа тохиолдолд ХСУХАТАТХ-иар хүлээлгэх

хариуцлагын хэмжээ 10 сая төргөр хүртэл байгаа нь дээрх үзэгдлийг таслан зогсооход нөлөөлөхгүйгээс гадна хууль зөрчин барилгын ажлын улмаас үүссэн хохирлыг үнэлж буй байдал байгаль орчны экологийн бодит үнэлгээнд хүрэхгүй байгаа нь мөн адил нөлөөлдөг гэж үзэж болохоор байна.

5. Эцэст нь хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний буюу НАА салбарт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байгаатай холбогдуулан хангагч, хэрэглэгчийн хариуцлагын асуудлыг ялгаатай зохицуулах шаардлага үүссэн байна. УХАТ-ын барилга, байгууламж өмчлөгч, эзэмшигч, энэ төрлийн үйлчилгээ үзүүлэгч буюу хангагч иргэн, ААН-ын эрх, үүрэг, хариуцлагын асуудлыг тодорхойлох шаардлага тулгамдаж байгаа нь судалгааны ажлын явцад ажиглагдаж байлаа.

Зөвлөмж

1. ХСУХАТАтХ-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагын хэмжээг чангатгах замаар хуулийн хэрэгжилтийг сайжруулах,
2. Хариуцлага хүлээлгэх асуудлыг хангагч, хэрэглэгч тус бүрээр тодорхойлох,
3. ХСУХАТАтХ-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага гарцаагүй тооцдог байх,
4. Хууль тогтоомж зөрчсөний улмаас үүссэн хохирлын үнэлгээг байгаль орчны экологийн бодит үнэлгээнд нийцүүлэхэд анхаарах.

2.2. ПРАКТИКТ НИЙЦЭЖ БУЙ БАЙДАЛ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХҮРЭЭНД ҮНЭЛСЭН БАЙДАЛ

5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтын хэрэгжилт

Хүснэгт № 17 5 дугаар зүйлийн 5.1 дэх заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	5 дугаар зүйл Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх	5.1.Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 5.1.1.хот, суурины УХАТ-ын ашиглалтын норм, дүрэм, нийтлэг мөрдөх журам, заавар батлах, стандартыг хянах 5.1.2.Усны тухай хуулийн 10.1.4-т заасны дагуу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд батлагдсан гадаргын болон гүний усны экологи, эдийн засгийн үнэлгээг мөрдүүлэх; 5.1.3.хот, суурины УХАТ-ын төрийн өмчийн барилга байгууламжийн захиалагчийн үүргийг Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар хэрэгжүүлэх; 5.1.4.хот, суурины УХАТ-ын талаарх төрийн бодлогыг усны хэрэглээний хандлага, усны нөөц, ашиглаж болох боломжит нөөц, усны менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах; 5.1.5.гамшиг болон аюул үүссэн тохиолдолд ус хангамжийн талаар мөрдөх журам батлах; 5.1.6.үйлдвэрийн газрын технологийн хэрэглээний усыг дахин ашиглахтай холбогдсон норм, дүрэм, журмыг баталж мөрдүүлэх; 5.1.7.аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын хэрэглээний халуун, хүйтэн ус, ариутгах татуургын норм, дүрэм, журмыг баталж мөрдүүлэх;

Судалсан байдал

УИХ-аас 1993 онд баталсан Монгол Улсын Засгийн газрын тухай¹⁹⁸ хуульд 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай¹⁹⁹ хууль, УИХ-ын 2016 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай²⁰⁰ хуулийн дагуу ЗГ-ын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудалд нийтийн аж ахуйн, газрын харилцаа, геодези, зураг зүйн, бохирдлын эсрэг үйл ажиллагаа хэрэгжүүлэх зэрэг асуудлыг хариуцуулсан.

Манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжил хурдацтай өөрчлөгдөхийн хэрээр хотжилт эрчимтэй өрнөж нийт иргэдийн 60-аас дээш хувь нь суурин газар амьдрах болсон өнөө үед НАА, УХАТ-ын асуудал хариуцсан яам бүтцийн хувьд бие даан хөгжих, чиглэлийн яамны хувьд хот байгуулалт, газрын харилцаа, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын асуудалд илүү ач холбогдол өгөх боломжийг бүрдүүлэх, тогтвортой бодлого, үйл ажиллагаатай байлгахад анхаарах шаардлагатай байна. Гэвч энэ асуудал тогтворгүй, засаг барьж буй намын бодлогоос хамааран өөрчлөгдөж ирснийг дээрх хүснэгтээс харж болох юм.

¹⁹⁸ <http://www.legalinfo.mn/law/details/344>

¹⁹⁹ <http://www.legalinfo.mn/additional/details/2669?lawid=344>

²⁰⁰ <http://www.legalinfo.mn/law/details/12057>

ХСУХАТАтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн асуудлыг тусгасан байна. ХСУХАТАтХ-д зааснаар төрийн захиргааны төв байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд

- хот, суурины УХАТ-ын ашиглалтын норм, дүрэм, нийтлэг мөрдөх журам, заавар батлах, стандартыг хянах,
- үйлдвэрийн газрын технологийн хэрэглээний усыг дахин ашиглахтай холбогдсон норм, дүрэм, журмыг баталж мөрдүүлэх;
- аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын хэрэглээний халуун, хүйтэн ус, ариутгах татуургын норм, дүрэм, журмыг баталж мөрдүүлэх
- гамшиг болон аюул үүссэн тохиолдолд ус хангамжийн талаар мөрдөх журам батлах чиг үүрэгтэй байна.

2011 онд ХСУХАТАтХ хуулийг шинэчлэн баталснаас хойш дээрх асуудлуудад холбогдох дүрэм, журам батлаж ирснээс харахад төрийн захиргааны байгууллага хуулиар хүлээсэн норм, дүрэм, нийтлэг мөрдөх журам, заавар батлах, стандартыг батлах үүргээ хангалттай биелүүлдэг гэж үзэж болох хэдий ч энэ хуульд заасан үйлдвэрийн газрын технологийн хэрэглээний усыг дахин ашиглахтай холбогдсон норм, дүрэм, журмыг батлаагүй хуулийн хийдэл үүсгэсэн байна.

Холбогдох дүрэм, журам батлах ажиллагаанд Барилгын хөгжлийн төв, УХАТАТАУ33-ийн оролцоо их бий. Тухайлбал, ундны ус, ус хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламжтай холбоотой 100 орчим стандарт²⁰¹, 20 орчим БНБД²⁰², 50 орчим ХСУХАТАУ33-ийн тогтоол²⁰³ хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Гэвч батлан гаргасан норм, дүрэм, журмыг мөрдүүлэх үйл ажиллагаа буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, түүнд хяналт, шалгалт хийх ажиллагаа хангалтгүй байна.

Үүнийг 1996 онд Нийтийн аж ахуйн үйлчилгээний яамыг татан буулгаснаас хойш УХАТ-ын талаар баримтлах нэгдсэн бодлого, үйл ажиллагаа төрийн бодлого төлөвлөлтөөс орхигдсон шинжтэй байгаатай холбож болох юм.

Хүснэгт № 18 Барилга, хот байгуулалтын яамны өөрчлөлт

Монгол Улсын Засгийн тухай нэмэлт, оруулах хууль	Улсын газрын хуульд өөрчлөлт тухай	Засгийн газрын бүтцийн тухай хууль	Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль
		Дэд бүтцийн хөгжлийн яам	Дэд бүтцийн хөгжлийн сайд
		Дэд бүтцийн яам; 2000.08.03	Дэд бүтцийн сайд; 2000.08.03
		Барилга, хот байгуулалтын яам; 2004.09.22	Барилга, хот байгуулалтын сайд; 2004.09.22
		Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам; 2008.09.17	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд; 2008.09.17
		Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд; 2012.08.16	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд; 2012.08.16
		Барилга, хот байгуулалтын яам; 2014.12.04	Барилга, хот байгуулалтын сайд; 2014.12.04

²⁰¹ Стандарт, хэмжил зүйн газар. Эх сурвалж: <http://www.estandart.gov.mn/>

²⁰² Барилгын хөгжлийн төв, Норс, нормативын хэлтэс. Эх сурвалж. <https://enorm.gov.mn/>

²⁰³ ХСУХАТАУ33-ийн тогтоолын жагсаалт. Эх сурвалж: <http://legalinfo.mn/law/158?subcat=165>

тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, салбарт хэрэгжиж байгаа төслүүдийг хэрэгжүүлэхэд зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, салбарын стандарт, норм, нормативыг боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, суурь судалгаа, статистик мэдээллийг нэгтгэж, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчийг мэдээллээр хангахад чиглэсэн үйл ажиллагааг бусад яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, орон сууц, нийтийн аж ахуйн байгууллага, аж ахуйн нэгж, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, мэргэжлийн холбоод, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

Харин Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт усны барилга байгууламжийн бодлого хариуцсан 1 мэргэжилтэн ажилладаг бөгөөд инженерийн дэд бүтцийн салбарын хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах үндсэн үүрэг хүлээж, энэ хүрээнд инженерийн дэд бүтцийн уялдаа холбоог зохицуулах, хууль тогтоомж, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах; инженерийн дэд бүтцийн салбарын норм, нормативын баримт бичгийг боловсронгуй болгох, батлуулах ажлыг зохион байгуулах, зохицуулах; инженерийн дэд бүтцийн салбарын мэдээллийн сан бүрдүүлэх, боловсронгуй болгох ажлыг зохион байгуулах, зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэгтэй.²⁰⁷

Үүнээс харахад ХСУХАТАТХ-ийн хүрээний асуудлыг яамны 2 газарт салгаж хариуцуулсан, аль аль газарт нь хүний нөөц хангалтгүй буюу үндсэндээ 3 мэргэжилтэн улсын хэмжээнд төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулж байгаа нь эрчимтэй өөрчлөгдөн хөгжиж, цар хүрээ нь тэлж байгаа энэ салбарын үйл ажиллагааны цаг үеийн шаардлагыг хангаж байгаа эсэх нь эргэлзээ төрүүлж байна. Тухайлбал, НАА-н салбарын УХАТ-ын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч ААН-үүдийн бүтэц, орон тооны судалгааг ХСУХАТАУ33-ийн даргын 2018.08.14-ний А/34 тоот тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс гаргасан. Судалгаагаар УХАТ-ын үйлчилгээг 2015 онд 500630 хэрэглэгчид 7134 ажилтан, 2016 онд 525950 хэрэглэгчид 8268 ажилтан, 2017 онд 571171 хэрэглэгчид 8739 ажилтан хүргэж ажилласан байна. НАА салбарын 8739 ажилтнаас 364 нь удирдах албан тушаалтан, 1927 нь инженер, техникийн ажилтан, 6448 нь мэргэжлийн ажилтан байсан бол эдгээрийн 42% нь орон нутгийн, 37,4% нь УБ хотын ОНӨААТҮГ, 20,5% нь УБ хотын хувийн хэвшлийн ТЗЭ байгууллагад ажилладаг байна.²⁰⁸

Үүнээс харахад БХБЯ-наас төрийн болон орон нутгийн өмчит ААН-үүдээс гадна хувийн хэвшлийн ААН-үүдийн стандарт, норм, нормативыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллээр хангахад чиглэсэн үйл ажиллагааг зохицуулах чиг үүргийг 3 мэргэжилтэн хэрэгжүүлж байна.

Түүнчлэн хуулийн 5.1.4-т зааснаар хот, суурины УХАТ-ын талаарх төрийн бодлогыг усны хэрэглээний хандлага, усны нөөц, ашиглаж болох боломжит нөөц, усны менежментийн

²⁰⁷ <https://mcud.gov.mn/p/176>

²⁰⁸ ХСУХАТАУ33-ийн мэдээллээс.

төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах эрх, үүрэг төрийн захиргааны төв байгууллагад бий.

УХАТ-ын асуудал нь усны нөөц, усны нэгдсэн менежментийн салшгүй нэг хэсэг болохын хувьд бусад яам, газруудтай харилцах зайлшгүй шаардлагатай юм. Бүтцийн зургаас харахад тухайлбал, ХСУХАТАТХ-ийн хүрээнд зохицуулагдаж буй уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүд хэрэглээний усаа эргүүлэн ашиглахтай холбоотой зохицуулалт УУХҮЯ, ЭХЯ-нд, ундны усны асуудал БОАЖЯ, ЭМЯ, ХХААХҮЯ-нд мөн адил хамааралтай. Үүнээс үүдэн БХБЯ-ны УХАТ-ын бодлого, усны барилга байгууламжийн бодлого хариуцсан мэргэжилтнүүд үндсэн чиг үүргийн хүрээнд тогтмол гүйцэтгэх ажил үүргээс гадна эдгээр яам, тамгын газруудтай харилцаж төрийн бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах чиглэлээр байнга хамтарч ажиллах шаардлага үүсдэг. Энэ байдал нь төрийн захиргааны төв байгууллагын асуудал хариуцсан албан хаагчдын ажлын ачаалал хэт их байх, үүний улмаас гүйцэтгэж буй ажлын чанар, хүртээмж сулрах, хамрах хүрээ хумигдах эрсдэлийг бий болгожээ.

УХАТ-ын барилга байгууламжийн ашиглалт, үйлчилгээ, барилгын стандарт, норм дүрмийг боловсруулах чиг үүрэг бүхий байгууллага бол БХБСайдын харьяанд үйл ажиллагаа явуулж буй Барилгын хөгжлийн төв юм.

Зураг № 9 Усны салбарын байгууллагууд



ЗГ-ын тогтоолоор 2012 онд байгуулагдсан Барилгын хөгжлийн төв²⁰⁹ ТӨҮГ нь 1996 оноос Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Нийтийн аж ахуйн үйлчилгээний газар, 2000 оноос Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар, 2004 оноос Барилга, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төв, 2006 оноос Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн үндэсний төв, 2009 оноос Газрын харилцаа, барилга, геодези зураг зүйн газар нэртэйгээр үйл ажиллагаа явуулж байжээ. Үүнээс

харахад НАА салбарын бодлого 2009 оноос эхлэн алдагдаж эхэлсэн гэж үзэж болохоор байна.

Одоогийн БХТ-ийн Нийтийн аж ахуйн хэлтэс нь НАА салбарын үйл ажиллагаанд зохицуулалт, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, орон сууцны дэд салбарын байгууллагын ашиглалт, үйлчилгээг сайжруулах, төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, орон сууцны төлөвлөлтийн норм, дүрэм, журам, стандартыг боловсруулах, хэрэгжүүлэх, орон сууцны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэн сүлжээ байгуулж ажиллах, НАА-н байгууллагуудын ашиглалт, үйлчилгээнд мониторинг, хяналт тавих чиг үүргийн хүрээнд орон сууц, нийтийн аж ахуйн салбарын хууль тогтоомж, төрийн

²⁰⁹ Засгийн газрын 2012 оны 47 дугаар тогтоолоор байгуулсан

хөтөлбөр, төрийн бодлогын биелэлтийг хангуулах, НАА салбарын инженерийн байгууламжийн техник ашиглалт, төлөвлөлтөд зохицуулалт, зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, сургалт зохион байгуулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.²¹⁰

Тус хэлтсийн үйл ажиллагаа нь ерөнхийдөө орон сууцны асуудалд түлхүү анхаардаг бөгөөд 5 мэргэжилтний 1 нь ус хангамж, ариутгах татуургад хамаарах асуудлыг бүхэлд нь хариуцан ажиллаж байгаа, Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш улсын байцаагчийн эрхгүй болсон зэрэг нь уг салбарын асуудлыг хариуцах байгууллага үр дүнтэй ажиллах боломжгүй байдлыг үүсгэжээ.

Дээрх мэдээллүүдээс харахад ХСУХАТАтХ-ийн 5 дугаар зүйлд заасан Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг 4 мэргэжилтэн гүйцэтгэж байгаа нь энэ салбарын бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны хүртээмж, хэрэгжилтэд тавих хяналт доголдоход хүргэж байна. Үүний нэг жишээ бол анх 2002 онд батлагдсан ХСУХАТАтХ-ийн хэрэгжилтэд 2010 онд, 2014 онд, нийт 2 удаа хяналт шинжилгээ хийсэн явдал юм.

Хуулийн 5.1.6- заасан үйлдвэрийн газрын технологийн хэрэглээний усыг дахин ашиглахтай холбогдсон норм, дүрэм, журмыг баталж мөрдүүлэх үүргийн хүрээнд уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүдийн технологийн хэрэглээний ус дахин ашиглах байдлыг тодорхойлсон эрх зүйн орчин бүрэлдсэн эсэхийг товч судалж үзэхэд 2012 онд батлагдсан Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 10.1.20-д ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл, стандартыг дэвшилтэт технологи, шинжлэх ухааны ололтод тулгуурлан боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, мөн Улсын усны мэдээллийн санд хаягдал усны дахин ашиглалтын талаарх мэдээлэл, аймаг, нийслэл, сум, дүүргээр /дахин ашиглагчийн нэр, хаяг, байршил, дахин ашиглахад хэрэглэсэн технологи, дахин ашиглалтын хэмжээг тогтоосон байгууллага, усны хэмжээ, чанар, хэмнэсэн ус, төлбөр/ нь гаргах асуудлыг БОАЖЯ-нд хариуцуулсан нь ХСУХАТАтХ-иар БХБЯ-нд хүлээлгэсэн чиг үүрэгтэй давхцал бий болгосон байна. Одоогийн байдлаар Улсын усны мэдээллийн сан дахь ус дахин ашиглалт, хаягдал усны талаарх мэдээлэл олон нийт, судлаачдад нээлттэй, ил тод бус байна.²¹¹

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар уул уурхайн салбарын усны норм²¹²ыг баталсан. Энэхүү нормоор Монгол Улсын эдийн засгийн салбаруудын хамрах хүрээг өргөтгөж нийт 14 салбар, үйлдвэр, нэгжийн 247 бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний ус хэрэглээний нормыг шинээр болон шинэчлэн тогтоосон ба энэ нь усны сав газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах, төслийн техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, усны

²¹⁰ Барилгын хөгжлийн төв. Эх сурвалж: <http://www.barilga.gov.mn/#/home/contentLast/32>

²¹¹ Услын усны мэдээллийн нэглдсэн сан. Эх сурвалж: <http://water.eic.mn/watersurface?t=7>

²¹² Уул уурхайн салбарын усны норм. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

тоолуургүй хэрэглэгч, ашиглагчдын усны хэмжээг тогтоох зэрэгт тодорхой үүрэг гүйцэтгэж байна.²¹³

УИХ-аас 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай ²¹⁴ хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Энэ хуулийн 6 дугаар зүйлд зааснаар ус, рашааны нөөц ашигласны төлбөр ногдох зүйлд уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усанд²¹⁵ төлбөр ногдуулах бөгөөд ус, рашааны нөөц ашигласны төлбөр тооцох үзүүлэлт²¹⁶ нь уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усыг шоо метрээр²¹⁷ тооцогдох юм. Хуулийн 15 дугаар зүйлд ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээг тогтоож өгсөн байх ба төлбөр ногдох ус, төлбөрийн хязгаарыг экологи-эдийн засгийн үнэлгээний хувиар тооцон уул уурхайн үйлдвэрлэлд ашигласан усны шоо метр тутамд: а/ашигт малтмал олборлох, баяжуулахад 10-60 төгрөг, б/зэсийн баяжмал, хайлуур жонш баяжуулах 10-70 төгрөг, в/усыг шавхан зайлуулах 10-50 төгрөг, г/эрэл, хайгуулын өрөмдлөг хийх 10-50 төгрөг байхаар тогтоосон бол эрчим хүчний үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан усны шоо метр тутамд 10-30 төгрөгийн төлбөр тогтоож өгчээ²¹⁸

Түүнчлэн “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, арга хэмжээний 3.3-т усны нөөцийн хуримтлалыг бий болгох, хүн амыг эрүүл ахуйн стандартын шаардлагад нийцсэн усаар хангаж, үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн ус хангамжийг сайжруулан тогтвортой хөгжлийг тэтгэх үндсэн нөхцөл бий болгох зорилтын хүрээнд 2010-2015 онд уул уурхай, хүнд үйлдвэр, дулааны станц зэрэг томоохон ус хэрэглэгчид болон бүх хэрэглэгчдийн ус хэрэглээний норм, нормчлолын стандартыг орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглах, түргэн нэвтрүүлэхэд түлхэц өгөх байдлаар шинэчлэн тогтоох, мөрдөх, хяналт тавих ²¹⁹ арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Өнөөдөр улсын хэмжээнд үйлдвэрлэлийн хэрэглээний усанд хамаарах 2 стандарт, MNS 5582:2006 Арьс шир боловсруулах үйлдвэрлэл төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх ус, MNS 6734:2018 Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага, мөн БОНХАЖСайд 2015 онд баталсан уул уурхайн салбарын усны норм²²⁰ мөрдөгдөж байгаа бол ХСУХАТХ-д заасан уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүд технологийн хэрэглээний усаа дахин ашиглахтай холбоотой норм, дүрэм, журам батлагдаагүй байна.

БХБЯ-наас “Ус” үндэсний хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө санхүүжилтийн эх үүсвэрийг нарийвчлан гаргаж, жил бүрийн улсын болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгө төсөвт хамруулан, шийдвэрлүүлэх тал дээр хариуцсан яамдууд түлхүү анхаарч ажиллах шаардлагатай гэж үзсэн бөгөөд тус хөтөлбөрийг

²¹³ ²¹³ “Ус” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан. 2016 он. Эх сурвалж: <http://www.parliament.mn/n/yejo>

²¹⁴ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль

²¹⁵ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6.1.2.

²¹⁶ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйл.

²¹⁷ Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 10.1.3.

²¹⁸ 44 хуудас <http://mglwater.com/wp-content/uploads/2018/03/Usnii-huuliin-emhetgel-2015.11.29..pdf>

²¹⁹ Ус үндэсний хөтөлбөрийн 3.3.21.

²²⁰ Уул уурхайн салбарын усны норм. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

хэрэгжүүлэхэд гадаадын зээл, тусламжийн санхүүжилт ихээхэн үүрэг гүйцэтгэсэн болохыг тэмдэглэжээ. Тухайлбал, Улсын төсвийн санхүүжилтээс гадна Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн “Дэд бүтэц төсөл”, АХБ-ны буцалтгүй тусламжаар “Өмнөговь, Дорноговь аймгийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн G0204 төсөл”, БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжсэн “Замын-Үүдийн дэд бүтцийг сайжруулах төсөл”-үүдийн цэвэр усны эх үүсвэрт гүний худаг, усан сан, цэвэр усны гол шугам сүлжээг шинээр барьж ашиглалтад оруулах, ундны усыг цэвэршүүлэх байгууламж барих ажлуудыг гүйцэтгэжээ.²²¹

Үнэлсэн байдал

ХСУХАТАтХ-ийн 5 дугаар зүйлд заасан Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд холбогдох судалгааг гүйцэтгэсний үндсэн дээр уг заалтын хэрэгжилт ПРАКТИКТ ХЭРЭГЖИХГҮЙ байна гэж үнэллээ.

Ийнхүү үнэлэх үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлов. Үүнд:

1. Хуулийн 5.1.1-д заасан хот, суурины УХАТ-ын ашиглалтын норм, дүрэм, нийтлэг мөрдөх журам, заавар батлах, стандартыг хянах бүрэн эрхийн хүрээнд БХБЯ, БХТ, ХСУХАТАУЗЗ-өөс хот, суурины ус, хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээнд хамаарах норм, дүрэм журам, стандартыг шинээр болон шинэчлэн батлах, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх ажил хангалттай сайн хийгдэж байна. Гэвч ус хангамж, ариутгах татуурга, технологийн хэрэглээний усыг эргүүлэн ашиглах зэрэг нь олон яам, агентлагийн эрхлэх асуудалд хамаарч байгаагаас үүдэн салбар дундын бодлого, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.
2. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, дүрэм журам, стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх асуудал төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа байгууллагад хангалтгүй хэрэгжиж байна. Үүнийг хүний нөөцийн дутмаг байдал, хууль тогтоомжийн шинэчлэлтээс үүдэн хяналт шалгалт хийх эрх зүйн орчин хязгаарлагдмал болсон зэрэгтэй холбон ойлгож болох юм.
3. Хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээтэй холбогдох төрийн бодлого төлөвлөлт эзэнгүйдэж, цалгардсан явдалд уг асуудлыг хариуцсан чиглэлийн яам болох БХБЯ-ыг хэд хэдэн удаа бусад чиглэлийн яамтай нэгтгэх, эргэн салгах зэрэг тогтворгүй байдалтай байлгасан нь нөлөөлсөн байх магадлалтай.
4. Төрийн захиргааны төв байгууллага болох БХБЯ, түүний харьяа байгууллага болох БХТ-д улсын хэмжээнд хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний асуудал хариуцсан 4 мэргэжилтэн ажиллаж байна. Үүнээс харахад БХБЯ хуулиар хүлээсэн эрх, үүргээ улсын хэмжээнд тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй, чанартай хэрэгжүүлэх хангалттай хүний нөөцгүй байгаа нь эрсдэл дагуулж байна.

²²¹ Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2016, 2017 оны нэгдсэн тайлангуудаас

5. Мөн БХБЯ нь Хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээтэй холбогдох асуудлыг 2 хувааж Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас гадна 2016 онд байгуулсан Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт харьяалуулсан нь салбарын бодлого хуваагдмал байдалд орох, хууль тогтоомж хэрэгжүүлэгчид хэд хэдэн газарт хүсэлт гаргах, мэдээлэл хүргүүлэхээр болж төрийн хүнд суртал, чирэгдлийн нэмэгдүүлэх эрсдлийн үүсгэжээ гэж үзэж болох байна.
6. Нийгмийн эрэлт, хэрэгцээнд тулгуурлан шинэ тутам баригдаж буй барилга, байгууламжийн тоо нэмэгдэхийн хэрээр НАА-н салбарт ТЗ эзэмшигч хувийн хэвшлийн ААН-ийн эзлэх хувь өсөж байна. ХСУХАТАтХ-д хот, суурины УХАТ-ын барилга, байгууламжийн эзэмшил, өмчлөл, ашиглалтад хувийн хэвшлийн оролцоо болон төр, хувийн хэвшлийн байгууллагуудын харилцааг тодорхойлоогүй, зохицуулаагүй байгаа нь асуудал дагуулж байна.
7. Хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээ хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зүгээс хот, суурины УХАТ-ын талаарх төрийн бодлогыг усны хэрэглээний хандлага, усны нөөц, ашиглаж болох боломжит нөөц, усны менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах шаардлагатай. Гэтэл яамны болон БХТ-ийн 4 мэргэжилтэн усны нэгдсэн менежментийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй 20 орчим байгууллага, мөн аймаг, нийслэлийн засаг дарга нартай байнгын харилцаа холбоотой байж, төрийн бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах чиглэлээр хамтарч ажиллах шаардлага үүссэн нь албан хаагчдын ажлын ачаалал хэт их байх, үүний улмаас гүйцэтгэж буй ажлын чанар, хүртээмж сулрах, хамрах хүрээ хумигдах эрсдлийн бий болгожээ.
8. Хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээ хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын зүгээс хот, суурины УХАТ-ын ашиглалтын норм, дүрэм, нийтлэг мөрдөх журам, заавар батлах, стандартыг мөрдүүлэх үйл ажиллагаа практикт хэрэгжихгүй байна. Энэ нь дээр дурдсан хүний нөөцтэй холбоотой асуудлаас гадна уг салбарт төрийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага, тухайлбал ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг байхгүй, мөн Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш УХАТ-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагууд болох БХТ, УСХАТАҮЗЗ улсын байцаагчийн эрхгүй болсон зэрэг нь үүнд нөлөөлж байна.
9. Төрийн захиргааны төв байгууллагын зүгээс ХСУХАТАтХ-ийн 5.1.7-д заасан “аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын хэрэглээний халуун, хүйтэн ус, ариутгах татуургын норм, дүрэм, журмыг баталж мөрдүүлэх” тухайд БНААХДТ-ийн даргын 2005 оны 65 дугаар тушаалаар баталсан БД 40-101-05 Жуулчны баазын инженерийн хангамжийн төлөвлөлтийн ерөнхий шийдэл хэрэгжиж байгаа бол 5.1.5-д заасан “гамшиг болон аюул үүссэн тохиолдолд ус хангамжийн талаар мөрдөх журам батлах” тухайд ЗГ-ын 2009 оны 05 дугаар сарын 27 -ны өдрийн 157 дугаар тогтоолоор батлагдсан “Газар хөдлөлтийн гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд тодорхой ажлууд хийгдэж²²² байгаа боловч тухайлан гамшиг болон

²²² Хөтөлбөрийн зорилго: Монгол орны нутаг дэвсгэрт учирч болзошгүй газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хүчтэй газар хөдлөлтийн голомт бүхий бүс нутагт гамшгийн эрсдэлийг бууруулах,

аюул үүссэн тохиолдолд ус хангамжийн талаар мөрдөх журам батлагдаагүй нь хуулийн хийдэл үүсгэжээ гэж үзэж болох байна.

10. Хуулийн 5.1.2-т заасан “Усны тухай хуулийн 10.1.4-т заасны дагуу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд батлагдсан гадаргын болон гүний усны экологи, эдийн засгийн үнэлгээг мөрдүүлэх” үйл ажиллагаа мөн адил практикт хэрэгжихгүй байна. Усны тухай хуулийн 3.1.17-д зааснаар “усны экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж усны нөөцийн байгалийн үнэ цэнэ, өгөөж, хэмжээ, чанар, хэрэглээний ач холбогдлыг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг ойлгох ба ЗГ-ын 2011 оны 10 дугаар 26-ны өдрийн 302 дугаар тогтоолоор Усны экологи, эдийн засгийн үнэлгээг шинэчлэн баталсан байдаг. БХБЯ-ны зүгээс ХСУХАТАТХ-ийн хүрээнд УХАТ-ын барилга байгууламжийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн этгээдийн байгаль орчин, ус хангамжийн эх үүсвэрт учруулсан хохирлыг тогтоох, экологи эдийн засгийн үнэлгээг бодитойгоор тооцох, холбогдох дүрэм, журмыг мөрдүүлэх асуудал хангалтгүй хэрэгждэг тухай энэхүү судалгааны ажлын Бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний хэсгээс харж болох юм. Түүнчлэн “Усны тухай хуулийн 10.1.4-т заасны дагуу” гэж эшэлсэн нь алдаатай байна.
11. ХСУХАТАТХ-ийн 5.1.6-д заасан ажил хангалтгүй хэрэгжих байна. Энэ нь нэгд, хуулийн 5.1.6, 5.1.7-д заасан норм, дүрэм, журмыг одоо хүртэл батлаагүй хийдэл үүсгэсэн, хоёрт, норм, дүрэм, журмыг мөрдүүлэх, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт, үнэлгээ хийх, тайлан мэдээг нэгтгэн боловсруулах өөрөөр хэлвэл хариуцах эзэнгүй байгаатай холбоотой байна. Тухайлбал, уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүдийн технологийн хэрэглээний ус дахин ашигласан талаарх нэгдсэн тайланг БХБЯ-наас гаргадаггүй, БОАЖЯ-наас хөтөлдөг Улсын усны мэдээллийн сан²²³ дахь хаягдал ус, ус дахин ашиглалттай холбоотой мэдээлэл байх боловч тэр нь олон нийтэд ил тод биш байна. Хэдийгээр эрх бүхий байгууллагаас уул уурхайн компаниудад ус ашиглуулах дүгнэлт гаргаж өгөхдөө ашигласан усныхаа 70-аас доошгүй хувийг эргүүлэн эргүүлэн ашиглах даалгавар өгч байгаа ч 5.1.6, 5.1.7 дахь зүйлийн хэрэгжилтийн талаар хуулиар хариуцлага хүлээлгэсэн этгээдүүд БХБЯ-нд бус БОАЖЯ-нд ус хангамжтай холбоотой зарим мэдээллийг хүргүүлдэг нь яамдын чиг үүргийн давхардлаас шалтгаалж байна.
12. ХСУХАТАТХ-ийн 5.1.6-д заасан үйлдвэрийн газрын технологийн хэрэглээний ус гэх нэр томъёог бусад хууль тогтоомж, норм, дүрэм, журамд бохир ус, үйлдвэрлэлийн хэрэглээний ус, саарал ус, хаягдал ус зэргээр ялгаатай байдлаар тусгасан байгаа нь хуулийн нэр томъёоны нэгдмэл байх шаардлагыг хангахгүй байна.

Зөвлөмж

1. Үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгаа болсон усны асуудал /хангамжийн эх үүсвэр, ус хангамжийн эх үүсвэрийн барилга

ашиглагдаж байгаа зарим барилга, байгууламжийн хийц, бүтээцийг хүчитгэх замаар эвдрэл, нуралтаас үүсэх хохирлыг багасгах, орон сууц, олон нийт, иргэн болон үйлдвэрийн барилга, зам гүүр, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, инженерийн шугам сүлжээний аюулгүй байдлыг хангаж, байгалийн болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх” хүрээнд 4 зорилт тавьж ажиллаж байгаагаас Хот суурин болон бүс нутгийн эрсдэлийн үнэлгээг хийх, Гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажлыг мэргэжлийн удирдлагаар хангах зорилууд нь ус хангамжид хамаарахаар байна.

²²³ <http://water.eic.mn/>

байгууламж, инженерийн шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээ, технологийн хэрэглээний усыг эргүүлэн ашиглах зэрэг/ нь олон яам, агентлагийн эрхлэх асуудалд хамаарч байгаагаас үүдэн салбар дундын бодлого, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах,

2. Төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа байгууллагад хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог нэмэгдүүлэх, улмаар БХБЯ ХСУХАТАтХ-иар хүлээсэн эрх, үүргээ улсын хэмжээнд тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй, чанартай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,
3. Хүн амыг стандартын шаардлагад нийцсэн унд, ахуйн хэрэглээний усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах замаар иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах, амьдралын наад захын хэрэгцээг хангах зорилго бүхий хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээтэй холбогдох төрийн бодлого төлөвлөлт тогтвортой, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээ тасралтгүй, үр дүнтэй байхад уг асуудлыг хариуцсан чиглэлийн яамны тогтвортой байдал нэн чухал үүрэг гүйцэтгэнэ. Иймд салбарын яамыг бусад чиглэлийн яамдтай хольж хутгалгүй, аль болох тогтвортой ажиллуулах талаар анхаарах шаардлагатай,
4. БХБЯ нь Хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээтэй холбогдох асуудлыг Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 2 хуваах шаардлага бий эсэхийг судлах,
5. ХСУХАТАтХ-д хот, суурины УХАТ-ын барилга, байгууламжийн эзэмшил, өмчлөл, ашиглалтад хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж буйтай холбогдуулан төр, хувийн хэвшлийн байгууллага хоорондын харилцааг зохицуулсан эрх зүйн орчны бий болгох,
6. Хот, суурины УХАТ-ын бодлого, хууль тогтоомж, норм, дүрэм, нийтлэг мөрдөх журам, заавар батлах, стандартыг мөрдүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч төрийн захиргааны байгууллагыг байгуулах,
7. ХСУХАТАтХ-д заасан 1/аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын хэрэглээний халуун, хүйтэн ус, ариутгах татуургын норм, дүрэм, журмыг, 2/гамшиг болон аюул үүссэн тохиолдолд ус хангамжийн талаар мөрдөх журмыг, 3/үйлдвэрийн газрын технологийн хэрэглээний усыг дахин ашиглахтай холбогдсон норм, дүрэм, журмыг тус тус баталж мөрдүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулах,
8. Хуулийн нэр томъёоны нэгдмэл байх шаардлагыг хангах үүднээс үйлдвэрийн газрын технологийн хэрэглээний ус гэх нэр томъёог бусад хууль тогтоомж, норм, дүрэм, журамд бохир ус, үйлдвэрлэлийн хэрэглээний ус, саарал ус, хаягдал ус зэргээр ялгаатай байдлаар тусгасан байгааг цэгцлэх.

6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын хэрэгжилт

Хүснэгт № 19 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
2	6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт	6.1.4.хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх	байгуулах, түүний байнгын ажиллагааг эрхлэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;
---	--

Судалсан байдал

ХСУХАТАтХ-ийн 6 дугаар зүйлд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тодорхойлсон боловч шууд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байна. БХБЯ-нд Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Барилгын хөгжлийн төвийн Нийтийн аж ахуйн хэлтэс зэрэг газар, харьяа агентлаг байгаа хэдий ч энэ нь тус хуулийн 5 дугаар зүйлд заасан төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийн хүрээнд бодлого тодорхойлох үндсэн чиг үүрэгтэй байна.

ХСУХАТАтХ-ийн 6 дугаар зүйлд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тусгаж өгсөн бөгөөд 6.1.4 дэх хэсэгт хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан байгуулах, түүний байнгын ажиллагааг эрхлэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах үүргийг ногдуулсан байна.

Барилга хот байгуулалтын сайдын 2006 оны 07 сарын 10-ны өдрийн Норматив, баримт бичиг батлах тухай 116 дугаар тушаалаар Монгол Улсын барилгын дүрэм инженерийн шугам сүлжээний зураглалын ажил хийх тухай нормыг баталж, шугам сүлжээний мэдээллийн сан хөтлөх болон шугам сүлжээний мэдээллийн хөтлөлтийн материалын нэг хувийг улсын газар зүйн мэдээллийн нэгдсэн санд заавал өгөхөөр зохицуулсан байна. БХБЯ-аас инженерийн шугам сүлжээг нэгдсэн мэдээллийн санд бүртгэх ажлыг хийж хэрэгжүүлэн үүсгэсэн цахим сангаа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт хүлээлгэж өгсөн байна.²²⁴

Шигтгээ

Сүүлийн 2 жилийн хугацаанд мэдээллийн нэгдсэн сан бий болсон. Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт өнгөрсөн өвөл яам албан ёсоор хүлээлгэж өгсөн гэсэн. Нэвтрэх эрх бид нарт байхгүй байгаа. Бид нар нэвтрэх эрх авахаар хүсэлт өгсөн, удирдлагаас зөвшөөрчихсөн байгаа. Аль аймгийн инженерийн шугам сүлжээ хэдэн жил болсон юм, хаагуураа явдаг юм гээд хайхаар мэдээлэл олддоггүй, мэддэггүй. Тухайн орон нутгийнх нь хариуцсан хүн нь бас шинэ,сүүлд ажилд орсон болохоор шугам сүлжээгээ мэддэггүй.

Барилгын хөгжлийн төв, Нийтийн аж ахуйн хэлтэстэй хийсэн ярилцлагаас

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний 1.2.5-д “Сумын төв, томоохон суурингийн газар доорхи шугам сүлжээний байр зүйн зураглал, орон зайн мэдээллийн сан байгуулах” техникийн төсөл боловсруулж, батлуулахаар, 1.2.6-д “Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах” ажлыг зохион байгуулахад оролцох, захиалагчийн хяналт хийхээр тус тус төлөвлөсөн байна.

²²⁴ Ганцаарчилсан ярилцлагаас

Энэ хүрээнд мөрдөгдөж буй дүрэм, журамд нийцүүлэн 2 аймгийн төвийн мэдээллийн санг үүсгэх, 19 аймгийн мэдээллийн санд баяжилт хийж үйлчилгээнд нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна гэжээ. Мөн түүнчлэн 2018 оны 2-6 сард аймгийн төвөөс бусад сумын төв, томоохон суурингийн төвүүдийн газар доорхи шугам сүлжээний байр зүйн зураглал, орон зайн мэдээллийн сан байгуулах техникийн төслийг батлуулах, мөн оны 10-12 сард Дорнод, Сүхбаатар аймгийн “Инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах” ажилд захиалагчийн хяналт хийх болон 2013-2017 онд байгуулсан, БОЗӨДБ-д оруулсан 19 аймгийн “Инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн сан”-д нэмэлт, өөрчлөлт орсон байх зэрэг гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт гаргасан байна.²²⁵

Үнэлсэн байдал

ХСУХАТАтХ-ийн 6 дугаар зүйлд заасан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж буй хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан байгуулах, түүний байнгын ажиллагааг эрхлэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах үйл ажиллагааг судалсны үндсэн дээр уг заалтын хэрэгжилт ПРАКТИКТ ЗАРИМ ТАЛААР ХЭРЭГЖИХГҮЙ байна гэж үнэллээ.

Ийнхүү үнэлэх үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлов. Үүнд:

1. ХСУХАТАтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэгт заасан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад үүрэг болгосон хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан байгуулах, түүний байнгын ажиллагааг эрхлэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах ажлыг БХБЯ хариуцан үйл ажиллагааг эхлүүлээд ГЗБГЗЗГ-аар дамжуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд ГЗБГЗЗГ БХБЯ-аас хүлээж авсан мэдээллийн сангаа баяжуулах ажлыг 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусгасан бөгөөд шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах ажлыг ГЗБГЗЗГ хариуцан, хэрэгжүүлж байна.
2. Мэдээллийн сан байгуулах ажил 2013-2017 онд тодорхой хэмжээнд хийгдэж 19 аймаг, нийслэлийн хэмжээний шугам сүлжээний байр зүйн зураглалыг хийсэн боловч бүрэн дуусаагүй буюу үлдсэн 2 аймаг болон аймгийн төвөөс бусад сумын төв, томоохон суурингийн төвүүдийн газар доорхи шугам сүлжээний байр зүйн зураглалыг 2018 онд хийхээр төлөвлөсөн байна. Мөн түүнчлэн хийгдсэн мэдээллийн санд тухай бүрт баяжилт хийх ажлыг зохион байгуулж байна.
3. ХСУХАТАтХ-ийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх хэсэгт заасан хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан байгуулах, түүний байнгын ажиллагааг эрхлэх үйл ажиллагаа хийгдэж байгааг дээрх үр дүнгээс харж болох юм. Гэсэн хэдий боловч энэхүү шугам сүлжээний ашиглалттай холбоотой мэдээллийн санд холбогдох байгууллага нэвтэрч мэдээлэл авах боломж бүрдээгүй, нээлттэй, ил тод бус байгаа нь тухайн заалт практикт зарим талаар хэрэгжихгүй байгааг харуулж байна.

²²⁵ Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2018 оны үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө <http://www.gazar.gov.mn/?p=791>

4. Шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбоотой буюу тухайн шугам сүлжээний насжилт, байр зүйн зураглалын мэдээлэл нь УСУГ, ХСУХАТАҮЗЗ, БХТ зэрэг шугам сүлжээний техникийн нөхцөл олгох, хяналт шинжилгээ, ашиглалт, засвар үйлчилгээ хийх чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад шаардлагатай байгаа боловч мэдээллээр хангагдаагүй байна.

Зөвлөмж

1. Мэдээллийн санг тогтмол баяжуулах, баяжилтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх,
2. Шугам сүлжээний ашиглалттай холбоотой мэдээллийн санд холбогдох байгууллага нэвтэрч мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх, нээлттэй, ил тод болгох,
3. Шугам сүлжээний насжилт, байр зүйн зураглалын мэдээллийг УСУГ, ХСУХАТАҮЗЗ, БХТ зэрэг шугам сүлжээний техникийн нөхцөл олгох, хяналт шинжилгээ, ашиглалт, засвар үйлчилгээ хийх чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудыг мэдээллийн санд нэвтрэх эрхээр хангах, ажлын уялдааг холбоог хангах.

9 дүгээр зүйлийн 9.11 дэх заалтын хэрэгжилт

<i>Хүснэгт № 20 9 дүгээр зүйлийн 9.11 дэх заалт</i>		
№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
3	9 дүгээр зүйлийн 9.11 дэх заалт Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиг лалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн бүтэц	9.11.Зохицуулах зөвлөл нь санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлнэ.

Судалсан байдал

Монгол Улсын Ерөнхий сайдын 2012 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 56 дугаар захирамжаар Зохицуулах зөвлөлийн анхны даргаар Ч.Эрдэнэчимэг, гишүүдээр Б.Жигжид, Ч.Баттогтох, Р.Нямжав, С.Чулуунхуяг нарыг томилсон байна. ХСУХАТАТХ-ийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу Зохицуулах зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа 6 жил байх бөгөөд Зохицуулах зөвлөлийн гишүүдийн анхны томилгоог 2, 4, 6 жилээр хийж, цаашид 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд томилолтын хугацааг нэг удаа сунгаж болно гэжээ.

Шигтгээ

Зөвлөлийн дарга миний бие болон орон тооны бус 4 гишүүн бид тав албан ёсны шийдвэр, Ерөнхий сайдын захирамжаа яамнаас 6 сарын 8-нд авч байсныг тод санаж байна. Би яамнаас гараад шууд л шинэ байгууллага бүртгүүлэхээр Улсын бүртгэлийн газар уруу явсан юм. Харин тэнд 3 хонож байж арай гэж бүртгүүлсэн. Яагаад гэвэл манай байгууллагын статус тодорхойгүй, өөрөөр хэлбэл салбарын хуулиас бусад төрийн албаны тухай, төрийн өмчийн тухай зэрэг аль ч хуулинд бие даасан зохицуулах байгууллагын тухай заагаагүй. Ингээд төрийн байгууллага, албан газар, улсын үйлдвэрийн газар гэдэг статусаар 2012 оны 06 дугаар сарын 19-ны өдөр бүртгэгдсэн.

Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан 2012-2017,


Зохицуулах зөвлөлийн анхны дарга Ч.Эрдэнэчимэг 2012-2016

2011 оны 10-р сарын 06-ны өдөр шинэчлэн баталсан “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-ийн дагуу Монгол Улсын Засгийн газрын 2012 оны

02 сарын 15-ны өдрийн 46, 05 сарын 30-ны өдрийн 183 дугаар тогтоолын дагуу “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл” үүсгэн байгуулагдсан. Тус зөвлөлийн үйл ажиллагаа нь “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”, Засгийн газрын 2012 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм”-ээр зохицуулагдах бөгөөд тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүрэгтэй хэрэглэгчийн төлөөлөл, салбарын мэргэжлийн төрийн бус байгууллагын төлөөлөл бүхий бие даасан, хараат бус хамтын удирдлагын байгууллага юм.²²⁶

ХСУХАТАҮЗЗ тухайн орон нутгийн онцлог, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаа, үйлчилгээний цар хүрээг харгалзан усны үйлчилгээний үнэ тарифыг ялгавартайгаар батлан мөрдүүлэх бөгөөд ингэснээр хүн ам, үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллагыг эрүүл ахуйн стандартад нийцсэн цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах үйлчилгээ эрхэлдэг нийтийн аж ахуйн байгууллагуудын цаашдын үйл ажиллагааны доголдлыг арилгах, усны алдагдлыг бууруулах, санхүүгийн алдагдлыг багасгах, НАА-н үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, дэлхийн бусад орнуудын дэвшилтэт технологи, туршлагыг нэвтрүүлэх, олон улсын ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай харилцаа холбоо тогтоон, хамтран ажиллаж байна. ХСУХАТАҮЗЗ эрхлэх асуудлынхаа чиглэлээр холбогдох дүрэм, журмыг батлан мөрдүүлэх, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, тухайн хот, суурин газарт хүн амыг цэвэр усаар хангах үйлчилгээний тарифыг боловсронгуй болгох арга хэмжээг зохион байгуулж ирсэн байна.

График № 8 Зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллахад асуудал тулгарч байсан эсэх



Улаанбаатар хот болон орон нутагт үйл ажиллагаа явуулж буй 47 ТЗЭ-чээс асуулгын судалгаа авахад тэдний 6.8% нь ХСУХАТАҮЗЗ-тэй хамтран ажиллахад аливаа асуудал тулгардаг гэжээ. Тулгарч байсан асуудлыг аваад үзвэл авлага нэмэгдэх асуудал, төлбөрөө хугацаандаа төлөхгүй асуудлаас болж алдангитай холбоотой маргаан гарах, үнэ тарифын асуудал, хүсэлтэд хариу өгөхгүй удаах зэргээр хүнд суртал гаргадаг гэжээ.

ХСУХАТАҮЗЗ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчид үзүүлсэн зохицуулалтын болон үнэ, тарифыг хянан баталгаажуулах үйлчилгээний хураамж, сургалт сурталчилгаа, мэдээллийн орлого зэргээс санхүүжих бөгөөд тухайн жилийн үйл ажиллагааны төсвөө Засгийн газраар батлуулж, гүйцэтгэлээ тайлагнадаг.²²⁷ Мөн түүнчлэн ТЗЭ байгууллагууд ХСУХАТАҮЗЗ-д эдийн засгийн хүчин чадал зэрэг санхүүгийн мэдээллээ

²²⁶ <http://www.wsrc.mn/new/mn/introduction>

²²⁷ <http://www.wsrc.mn/new/mn/introduction>

ирүүлдэг бөгөөд ТЗЭ байгууллагуудын санхүүгийн үзүүлэлтийг хэрэглэгчдэд нээлттэйгээр мэдээлэх байдал орхигдсон байна.

ХСУХАТАҮЗЗ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь хэсэгт заасан төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч тул шилэн дансны тухай хуулийн дагуу үйл ажиллагааны төсөв, гүйцэтгэлээ тайлагнах үүрэгтэй байна. ХСУХАТАҮЗЗ-ийн цахим хуудас Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны бие даасан цэстэй байх, мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулсан байх, мэдээллийг тогтмол шинэчилж байх, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжтой байх зэрэг шаардлагыг бүрэн ханган ажиллаж байна.

Зураг № 10 ХСУХАТАҮЗЗ-ийн цахим хуудас дахь шилэн дансны цэс

2018 оны 11-р сарын 08, Пүрэв гариг Мэдээ Ажлын байр Санал авах Санал асуулга Шилэн данс Холбоо барих Хайх үгээ энд бичнэ үү. MON ENG

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ

НҮҮР ХУУДАС БИДНИЙ ТУХАЙ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ҮНЭ ТАРИФ ХУУЛЬ ТОГТООМЖ ХЭРЭГЛЭГЧИЙН БУЛАН

ШИЛЭН ДАНС

Төсөв, гүйцэтгэл

Тендер, худалдан авалт

Байгууллага

Хэвлэх

ТӨСӨВ, ГҮЙЦЭТГЭЛ

- Санхүүгийн тайлан
- 2015 оны 1-р улирлын тайлан
- 2015 оны 2-р улирлын тайлан
- 2015 оны 3-р улирлын тайлан
- 2015 оны Аудитын хийгдсэн санхүүгийн байдлын тайлан
- 2016 оны 2-р улирлын тайлан
- 2016 оны хагас жилийн тайлан
- 2015 оны зохицуулалтын үйлчилгээний хөлс
- 2015 оны орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
- 2016 оны орлого, зарлагын мөнгөн гүйлгээ
- 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан /09 сарын 30 хүртэл/
- 2016 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан /11 сарын 30 хүртэл/

ШИНЭ МЭДЭЭ

Зохицуулах зөвлөлийн ээлжит аравдугаар хуралдаан боллоо 2018.11.02

Төвийн аймгуудын уулзалт, зөвлөгөөн боллоо 2018.10.23

www.wccr.mn/news/mn/account-1

Аудитын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэгт заасны дагуу төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээр өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд аудит хийх хугацааны асуудлыг Төсвийн тухай болон бусад хуулиар зохицуулна гэжээ. Харин ХСУХАТАТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэгт заасны дагуу Зохицуулах зөвлөл нь санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх үүрэгтэй байна. ХСУХАТАҮЗЗ байгуулагдсанаас хойшхи 6 жилийн хугацаанд тус зөвлөл 2015 оны санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулан нийтэд нээлттэйгээр мэдээлсэн байна.

Үнэлсэн байдал


ХСУХАТАТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэгт заасан Зохицуулах зөвлөл нь санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх үйл ажиллагааг судалсны үндсэн дээр уг заалтын хэрэгжилт ПРАКТИКТ ХЭРЭГЖИХГҮЙ байна гэж үнэллээ.

Ийнхүү үнэлэх үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлов. Үүнд:

1. ХСУХАТАУЗЗ нь байгуулагдсанаас хойшхи 6 жилийн хугацаанд 1 удаа буюу 2015 онд санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулан цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлсэн байна.
2. ХСУХАТАУЗЗ нь ТЗЭ-чдээс авч буй зохицуулалт үйлчилгээний хөлс болон бусад санхүүгийн тайланг шилэн дансанд байршуулж буй боловч аудитаар баталгаажуулсан тайланг, нийтэд мэдээлэх үүргээ сүүлийн 2 жил хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөмж

1. ХСУХАТАУЗЗ хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд аудитаар тайлангаа баталгаажуулж, нийтэд мэдээлэх,
2. ХСУХАТАУЗЗ төдийгүй ТЗЭ байгууллагууд хэрэглэгчдэд санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулж тайлагнах.



10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалтын хэрэгжилт

Хүснэгт № 21 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
4	10 дугаар зүйлийн 10.1.7 дахь заалт: Зохицуулах зөвлөлийн бүрэн эрх	10.1.7.тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах;

Судалсан байдал

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн Тусгай зөвшөөрлийн алба нь "Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 10 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах, нэгтгэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.²²⁸

ХСУХАТАҮЗЗ-ийн даргын 2014.12.15-ны өдрийн А/50 тоот тушаалаар Мэдээллийн сан боловсруулах тендерийг холбогдох журмын дагуу зохион байгуулах, үнэлэх үнэлгээний хороог байгуулж, үнэлгээний хорооноос Мэдээллийн сан боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийн урилгыг Худалдан авах ажиллагааны удирдлага, хяналт шинжилгээний мэдээллийн систем болон "Өдрийн сонин"-ны 2015.01.21-ний өдрийн №015 (4967) дугаарын 11 дэх нүүрт байрлуулан олон нийтэд мэдээлсэн байна. Уг зөвлөх үйлчилгээний тендерийн хураангуй жагсаалтад "Эм ти" ХХК, "Инфосистемс" ХХК, "Интерактив" ХХК, "Инно солюшн" ХХК гэсэн 4 хуулийн этгээд оролцох саналаа ирүүлсэн боловч техникийн болон санхүүгийн саналыг хүлээн авах хугацаанд "Инфосистемс" ХХК, "Инно солюшн" ХХК тус тус саналаа ирүүлсэн байна.

Тус хоёр компанийн үнэлгээний дүнг хүснэгтэлж харуулахад.

№	Хуулийн этгээдийн нэр	Техникийн оноо	Санхүүгийн /төг/	санал	Тайлбар
1.	"Инфосистемс" ХХК	76,75	180,000,000		Төлөвлөсөн төсвөөс давсан тул шалгараагүй.
2.	"Инно солюшн" ХХК	87,37	23,464,800		Шалгарсан.

Мэдээллийн сан боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан "Инно солюшн" ХХК-тай гэрээ байгуулах мэдэгдлийг холбогдох журмын дагуу илгээж, 2015 оны 3-р сарын 12-ны өдөр Мэдээллийн сан боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулснаар тусгай зөвшөөрлийн программ боловсруулах ажил эхэлсэн байна. Энэхүү мэдээллийн сангийн зорилго нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхэлдэг тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийг дэлгэрэнгүй бүртгэх, албан тушаал, инженер техникийн ажилчид, ажлын байр, үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан мэдээ, хэрэгцээ шаардлагыг бүрэн тусгаж зохицуулалт,

²²⁸ Тусгай зөвшөөрлийн алба. <http://www.wsrc.mn/new/mn/license-department>

төлөвлөлт хийх боломжийг бүрдүүлэх зорилготой тусгай зөвшөөрлийн онлайн бүртгэлийн програм хангамж боловсруулах явдал юм.

2016 онд мэдээллийн санг Үндэсний дата төвийн серверт суурилуулж, Зохицуулах зөвлөл болон тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд мэдээллийн сангийн программын сургалтыг зохион байгуулсан байна.²²⁹ Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэгч ТЗЭ-чдийн Мэдээллийн сан боловсруулах Зөвлөх үйлчилгээний тендер хэрэгжүүлэгч “Инно солюшн” ХХК-ийн боловсруулсан тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээллийн сангийн программ хангамжийг тестлэх ажилд хяналт тавьж, хүлээн авах ажлын хүрээнд дараахь ажлуудыг хийсэн байна. Үүнд:

1. Инно солюшн ХХК-иас Зохицуулах зөвлөлийн ажилтан, албан хаагчдад Мэдээллийн сангийн сургалтыг зохион байгуулсан.
2. Мэдээллийн санд нийт 109 засвар, өөрчлөлт оруулснаас 62 алдааг засч, 47 өөрчлөлт оруулах хүсэлтийн дагуу засварласан.
3. ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн сангийн программд Санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн маягтыг боловсруулан, программ шалгах, хамтарсан тестлэх ажлыг 2 удаа хийсэн.
4. Мэдээллийн санд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагуудад 2015 оны мэдээлэл шивж оруулах явцад заавар, зөвлөгөө өгч, нийт 120 ТЗЭ аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэл бүхий бааз үүсгэсэн.²³⁰

Үнэлсэн байдал

ХСУХАТАТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах үйл ажиллагааг судалсны үндсэн дээр уг заалтын хэрэгжилт ПРАКТИКТ ХЭРЭГЖИЖ байна гэж үнэллээ.

Ийнхүү үнэлэх үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлов. Үүнд:

1. УХАТ-ын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэгч ТЗЭ-дийн Мэдээллийн сангийн программ хангамжийг хүлээн авч, салбарын хүний нөөц, техник технологи, санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн нэгдсэн мэдээллийн санг байгуулснаар усны үйлчилгээний мэдээллийн урсгалыг оновчтой зохион байгуулах, салбарыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын бодлогыг дэмжих, улмаар түүний өгөөжийг зөв тооцох, удирдлагын менежментийн бүх түвшний ухаалаг бодлого явуулж ажиллах суурь нөхцөл тавигдсан байна.²³¹
2. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгосноор ТЗЭ-дийн боловсон хүчний давхардал, эдийн засгийн чадавхи зэргийн мэдээллийг нэг дороос харах боломж бий болсон байна.

²²⁹ ХСУХАТАУ33, Тендер, худалдан авалт. <http://www.wsrc.mn/new/mn/account-2>

²³⁰ ХСУХАТАУ33, Үйл ажиллагааны тайлан, 2016

²³¹ ХСУХАТАУ33, Үйл ажиллагааны тайлан, 2012-2017

3. Гэхдээ энэхүү санг хариуцан ажиллах мэргэжлийн боловсон хүчний дутагдал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан уг мэдээллийн санг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгааг анхаарах шаардлагатай.
4. Тус мэдээллийн санг ашиглах боломж, нэвтрэх эрхийг НАА салбарын бодлого хариуцсан БХБЯ-ны холбогдох газарт олгох нь төрийн захиргааны төв байгууллагаас хэрэгжүүлэх хяналт-шинжилгээ, хяналт шалгалт, үнэлгээг гүйцэтгэх, нэгдсэн тоо мэдээлэл үнэн бодитоор гарахад чухал нөлөөтэй болохыг анхаарах шаардлагатай байна.

Зөвлөмж

1. Мэдээллийн санг нээлттэй болгох замаар эрх бүхий байгууллагуудаас гадна хэрэглэгчид хангагч байгууллагын үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологийн, эдийн засгийн үзүүлэлтийн талаар нээлттэйгээр мэдээлэл авах боломжийг бүрдүүлэх
2. Мэдээллийн санд байршиж буй инженер, мэргэжилтнүүдийн давхардал хийдлийг нягтлах

12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтын хэрэгжилт

Хүснэгт № 22 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
5	12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт Тусгай зөвшөөрөл, түүний ангилал	12.1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөлөөс олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

Судалсан байдал

ХСУХАТАҮЗЗ-ийн Тусгай зөвшөөрлийн алба нь УХАТ-ийн ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хуулийн этгээдэд олгох, сунгах, хүчингүй болгох тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах, УХАТ-ын ашиглалттай холбоотой маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх, холбогдох дүрэм журмыг боловсруулан батлуулах зэрэг тусгай зөвшөөрлийн зохицуулалтын чиг үүргийг хэрэгжүүлж байна. Тусгай зөвшөөрлийн алба нь нийт 5 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг бөгөөд албаны дарга 1, ахлах мэргэжилтэн 1, мэргэжилтэн 3 орон тоотой байна.

Тусгай зөвшөөрлийн алба нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.14 дэх хэсэгт заасан Барилга, хот байгуулалтын чиглэлээр нийтийн аж ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх байгууллагад тусгай зөвшөөрөл олгох асуудлыг хариуцаж байна. Энэ хүрээнд ХСУХАТАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасны дагуу Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөлөөс олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

ХСУХАТАҮЗЗ-өөс УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний салбарт зохицуулалт хийхэд шаардлагатай, холбогдох 20 гаруй дүрэм, журам, аргачлалыг боловсруулан баталж, хэрэгжүүлж байна. Үүнд:²³²

1. Аж ахуйн харилцааны дүрэм /2017.05.19-ний 74 тоот тогтоол/
2. Ус хангамж, ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд хэрэглэгчийг холбох техникийн нөхцөл олгох журам
3. ТЗЭ-дэд олгох шагналын журам
4. Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээний үнэ тарифын саналыг хянан шалгах дотоод журам
5. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний загвар, түүнийг хэрэглэх журам
6. Тусгай зөвшөөрөл бүхий бохир ус зөөвөрлөх автомашинд хэрэглэх таних тэмдэг буюу лого ашиглах журам
7. Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага /2016.12.07-ны 98 тоот тогтоол/ зэрэг ТЗЭ-чдэд чиглэсэн хэм хэмжээний актуудыг баталсан байна.

ХСУХАТАҮЗЗ-ийн 2016 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 98 дугаар тогтоолоор баталсан Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад ХСУХАТАТХ-ийн 12 дугаар зүйлд заасан 14 тусгай зөвшөөрлийн ангиллыг 11 болгон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг дараахь байдлаар багцалсан байна. Тухайлбал:

1. ХСУХАТАТХ-ийн 12.2.1.хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ;
2. ХСУХАТАТХ-ийн 12.2.2.ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ;
3. ХСУХАТАТХ-ийн 12.2.3, 12.2.4 цэвэр ус дамжуулах, түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ;
4. ХСУХАТАТХ-ийн 12.2.5.орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ;
5. ХСУХАТАТХ-ийн 12.2.6.ус дамжуулах төвийн ашиглалт, засвар, үйлчилгээ;
6. ХСУХАТАТХ-ийн 12.2.7, 12.2.8, 12.2.9 Бохир усны гаргалгааны, цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар үйлчилгээ
7. ХСУХАТАТХ-ийн 12.2.10.бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ;
8. ХСУХАТАТХ-ийн 12.2.11.ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ;
9. ХСУХАТАТХ-ийн 12.2.12.хот, суурины ус түгээх байрны ашиглалт, засвар, үйлчилгээ;
10. ХСУХАТАТХ-ийн 12.2.13.зөөврийн ус хангамжийн үйлчилгээ;
11. ХСУХАТАТХ-ийн 12.2.14.бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ зэргээр багцлан 11 төрлийн нөхцөл, шаардлага тавьж байна.

²³² Мөн тэнд

Анкетын судалгаанд хамрагдсан ТЗЭ байгууллагуудын 76.2 хувь нь тусгай зөвшөөрлийг багцлах хэрэгцээ шаардлагатай гэж үзэж байна.

График № 9 Тусгай зөвшөөрлийг багцлах хэрэгцээ, шаардлага бий эсэх



Мөн ТЗЭ байгууллагууд ХСУХАТАҮЗЗ-өөс авсан тусгай зөвшөөрлийн дагуу 100 хувь үйл ажиллагаа явуулж байгаа гэжээ. ХСУХАТАтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт тусгай зөвшөөрлийн ангиллыг 14 төрөлд

хуваасныг багцлах хэрэгцээ шаардлагатай талаар анкетын судалгаанд хамрагдсан ТЗЭ байгууллагууд болон салбарын мэргэжилтнүүдтэй ганцаарчилсан ярилцлага зохион байгуулах үеэр онцолж байв. Мөн ХСУХАТАҮЗЗ-өөс боловсруулсан Тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагад 14 төрлийн тусгай зөвшөөрлийг 11 болгон багцалж, ижил төстэй тусгай зөвшөөрөлд 1 төрлийн нөхцөл, шаардлага тавьж байна.

Хүснэгт № 23 ТЗЭ-ийн төрөл, тоо

№	ТЗЭ-чийн төрөл	Он/тоо						
		2012	2013	2014	2015	2016	2017	2018
1	УСУГ болон аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагууд	39	42	44	42	42	48	50
2	Орон сууц ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагууд:							
	Үүнээс: УБ хотын улсын өмчит	23	24	3	6	6	4	3
	УБ хотын хувийн хэвшлийн	33	43	52	63	78	77	79
3	Бохир ус тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхэлдэг компани	0	5	20	27	28	40	41
4	УХАТ-ын туршилт, тохируулгын компани	0	1	1	1	0	1	2
5	Бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт эрхэлдэг байгууллага	1	1	1	1	1	1	1
6	Цэвэр ус олборлон цэвэршүүлдэг компани	2	7	9	8	7	1	2
	Дүн	98	123	130	148	162	172	178

ХСУХАТАҮЗЗ-өөс тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлж буй хуулийн этгээдийн тоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж буйг дээрх хүснэгтээс харж болно. Сүүлийн жилүүдэд өөрийн ус хангамжийн эх үүсвэр болох гүний худаг ашиглах, гэр хорооллын айл өрхүүд төвлөрсөн ус хангамжийн системд холбогдсоноор бохир усыг цооногт хуримтлуулан, зөврөөр татан зайлуулах хэрэглэгчдийн тоо өсөн нэмэгдэж, орон нутгийн байгууллагууд хэрэглэгч нэг бүрт хүрч үйлчлэхэд хүндрэлтэй болсноор хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд тусгай зориулалтын машинаар бохир ус зөөвөрлөх

үйлчилгээ эрхлэх болсонтой холбогдуулан энэ төрлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тоо огцом өсөхөд нөлөөлсөн байна.²³³

ХСУХАТАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт тусгай зөвшөөрлийг 14 төрөлд ангилсан боловч ХСУХАТАУ33-ийн Тусгай зөвшөөрлийн албанаас 14 тусгай зөвшөөрөл тус бүрээр бус Хүснэгтэд заасны дагуу УСУГ болон аймаг, орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллага, орон сууц ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, бохир ус тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхэлдэг компани, УХАТ-ын туршилт, тохируулгын компани, бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт эрхэлдэг байгууллага, цэвэр ус олборлон цэвэршүүлдэг компани гэсэн 6 төрлөөр ТЗЭ-чдийн тоон мэдээллийг гаргаж байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага хангасан хуулийн этгээд нь тусгай зөвшөөрөл шинээр авах болон сунгуулах тухай өргөдлөө эрхлэх үйл ажиллагааны төрөлтэй уялдуулан ХСУХАТАУ33-өөс боловсруулсан маягтын дагуу холбогдох бичиг баримтыг хавсарган ирүүлэх бөгөөд үндсэн 3 төрлийн маягтын дагуу тусгай зөвшөөрлийн төрлөөс хамаарсан ялгаатай материалыг бүрдүүлж байна. Мөн тусгай зөвшөөрөл авч буй төрөл бүр дээр үйл ажиллагааны танилцуулга, тайлбар өгөхийг тухайн маягтад зааж өгчээ. Өргөдлийн маягтын ангиллыг авч үзвэл:


1. Аймаг, орон нутгийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ эрхлэх байгууллага: ХСУХАТАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан 14 төрлийн тусгай зөвшөөрлийг хүссэн ТЗЭ бөгөөд 2018 оны байдлаар 50 ТЗЭ ХСУХАТАУ33-д бүртгэлтэй байна.
2. Орон сууцны ашиглалт, үйлчилгээ эрхлэх байгууллага: ХСУХАТАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан дараах 5 төрлийн тусгай зөвшөөрлийг эзэмшигч бөгөөд 2018 оны байдлаар 82 ТЗЭ ХСУХАТАУ33-д бүртгэлтэй байна.
3. Бохир ус тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхэлдэг компани: ХСУХАТАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2.4 дахь хэсэгт заасан бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг хүссэн хуулийн этгээд тухайн маягтыг бөглөж ирүүлнэ. Бохир ус тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхэлдэг ТЗЭ 2018 оны байдлаар 41 бүртгэлтэй байна.

ТЗЭ-дээс ирсэн санал, хүсэлтийн дагуу судалгаа явуулсны үндсэн дээр Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг багасган тогтоох саналыг Зохицуулах зөвлөлөөс БХБЯ-нд 2012 оны 12 дугаар сарын 24-ны өдөр хүргүүлсэн бөгөөд уг санал дэмжигдсэнээр Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 136 дугаар тогтоолоор Улсын тэмдэгтийн хураамжийг 400.000 төгрөг болгон бууруулсан нь Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын аж ахуйн нэгж, байгууллагуудад тулгарч байсан зарим дарамтыг бууруулах ач холбогдолтой болсон²³⁴.

²³³ Мөн тэнд

²³⁴ <http://www.wsrc.mn/new/mn/contents/23>

График № 10 Тусгай зөвшөөрлийн жилийн хураамжийн хэмжээ тохиромжтой эсэх



Тусгай зөвшөөрлийн жилийн хураамжийн хэмжээнд ТЗЭ байгууллагуудын 61.7 хувь нь сэтгэл хангалуун, тохиромжтой гэж үзэж байна. Гэсэн хэдий боловч 38.3 хувь буюу 3 ТЗЭ-чийн 1 нь тусгай зөвшөөрлийн жилийн хураамжийн хэмжээ өндөр, бууруулах шаардлагатай гэж үзэж байна. Энэ нь ашиглаж буй тусгай зөвшөөрлийн хэмжээ болон хэрэглэгчдийн тооноос тодорхой хэмжээнд хамааралтай байна.

Судалгаанд хамрагдсан ТЗЭ-ийн 59.6 хувь нь тусгай зөвшөөрлийг 3 жилээр сунгаж буй нь тохиромжгүй байна гэж үзжээ. Ялангуяа тогтвортой үйл ажиллагаа явуулдаг, эдийн засгийн болон хүний нөөц, техник технологийн чадавхитай ТЗЭ-дэд 5 хүртэл жилээр тусгай зөвшөөрлийг сунгаж өгөх нь тохиромжтой гэж үзжээ.

График № 11 Тусгай зөвшөөрлийг сунгаж буй хугацаа тохиромжтой эсэх





График № 12 ХСУХАТAmX-иар ТЗЭ-д үүрэг болгосон заалтын хэрэгжилтийн байдал



Гэрээний нөхцөлд тохирсон тоо, хэмжээ, стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах, технологийн дагуу цэвэрлэх, чанар, аюулгүй байдлын шаардлагад хяналт тавих байдал хэрэгждэггүй гэж судалгаанд хамрагдсан ТЗЭ-чдийн 6.4 хувь нь хариулжээ. Энэ нь практик дээр хэрэгжих боломжгүй бөгөөд зэв их гарч байгаа, улсын байцаагчийн эрхтэй холбогдсон өөрчлөлтөөр хяналт хийх боломжгүй зэрэг асуудал тулгардаг байна.

Хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулахад зориулсан тоног төхөөрөмж суурилуулах, туршилт тохируулга хийж, аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөөгөөр хангах үүрэг хэрэгждэггүй гэж судалгаанд хамрагдсан ТЗЭ байгууллагуудын 4.3 хувь нь хариулжээ. Тухайн заалт хэрэгжихгүй байгаа шалтгаан нь төвлөрсөн бохирын шугам байхгүй газруудтай холбоотой байдаг байна. Зөөврийн машинаар бохир усыг зайлуулдаг эсхүл цэвэрлэх байгууламжийн хүчин чадлын 40-50%-г ашигладаг учир бохирын нэгдсэн төв шугамтай болох шаардлагатай. Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал багадаж байгаа талаар онцолж байв.

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаарх хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөх байдал хэрэгждэггүй гэж ТЗЭ-чдийн 2.2 хувь нь хариулжээ. Мөн түүнчлэн практик дээр гэрээний үүргээ биелүүлээгүй хэрэглэгчийг усаар хангахгүй байх заалтыг хэрэглэх боломжгүй байна.

Өөрийн ашиглалт, өмчлөлд байгаа инженерийн барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжид технологийн шаардлагын дагуу засвар, үйлчилгээ, шинэчлэлтийг тогтоосон хугацаанд нь хийх үүрэг хүлээсэн заалт хэрэгждэггүй гэж судалгаанд хамрагдсан ТЗЭ-чдийн 8.7 хувь нь хариулжээ. Хэрэгжихгүй байгаа шалтгаан нь норм, дүрмийн талаар мэдлэг хангалттай биш, солих шаардлагатай шугам сүлжээг 100% солих санхүүгийн боломж байдаггүйтэй холбоотой байна.

Гэнэтийн осол, аваар гарсан болон зайлшгүй урьдчилан сэргийлэх, засвар, үйлчилгээ хийх үед энэ тухай хэрэглэгчид мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээ авах үүрэг болгосон заалтын хэрэгждэггүй гэж ТЗЭ-чдийн 2.2 хувь нь хариулжээ. Хэрэгжихгүй байгаа шалтгаан нь зарим үед урьдчилж мэдэгдсэн тохиолдолд хэрэглэгчид ус их хэмжээгээр нөөцөлж ажилд хүндрэл учруулдаг талаар ТЗЭ-чид онцолжээ.

ХСУХАТАҮЗЗ-өөс ХСУХАТАтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.8-д заасны дагуу “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийг шинэчлэн баталж, Улсын бүртгэлд 2017 оны 06 дугаар сарын 14-ний өдөр бүртгүүлсэн байна. Тус аж ахуйн харилцааны дүрмээр ТЗЭ хоорондын харилцааг зохицуулж байгаа бөгөөд ТЗЭ-чид хоорондын харилцаанд нийтлэг тулгардаг асуудлын талаар судалгаанд оролцсон ТЗЭ-ид дараахь саналуудыг өгсөн байна. Үүнд:

1. Адил эрхтэй ажилладаг боловч нэгнийхээ эзэмшдэг эд хөрөнгө рүү дайрч булааж авдаг,
2. Зэвтэй усыг хөнгөлөх,
3. Спирт бал бурам ХХК-тай бохир усны төлбөрийн асуудалтай тулгарч байсан,
4. Тоолуурын маргаан тулгардаг,

5. УСУГ-аас ирсэн нэхэмжлэлийн дагуу сар бүр төлж өргүй гардаг ч 25-аас хойш тоолуур салгаж байрыг нийтээр нь усыг хааж байсан,
6. Цемент шохой ХК-тай холбоотой усны тоолуурын заалт зөрүүтэй гарч асуудал тулгарсан,
7. Цэвэр усаар хангах асуудал нь МУ-ын үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой учир өндөр нөхцөл шаардлагаар бусад байгууллагад тусгай зөвшөөрөл олгох ёстой байтал тусгай зөвшөөрлийн шаардлага доогуур байна зэрэг асуудлыг дурджээ.

Үнэлсэн байдал

ХСУХАТАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөлөөс олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ гэх заалтын хэрэгжилт ПРАКТИКТ ХЭРЭГЖИХГҮЙ байна гэж үнэллээ.

Ийнхүү үнэлэх үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлов. Үүнд:

1. ХСУХАТАТХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан 14 төрлийн тусгай зөвшөөрлийг багцаар нь авахад болон бохир ус соруулах, зөөвөрлөх гэсэн 1 төрлийн тусгай зөвшөөрөлд ч ялгаагүй ижил үнийн дүн бүхий тэмдэгтийн хураамж төлж буй нь учир дутагдалтай байна.
2. Тухайлбал тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрийн дагуу явуулж буй үйл ажиллагааны тайлан мэдээлэл гаргуулах, мөн тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрийн дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийх боломж хязгаарлагдах эрсдэл үүсч байна.

Зөвлөмж

1. Тусгай зөвшөөрлийг практикт олгож буй төрлөөр багцлах,
2. Тусгай зөвшөөрлийн хураамжийн төлбөрийг тусгай зөвшөөрөл авч буй төрөл, түүний тоотой уялдуулах
3. Тусгай зөвшөөрлийн хугацааг тогтвортой үйл ажиллагаа явуулж буй, эдийн засгийн чадамжтай ТЗЭ-дэд 5 хүртэл жилээр сунгаж олгох боломжийг судлах

15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтын хэрэгжилт

Хүснэгт № 24 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт


№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
6	15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт Хэрэглэгчийн эрх, үүрэг	15.1.3.цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх;

Судалсан байдал

Улаанбаатар хотын хэмжээнд ТЗЭ 66 байгууллагын хүний нөөцийн дунд хийсэн судалгаагаар 112322 хэрэглэгчид нийт 1431 ажилтан ногдож байгаа бөгөөд энэ нь 1000 хэрэглэгч тутамд 22 ажилтан ногдож буй үзүүлэлт юм. ТЗЭ-чдийн хүний нөөцийн хүчин чадлыг 1000 хэрэглэгчид ногдож буй ажилтны тоогоор авч үзэхэд ОСНААУГ 1000 хэрэглэгч тутамд 141 ажилтан ногдож буй нь хамгийн өндөр үзүүлэлт байгаа бол Жинст

Өргөө ХХК 1000 хэрэглэгч тутамд 4.6 ажилтан ногдож буй нь хамгийн бага үзүүлэлт байна.²³⁵ Харин орон нутгийн ТЗЭ-чдийн хувьд 1000 хэрэглэгч тутамд 37.9 ажилтан ногдож байгаа нь Улаанбаатар хотоос илүү хүртээмжтэй байгаа юм. Энэхүү үзүүлэлтээс ТЗЭ-чдийн хүний нөөцийн чадавхи харилцан адилгүй байгааг харж болох юм. Мөн түүнчлэн ТЗЭ-д тавигдах нөхцөл, шаардлагад хэрэглэгчийн тоо болон ажилтан, албан хаагчдын тоон хамаарлын харьцааг уялдуулах хэрэгцээтэй байна.

График № 13 ТЗЭ байгууллагаар үйлчлүүлж буй орон сууцны айл өрхийн тоо²³⁶



ХСУХАТАҮЗЗ-ийн Тусгай зөвшөөрлийн албаны мэдээллээр 2018 оны 01 сарын 01-ны өдрийн байдлаар ТЗЭ байгууллагуудын хэрэглэгч орон сууцны айл өрх 202923, ААНБ 11840 байна гэжээ. ТЗЭ байгууллагуудын хэрэглэгчдийн тоо жил ирэх тусам өсөн нэмэгдэж байгаа бөгөөд хэрэглэгчдэд хүртээмжтэйгээр, цаг тухай бүрт хүрч үйлчлэх асуудал тулгамдах шинжтэй байна.

2018 оны 10 сарын байдлаар ТЗЭ байгууллагуудад хэрэглэгчээс ирсэн нийт санал, засварын дуудлагын тоо 89977 бүртгэгдсэн байна. Үүнд:

- Усны тасалдал – 11,511 буюу 13%
- Усны чанартай холбоотой – 11,491 буюу 13%
- Үйлчилгээний соёлтой холбоотой – 1,507 буюу 2%
- Төлбөр тооцоотой холбоотой – 4,041 буюу 4%
- Дуудлагын засвар үйлчилгээний - 61,427 буюу 68%-ийг тус тус эзэлж байна. Нийт санал, дуудлагын үйлчилгээний барагдуулалт – 99.7%-тай гарсан байна.

Судалгаанд хамрагдсан ТЗЭ байгууллагуудын зүгээс хэрэглэгчийн зүгээс гомдол санал их ирүүлж буй асуудлыг дараах байдлаар нэрлэж байна. Үүнд.

1. Амралтын өдрүүдэд өндөр давхруудад ус хүрэхгүй болдог, өндөр барилгад дээд давхарт ус хүрэхгүй, УСУГ даралт хагас бүтэн сайнд их муу хүрэхгүй байна
2. Угаалтуур бөглөрөх
3. Дундын эзэмшлийн шугам сүлжээ

²³⁵ ХСУХАТАҮЗЗ, Хүний нөөцийн судалгаа, 2018

²³⁶ ХСУХАТАҮЗЗ, Тусгай зөвшөөрлийн албаны мэдээлэл, Орон сууцны айл өрхийн судалгаа, 2018.01.01

4. Зэвтэй ус байнга гарч шугам хоолой хурдан цоорч байна. Төвийн бохирын шугам хэвийн ажиллахгүй байгаа нь эрүүл мэндэд хортой. Зэвтэй ус, УСУГ эх үүсвэр муудсан. Ус зэвтэй байна, шугам сүлжээг ПВС хийх
5. Техник нэмэх, ажилтан нэмэх, шаардлагатай орон тоогоор ажиллах
6. Тоолуур үнэн зөв зааж байгаа эсэх дээр
7. Тоолуурын заалтаа цаг хугацаандаа өгдөггүйгээс үүссэн төлбөрийг их байна гэдэг гомдол ихэвчлэн гардаг
8. Усны хатуулгийн талаар хэрэглэгчдээс гомдол санал ирж байна гэжээ.

ХСУХАТАТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь хэсэгт заасны дагуу хэрэглэгч нь цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх үүрэгтэй. Гэсэн хэдий боловч төлбөрөө төлдөггүйгээс ТЗЭ-д хангагч байгууллага буюу УСУГ-т усны үйлчилгээний төлбөр төлөөгүйн улмаас усаа хязгаарлуулах, их хэмжээний өр үүсэх зэрэг асуудлууд тулгардаг байна.

Хүснэгт № 25 УСУГ, Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн өр авлагын жагсаалт

Д/д	Хэрэглэгчийн нэр	2018.09.30-ны байдлаар өр
1	Ган тус өргөө ХХК /о.с/	29,864,676.9
2	Ган тус өргөө ХХК /41-р байр/	14,247,084.7
3	Би би инженеринг ХХК /30,35а,35б,2б,3а,6а,6б,хц-49,24,5х-24/	20,678,968.5
4	Чандмань Налайх ОНӨААТҮГ	2,502,504,460.0
5	Ганманлай ХХК орон сууц /31/	14,692,842.1
6	Дэнж хотхон ХХК /44/1-44/4/	1,782,194.0
7	Дэнж хотхон ХХК /62-р байр/	2,610,772.4
8	Зүмбэр Орд өргөө ХХК /о.с//85/	88,110,910.4
9	УНК ХХК	12,914,141.1
10	Комфорт монгол нэтворк ХХК /66а/	8,058,472.3
11	Тохилог шинэ ертөнц ХХК /ос//100/	4,096,649.7
12	Бадамлах нар ХХК /112,113/	5,582,181.7
13	Цэцэнбээс ХХК /26-4,26-5/	4,195,041.9
14	Жи Эй Би Өү Ти ХХК /1001-1022,1025-1032/	4,999,999.6
Дүн		2,714,338,395.2

УСУГ нь ХСУХАТАУЗЗ-өөс 14 төрлийн тусгай зөвшөөрлийг эзэмшиж буй бусад ТЗЭ-чдийн хангагч байгууллага юм. УСУГ-т өр авлага бүхий ТЗЭ байгууллагууд нь гэрээ хийсэн хэрэглэгч буюу айл өрх, ААНБ-аас төлбөрийг авч чадаагүй учраас их хэмжээний өр төлбөрт орох асуудал үүсч байна.

Шигтгээ

Хангагч байгууллага болох УСУГ усны төлбөрөө төлөөгүй гэсэн шалтгаанаар ус таслах тохиолдол гардаг. Хэрэглэгч айл өрхүүдийн хувьд алаг цоог төлбөрөө төлдөг, огт төлдөггүй өр нь хураагдчихсан айл өрхүүд ч байна. УСУГ-аас ус хязгаарлахдаа төлсөн, төлөөгүй гэж ангилалгүй, нийтээр нь хэрэглээний цэвэр усыг хаадаг. Мөн өр авлагаа хугацаандаа төлөөгүй гэсэн шалтгаанаар өр барагдуулах арга хэмжээг шүүхийн шатанд хүртэл авдаг. Гэтэл ТЗЭ-чдийн хувьд хэрэглэгч болох айл өрх, ААНБ-ээс хангасан усны төлбөрийг авч чадаагүй учир

төлбөр төлөх боломжгүй байдаг. Иймд хэрэглэгчийн үүргийг өндөрсгөх, тухайн төлбөр төлөөгүй хэрэглэгчийн усыг хязгаарлах, УСУГ-аас шүүхээр нэхэмжлэл гаргуулахдаа ТЗЭ-тэй биш төлбөр төлөөгүй айл өрх, ААНБ-аас хамтарч нэхэмжилдэг байх хэрэгтэй байна.

ТЗЭ-тэй хийсэн ярилцлагаас


График № 14 Хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, учирсан хохирлоо төлүүлэхийг шаардах ТЗЭ-ийн эрхийн хэрэгжилт



Судалгаанд хамрагдсан ТЗЭ байгууллагуудын 23.4 хувь нь хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, учирсан хохирлоо төлүүлэхийг шаардах хуулийн заалт хэрэгжихгүй байна гэжээ. Энэ нь дараахь шалтгаантай байна. Үүнд:

1. Айл өрхийн усыг хязгаарлах боломжгүй тул гэрээнд заасан заалт хэрэгжих боломжгүй.
2. Жил, олон сар дамнасан хэрэглэгчдийн тоолуурыг салгах эрхгүй байдаг нь хүндрэлтэй байдаг.
3. ОНӨХК Эрдэнэт-Ус 2-н гэрээний үүргийн биелэлтэнд аймгийн ИТХ, ЗДТГ-с Эрдэнэт үйлдвэрт шахалт үзүүлдэг.
4. Төлбөр төлөөгүй 1 жилээс дээш өртэй хэрэглэгчийг шүүхээр шийдвэрлүүлж байна. Бусад тал дээр эрх зүйн орчин сул байдгаас хэрэглэгчдэд шаардлага мэдэгдэх хуудас өгөхөөс өөр арга хэмжээ авч чаддаггүй.
5. Хариуцсан байцаагч, хууль зүйн орчин байхгүй дутмаг.
6. Хэдийгээр хуулинд заасан байгаа ч хэрэгждэггүй, механизм нь бүрхэг.
7. Хэрэглэгч тус бүрийн усны шугамыг хаах, хязгаарлах боломжгүй. Нийтийн эрх ашиг хөндөгдөх тул гэрээг цуцлах боломж байхгүй.

График № 15 Цэвэр усны төлбөр, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөр зохистой эсэх



Судалгаанд хамрагдсан ТЗЭ байгууллагуудын 48.7 хувь нь цэвэр усны төлбөр, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөр зохист хэмжээнд байна гэж үзсэн бол 36.6 хувь нь бага байна, өсгөх шаардлагатай

гэсэн байр суурьтай байна.

Үнэлсэн байдал

ХСУХАТАТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь хэсэгт заасан цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх хэрэглэгчийн

үүргийг судалсны үндсэн дээр уг заалтын хэрэгжилт ПРАКТИКТ ХЭРЭГЖИХГҮЙ байна гэж үнэллээ.

Ийнхүү үнэлэх үндэслэлийг дараахь байдлаар тодорхойлов. Үүнд:

1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хангагч нь ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжид эрчим хүчний гэнэтийн тасалдал гарсан, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас усны хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай болсон, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжид ноцтой гэмтэл гарсан тохиолдолд цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох нөхцөл үүсэхээр байна.
2. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасны дагуу хангагч нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд аюултай нөхцөл байдал үүссэн, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд төлөвлөгөөт урсгал болон их засвар хийх болсон, цэвэр усны алдагдал, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн гэмтлийг тогтоосон хугацаанд засварлаагүй, ус хангамжийн байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд хангагчийн зөвшөөрөлгүйгээр холбосон, усны тоолуурын битүүмжлэл, байрлал, холболтыг дураараа өөрчилсөн, энэ хуулийн 18.1-д заасны дагуу тогтоосон бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг хангаагүй бохир ус нийлүүлсэн нөхцөлд хэрэглэгчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагааг хязгаарлах буюу зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй байна.
3. Эдгээрээс бусад нөхцөлд хэрэглэгчийн цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагааг хязгаарлах буюу зогсоох боломжгүй байна. Гэсэн хэдий ч хангагч байгууллагаас авсан үйлчилгээний төлбөрөө төлөөгүй хэрэглэгчийг хангагч байгууллагаас хязгаарлах явдал практикт цөөнгүй тохиолдож байна.
4. Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль зөрчих буюу хангагч, эсхүл хэрэглэгч ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаархи хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэжээ. Энэ заалт нь хэрэглэгч гэрээнд заасны дагуу үйлчилгээний төлбөрөө төлөх үүрэгт мөн үйлчлэхээр байна.
5. Судалгаанд хамрагдсан ТЗЭ байгууллагуудын зүгээс хэрэглэгчтэй холбоотой дараахь нийтлэг асуудал тулгардаг гэв. Үүнд:
 - Дундын эзэмшлийн шугам хоолой цоорсон, эсвэл шугам сүлжээ рүү тамхины иш хийж шугам хоолойг шатаасан гэх мэт гэмтэл гарсан үед СӨХ засвар хийхэд шаардлагатай материалыг авч өгч чаддаггүйгээс хэрэглэгч хохирох асуудал гардаг. Иймд дундын өмчлөлийг мэргэжлийн байгууллагад ОСК-т хариуцуулах хууль эрх зүйн орчин шаардлагатай байна. Мөн дундын байгууллагуудын шугам хоолой цоорох, бохир бөглөрөх үед УСУГ тухайн гэмтлийг болон бөглөрлийг

засварт хамрагдах байгууллагууд ижил хэмжээгээр зардлыг хувиар нэхэмжилж авах хэрэгтэй. Ихэнх тохиолдолд контор дангаараа хийдэг.

- Зарим хэрэглэгчид тоолуурын заалт өгдөггүй, тоолуураа албаар гацаах, хэрэглэсэн усаа нууж ухраах гэх мэт асуудал үүсдэг. Үүнд арга хэмжээ авахад дургүйцдэг. Мэргэжлийн хяналтад гомдол гаргадаг.
- Түр ус хаах, бохир шингэн бөглөрөх үед бухимдал хэрэглэгчээс ирдэг. Хэрэглэгч хаан гэсэн байдлаар ханддаг.
- Хэрэглэгч ОСНААУГ, хувийн контор, УСУГ-ийн ялгаа тус тусдаа бие даасан газар гэдгийг мэддэггүй.
- Хэрэглэгчдийн зүгээс гаргасан буруутай асуудлыг шийдвэрлэх эрх мэдэл (торгох арга хэмжээ) байхгүй.
- Шугам засварлах үед тодорхой хугацаанд зэвтэй ус гардаг. Зарим өндөрлөг газарт усны даралт багасдаг.

Зөвлөмж

1. Хэрэглэгчдийн тоолууржилтыг жил бүр тодорхой хувиар өсөн нэмэгдүүлэх замаар ОБУ-ны хувийг бууруулах
2. Төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөөгүй хэрэглэгчийн цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээг хязгаарлах эрх зүйн боломжийг бүрдүүлэх
3. Хангагч байгууллага, түгээгч байгууллага, эцсийн хэрэглэгчдийн ялгааг тодорхой болгох замаар эцсийн хэрэглэгчийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх

18 дугаар зүйлийн 18.2 дэх заалтын хэрэгжилт

Хүснэгт № 26 18 дугаар зүйлийн 18.2 дэх заалтын хэрэгжилт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
7	18 дугаар зүйлийн 18.2 дахь заалт Цэвэрлэх байгууламж	18.2.Цэвэрлэх байгууламжийн байршлыг дараах зүйлийг харгалзан тогтооно: 18.2.1.хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө; 18.2.2.байгалийн гэнэтийн аюул /усны үер, гал түймэр, газар хөдлөлт г.м/-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө; 18.2.3.цэвэрлэх байгууламжийг өргөтгөх боломж; 18.2.4.хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох талбай; 18.2.5.ажиллагсдын эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын болон аюулгүй ажиллагааны нөхцөл. 18.3.Цэвэрлэх байгууламж нь саарал усыг цэвэршүүлэн эргүүлэн ашиглах технологи бүхий тоног төхөөрөмжтэй байна. 18.4.Цэвэрлэсэн бохир усны найрлагад эрүүл мэнд, байгаль орчны хяналтын алба, технологийн горимд дэд бүтцийн хяналтын алба тус тус хяналт тавина. 18.5.Үйлдвэрийн хэрэглээнээс гарсан бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэсний дараа татан зайлуулах шугам сүлжээнд нийлүүлэх, технологийн хэрэглээндээ эргүүлэн ашиглана.

Судалсан байдал

ХСУХАТАТХ-ийн 18 дугаар зүйлд цэвэрлэх байгууламжийн байршил тогтоох, цэвэрлэх байгууламж саарал усыг эргүүлэн ашиглах, цэвэрлэх байгууламжийн бохир усны найрлага, технологийн горимд хяналт тавих, үйлдвэрлэлийн усыг урьдчилсан цэвэрлэх байгууламжаар дамжуулах зэрэг харилцааг зохицуулахаар тусгасан байна.

УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зорилго бүхий энэхүү хуулийн зорилго нь хүн амын унд, ахуйн зориулалтын стандартын шаардлагад нийцсэн усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг стандартын шаардлагад нийцтэл цэвэрлэн байгальд нийлүүлэх замаар иргэдийн орчны бохирдлоос хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэгдсэн гэж үзэж болох юм.

УХАТ-ын үйлчилгээн нь ус олборлолтоос, цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал ус, лагийн ашиглалт хүртэлх бүхий л үйл ажиллагаа хамаарах шаардлагатай байдаг. Гэтэл одоогоор лагийг дахин боловсруулах, хоргүйжүүлэн байгальд нийлүүлэх асуудал эхлэл төдий байна.

Бохир усыг татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх төхөөрөмж, байгууламж нь улс орны хувьд нэн чухал дэд бүтэц юм. Бохир ус цэвэрлэх байгууламж нь байгаль орчин, хүн амд хор хөнөөл учруулахгүй байх ёстой ба цэвэрлэх байгууламжаас цэвэршүүлэгдэн гарсан хаягдал усыг дахин ашигладаг байх хэрэгтэй. Өнөөдрийн байдлаар үйлдвэр, уурхайн үйл ажиллагаанаас гарч буй бохир ус анхан шатны цэвэрлэгээгүйгээр их хэмжээгээр ариутгах татуургын системд буюу бохир ус цэвэрлэх байгууламжруу шууд нийлүүлэгдэж байгаа нь бохир ус цэвэрлэгээний цэвэршүүлэх төвшинг бууруулж, эдийн засгийн өндөр алдагдалд хүргэж байна. Ашиглалтын хугацаа хэтэрсэн бохир усны шугам сүлжээний хоолойд механик зүйлс, модны үндэс гэх мэт хаягдал шугам хоолойд нэвтэрч бөглөрөл үүсгэж, ашиглалтын үед хүндрэл үүсгэж байдаг. Түүнчлэн үйлдвэрээс хаягдах бохир усанд анхан шатны цэвэрлэгээ дутагдалтай хэвээр, гэр хорооллын бүсэд төвлөрсөн бус ус хангамж, ариутгах татуургын систем одоог хүртэл шийдэгдээгүй байдал үргэлжилсэн хэвээр байгаа нь УХАТ-ын ЦБ-ын асуудлыг хүндрүүлдэг.

Өнөөдөр Улсын хэмжээнд 130 гаруй бохир ус цэвэрлэх байгууламж /цаашид ЦБ гэх/ байгаа бөгөөд үүнээс хэвийн ажиллагаатай 51, хагас ажиллагаатай 27, огт ажиллагаагүй 47 байна²³⁷ гэсэн тоо баримт бий. Үүнээс харахад улсын хэмжээнд байгаа нийт ЦБ-ийн талаас илүү хувь нь үйл ажиллагааны доголдол, эвдрэлтэй байгаагаас үүдэн жилд 120 сая гаруй м³ бохир ус байгальд шууд хаягдаж, Туул, Хараа, Орхон, Хангал зэрэг голуудыг маш ихээр бохирдуулж байна гэж үздэг.

Гэхдээ Усны мэдээллийн сан дахь Усны барилга байгууламжийн мэдээллийн санд бүртгэгдсэн албан ёсны мэдээллээс харахад 2018 оны 11 сарын байдлаар 2013 оны улсын тооллогоор бүртгэгдсэн 98 цэвэрлэх байгууламж²³⁸ байна. Дээрхээс харахад усны мэдээллийн сан дахь мэдээлэл, албаны эх сурвалжаас өгсөн мэдээлэл хооронд ихээхэн


²³⁷ ХСУХАТАУ33-ийн мэдээллээс. 2018 он.

²³⁸ Усны барилга байгууламжийн мэдээллийн сан. Ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж <http://eic.mn/waterconstruction/?id=2&page=8>

зөрүү байгаа нь байгаль экологийн, усны нөөцийн бохирдол үүсгэхэд нөлөөлөх хамгийн том хүчин зүйлийн талаар баталгаатай нэгдсэн мэдээлэл байхгүй байна. Үүнийг ЦБ-ын асуудал бодлогын төвшинд хаана харьяалагдаж буй нь тодорхойгүй, түүний бүртгэл, мэдээллийг шинэчлэх ажил удаашралтай байгаатай холбож болох байна.

Усны мэдээллийн сангийн Усны барилга байгууламжийн мэдээллийн сан дахь мэдээлэлд дүн шинжилгээ хийхэд хүчин чадал болон бусад үзүүлэлтээр өндөр ЦБ-ийн дийлэнх нь УБ хотод байх ба тэдгээрийн дунд хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан урьдчилсан ЦБ цөөнгүй байна. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай ЦБ-ийн хувьд ХСУХАТАТХ-ийн хамгаалалтын болон

График № 16 Цэвэрлэх байгууламжийн ажиллагаа



эрүүл ахуйн бүс тогтоох, өргөтгөх боломжийг харгалзах, саарал усыг эргүүлэн ашиглах технологи бүхий тоног төхөөрөмжид тавигдах шаардлага хангах, хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах зэрэг асуудал хэрэгжихгүй байна. Үүний шалтгааныг хувийн компаниудын хувьд гол төлөв ноос, ноолуур, арьс, шир боловсруулах үйлдвэрүүд өөрийн өмчлөл, эзэмшлийн газарт ЦБ барих шаардлагатай тулгардаг, энэ нь хот төлөвлөлт гэхээсээ илүү үйлдвэрийн байршил, газрын хэмжээнээс илүү, хамаарч байгаа тул ХСУХАТАТХ-ийн 18.2-т тавигдаж буй шаардлагууд хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдсан ЦБ-ийн хувьд төдийлөн хэрэгжих боломжгүй байна гэж үзэж болох юм. Мөн хуулийн 18.5-д заасан “Үйлдвэрийн хэрэглээнээс гарсан бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэсний дараа татан зайлуулах шугам сүлжээнд нийлүүлэх, технологийн хэрэглээндээ эргүүлэн ашиглана.” гэх заалтын хэрэгжилт дийлэнх нь механик, химийн цэвэрлэгээ хийдэг, цэвэрлэсэн усаа төвлөрсөн шугам сүлжээнд шууд нийлүүлдэг эдгээр ЦБ-уудын хувьд хэрэгжихгүй байна. Зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэсний дараа татан зайлуулах шугам сүлжээнд нийлүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авч байгаа боловч энэ нь үр дүн муутай байдаг аж.

Харин уул уурхайн компаниудын хувьд шинээр баригдсан ЦБ-уудын харуул, хамгаалалтын, эрүүл ахуйн болон хамгаалалтын бүс тогтоосон байх, цэвэрлэсэн усаа дахин ашиглах асуудал хуулийн шаардлага хангасан байх боловч ийм ЦБ-тай компани хуруу дарам цөөн байгаад анхаарал хандуулах шаардлага байна.

Улсын болон орон нутгийн өмчит ЦБ-уудын хувьд байдал төдийлөн сайн биш байна. Эдгээрийн дийлэнх нь 70-80-аад онд ашиглалтад орсон, ашиглалтын байдал доголдолтой, бетон хийцүүд элэгдэж муудсан, хүчин чадал хүрэлцэхгүй болсны улмаас тэдгээрийн цэвэрлэсэн усны бохирдол өндөр, хаягдал усны бохирдлын хэмжээ MNS 5582:2006 стандартаас хэт давсан нийтлэг дүр төрхтэй байна. Иймээс хуучирсан, хэрэглээнээс гарсан, алдагдал өндөртэй болсон ЦБ-уудын эзэмшил тодорхойгүй болох эрсдэл гардаг байна. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Номгон сум дахь улсын хөрөнгөөр 1984 онд улсын хөрөнгөөр баригдсан ЦБ-д эзэмшигч, өмчлөгч байхгүй гэж бүртгэгдсэн,

ашиглаж байгаа боловч, тоног төхөөрөмж тоногдсон²³⁹ зэрэг мэдээлэл бүхий бүртгэлтэй байгаа нь анхаарал татаж байна.

Улсын хэмжээнд төсвийн болон гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрийн хүрээнд ЦБ-уудыг сайжруулах, шинээр барих асуудал эрчимтэй хэрэгжиж эхлэх суурь

Зураг № 12 Цэвэрлэх байгууламжийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл хөтөлбөр



болжээ. Одоо ажиллаж буй ЦБ-ийг сайжруулах, түүнээс гарсан хаягдал усыг дахин ашиглах боломжийг бүрдүүлэх зорилгоор төрөөс гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран хэд хэдэн томоохон төсөл хэрэгжүүлж байна. Тухайлбал, АХБ-ны 21.17

сая америк долларын зээлээр 9 аймгийн ЦБ-г шинээр болон шинэчлэн барихаас 5 аймгийн ЦБ баригдаж эхэлсэн, эхнээсээ ашиглалтад орсон байна. Харин Польш Улсын ЗГ-ын хөнгөлөлттэй зээлээр 5 ЦБ барих ажил төлөвлөгдөж байна. Эдгээр төслүүд хэрэгжсэнээр аймгийн төвийн иргэдийн хэрэглээнээс гарсан бохир усыг цэвэршүүлэх, эргүүлэн ашиглах асуудал шинэ шатанд гарах, мөн ЦБ-ын зардал буурах зэрэг дэвшил гарна гэсэн хүлээлттэй байна.

Дээрхээс гадна ЦБ-ын үйл ажиллагааг сайжруулах, орчин үеийн технологийн шаардлагад нийцүүлэх, саарал усыг хэрэглэх боломжийг бүрдүүлэх талаар авч хэрэгжүүлж буй нэг томоохон ажил бол Мянганы сорилтын корпорацитай байгуулсан 2 дахь Компакт гэрээний хүрээнд авах 350 сая америк долларын буцалтгүй тусламжийн асуудал юм. 2018 онд байгуулсан уг гэрээний дагуу Улаанбаатар хотын газрын доорх усны доод эх үүсвэрийг шинээр байгуулах, хаягдал усыг дахин боловсруулж, үйлдвэрийн зориулалтаар ашиглах, усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааг хэрэгжүүлж, холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг ажлыг 2023 он хүртэл 3 үе шаттай гүйцэтгэх юм. Үүнд ЦБ-тай холбоотойгоор саарал усыг дахин ашиглах дэд бүтцийг бий болгох, тухайлбал цэвэрлэсэн усыг ДЦС-д хэрэглэх боломжийг бүрдүүлэх асуудал тусгагджээ.

Өнөөдөр улсын хэмжээнд ЦБ, ариун цэврийн байгууламжид хамаарах маш олон эрх зүйн акт хүчин төгөлдөр мөрдөгддөг боловч түүнийг мэддэг хүн, ААН цөөн байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан болж байна.

Тухайлбал, төвлөрсөн ариутгах татуургын системд холбогдоогүй газруудад амралт, сувиллын газар, авто зам дагуу цогцолбор үйл ажиллагаа явуулахад Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй Байгаль орчныг хамгаалах тухай, Хот, суурины ус хангамж,

²³⁹ Сэлэнгэ, Номгоны ЦБ-ийн тухай. Эх сурвалж: <http://eic.mn/waterconstruction/?id=2&page=4&action=more&gid=66>

ариутгах татуургын ашиглалтын тухай, Хог хаягдлын тухай, Усны тухай, Эрүүл мэндийн тухай, Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай зэрэг хууль тогтоомжийн хүрээнд²⁴⁰ барилга, байгууламжийг барих угсрах, үйлчилгээ явуулах шаардлагатай байдаг. Эдгээр хууль тогтоомжид ариун цэврийн байгууламж, түүнээс үүссэн хүний эрүүл мэнд, орчны эрүүл ахуйд үзүүлэх сөрөг нөлөөлөл, хөрс, усны чанарыг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр салбарын яамд, төв болон орон нутгийн удирдах байгууллагын үйл ажиллагааны чиглэл, үүрэг хариуцлагын болон хяналтын механизмыг тодорхой зааж өгсөн байдаг. Үүнд: Төвлөрсөн ариутгах татуургын системд холбогдоогүй газруудад барьж буй ариун цэврийн байгууламжуудад хамаарах 5 стандарт²⁴¹, ЦБ-ийн үйл ажиллагаа, байршил, хаягдал ус болон лагт хамаарах 8 стандарт²⁴², мөн урьдчилсан болон төв ЦБ, тэдгээрээс гарсан хаягдал устай холбоотой, бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ, үндсэн шаардлагууд, төвлөрсөн бус АЦБ-тай холбоотой 20 орчим стандарт хэрэгжиж байна

Хүн амын ундны усны аюулгүй байдлыг хангах асуудалд чухал нөлөө бүхий асуудал бол хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, ЦБ-аас гарсан усыг стандартын шаардлагын төвшинд хүргэх, түүнийг байгальд эргүүлэн нийлүүлэх зэрэг асуудлаар цөөнгүй хурал, хэлэлцүүлэг зохион байгуулагддаг боловч тодорхой үр дүнд хүрэх нь ховор байдаг. Учир нь эдгээр хурал, зөвлөгөөнөөр ус хангамж ариутгах татуургын системийг боловсронгуй болгох цаашид тогтвортой хөгжүүлэх чиглэлээр тулгамдаж буй асуудлуудыг талууд харилцан сонсдог, ярилцдаг хэдий ч ашгийн бус энэ салбарын санхүүжилтийг шийдвэрлэж чаддаггүйн улмаас гацдагтай холбоотой байна.

Хүн амыг аюулгүй, чанартай усаар хангах нь нь дэлхий нийтийн тулгамдсан асуудлын нэг. УХАТ-ын салбар өнөөдөр зөвхөн аюулгүй, чанартай ус гэх ойлголтоос хальж усны хүртээмжтэй байдал, усны нөөцийн аюулгүй байдлыг анхаарах шаардлага үүсч байна. Учир нь УХАТ салбар нь өөрөө ус түгээгчээс гадна ус бохирдуулагч субъект болсонтой холбоотой юм. УХАТ-ын салбарын гинжин холбоотой үйл ажиллагаа ус олборлолтоос

²⁴⁰ Монгол Улсын хууль – 6 УИХ-ын тогтоол – 2 Засгийн газрын тогтоол – 4 Салбарын сайдуудын хамтарсан тушаал -3 Сайдын тушаал – 1 Стандарт – 6

²⁴¹ MNS5924:2015, Нүхэн жорлон угаадасны нүх техникийн шаардлага стандарт

MNS5824:2007, Аялал жуулчлалын байр сууцны төрөл, үндсэн шаардлага

MNS6426:2013, Тусгай хамгаалалттай газар нутаг дахь эко аялал жуулчлалын зориулалттай байр сууц.

Үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага

MNS5537:2016, Авто замын дагуух үйлчилгээний цогцолбор. Ангилал, ерөнхий шаардлага

MNS5409:2004, Аялал жуулчлал, байрны төрлийн үндсэн нэр томьёо

²⁴² MNS 4288 : 1995 6 х. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи. Түвшинд тавих үндсэн шаардлага

MNS 4943 : 2015 4 х. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага

MNS 5667 : 2006 2 х. Бохир ус. Лагийн чийглэг ба үнслэгийг тодорхойлох арга.

MNS 5668 : 2006 12х. Усны биологийн шинж чанарын шинжилгээ. Бохир усны микробиологийн шинжилгээний арга

MNS 6390 : 2013 3х Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус. Техникийн шаардлага

MNS 6561 : 2015 6 х. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага

MNS ISO 24511 : 2012 57 х Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ. Ариутгах татуургын барилга, байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт үйлчилгээний түвшинг үнэлэх аргачлал.

MNS BS 8525-1 : 2015 40 х. Саарал усны систем. Ерөнхий шаардлага

хаягдал ус болон лагийг байгальд эргүүлэн нийлүүлэх хүртэлх цогц үйл ажиллагаанаас бүрдэх тухай дээр дурдсан. Иймээс Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас улс орнуудыг “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө” /цаашид УАБТ гэх/ боловсруулах, хэрэгжүүлэхийг зөвлөж байгаа ба түүнийг хэрэгжүүлэхэд төрөл бүрийн дэмжлэг, туслалцаа үзүүлж байна. Үүний нэг жишээ бол манай улс 2012 оноос ДЭМБ-ын идэвхтэй дэмжлэгтэйгээр дээрх төслийг хэрэгжүүлж эхэлсэн нь усны чанар, аюулгүй байдалд нөлөөлж болох эрсдэлийг тогтоож, түүнийг арилгах, бууруулах арга хэмжээг тодорхой болгох чухал ач холбогдолтой ажил болсон юм.²⁴³ УАБТ-г боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахын тулд ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу олон талт ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүний нэг нь цаашид бохир усыг татан зайлуулах, ариутгах татуургын аюулгүй байдлыг хангах чиглэлээр эрсдэлийн үнэлгээ явуулж, үе шаттайгаар авах арга хэмжээг төлөвлөх ажил юм. Энэ хүрээнд НИТХ-ын 2014 оны 9 сарын 22-ны өдрийн 19/22 дугаар тогтоолоор Ундны усны аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг²⁴⁴ баталсан бол Эрүүл мэнд, спортын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 74/37 дугаар “Заавар батлах тухай” тушаалаар²⁴⁵ “Хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах заавар”-ыг батлан төлөвлөгөөг тухайн орон нутгийн ИТХ-аар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймаг, нийслэл, сумын ЗД нарт үүрэг болгосон байдаг.

Дээрхээс гадна төрөөс байгалийн нөөцийг хэмнэлттэй ашиглах, орчны бохирдол, хаягдлыг багасгах, байгальд халгүй техник, тоног төхөөрөмжийн ашиглалтыг, мөн эрчим хүч хэмнэх, дулааны үйлдвэрлэл, бохир ус цэвэрлэх, усны хэмнэлттэй техник, тоног төхөөрөмжийн импортыг нэмэгдүүлэх, дэмжих зорилгоор тодорхой арга хэмжээ авч байна. Тухайлбал, ЗГ-ын 2013 оны 303 дугаар тогтоол, 2017 онд 168 дугаар тогтоолыг тус тус баталж гаалийн болон импортын албан татвараас 100% чөлөөлсөн явдлыг энд дурдаж болох юм.

Усны нөөц, ус хангамжийн эх үүсвэрийг бохирдуулах дараагийн нэг хүчин зүйл нь хот, хөдөөгийн гэр хорооллын буюу төвлөрсөн шугам, сүлжээнд холбогдоогүй өрхийн ариун цэврийн байгууламжийн ашиглалттай холбоотой асуудал юм. Хот, суурин газрыг тойрсон гэр хороололд ус хангамж, бохир ус зайлуулах систем одоог хүртэл байхгүй, одоо байгаа гэр хорооллын усан хангамж, ариун цэврийн нөхцөл байдал нь дутмаг, хэрэглээний болон ундны усаа зөвхөн ус түгээх байрнаас зөөвөрлөн авдаг, ариун цэврийн шаардлага хангаагүй нүхэн жорлон ашиглаж байгаа нь хөрсний бохирдол үүсгэн улмаар халдваржуулаагүй орчин нөхцөл, цэвэршүүлээгүй ундны ус, ил задгай бохирдолт, нүхэн жорлон зэрэг нь хүн амын дунд халдварт өвчлөл үүсгэх гол шалтгаан болж, эрүүл аюулгүй амьдрах эрхэд халдаж байна. Тухайлбал, УБ хотын иргэдийн 60 орчим хувь нь амьдардаг гэр хорооллын хөрсний бохирдол их, ариун цэврийн байгууламж буюу нүхэн жорлонгийн тоо зэрэг нь өнөөдөр гамшгийн төвшинд хүрсэн

²⁴³ Ус сувгийн удирдах газраас мэдээллээ.Эх сурвалж: <https://www.slideshare.net/BukaKing/togtool-40103494>

²⁴⁴ <https://www.slideshare.net/BukaKing/togtool-40103494>

²⁴⁵ Эрүүл мэнд, спортын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 74/37 дугаар “Заавар батлах тухай” тушаал

байгаа нь ундны усны бохирдолд нөлөөлөх хүчин зүйл болсон талаар олон судалгаанд дурдсан байдаг. Иймээс цаашид хүн амын ундны усны чанар, аюулгүй байдалд нөлөөлж

Зураг № 13 Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй өрх



буй хүчин зүйлийг арилгах, бууруулах, бохир усыг татан зайлуулах, ариутгах татуургын системийн аюулгүй ажиллагааг хангах, гэр хорооллын айлуудын хөрсний бохирдлыг багасгах, ариун цэврийн байгууламжийг боловсронгуй болгох асуудлыг шийдвэрлэхэд энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг яам, тусгай газрууд, нийслэлийн төр, захиргааны байгууллага болон холбогдох агентлагууд, олон улсын болон төрийн бус байгууллагуудад хандан идэвх санаачилгатай хамтран ажиллах шаардлага бий.

ХСУХАТАТХ-иар хот, суурины хэрэглэгчийн хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилготой боловч уг хуулийн 10 дугаар зүйлд тусгасан ХСУХАТАУЗЗ-ийн тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох бүрэн эрхийн хүрээнд мөн хуулийн 12.2.14-т заасан бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгож байгаа нь хуулийн үйлчлэх хүрээг зөвхөн инженерийн шугам сүлжээгээр хязгаарлах боломжгүй, хуулийн үйлчлэх хүрээг тэлж, хийдлийг арилгах шаардлагатайг харуулж байна.

Цэвэрлэх байгууламжид нийлүүлэгдэж буй ахуйн болон үйлдвэрлэлийн хэрэглээнээс гарч буй бохир усны хэмжээг бууруулах, бохир усны төлбөр тооцоог тогтооход Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль чухал нөлөөтэй. Тухайлбал ХСУХАТАТХ-ийн хүрээнд уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүдийн хаягдал усны хэмжээ, түүний бохирдуулагч бодисын хэмжээнээс хамааралтай төлбөрийн хэмжээ тогтоох зэрэг олон асуудал уг хуульд хамаарна. УИХ-аас 2012 онд баталсан Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай 5 журам батлагдахаас 2 журмыг ²⁴⁶ баталж, “Ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал уснаас төлбөр авах журам” зэрэг 3 журмыг өнөөг хүртэл батлаагүй байна. Түүнчлэн, төлбөрийн хэмжээг усны сав газар тус бүрээр усны экологи-эдийн засгийн үнэлгээнд үндэслэн Засгийн газраас тогтоогоогүй, мөн усны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сав газрын захиргаа төлбөр төлөгчийн мэдээллийг татварын албанд ирүүлдэггүй, усны бохирдлын хэмжээг ямар байгууллага хэрхэн тогтоох нь тодорхойгүй зэрэг шалтгаан нь ус бохирдуулсны

Зураг № 14 Бохир усны цооног




²⁴⁶ Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам”, “Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцох аргачлал”-ыг баталсан.

төлбөрийг бодитойгоор тооцох, төлбөрийг гүйцэт хураах зэрэг асуудлыг хүндрүүлдэг байна. Ялангуяа ЦБ-д хаягдал усаа нийлүүлж буй тохиолдолд дээрх төлбөр төлөгчийн болон төлбөрийн хэмжээ тогтоосон заалтуудыг ашиглан ЦБ-ын алдагдлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах боломжтой юм.

Монгол Улсын хүн амын талаас илүү хувь нь амьдардаг УБ хот нь хотуудын зэрэглэлээр метрополис хотын²⁴⁷ хэмжээнд хүрсэн хэдий ч ус хангамж, ариутгах татуургын хөгжил нь нүүдэлчин соёлоосоо салаагүй байна гэж үзэхэд буруудахгүй байна. Өсөлтөөрөө мега хотын төвшинд хүрсэн атлаа хөгжлөөрөө хоцорч яваа УБ-ын иргэдийг унд, ахуйн усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх асуудал дан ганц УСУГ-т. Үүнээс хараад УСУГ нь метрополис хотын монополь байгууллага юм. Иймээс УСУГ-ын үйл ажиллагаатай холбоотой бүхий л асуудлыг шийдвэрлэх гарц, гаргалгаа олж чадсан тохиолдолд аймгийн хэмжээний ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн асуудлыг шийдвэрлэхэд шийдэл, жишиг болох боломжтой гэж үзлээ. Тухайлбал, УСУГ нь хоногт 150,0-160,0 мянган м³ цэвэр ус олборлон түгээж, 160,0-180,0 мянган м³ бохир ус татан зайлуулдаг. 5000 гаруй үйлвэр аж ахуйн газрыг ундны цэвэр усаар хангах томоохон 7, жижиг 3 эх үүсвэртэй бөгөөд цэвэрлэх байгууламж 1, бага оврын цэвэрлэх байгууламж 2-тойгоор ажилладаг. Ариутгах татуургын системийн ашиглалт, суурьлуулалтын хурд суурьшилын өсөлтийн хурдыг гүйцэхгүй байна. Тиймээс их хэмжээний цэвэршүүлээгүй бохир ус шууд байгаль орчинд хаягдсаар байна.

Зураг № 15 УСУГ-ын бүтэц



Ялангуяа хур бороо элбэгтэй улирал, жилд 200 гаруй мянган м³ орчим бохир ус ТЦБ-д ирдэг байна. Энэ нь хот төлөвлөлттэй шууд хамааралтай байна. Тухайлбал, хөрсний ус татан зайлуулах шугам сүлжээгүй барилга, байгууламжийн тоо ихэссэн, замын хажуугийн хаялга, ус зайлуулах суваг, шуудууг хийдэггүйгээс улбаалан ТЦБ-ийн шугам сүлжээнд хөрсний болон борооны ус ихээр орж ирж байгаа нь ТЦБ-ийн үйл ажиллагааг доголдуулах, байнга аваарийн төвшинд ажиллах, цэвэрлэсэн ус стандартын шаардлага

²⁴⁷ Метрополис хот гэж тухайн үндэстнийхээ хүн ам, эдийн засаг, шинжлэх ухааны дэвшил, сэтгэхүйн хэмжээс, соёлын чиг хандлагын төв цэг болсон саяас дээш хүн амтай соёлт хотыг хэлнэ.

хангахгүй байх, бохир усны төлбөр тооцоо хариуцах эзэнгүй үлдэх, улмаар алдагдалтай ажиллах гол шалтгаан болдог тухай ТЦБ-ийн холбогдох албан тушаалтан ярьж байна.

УСУГ-ын харьяа Төв цэвэрлэх байгууламжийн хувьд 1964 оноос үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх шаардлагатай хэдий ч дотоод нөөц бололцоондоо тулгуурлан усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж байгальд нийлүүлдэг гэж үздэг. Гэвч ТЦБ-ын цэвэршүүлсэн усаа нийлүүлдэг Туул голын усны үзүүлэлт үүнийг үгүйсгэж байна.

Кейс МХБ-ын мэдээллээс

НМХГ-аас шалгалт хийхэд Төв аймгийн Алтанбулаг сумаас доош 60 км хүртэл, жилийн аль ч улиралд усны өөрөө цэвэршилт ажиглагдаагүй байна. Мөн эрүүл зүйн химийн болон нян судлалын гол үзүүлэлтүүдээр хамгийн их бохирдолттой ангилалд хамаарчээ. Мөн гадаргын усны чанарын шалгуур үзүүлэлттэй харьцуулахад усны исэлдэх чанар Туул голын доод хэсэгт /Сонгиноос Алтанбулаг хүртэл/ нормоос 4-6 дахин их, бусад хэсгээр 2-3 дахин их, ууссан хүчил төрөгчийн хэмжээ голын доод хэсэгт байх ёстой хэмжээнээс 2-3 дахин бага, бусад хэсэгт нормын хэмжээнд байсан аж. Эрүүл зүйн нян судлалын үзүүлэлтээр нянгийн нийт тоо стандартад заасан нормоос Налайх орчимд долоо дахин, Туул голын доод хэсгээр 47-70 дахин их, гэдэсний савханцарын тоо 10-100 дахин их, Алтанбулаг сумын орчимд эмгэг төрөгч нян буюу салмонела тус тус илэрсэн байна

ТЦБ-ийн тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг Испани, Хятад, Япон зэрэг гадаад орнуудын тусламжтайгаар хэрэгжүүлж ирсэн боловч ТЦБ-аас гарч буй хаягдал ус стандартын шаардлага хангахгүй байх гол шалтгаан нь зөвхөн ахуйн бохир ус л хүлээж авах зориулалтаар баригдсан уг байгууламжид үйлдвэр, аж ахуйн нэгжийн бохир усыг нийлүүлдэг болсонтой холбоотой гэж мэргэжлийн хүмүүс үзэж байна. Тухайлбал, УБ хот дахь арьс ширний үйлдвэрийн гүн бохирдолтой усны хэмжээ жилээс жилд нэмэгдэж байгаа, зарим үйлдвэрүүд энэ усаа шууд ТЦБ-ийн шугам сүлжээнд нийлүүлдэг, “Харгиа” ЦБ-ийн хүчин чадал хүрэлцэхгүй байх, цэвэрлэсэн усны нь бохирдол хэт өндөр байх асуудал байнга тулгардаг байна. Энэ асуудал зөвхөн УБ хотоор хязгаарлагдахгүй, хүн ам төвлөрсөн, үйлдвэрлэл хөгжсөн суурин газар бүр үүсдэг, цаашид үүсэх эрсдэлтэй юм.

Ерөнхийдөө ЦБ-аас гарч буй хаягдлын тухайд зөвхөн байгальд нийлүүлж буй хаягдал усанд анхаарал хандуулах нь түгээмэл байна. Гэтэл лагийн асуудал давхар үүсч байдаг бөгөөд үүнийг зохицуулах техник, технологийн болон эрх зүйн зохицуулалтын асуудал саяхнаас хөндөгдөж эхэлсэн. Үүнд нөлөөлсөн хүчин зүйл нь УБ хотын баруун хэсэгт нэлэнхийдээ тархсан, иргэдийн ая тухыг алдагдуулсан, тэдний эрүүл мэндэд ч сөргөөр нөлөөлөхүйц хэмжээнд хүрсэн ЦБ-ийн үнэр гэж үзэж болох юм. Үнэр гарах нэг шалтгаан бол лаг нөгөө нь арьс шир, өлөнгийн цехүүдээс нийлүүлэгддэг бохирын үнэр гэж үздэг. ЦБ хоногт 160-190 мянган метр куб ахуйн болон үйлдвэрийн бохир ус хүлээн авч цэвэрлэдэг бөгөөд лаг боловсруулах байгууламжгүй учир хоногт 1000-1200 метр куб нойтон лагийг ил талбайд хатаадаг ажээ. Гарсан лагийг усгүйжүүлж, ялгаж авсан лагийг байгалийн аргаар 2-3 жил хатаагаад хаядаг бөгөөд энэхүү лагийг 50 жил хурааж 900 мянган метр/куб хур лаг үүссэн²⁴⁸ байна.

Лаж бол дахин ашиглах нэг түүхий эдийн нөөц бөгөөд хуучин хуримтлагдсан болон шинээр үүсч байгаа лагийг хоргүйжүүлж, үнэргүйжүүлэн бордоо болгосноор нийтийн эзэмшлийн зүлэг ногоог бордох гэх мэт хүнсний ногоо тариалахаас бусад зориулалтаар

²⁴⁸ төв цэвэрлэх байгууламж 50 гаруй жилийн дараа шинэчлэгдэж байна.Эх сурвалж: <http://oloo.mn/n/56394.html>

ашиглах боломжтой юм. Хуримтлагдсан лагийг боловсруулах, хоргүйжүүлэх зорилгоор Японы болон АХБ-ны хэд хэдэн төсөл хэрэгжиж байгаа бол БНХАУ-аас Монгол Улсад олгож буй 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлээр гүйцэтгэх “Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг барих төсөл”-ийн хүрээнд хоногт 250 мянган метр куб бохир ус хүлээн авч цэвэрлэх хүчин чадал бүхий дэвшилтэт технологи ашигласан, байгаль орчинд ээлтэй, лагийг бүрэн боловсруулах боломжтой болох юм.

Одоогоор лагийг дахин боловсруулах боломжтой 1 ЦБ 2018 оны 11 сард ашиглалтад орсон бөгөөд 33 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр баригдсан нийслэлийн Яармаг, Нисэхийн орон сууцны 160 мянга гаруй айл өрх, ААН-үүдийн бохир усыг цэвэрлэх байгууламж нь хоногт 20 мянган м3 усыг цэвэрлэх хүчин чадалтай, мөн лагийг дахин боловсруулж, метан хийг гаргаж авах, бохир усыг химийн арга, хэт ягаан туяа ашиглан халдваргүйжүүлэн 98 хувь цэвэрлэх дэвшилтэт технологитой энэхүү байгууламжаас шүүгдэж гарсан усыг техникийн хэрэгцээнд ашиглах, мөн лагийг дулааны аргаар боловсруулж био хий гаргаж авах ба түүнийгээ цэвэрлэх байгууламжийн дотоодын дулааны хэрэгцээг хангах, боловсруулж усгүйжүүлсэн лагийг хөрс бордох, газар тариаланд хэрэглэх боломжтой юм.²⁴⁹ Үүнтэй ойролцоо ЦБ-ууд Эрдэнэт, Дархан хот болон Өвөрхангай аймагт баригдаж байна. Одоогоор Улаанбаатар, Эрдэнэт, Дархан зэрэг томоохон хотуудын бохир ус цэвэрлэх байгууламж 50-аас илүү жилийн туршид үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тогтвортой, байгаль орчинд халгүйгээр бохир усыг цэвэрлэх боломжгүй нөхцөл байдалтай байгаа юм.

Ариутгах татуургын төвлөрсөн шугам, сүлжээгээр нийлүүлэгдэж буй бохир усыг цэвэршүүлэх, лагийг боловсруулах ажил ийнхүү хэрэгжиж байгаа бол төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй, гэр хорооллын айл өрхийн ариун цэврийн байгууламж буюу нүхэн жорлонгийн бохир ус, лагийн асуудал тулгамдсан асуудал болж байгаа тухай дээр дурдсан. Үүнтэй холбоотой хэрэгжиж буй төслийн нэг бол АХБ-ны “ТА9100-МОН: Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжууд болон бохир ус цэвэрлэх байгууламжаас гарах лагийг дахин ашиглах, менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх төсөл” юм. Уг төслийн хүрээнд ахуйн хэрэглээнээс гарсан лагийг дахин ашиглахтай холбоотой судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэн, үүнд холбогдох хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн үйл ажиллагаа үргэлжилж байна. Төслийн багийн гишүүдтэй хийсэн уулзалт ярилцлагаас харахад өнөөдөр манай улс “лаг” гэх ойлголтыг тодорхойлсон нэгдмэл ойлголтгүй, хэрхэн, хаана, хэзээ ашиглах талаар дүрэм, журам байхгүй, шинэ харилцаа болж байна гэв. Харин Хог хаягдын тухай хуульд лагийн тухай зохицуулалт шинээр орсон нь энэ асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэх хэрэгцээ шаардлагыг тогтооход ихээхэн нөлөөтэй боловч лаг нь хатуу хог хаягдалд тооцогдох эсэх нь эргэлзээтэй гэж үзэж байна.²⁵⁰

Хот, суурин газрын усны эргэлтийн чанар нь усны ашиглалтын хэмжээ, бохир ус цэвэрлэгээний чанараас шууд шалтгаалж байдаг бөгөөд энэ нь хот, суурин газрын усны үйлчилгээ болох ус олборлон нийлүүлэх, хаягдал бохир усыг цэвэрлэх байгууламжид

²⁴⁹ <http://montsame.mn/en/read/170407>

²⁵⁰ АХБ-ны “ТА9100-МОН: Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжууд болон бохир ус цэвэрлэх байгууламжаас гарах лагийг дахин ашиглах, менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх төслийн багийн гишүүдтэй хийсэн уулзалтаас

нийлүүлэх, түүний цэвэрлэгээ, усыг дахин ашиглах үйл явц нь ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээн дэх цогц систем юм.

Бага хүчин чадалтай, бие даасан цэвэрлэх байгууламжийн тухайд

Аялал жуулчлалын газар, жуулчлалын маршрут, зам харилцааны төвлөрсөн бүс, амралт, сувилал, хүүхдийн зуслан зэрэг газруудад баригдах ариун цэврийн байгууламж нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа ариун цэврийн барилга болон бохир ус цэвэрлэх байгууламжийн холбогдох стандарт, норм, дүрэм журмыг хангасан байхаас гадна бусад эрүүл ахуй, хүрээлэн буй орчны ерөнхий шаардлагуудыг хангасан байвал зохино. Тухайлбал, аялал жуулчлалын байр сууцны төрөл, үндсэн шаардлагыг MNS 5824: 3.цэвэрлэх байгууламжтай ариун цэврийн байгууламж 2007 стандартаар, Авто тээврийн үйлчилгээ. Зорчигч тээврийн буудал. Ерөнхий шаардлага MNS 6200 : 2011 стандартаар, Чөлөөт цаг, аялал жуулчлал, байрны үндсэн нэр томъёог MNS 5409 : 2004 стандартаар, авто зам дагуух үйлчилгээний цогцолборын ангилал, ерөнхий шаардлагыг MNS 5537 : 2016 стандартаар зохицуулсан бөгөөд энэ нь үйлчилгээний цогцолбор, барилга байгууламжид тавигдах нөхцөл, үндсэн шаардлагуудыг цогцоор нь зааж өгсөн байдаг.

Барилга, хот байгуулалтын яам 2012 онд хот, суурин газрын усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, “Ариутгах татуурга, гадна шугам сүлжээ ба байгууламж” /БНБД 40-0106/ барилгын норм дүрэм болон MNS EN 12566:2011 цуврал стандартын шаардлагад нийцүүлэн “бага оврын цэвэрлэх байгууламж”-ийн давтан хэрэглэх боломжтой 5 төрлийн зураг төслийг боловсруулсан байдаг. Үүнд 1/Ахуйн бохир ус цэвэрлэх бага хүчин чадалтай, энгийн буюу байгалийн биологийн цэвэрлэгээний байгууламж, 2/Ахуйн бохир ус цэвэрлэх бага хүчин чадалтай, энгийн буюу байгалийн биологийн цэвэрлэгээний байгууламж, 3/Ахуйн бохир ус цэвэрлэх бага хүчин чадалтай, зохиомол биологийн цэвэрлэгээний байгууламж, 4/Септик танк, 5/Бохир усны биологийн цэвэрлэх байгууламж багтана.²⁵¹

Ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй, холбох ажиллагаа ихээхэн төсөв хөрөнгө шаардагдах тохиолдолд аймаг, орон нутагт болон хотын алслагдсан хэсгүүд, гэр хороололд бага оврын цэвэрлэх байгууламж²⁵² барьж, ашиглах боломжийг судлах шаардлагатай гэж үзэж байна. Сүүлийн үед өндөр хөгжилтэй орнуудад үнэ өртөг ихтэй, олон зуун км бохирын шугам хоолойг ашиглан, зардал ихээхэн шаарддаг, нүсэр төвлөрсөн төв цэвэрлэх байгууламжаас татгалзах хандлагатай болж түүний оронд инженерийн шугам хоолой, холболт шаарддаггүй, хямд төсөр, бага оврын, бохирыг шууд цэвэршүүлж байгальд шингээдэг төвлөрсөн бус системийг нэвтрүүлж байгааг анхаарах нь зүйтэй байх.

Үнэлсэн байдал

ХСУХАТАтХ-ийн 18 дугаар зүйлд цэвэрлэх байгууламжийн байршил тогтоох, цэвэрлэх байгууламж саарал усыг эргүүлэн ашиглах, цэвэрлэх байгууламжийн бохир усны

²⁵¹ Ахуйн бохир ус цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламжийн гарын авлага 2017 он. <http://esd.mn/wp-content/uploads/2018/04/%D0%90%D0%A6%D0%91-%D0%BD%D0%BE%D0%BC-1.pdf>

²⁵² <http://news.barilga.mn/r/71637>

найрлага, технологийн горимд хяналт тавих, үйлдвэрлэлийн усыг урьдчилсан цэвэрлэх байгууламжаар дамжуулах зэрэг харилцааг зохицуулахаар тусгасан байна.

Хуулийн заалтын зорилго нь хүн амын хэрэглээнээс гарсан бохир усыг стандартын шаардлагад нийцтэл цэвэрлэн байгальд нийлүүлэх замаар иргэдийн орчны бохирдлоос хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад чиглэгдсэн гэж үзсэн бөгөөд ПРАКТИКТ ХЭРЭГЖИХГҮЙ байна гэж үнэллээ.

Ийнхүү үнэлэхэд дараахь хүчин зүйлс нөлөөлсөн болно. Үүнд:

1. УХАТ-ын үйлчилгээн нь ус олборлолтоос, цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал ус, лагийн ашиглалт хүртэлх бүхий л шатанд хамаарах цогц үйл ажиллагаа юм. Гэтэл одоогоор зохицуулалтаар ЦБ-ийн байршил тогтоох, цэвэрлэх байгууламж саарал усыг эргүүлэн ашиглах, цэвэрлэх байгууламжийн бохир усны найрлага, технологийн горимд хяналт тавих, үйлдвэрлэлийн усыг урьдчилсан цэвэрлэх байгууламжаар дамжуулах зэрэг харилцааг хуульчилж, төвлөрсөн бус ЦБ-ийн асуудлыг, лагийг дахин боловсруулах, хоргүйжүүлэн байгальд нийлүүлэх асуудлыг орхигдуулсан байна.
2. Өнөөдрийн байдлаар үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарч буй бохир ус анхан шатны цэвэрлэгээгүйгээр их хэмжээгээр ариутгах татуургын системд шууд нийлүүлэгдэж байгаа, мөн гэр хорооллын нүхэн жорлон, авто угаалга, мал нядалгааны газраас соруулсан бохирыг ариутгах татуургын шугам, сүлжээнд шууд нийлүүлж байгаа зэргээс шалтгаалан ЦБ-ийн ус цэвэрлэгээний цэвэршүүлэх төвшин буурч, эдийн засгийн өндөр алдагдалд хүргэж байна.
3. Түүнчлэн ихэнх уул уурхайн компани ЦБ-гүй тул тенологийн хэрэглээний усаа байгальд шууд нийлүүлдэг байдал өөрчлөгдөхгүй байна.
4. Улсын хэмжээнд 130 гаруй бохир ус цэвэрлэх байгууламж байгаагаас хэвийн ажиллагаатай 51, хагас ажиллагаатай 27, огт ажиллагаагүй 47 байгаа ба ЦБ-ийн талаас илүү хувь нь үйл ажиллагааны доголдол, эвдрэлтэй байгаагаас үүдэн жилд 120 сая гаруй м3 бохир ус байгальд шууд хаягдаж байгаль орчныг бохирдуулдаг. Энэ нь хуулийн 18.3-т заасан цэвэрлэх байгууламж нь саарал усыг цэвэршүүлэн эргүүлэн ашиглах технологи бүхий тоног төхөөрөмжтэй байх шаардлагыг хангах боломжгүй байдлыг илтгэж байна.
5. ЦБ-ийн талаарх судалгаа, тоо баримтууд зөрүүтэй, ЦБ-ын асуудал бодлогын төвшинд хаана харьяалагдаж буй нь тодорхойгүй, түүний бүртгэл, мэдээллийг шинэчлэх ажил удаашралтай байна.
6. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай ЦБ-ийн хувьд ХСУХАТатХ-ийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох, өргөтгөх боломжийг харгалзах, саарал усыг эргүүлэн ашиглах технологи бүхий тоног төхөөрөмжид тавигдах шаардлага хангах, хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах зэрэг асуудал хэрэгжихгүй байна. Үүний шалтгааныг хувийн компаниудын хувьд өөрийн өмчлөл, эзэмшлийн газарт ЦБ барих шаардлагатай тулгардаг, энэ нь хот төлөвлөлт гэхээсээ илүү үйлдвэрийн байршил, газрын хэмжээнээс илүү хамаардагтай холбоотой.
7. Урьдчилсан ЦБ-аар зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэсний дараа татан зайлуулах шугам сүлжээнд нийлүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авч байгаа боловч энэ нь үр дүн муутай.

8. Улсын хэмжээнд ЦБ, ариун цэврийн байгууламжид хамаарах маш олон эрх зүйн акт хүчин төгөлдөр мөрдөгддөг боловч түүнийг мэддэг хүн, ААН цөөн байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан болж байна.
9. Хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, ЦБ-аас гарсан усыг стандартын шаардлагын төвшинд хүргэн цэвэршүүлэх, түүнийг байгальд эргүүлэн нийлүүлэх зэрэг асуудлаар мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын зүгээс тодорхой санал, зөвлөмжүүдийг гаргадаг боловч ашгийн бус энэ салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлаас шалтгаалан хэрэгждэггүй.
10. УХАТ салбар нь өөрөө ус түгээгчээс гадна ус бохирдуулагч субъект бөгөөд ХСУХАТАтХ-иар ус олборлолтоос хаягдал усыг ЦБ-д хүргэх хүртэлх харилцааг зохицуулсан бөгөөд үүний дараагийн шат болох лагийг байгальд эргүүлэн нийлүүлэхтэй, мөн хот, хөдөөгийн гэр хорооллын буюу төвлөрсөн шугам, сүлжээнд холбогдоогүй өрхийн ариун цэврийн байгууламжийн ашиглалттай холбоотой харилцааг тусгаагүй, хуулийн хийдэл үүсгэсэн.
11. ХСУХАТАтХ-ийн 10 дугаар зүйлд тусгасан ХСУХАТАҮЗЗ-ийн тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох бүрэн эрхийн хүрээнд мөн хуулийн 12.2.14-т заасан бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгож байгаа нь хуулийн үйлчлэх хүрээг зөвхөн ариутгах татуургын инженерийн шугам сүлжээгээр хязгаарлах боломжгүй, хуулийн үйлчлэх хүрээг тэлж, хийдлийг арилгах шаардлагатайг харуулж байна.
12. Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, БОАЖЯ-наас Ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал уснаас төлбөр авах журам зэрэг холбогдох дүрэм журмыг боловсруулаагүй, усны бохирдлын хэмжээг ямар байгууллага хэрхэн тогтоох нь тодорхойгүй зэрэг шалтгаан нь ус бохирдуулсны төлбөрийг бодитойгоор тооцох, төлбөрийг гүйцэт хураах зэрэг асуудлыг хүндрүүлдэг.
13. Хот төлөвлөлт, зам, талбай, барилга байгууламжийн усны хаялагын асуудлыг шийддэггүй, түүнд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага сул байгаа нь хөрсний ус татан зайлуулах шугам сүлжээгүй барилга, байгууламжийн тоо ихсэх, замын хажуугийн хаялга, ус зайлуулах суваг, шуудууг хийхгүй орхиход нөлөөлдөг. Үүний улмаас ТЦБ-ийн шугам сүлжээнд хөрсний болон борооны ус ихээр орж ирж хэвмйн үйл ажиллагааг доголдуулах, байнга аваарийн төвшинд ажиллах, цэвэрлэсэн ус стандартын шаардлага хангахгүй байх, бохир усны төлбөр тооцоо хариуцах эзэнгүй үлдэх, улмаар алдагдалтай ажиллах гол шалтгаан болдог.
14. Үйлдвэрийн болон гэр хорооллын жорлонгоос соруулсан бохирдлын концентрац өндөртэй бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламж бараг байхгүй байна гаа нь хуулийн 18.5-д заасан .Үйлдвэрийн хэрэглээнээс гарсан бохир усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэсний дараа татан зайлуулах шугам сүлжээнд нийлүүлэх, технологийн хэрэглээндээ эргүүлэн ашиглах тухай зохицуулалт хэрэгжихгүй байх шалтгаан болж байна.
15. ЦБ-аас гарч буй 2 төрлийн бүтээгдэхүүний 1 болох бохир усыг цэвэршүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт хангалттай байгаа бол 2 дахь бүтээгдэхүүн болох лагийн ашиглалт, халдваргүйжүүлэлт, хоргүйжүүлэлтийн тухайд эрх зүйн зохицуулалтгүй байна.
16. Ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй, холбох ажиллагаа ихээхэн төсөв хөрөнгө шаардагдах тохиолдолд аймаг, орон нутагт болон хотын

алслагдсан хэсгүүд, гэр хороололд бага оврын цэвэрлэх байгууламж²⁵³ барьж, ашиглах боломжийг дэмжих замаар ус хангамжийн болон хөрсний бохирдлоос хамгаалах арга хэмжээ дутмаг байгаа нь хуулийн заалт практикт хэрэгжихгүй байна гэж үнэлэх үндэслэл болжээ.

17. ЦБ-ийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, норм, дүрэм, журамд хуулийн нэр томъёо ихээхэн зөрүүтэй хэрэглэгдэж байгаа нь хуулийн нэр томъёоны нэгдмэл байдлыг алдагдуулахаас гадна хууль хэрэглэгчдийн төөрөгдүүлэх эрсдэл үүсгэжээ. Тухайлбал, хаягдал ус, бохир ус, саарал ус, хэрэглээнээс гарсан, ЦБ-ын цэвэрлэсэн ус гэх зэрэг олон байдлаар тусгасан, түүнийг тайлбарласан, ялгаа заагийн тогтоосон зүйл байхгүй

Зөвлөмж

1. Төрийн, орон нутгийн болон хувийн хэвшлийн хөрөнгөөр шинээр баригдах ЦБ-уудын хувьд ХСУХАТАТХ-ийн 18.2-т заасан ЦБ-ийг хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн, зай талбайн хувьд өргөтгөх, эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөх боломжтой байх шаардлагыг хангуулахад анхаарах,
2. УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ нь ус олборлолтоос, цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал ус, лагийн ашиглалт хүртэлх бүхий л шатанд хамаарах цогц үйл ажиллагаа болохын хувьд ЦБ-аас гарч, байгальд эргэн нийлүүлэгдэж буй бохир ус, лагийн асуудлыг хуульчлах,
3. ЦБ-ийн үйл ажиллагаа, ашиглалт, үйлчилгээтэй холбоотой судалгаа, тоо баримтуудыг нэгдсэн байдлаар гаргадаг байх, тухайлбал улсын хэмжээнд нийт ЦБ-ууд хэдэн м3 усыг ямар төвшинд цэвэрлэж байгальд нийлүүлсэн, хэдэн м3 цэвэрлэсэн усыг дахин ашигласан талаар тоо баримтыг гаргадаг, үр дүнд суурилсан үнэлгээ хийдэг, үд дүнд суурилсан урамшуулал, дэмжлэгийг төр, хувийн хэвшлийн гэж ялгалгүйгээр үзүүлдэг байх,
4. Төвлөрсөн шугам, сүлжээнд холбогдоогүй хот, хөдөөгийн гэр хорооллын өрх, ААН-ийн ЦБ-ийн ашиглалт, үйлчилгээнд хамаарах, эрх зүйн зохицуулалтыг бий болгох,
5. Мөн төвлөрсөн шугам, сүлжээнд холбогдоогүй өрх, ААН-ээс гарч буй бохирдол өндөртэй хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар дамжуулах хуулийн шаардлага, эрх зүйн орчныг бий болгох, бага оврын ЦБ-ийн ашиглалтыг бодлогоор дэмжих замаар хуулийн 18.5 дахь заалтын хэрэгжилтийг хангуулах,
6. Нийтийн болон хувийн эзэмшлийн зам, талбай, барилга байгууламжийн усны хаялагын асуудлыг шийдээгүй, ариутгах татуургын шугам, сүлжээнд нийлүүлж буй тохиолдолд уг этгээдээс ариутгах татуургын шугам, сүлжээ ашигласны төлбөрийг авах боломж бүрдүүлсэн эрх зүйн зохицуулалт бий болгох замаар нэг талаас ЦБ-ийн алдагдлыг бууруулах, нөгөө талаас зам, барилгын салбарт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлэх,
7. ЦБ, түүний үйл ажиллагаа, ашиглалт, үйлчилгээнд хамаарах хууль тогтоомжийн нэр томъёог нэгдмэл байдалд оруулах, цэгцлэх,

²⁵³ <http://news.barilga.mn/r/71637>

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 2-т хүн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж тус тус заасан байдаг. Энэхүү Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг хангах, мөн улс орны үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, орчны бохирдлоос хамгаалахад чиглэгдсэн суурь зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлэх онцгой үйл ажиллагааны нэг бол хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ юм.

УИХ-аас анх 2002 онд Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийг баталснаар хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн үндэс бүрдсэн байна. УХАТ-ын ашиглалтын тухай анхдагч хуулийн зохицуулалт бий болсноор хот, суурин газар оршин суугаа иргэдийг цэвэр усаар хангах, хэрэглээний бохир усыг стандартад нийцүүлэн зайлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хангагч, хэрэглэгч хоорондын харилцааг зохицуулсан эрх зүйн орчин бүрдсэн нь хотжилт, үйлдвэржилт, хүн амын төвлөрөл эрчимжсэн өнөө цагийн эрэлт хэрэгцээ, шаардлагад хийцсэн алхам болжээ.

2011 онд ХСУХАТAtX-ийн шинэчилсэн найруулгыг баталснаас хойш хуульд нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан ба эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь гол төлөв шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжтой холбоотой байсан бөгөөд үндсэн асуудлыг хөндөөгүй. Иймээс одоогийн эрх зүйн зохицуулалт 1/нийгэм, эдийн засгийн хөгжил ахихын хэрээр төр, орон нутаг, ААН, иргэдийн өмчийн асуудал хурцаар хөндөгдөх болсон, 2/нэг талаас хүн амын суурь хэрэглээний нэг болох стандартын шаардлага хангасан, баталгаат ус хангамж, ариутгах татуургын асуудлыг зөвхөн хот, суурин газрын инженерийн барилга, байгууламж, шугам, сүлжээнд холбогдсон иргэдээр хязгаарласан нь Үндсэн хууль болон олон улсын гэрээнд заасан хүний үндсэн эрхийг зөрчсөн төдийгүй төрийн нийтийн үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, ялгаварлан гадуурхалгүйгээр хүргэх үүргийг хөсөрдүүлж хөдөөгийн болон суурин газрын гэр хорооллын орон сууц худалдан авах санхүүгийн чадваргүй/боломжгүй болон ядуу иргэдийн баталгаат унд, ахуйн усаар хангагдах эрхийг зөрчсөн, нөгөө талаас 500-аас доош хүн амтай газрын инженерийн шугам, сүлжээг хуулийн зохицуулалтын гадна үлдээж хийдэл үүсгэсэн 3/мөн хуулийн хэрэгжилтийг хангуулах чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага байгуулагдаагүй, ХСУХАТАУЗЗ-ийн статус, эрх зүйн байдал тодорхойгүй, БХБЯ-ны харьяа Барилгын хөгжлийн төв барилгын норм, дүрэм, журам, стандарт боловсруулахаас цааш эрх мэдэлгүй, НАА-н бодлогыг барих БХБЯ хүний нөөцийн дутагдалтай, үндсэндээ 3 мэргэжилтэн улсын хэмжээнд УХАТ-ын салбарын хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, салбар хоорондын уялдаа холбоог хангаж ажилладаг байдал, 4/усны асуудал нь хэт олон байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт хамаардгаас болж чиг үүргийн давхардал үүссэн, 5/УХАТ-ын салбар нь байгалийн баялаг ашиглагчаас байгаль орчныг бохирдуулагч субъект болохын хувьд цэвэрлэх байгууламжаас гарах цэвэрлэсэн ус, лагийг байгальд хоргүйгээр зайлуулах, ашиглах, хадгалах, устгах зэрэг асуудал эрх зүйн зохицуулалтгүйн улмаас өнөөдөр хэдэн арван жил хуримтлагдсан лаг байгаль орчин болон хүний эрүүл

мэнд, ая тухтай амьдрах орчинд сөргөөр нөлөөлж буй байдал, 6/гэр хорооллын нүхэн жорлонгийн ашиглалт, түүнд тавигдах шаардлага, үзүүлэх үйлчилгээ тодорхойгүй явж ирсэн нь усны нөөц, хөрсний бохирдол үүсгэх, нийтийн эрүүл ахуй, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх гол хүчин зүйл болсон зэрэг олон шалтгааны улмаас хуулийг шинэчлэх шаардлага үүссэн гэж үзлээ.

Хуулийн шинэчилсэн найруулга боловсруулах хууль зүйн үндэслэл *нэгдүгээрт*, УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.90-д “Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлнэ.” гэж 2.94-д “Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг саарал усны стандартын шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.” гэж, 2.96-д “Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.” гэж, 4.2.3-т Усны нөөцийг хамгаалж, хомстлоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ.” гэж, *хоёрдугаарт*, УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 44-т “Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах”-аар тус тус тусгасанд оршино. .

Түүнчлэн усыг хэмнэлттэй ашиглах, саарал усыг дахин ашиглах асуудлыг Монгол Улсын мянганы хөгжлийн зорилгод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого, “Ус” үндэсний хөтөлбөр, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Усны тухай хууль, Ногоон хөгжлийн бодлого, Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, ЗГ-ын Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр, Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдэд, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай, Хот байгуулалтын тухай зэрэг хуулиудад тусгасан байх боловч хэрэгжилт төдийлөн сайнгүй гэж үнэлж болох байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээг хийхдээ “зорилгод хүрэх төвшин”, “практикт хэрэгжиж буй байдал” шалгуур үзүүлэлтүүдийн хүрээнд нийт 21 заалт сонгон судалж, үнэлгээ хийлээ. Хуулийн зүйл, заалтыг сонгохдоо судалгааны ажлын удирдамжийг боловсруулах, суурь судалгаа, судлагдсан байдлын судалгааг гүйцэтгэх шатанд уг хуулийг хэрэглэгчдийн зүгээс хамгийн “ойлгомжгүй, хэрэгждэггүй” гэх тодотголтой заалтуудыг сонгон судалсан тул дийлэнх үнэлгээ “зорилгодоо хүрээгүй”, практикт хэрэгжихгүй” гэсэн үнэлгээ авсан болно. Хуулийн хэрэгжилтийг үр дагаврын үнэлгээг сэдэвчилсэн байдлаар танилцуулъя.

Зарчмын өөрчлөлтийн хүрээнд хөндөгдөх асуудал

ХСУХАТАТХ-иар хүн амын стандартын шаардлага хангасан, баталгаат ундны усаар хангагдах эрхийг зөвхөн хот, суурин газраар, түүн дотроо зөвхөн инженерийн шугам, сүлжээнд холбогдсон иргэдээр хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулиар баталгаажсан хүн бүр эрүүл, аюулгүй орчинд амьдрах, амьд явах, орчны бохирдлоос хамгаалуулах эрхийг хангах төрийн үүргийг иргэдийн орлого, амьжиргааны төвшин, хот, хөдөө, орон сууц, гэр хороолол зэрэг оршин суугаа газраар нь ялгаварлан гадуурхсан байдлаар хэрэгжүүлэх, Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр хүлээсэн “ялгаварлан гадуурхахгүй байх” үүргээ зөрчсөн эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байна.

УХАТ-ын салбар нь байгалийн баялаг ашиглагчаас байгаль орчныг бохирдуулагч субъект болохын хувьд цэвэрлэх байгууламжаас гарах цэвэрлэсэн ус, лагийг байгальд хоргүйгээр зайлуулах, ашиглах, хадгалах, устгах зэрэг асуудал, мөн төвлөрсөн бус ариун цэврийн байгууламж буюу гэр хорооллын нүхэн жорлонгийн ашиглалт, түүнд тавигдах шаардлага, үзүүлэх үйлчилгээний асуудал эрх зүйн зохицуулалтгүй явж ирсэн нь усны нөөц, хөрсний бохирдол үүсгэх, нийтийн эрүүл ахуй, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх гол хүчин зүйл болж, тухайлбал, өнөөдөр хэдэн арван жил хуримтлагдсан ЦБ-ийн лаг байгаль орчин болон хүний эрүүл мэнд, ая тухтай амьдрах орчинд сөргөөр нөлөөлж байна.

Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг хамгаалах тухай их олон хууль тогтоомж хэрэгжиж, мөрдөгдөж байгаа боловч хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх үйл ажиллагаа Газрын тухай хуультай салшгүй холбоотой болохыг тодорхойлоогүй, түүнд эдгээрийн уялдаа холбоог хангах эрх зүйн зохицуулалтыг оруулаагүй тул дээрх бүсүүдэд хууль бусаар оршин суугаа, үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, ААН-үүдийн зохисгүй үйлдэл нь усны нөөцийг бохирдуулах, улмаар үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх эрсдэлийг бий болгожээ.

Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм, түүний хэрэгжилтийн тухайд

Монгол Улсын Үндсэн хууль, ЗЗНДНУтХ, Усны тухай хууль, ХСУХАТАТХ болон Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам, бусад холбогдох тогтоол, шийдвэрийн хүрээнд ХСУХАТАТХ-ийн 7.1.2, 17.2, 17.4, 17.5, 17.6, 17.7, 17.8.2, 17.8.4 дэх заалтын хэрэгжилтийг судалж үзэхэд дээрх заалтуудаар зохицуулахыг зорьсон ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, шугам сүлжээний харуул хамгаалалт, хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмд холбогдох эрх зүйн зохицуулалт хэрэгжихгүй байгаа нь хамгийн ноцтой асуудал гэж харагдаж байна. Үүнийг дээрх асуудлыг зохицуулж буй хууль тогтоомж, дүрэм, журмын зөрчилтэй байдал, нэр томъёоны нэгдмэл бус байдал, аймаг, нийслэлийн ИТХ-ын улс төр, эдийн засгийн нөлөөлөлд автах эрсдэл, асуудлыг мэргэжлийн талаас шийдвэрлэх чадамжгүй байдал, Засаг дарга нарын хууль хэрэгжүүлэх, газар олгох эрх, үүргийн зөрчилтэй байдал, хот, суурин газрын төлөвлөлт зохион байгуулалтгүй хэрэгжсэн, одоо ч зохион байгуулалтгүй, хууль тогтоомж зөрчсөн газар олголт байгаа зэрэг шалтгаанаас үүдэлтэй гэж үзэж болох байна.

ХСУХАТАтХ-ийн 7.1.2-т заасан “... ундны усны эх үүсвэр” гэх хуулийн нэр томьёо холбогдох хууль тогтоомжид байхгүй, бөгөөд Усны тухай хуулийн 3.1.6-д “усны эх үүсвэр” гэж ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа усны нөөц болон гол мөрний урсац бүрэлдэх эхийг; 3.1.15-д “ус хангамжийн эх үүсвэр” гэж худаг, татах, цуглуулах, цэвэршүүлэх байгууламж, түгээх зориулалт бүхий усны барилга байгууламжийг ойлгоно гэжээ. Үүнээс харахад ус хангамж, ариутгах татуургад хамаарах хуулийн нэр томьёоны нэгдмэл байдал хангалтгүй байна. Иймээс хуулийн нэр томьёог салбарын ерөнхий хууль болох Усны тухай хуульд нийцүүлэх замаар хуулийн хэрэгжилтийг сайжруулах шаардлагатай байна.

Дээрх хуулиудын зохицуулалтаас харахад ИТХ нь ХСУХАТАтХ-д заасан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоохдоо Засаг дарга, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн хяналтын байгууллагын хот, суурины УХАТ-ын улсын байцаагч зэргээс санал, дүгнэлтийг авах шаардлага тавьжээ. Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтооход санал, дүгнэлтийг нь авах зайлшгүй шаардлагатай байгууллага, албан тушаалтанд холбогдох эрх зүйн зохицуулалтууд хууль хэрэглэгчдэд, ялангуяа 4 жил тутамд шинээр сонгогддог, мэргэжлийн гэхээс илүүтэй улс төрийн нөлөө бүхий хүмүүсээс бүрддэг байгууллага болох ИТХ-ын хувьд хуулийн зүйл заалтын дунд төөрөгдөл үүсгэх эрсдэлтэй байна.

Усны болон ус хангамжийн эх үүсвэр, усан сан бүхий газрын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчих явдал нь хэвийн үзэгдэл мэт болж, улмаар хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэгчдийн эрх мэдэл, үйл ажиллагаа хүчгүйдэж байна. Үүний тод жишээ бол Туул гол орчимд баригдаж буй барилгын талбайд мэргэжлийн хяналтын байгууллага бүү хэл УИХ-ын гишүүн өргөдөл, гомдлын мөрөөр хяналт, шалгалт хийх боломжгүй байгаа байдал юм.

Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоосон ИТХ-ын тогтоол, шийдвэр тогтворгүй байна. Энэ нь тухайн орон нутагт хөрөнгө оруулалт татах горьдлого, сонгуульд ялалт байгуулсан намын бодлого, иргэд, ААН-ийн эсэргүүцлээс эмээх, хөрөнгө мөнгө, эрх мэдэл бүхий этгээдийн нөлөөнд автах зэрэг байдлаас ихээхэн хамаарч байна. Хэдийгээр УИХ-аас 2015 онд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай, 2008 онд Хот байгуулалтын тухай зэрэг хуулиудыг баталсан ч хэрэгжилт хангалтгүй байгаа нь ялангуяа хот, суурин доторх ус хангамжийн шугам сүлжээ, барилга байгууламжийн хамгаалалтын бүсийг тогтооход хүндрэл учруулж байна.

Аймаг, нийслэлийн ЗД нь нэг талаас ИТХ-аас хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй холбогдуулан гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэгч, нөгөө талаас орон нутагтаа газар эзэмшүүлэх, өмчлүүлэх шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан байгаа нь бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангах, эсхүл түүнийг зөрчих асуудлыг тухайн хүнд даатгаад үлдээсэнтэй адил байна.

Эрх бүхий байгууллага, олон нийтийг мэдээллээр хангах, нэгдсэн тооцоо судалгаа, статистиктай байх, ашиглах зорилгоор хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн санг хариуцах төрийн захиргааны байгууллагагүйгээс энэ чиглэлээр хийгдсэн хоёр ч мэдээллийн санг ашиглах боломжгүй байна. ХСУХАТАУ33-д

УХАТ-ын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан байх боловч түүнийг ажиллуулах, хөтлөх хүний нөөцгүй тул зөвхөн байгууллагын дотоод хэрэгцээг хангах төдийд хөтөлдөг, харин БХБЯ-ны харьяа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт төслийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн Инженерийн барилга байгууламж, шугам сүлжээний мэдээллийн санг шилжүүлсэн боловч, түүнд хандах эрх БХБЯ-ны НААБЗГ, ХСУХАТАҮЗЗ, БХТ, бусад салбарын байгууллагуудад болон газрын зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд нээгдээгүй байгаа нь хуулийн заалтын хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна.

ИТХ нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд ус хангамж, ариутгах татуургыг хөгжүүлэх бодлого боловсруулан, биелэлтэд хяналт тавих, энэ талаар Засаг даргын тайланг хэлэлцэж, дүгнэлт өгөх эрхтэй боловч энэ эрхээ бүрэн хэрэгжүүлдэггүй, зарим тохиолдолд эс үйлдэхүйгээр хандаж байгаа, мөн газар эзэмших, тодорхой үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг олон байгууллагаас олгодог, бие биенээсээ санал авдаггүй байдал нь ИТХ-ын гишүүдийн энэ асуудалд өгч буй ач холбогдол, үзэмжээс хамаарч хууль хэрэгжих боломжтой байдлыг бий болгосон байна.

Ус хангамжийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох орон зайн хэмжээ, хязгаар хууль тогтоомжуудад адил төстэй байгаа хэдий ч ашиглагдаж буй нэр томъёоны хувьд “усны эх үүсвэр”, “ус хангамжийн эх үүсвэр”, “ус хангамжийн гадаргын усны эх үүсвэр”, “ундны усны эх үүсвэр”, “усан сан бүхий газар”-ын хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс зэрэг олон хэлбэрээр ашиглагдаж байгаа нь, мөн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох тухай зохицуулалт агуулсан Усны тухай хууль, ХСУХАТАтХ дахь зарим заалтууд ойлгомжгүй, өөр өөрийн өнцгөөс тайлбарласан, жишээ нь Усны тухай хуульд онцгой болон энгийн, эрүүл ахуйн бүс нь хязгаарлалтын болон хориглолтын гэсэн ялгаатай байхаар зохицуулсан атал ХСУХАТАтХ-д зөвхөн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй байх зохицуулалттай, харин Бүсийн дэглэмийн 2.4-д хот суурины... ус, цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн байгууламж бүхий газарт онцгой хамгаалалтын бүс тогтоохгүй гэж, 3.17-д төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугам хоолойн тэнхлэгээс хоёр тийш 5 метрт эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно гэж заасан бол ХСУХАТАтХ-ийн 17.6-д төвлөрсөн ус хангамжийн дамжуулах, түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш таван метрт хамгаалалтын зурвас тогтооно гэх зөрүүтэй зохицуулалт хэрэгжиж байна. Мөн ХСУХАТАтХ-ийн 17.4.1-д хот, суурины төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд тогтоохоор заасан бол Бүсийн дэглэмд төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн хувьд 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүсийг, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтооно гэж янз бүрээр томъёолсон нь хууль хэрэглэгчдийг төөрөгдүүлэх эрсдэлтэй байна. Иймд хуулийн зохицуулалтуудын уялдаа холбоог сайжруулах, хуулийн нэр томъёог цэгцлэх, хууль хэрэглэгчдэд аль болох ойлгомжтой, нэг мөр ойлгоход хялбар байдлаар томъёолох, шаардлагатай байна.

ИТХ-аас тогтоосон хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг хамгаалах үйл ажиллагаа, эрх зүйн орчин сул байна. Усны тухай хууль, ХСУХАТАтХ болон Бүсийн дэглэмийг мөрдөх журмын хэрэгжилтийг хангах, хэрэгжилтэд тавих хяналт, хууль сахиулах ажиллагаа аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны ЗД, усны сав газрын захиргаа, аймаг,

нийслэлийн байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын эрх бүхий байцаагч, байгаль хамгаалагчид гүйцэтгэхээр байгаа хэдий ч Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш зөвхөн мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын улсын байцаагчид арга хэмжээ авах эрхийг үлдээсэн нь МХБ-ын хүн хүч дутмаг, зөвхөн төлөвлөгөөний дагуу хяналт хийдэг байдлаас шалтгаалан зөрчлийг цаг тухайд нь таслан зогсоох боломжгүй байдалд хүргэжээ. Мөн мэргэжлийн байгууллагуудын хяналт, шалгалт хийх боломж хумигдсан, зөрчлийг илрүүлэх процесс удаашралтай болсон, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах үндсэн чиг үүрэг бүхий байгууллагуудад арга хэмжээ авах, хариуцлага тооцох эрхгүй болсон, Зөрчлийн тухай хуулийн хүрээнд хүлээлгэж буй торгуулийн арга хэмжээний хэмжээ бага байгаа зэрэг хүчин зүйлсээс хамааралтай байна.

Нийслэл хотын хувьд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох асуудлаар онцлог зохицуулалт хэрэгждэг бөгөөд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох эрхийг тухайн орон нутгийн ИТХ-д Усны тухай хууль болон ХСУХАТАТХ-иар олгосон, гэтэл Усны тухай хуулийн 22.5-д “нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг байгаль орчны болон газрын харилцааны асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хамтран тогтооно” гэж заасан нь нийслэлийн ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоох асуудлаар 2016 оны “Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох тухай” НИТХ-ын 50 дугаар тогтоол, 2018 оны “Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг тогтоох тухай” БХБСайд, БОАЖСайдын хамтарсан А/02/01 дугаар тушаал гэсэн баримт бичиг гаргах үндэслэл болсон байна. НИТХ-ын 50 дугаар тогтоолын хавсралтуудтай танилцах боломжгүй, тэдгээр нь олон нийтэд нээлттэй, ил тод бус байсан байгаа нь бүсийн дэглэмийг зөрчих эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Газрын тухай хуулийн 13.1-д зам, шугам сүлжээний газарт ... ус хангамж, ариутгах татуурга, ... зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газар хамаарна гэж заасан бөгөөд үүнд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг оруулалгүй орхигдуулсан. Иймээс хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг тогтоож, кадастр хийлгэсэн цагаас эхлэн газрын төлбөрийн асуудал хөндөгддөг. Орон нутгийн төсөвт энэ чиглэлээр зарцуулах санхүүжилт тусгагддаггүй, ус хангамжийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын дийлэнх нь эдийн засгийн чадамжгүй, алдагдалтай ажилладаг тул ус хангамжийн барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн газрын төлбөрийг төлөх төлбөрийн чадваргүй байна. Үүнээс шалтгаалан кадастрын зураглал хийлгэдэггүй, улмаар кадастрын зураглалын мэдээллийн санд болон газрын мэдээллийн санд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн тухай мэдээллийг оруулдаггүй байдал нь энэ бүсэд газар олгох асуудлыг даамжруулж байна.

Өмчлөл, ашиглалт, үйлчилгээ, түүний хэрэгжилтийн тухайд

Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байснаар түүний засвар, үйлчилгээ, хэвийн ажиллагаа баталгаатай, тасралтгүй байна, мөн эдгээр барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг хариуцах эрхийг зөвхөн төр, хувийн хэвшлийн түншлэлийн

хүрээнд хувийн хэвшилд шилжүүлэх зорилгыг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Хуульд зааснаар 1/ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, 2/цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, 3/цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байна гэж заасан. Үүнээс харахад УХАТ-ын барилга байгууламж бүхэлдээ буюу магистрал болон салбар шугам сүлжээ мөн адил төрийн болон орон нутгийн өмчид байхаар байна. Нийгмийн хөгжил, эрэлт, хэрэгцээ, зарим тохиолдолд хуулийн шаардлагаар бие даасан ус хангамжийн эх үүсвэр, шугам сүлжээ бүхий орон сууцны хотхон, хороолол баригдсан, үйлдвэр, ААН-үүд өөрийн бага оврын цэвэрлэх байгууламжийг ашигладаг болсон, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай барилга байгууламжийн УХАТ-ын салбар шугам сүлжээ нь иргэн, ААН, орон сууцны контор, СӨХ-ийн эзэмшил, өмчлөлд байхад нөлөөлжээ.

2018 оны байдлаар ХСУХАТАҮЗЗ-өөс гаргасан орон сууц ашиглалтын байгууллагуудын шугам, сүлжээний мэдээллээс харахад УХАТ-ын шугам сүлжээний өмчлөлийн асуудал аймаг, орон нутагт ХСУХАТАтХ-ийн 19 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжиж 100% орон нутгийн өмчид байгаа бол УБ хотод бохир усны шугам, сүлжээний 65,6%, цэвэр усны шугам, сүлжээний 20,5% нь хувийн хэвшлийн өмчид байна. Үүнээс харахад хотжилтын нөлөөгөөр буюу хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрөл нэмэгдэх тусам УХАТ-ын барилга байгууламжийн өмчлөл, эзэмшлийн асуудал хурцаар хөндөгдөх, хувийн хэвшлийг оролцоо цаашид ч өсөх хандлагатай байна. Нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинээр баригдаж буй барилга, байгууламжийн УХАТ-ын барилга, байгууламж, төвлөрсөн болон салбар шугам сүлжээ хувийн хэвшлийн болон дундын өмчлөлийн байх тохиолдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж ХСУХАТАтХ энэхүү харилцаа зохицуулж чадахгүй байгаа нь хүндрэл учруулж байна.

Хэдийгээр ХСУХАТАтХ-ийн 19.1-д “Хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байна” гэж тодорхой хуульчилж өгсөн боловч 2003 онд батлагдсан Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулиар ус, дулаан хангамжийн нэгдсэн системийг хэсэгчлэн хувааж, олон эзэнтэй болгосон, 2008 оны Барилгын тухай хуульд барилгын чанарын баталгаат хугацааг 3 жил байхаар тогтоож өгсөн нь хувийн хэвшлийн эзэмшил, өмчлөл бүхий УХАТ-ын барилга байгууламж бий болох орчинг бүрдүүлсэн бол НИТХ-ын 2014 оны 68 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчид үнэ төлбөргүйгээр шилжин ирж буй нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авах тухай журам”-д хувийн хөрөнгөөр барьсан орон сууцны барилгын түгээх шугам сүлжээ, тоног төхөөрөмж, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг нийслэлийн өмчид үнэ төлбөргүй шилжүүлэх иргэн, аж ахуйн нэгж нь хангагч байгууллагад авлага, өглөггүй байх, эд хөрөнгийн ашиглалтад орсон үеэс байгуулсан хуримтлагдсан элэгдлийн зардлыг төлөх зэрэг шаардлага тавьсан нь хувийн хэвшлийн хөрөнгөөр баригдаж, ашиглалтад орсон УХАТ-ын инженерийн шугам, сүлжээг орон нутгийн өмчид үнэгүй шилжүүлэх хүсэлт гаргахгүй байх шалтгаан нөхцөл болжээ гэж үзэж болохоор байна.

ХСУХАТАҮЗЗ-д үйл ажиллагааныхаа тайланг ирүүлсэн 104 байгууллагын дүнгээс харахад эдгээр байгууллагууд нийт үйл ажиллагаагаараа 269.7 тэрбум төгрөгийн орлого

олж, 300 тэрбум төгрөгийн зардалтай ажилласан байна. Үүнээс харахад нийт дүнгээрээ 30,3 тэрбум төгрөгийн алдагдал хүлээсэн судалгаа гарсан нь энэ салбарын санхүү, эдийн засгийн чадамж сул, УХАТ-ын шугам, сүлжээний засвар, үйлчилгээг гүйцэтгэх хангалттай хөрөнгө, санхүүгийн нөөц хувийн хэвшлийн ОСК-уудад байхгүй болохыг харуулж байна. Энэ нь нийслэлээс тавьж буй шаардлагыг тэр бүр хангах боломжгүйг мөн адил харуулж байна.

УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ хариуцдаг хувийн хэвшлийн ТЗ бүхий ААН-үүдийн үйл ажиллагааны орлого, зарлагын баланс алдагдаж ихэнх нь алдагдалтай ажилладаг, үндсэн хөрөнгө, хуримтлал муутайгаас үүдэн элэгдэл, хорогдлын хуримтал үүсгэдэггүй, түүнийгээ бусад зардалдаа зарцуулдаг зэрэг нийтлэг дүр төрх нь энэ салбарын өр төлбөрийн хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэхэд нөлөөлдөг. Үүний улмаас нийслэлийн өмчид төлбөргүй шилжүүлэх нөхцөлийг хангах шугам сүлжээний тоо цөөрөх, хожим хувийн хэвшлийн өмчлөл, эзэмшилд байгаа УХАТ-ын инженерийн шугам, сүлжээний ашиглалтын хугацаа дуусах, эвдрэл, гэмтэл гарах үед санхүүжилтийг төр, орон нутгийн төсвөөс гаргах эрсдэлийг бий болгож байна.

ХСУХАТАтХ-ийн 19.2-т заасан барилга байгууламж, шугам сүлжээ, байгууламжийн ашиглалт, үйлчилгээг зохих ТЗ бүхий хуулийн этгээд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж болно гэж тодорхой зааж өгсөн. ХСУХАТАҮЗЗ-өөс гаргаж буй статистик, мэдээлэлд “хувийн өмчийн” гэх нэгдсэн нэр томъёо ашиглаж байгаа нь УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй ТЗ бүхий ААН-үүдийн хэд нь, нийт УХАТ-ын барилга байгууламж, шугам сүлжээний хэдэн хувь нь ТХХТ-ийн хүрээнд үйл ажиллагаа явуулж, ашиглалт үйлчилгээ хариуцаж байгаад үнэлэлт, дүгнэлт хийх боломжгүй байдалд хүргэсэн нь ТХХТ-ийн хүрээнд хувийн хэвшлийн өмчлөл, ашиглалтад байгаа УХАТ-ын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийг тусад нь бүртгэх, хөтлөх шаардлагыг тодорхойлж байна.

ХСУХАТАҮЗЗ-өөс гаргаж буй статистик, мэдээлэлд “хувийн өмчийн” гэх тодотголтой УХАТ-ын барилга байгууламж, шугам сүлжээ нь гол төлөв ТЗ эзэмшигч ОСК-уудын өмчлөл, эзэмшилд байгаа нь анхаарал татаж байна. Учир төр, хувийн хэвшлийн түншлэлээс бусад хэлбэрээр, ашгийн төлөө барьж байгуулагдсан орон сууцны УХАТ-ын барилга байгууламж, шугам сүлжээний хөрөнгө оруулалтын зардал тухайн орон сууцыг борлуулах үнэд шингэсэн байх тул эдгээр шугам, сүлжээ ОСК-ын биш оршин суугчдын өмчид хамаарах нь зохистой байна. Иймээс УХАТ-ын салбарын өмчлөлийн асуудал, хувийн хэвшлийн оролцоог зохицуулсан эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг хангуулах орчин нөхцөлийг бий болгох шаардлагатай.

Тусгай зөвшөөрөл, түүнд холбогдох эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн тухайд

Хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг ашиглах, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 10.1.3-т зааснаар ХСУХАТАҮЗЗ бүрэн эрхийнхээ хүрээнд олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, 10.1-д зааснаар ТЗЭ-ийн үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг хүлээжээ.

Тусгай зөвшөөрөлд холбогдох, хуулиар хүлээсэн эрх, үүргийг ХСУХАТАҮЗЗ сайн гүйцэтгэж байгаа боловч тусгай зөвшөөрлийн тоо олон, ТЗ эзэмшигчдэд тавих эдийн засгийн шаардлага сул, хэт олон ТЗ эзэмшигч байгаа зэрэг асуудал тулгарч байна.

Хуулийн нэр томъёоны зөрчлийн тухайд

ХСУХАТАтХ-д ашиглагдаж буй хуулийн нэр томъёо нь бусад хууль тогтоомжтой зөрчилдөх тохиолдол цөөнгүй байгаа бол барилга, УХАТ-ын салбарын стандарт, норм, дүрэм, журамд ашигласан нэр томъёоны зөрчил их байна. /Энэ талаар ХСУХАТАтХ-ийн зөрчил, хийдэл, давхардлын судалгааны тайлангаас дэлгэрүүлэн үзнэ үү/ Тухайлбал:

Хуулийн нэрийг “Хот, суурины...” гэж томъёологдсон нь УИХ-аас 1993 онд баталсан Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд заасан хот, тосгоныг суурин газар гэж үзнэ гэх хуулийн заалттай зөрчилдөж байна. Уг хуулийн 3 дугаар зүйлийн 1-д Хот нь 15000-аас доошгүй оршин суугчтай ... суурин газар мөн, 2-т Тосгон нь 500-15000 оршин суугчтай ... суурин газар мөн гэж заажээ. Үүнээс харахад “хот, суурин газрын” гэж томъёолох нь хуулийн нэр томъёоны нэгдмэл байдлыг алдагдуулсан байна.

ХСУХАТАтХ-ийн “17.2.Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр нь хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй байх бөгөөд тэдгээрийн дэглэмийг Усны тухай хуулийн 31.3, 31.4-т заасны дагуу тогтооно., 17.4.2.төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн энгийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүсийг Усны тухай хуулийн 31.3-т заасны дагуу; 17.4.4.урсгал усыг төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа тохиолдолд тухайн газрын хөрс, чулуулгийн тогтолцоо, голын урсцыг харгалзан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг Усны тухай хуулийн 31.4-т заасны дагуу., 17.7.Хотын доторх цэвэр усны дамжуулах, түгээх, бохир усны гаргалгааны болон бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам ашиглалтын явцад засвар, үйлчилгээ хийх хамгаалалтын зурвас газартай байна., 17.8-д Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд Усны тухай хуулийн 31.2.1-д зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:” гэх заалтуудын эшлэл буруу, 2012 онд баталсан Усны тухай хуулийн шинэчилсэн найруулгатай нийцэхгүй байна.

Хяналт, шалгалт, хариуцлага, түүний хэрэгжилтийн тухайд

ХСУХАТАтХ-ийн 23 дугаар зүйлийн 23.1-д заасан “Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэх заалтын хэрэгжилтийг хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны явцад төрийн албан тушаалтан, албан хаагчийн зүгээс гаргасан зөрчил, дутагдалд Төрийн албаны болон ЗЕХ-ийн дагуу авсан арга хэмжээний талаар тодорхой тоо баримт гаргах боломжгүй байна. Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах чиг үүрэг бүхий БХБЯ, ХСУХАТАҮЗЗ, БХТ, ОСНАҮГ зэрэг төрийн болон төрийн оролцоотой байгууллагуудын хүний нөөцөд хамаарах тушаал, шийдвэрүүдийг олон нийтэд ил тод, нээлттэй байршуулаагүй дутагдал, мөн тушаал, шийдвэрийн үндэслэл хэсэг хэт ерөнхий, тухайлбал, “ажил үүргээ хангалттай биелүүлээгүй”, “өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлээгүй” зэргээр томъёологдсон байдал зэргээс Төрийн албаны тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл хүлээж буй албан хаагч ямар үйл ажиллагаанд хамаарах ямар асуудлаар шийтгэл хүлээснийг олж тогтоох боломжгүй байна.

ХСУХАТАтХ-д хамаарах асуудлаар ЗЕХ-д заасан “албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиргааны байгууллагад хохирол учирсан бол хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар Иргэний хуулийн 498-д заасны дагуу буцааж төлүүлэх замаар байгууллагад учруулсан хохирлыг барагдуулсан тохиолдол гараагүй байна.

Харин Төрийн албаны тухай болон ЗЕХ-д зааснаар албан тушаалтан, төрийн албан хаагч хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдаанаас бусдад учруулсан хохирлыг төр хариуцан БХБЯ-аас 1,284,4 сая төгрөгийн нөхөн төлбөр төлөхөөр байна. Энэ нь албан тушаалтны буруутай үйл ажиллагааны эрсдэлийг төр хариуцдаг ойлголт бат бэх оршиж, төрөөс төлбөрийг барагдуулж байгаа нь албан тушаалтны хариуцлага, хандлага өөрчлөгдөхгүй байх эрсдэлийг дагуулж байна.

ХСУХАТАтХ-ийг хэрэгжүүлэгч байгууллагуудын ажилтан, албан хаагчдад Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэдэггүй байдал нь энэ салбарт зөрчил гардаггүй гэсэн агуулгаас илүүтэй салбарын үйл ажиллагаа, төсөв, санхүүжилтэд тавьж буй хяналт сул, хариуцлага тооцох үйл ажиллагаа хангалтгүй байна гэх дүгнэлтэд хүргэсэн.

ХСУХАТАтХ-ийн 23.2-т заасан “Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэх зохицуулалтын зорилгыг хуулиар хүлээлгэх хариуцлагын хэмжээ нь хууль зөрчихөөс урьдчилан сэргийлэх, хууль зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, хууль зөрчсөн үйлдлийн улмаас учирсан хохирлыг барагдуулахуйц байна гэж тодорхойлсон бөгөөд хэрэгжилтийн үнэлгээгээр УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ, өмчлөлийн асуудалд холбогдуулан Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэгт хамаарах Байгаль орчныг бохирдуулах гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдон эрүүгийн хариуцлага тооцсон тохиолдлыг судалж үзсэн бөгөөд 2016 оны 6 сарын 1-нээс хойших хугацаанд ийм шийдвэр гараагүй байна. Энэ нь энэ төрлийн хэрэг маргааныг шалгах, хариуцлага тооцох ажиллагаа сул байгааг харуулж байна.

Зөрчлийн тухай хуулийн Зургадугаар бүлэгт Нийтийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчлүүд, түүнд хүлээлгэх хариуцлагын асуудлыг тусгаж торгох, хохирол нөхөн төлүүлэх, эрх хасах арга хэмжээ авах боломжтой байдлаар тусгасан боловч хууль хэрэгжиж эхэлснээс хойших тоо баримт тодорхойгүй, энэ төрлийн зөрчлийг тусад нь бүртгэдэггүй зэрэг нь мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжгүй байдалд хүргэж байна.

Эрүүгийн болон Зөрчлийн хуулиар ял шийтгүүлж, хариуцлага тооцуулсан тохиолдол цөөн байгаа нь томоохон хэргийн хувьд Үндсэн хуулиар баталгаажсан хүний амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгаа болсон стандартын шаардлага хангасан ундны усаар хангагдах эрхийг зөрчиж, цаашлаад үндэсний аюулгүй байдалд заналхийлж болзошгүй нөхцөл байдал үүсгэж, хууль тогтоомж зөрчиж буй этгээдүүдтэй хийж буй тэмцэл шат шатны хууль, хяналтын байгууллагуудын эрх хэмжээнээс хэтэрсэн, хэн нэгний эрх ашгийг хамгаалсан, улс төр, эдийн засгийн нөлөөнд автсан байдалд орсон нь хууль хэрэгжихгүй байх гол шалтгаан болжээ гэж үнэлж болох байна.

Түүнчлэн хуулиар хүлээлгэх торгуулийн арга хэмжээ нь энэ асуудалд хандах хандлагыг өөрчлөх, зөрчил гаргахгүй байлгах, гэмтлийг шуурхай арилгах арга хэмжээ авах

хэмжээнд хүртэл нөлөөлөхгүй байна. Тухайлбал, ХСУХАТАтХ-ийн 17.8.3, .17.8.4 дүгээр заалтыг зөрчин баригдсан барилга, байгууламжууд хэдэн зуун сая, тэрбумын хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа тохиолдолд ХСУХАТАтХ-иар хүлээлгэх хариуцлагын хэмжээ 10 сая төгрөг хүртэл байгаа нь дээрх үзэгдлийг таслан зогсооход нөлөөлөхгүйгээс гадна хууль зөрчин барилгын ажлын улмаас үүссэн хохирлыг үнэлж буй байдал байгаль орчны экологийн бодит үнэлгээнд хүрэхгүй байгаа нь мөн адил нөлөөлдөг гэж үзэж болохоор байна.

23 дугаар зүйлийн 23.1, 23.2-т заасан хуулийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байгаа нь, мөн хуулийг хэрэгжилтийг хангуулах, хяналт, шалгалт хийх, арга хэмжээ авах эрх бүхий этгээдийн тоо цөөн, зарим тохиолдолд ашиг сонирхлын зөрчилтэй байгаа нь энэ хууль хэрэгжихгүй байх гол шалтгаан болж байна. Тухайлбал, Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээр УХАТ-ын ашиглалт үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын мөрөөр БХТ, ХСУХАТАҮЗЗ-д УХАТ-ын улсын байцаагч ажиллах боломжгүй болж, зөрчилд арга хэмжээ авах эрх зөвхөн МХБ-ын улсын байцаагчид үлдсэн. Хэрэв МХБ байцаагч зөрчлийн хэрэг үүсгэвэл тухайн хэрэг прокурорын хяналтад ордог зэрэг ойлгомжгүй, үйл ажиллагааг удаашруулсан зохицуулалтууд хэрэгжиж байна.

Эцэст нь хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний буюу НАА салбарт хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байгаатай холбогдуулан хангагч, хэрэглэгчийн хариуцлагын асуудлыг ялгаатай зохицуулах шаардлага үүссэн байна. УХАТ-ын барилга, байгууламж өмчлөгч, эзэмшигч, энэ төрлийн үйлчилгээ үзүүлэгч буюу хангагч иргэн, ААН-ын эрх, үүрэг, хариуцлагын асуудлыг тодорхойлох шаардлага тулгамдаж байгаа нь судалгааны ажлын явцад ажиглагдаж байлаа.

УХАТ—ын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын тогтолцооны тухайд

ХСУХАТАтХ-ийн 5 дугаар зүйлд заасан Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд хүний нөөцийн болон хэрэгжүүлэгч байгууллагын хомсол үүссэн нь БХБЯ-ын “шүдгүй арслан” болгоход нөлөөлсөн гэж харж байна.

Хуулийн 5.1.1-д заасан хот, суурины УХАТ-ын ашиглалтын норм, дүрэм, нийтлэг мөрдөх журам, заавар батлах, стандартыг хянах бүрэн эрхийн хүрээнд БХБЯ, БХТ, ХСУХАТАҮЗЗ-өөс хот, суурины ус, хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээнд хамаарах норм, дүрэм журам, стандартыг шинээр болон шинэчлэн батлах, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэх ажил хангалттай сайн хийгдэж байна. Гэвч ус хангамж, ариутгах татуурга, технологийн хэрэглээний усыг эргүүлэн ашиглах асуудал зэрэг нь олон яам, агентлагийн эрхлэх асуудалд хамаарч байгаагаас үүдэн салбар дундын бодлого, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, чиг үүргийн давхардлаас үүдэн хууль хэрэгжихгүй байх тохиолдол гарсаар байна.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй норм, дүрэм журам, стандартыг мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх асуудал төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа байгууллагад хангалтгүй хэрэгжиж байна. Үүнийг хүний нөөцийн дутмаг байдал, хууль тогтоомжийн шинэчлэлтээс үүдэн хяналт шалгалт хийх эрх зүйн орчин хязгаарлагдмал болсон зэрэгтэй холбон ойлгож болох юм. Тухайлбал, хот,

суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээтэй холбогдох төрийн бодлого төлөвлөлт эзэнгүйдэж, цалгардсан явдалд уг асуудлыг хариуцсан чиглэлийн яам болох БХБЯ-ыг хэд хэдэн удаа бусад чиглэлийн яамтай нэгтгэх, эргэн салгах зэргээр тогтворгүй байсан, НАА бодлого хариуцсан БХБЯ, түүний харьяа байгууллага болох БХТ-д улсын хэмжээнд хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний асуудал хариуцсан 4 мэргэжилтэн ажиллаж, усны нэгдсэн менежментийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй 20 орчим байгууллага, мөн аймаг, нийслэлийн засаг дарга нартай байнгын харилцаа холбоотой байж, төрийн бодлого, хууль тогтоомж, үйл ажиллагаа, төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах чиглэлээр хамтарч ажиллах шаардлага үүссэн нь албан хаагчдын ажлын ачаалал хэт их байх, үүний улмаас гүйцэтгэж буй ажлын чанар, хүртээмж сулрах, хамрах хүрээ хумигдах эрсдэлийг бий болгожээ. Үүнээс харахад БХБЯ хуулиар хүлээсэн эрх, үүргээ улсын хэмжээнд тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй, чанартай хэрэгжүүлэх хангалттай хүний нөөцгүй байгаа нь эрсдэл дагуулж байна.

Мөн БХБЯ нь Хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээтэй холбогдох асуудлыг 2 хувааж Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас гадна 2016 онд байгуулсан Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт харьяалуулсан нь салбарын бодлого хуваагдмал байдалд орох, хууль тогтоомж хэрэгжүүлэгчид хэд хэдэн газарт хүсэлт гаргах, мэдээлэл хүргүүлэхээр болж төрийн хүнд суртал, чирэгдлийн нэмэгдүүлэх эрсдэлийг үүсгэж, угаасаа олон газар задарсан УХАТ-ын асуудлыг дахин хуваасан хэрэг болжээ гэж үзэж болох байна.

Хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээ хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын хот, суурины УХАТ-ын талаарх төрийн бодлогыг усны хэрэглээний хандлага, усны нөөц, ашиглаж болох боломжит нөөц, усны менежментийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулах, УХАТ-ын ашиглалтын норм, дүрэм, нийтлэг мөрдөх журам, заавар батлах, стандартыг мөрдүүлэх үйл ажиллагаа практикт хангалттай хэрэгжихгүй байна. Энэ нь дээр дурдсан хүний нөөцтэй холбоотой асуудлаас гадна уг салбарт төрийн бодлогыг хэрэгжүүлэгч байгууллага, тухайлбал ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг байхгүй, мөн Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш УХАТ-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллагууд болох БХТ, УСХАТАУЗЗ улсын байцаагчийн эрхгүй болсон зэрэгтэй холбоотой байна.

ХСУХАТАТХ-д бүрэн эрхийг нь тодорхойлсон УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага байгуулагдаагүй, төрийн захиргааны төв байгууллага, түүний харьяа газруудад УХАТ-ын асуудал хариуцсан хүний нөөцийн дутагдалтай, ХСУХАТАТХ-ийн хүрээнд үүсгэн ХСУХАТАУЗЗ-ийн статус, эрх зүйн байдал тодорхойгүй байгаа нь УХАТ-ын бодлого төлөвлөлт, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах, салбар дундын зохицуулалтыг сайжруулах, хариуцлагыг дээшлүүлэх зэрэг олон ажил хариуцах эзэнгүй хаягдахад нөлөөлж байна.

ХСУХАТАТХ-иар зохицуулсан нийт харилцаанаас зөвхөн усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргахтай холбоотой

харилцаа ХСУХАТАҮЗЗ-д хамааран хэрэгжиж байгаа бол бусад асуудлыг хариуцах байгууллага тодорхойгүй байна.

ХСУХАТАтХ-ийн 6 дугаар зүйлд Хот, суурины УХАТ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийг тодорхойлсон нь салбарын хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, салбарыг нэгдсэн удирдлага, арга зүй, зохион байгуулалтаар хангах, салбарын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, салбарын үйл ажиллагааны үр дүн, нэгдсэн мэдээ мэдээлэл, статистик гаргах, хяналт шалгалт хийх, хариуцлагыг дээшлүүлэх зэрэг зорилготой боловч төрийн захиргааны байгууллага байгуулагдаагүйгээс дээрх асуудлыг шууд хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага байхгүй байна. УХАТ-ын өмчлөл, ашиглалт, үйлчилгээнд хамаарах харилцаа төрийн болон орон нутгийн өмчийн хэлбэрээс хальж хувийн хэвшлийн оролцоотой болсон, усны асуудал нь бараг бүхий л яамдын үйл ажиллагаанд хамаарч байгаа үед энэ хуулийн хэрэгжилт, хуулийн норм, стандартыг мөрдүүлэх ажиллагааг хариуцах бие даасан бүтэц, төрийн захиргааны байгууллага байхгүй нь УХАТ-ын салбарыг “дайвар, хавсарга” салбар болгожээ.

Мөн Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан агентлагийн Засгийн газрын үйл ажиллагааны зохих салбар, хүрээний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх чиг үүргийн асуудал УХАТ-ын салбар дотроо 3 хуваагдсан байгаа нь салбарын нэгдсэн бодлого хэрэгжихгүй байх, зарим асуудал хаягдахад нөлөөлжээ.

Төрийн захиргааны байгууллагагүй байгаа нь УХАТ-д хамаарах хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг хэнд хамааралтай болох нь тодорхойгүй, хэрэгжилтийг судлах, үнэлэх ажиллагаа орхигдсон, энэ салбарын хөрөнгө оруулалт бусад салбарын давлагаан дор, хавсарга шинжтэй болсон, салбарт хийгдсэн, хийгдэж буй хөрөнгө оруулалт тухайн орон нутгийн удирдлагын авхаалж самбаанаас хамааралтай болсон, зээл тусламж авах, өр төлбөрийг эргэн төлөх асуудал нэгдсэн бодлого, төлөвлөлтгүй болсон, УХАТ-ын үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд олон газарт буюу орон нутгийн удирдлага, ХСУХАТАҮЗЗ, сав газрын зөвлөл гээд хэд хэдэн газарт тайлан, мэдээллээ хүргүүлж төрийн хүнд суртлын дарамтад орсон, салбарын стратеги, бодлого төлөвлөлт боловсруулах, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах ажил орхигдоход хүргэжээ.

Тухайлбал, ХСУХАТАтХ-ийн 6 дугаар зүйлд заасан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлж буй хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээтэй холбоотой мэдээллийн сан байгуулах, түүний байнгын ажиллагааг эрхлэх, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах үйл ажиллагааг БХБЯ хариуцан үйл ажиллагааг эхлүүлээд ГЗБГЗЗГ-аар дамжуулснаар УХАТ-ын шугам сүлжээний мэдээллийн сан байгуулах, хөтлөх ажлыг ГЗБГЗЗГ хариуцан, хэрэгжүүлж байна. Энэхүү мэдээллийн санд байршуулсан УХАТ-ын шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээтэй холбоотой буюу тухайн шугам сүлжээний насжилт, байр зүйн зураглалын мэдээлэл нь УСУГ, ХСУХАТАҮЗЗ, БХТ зэрэг шугам сүлжээний техникийн нөхцөл олгох, хяналт шинжилгээ, ашиглалт, засвар үйлчилгээ хийх чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад шаардлагатай байгаа боловч мэдээллээр хангагдах боломжгүй буюу УХАТ-ын асуудал хариуцсан холбогдох байгууллага өөрийн эрхээр нэвтэрч мэдээлэл авах боломж бүрдээгүй,

нээлттэй, ил тод бус байгаа нь тухайн заалт практикт зарим талаар хэрэгжихгүй байгааг харуулж байна.

ХСУХАТАтХ-ийн хүрээнд үүсгэн байгуулагдсан ХСУХАТАҮЗЗ нь тариф тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах, сургалт зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бөгөөд уг байгууллагын статус, эрх зүйн байдал тодорхойгүй 5 жил өнгөрсөн байна.

ХСУХАТАтХ-иар ХСУХАТАҮЗЗ-д хариуцуулснаас бусад асуудал хариуцах эзэнгүй үлдсэн нь ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангах тогтолцоо бодлогоос орхигдсон шинжтэй болж энэ салбарыг удирдах өнөөгийн тогтолцоо нь тархай бутархай, олон яам, агентлагуудад харьяалагдаж байгаа нь энэ чиглэлээр хийж гүйцэтгэж буй ажлууд уялдаа холбоогүй, өөр хоорондоо зөрүүтэй, салбарын нэгдсэн мэдээлэл, тоо судалгаа гаргах боломжгүй байдалд хүргэсэн байна.

БХБЯ-ны харьяа Барилгын хөгжлийн төв болон ХСУХАТАҮЗЗ-д салбар дундын зохицуулалт хийх эрх зүйн үндэс байхгүй, мөн төрийн захиргааны байгууллагын зохицуулалт хийх чиг үүргийг хэрэгжүүлэх боломжгүй, энэ талын хууль эрх зүйн орчин тодорхойгүй байна.

УХАТ-ын ашиглалт, үйлчилгээний байгууллагууд нийтийн эрх, ашиг сонирхлын үүднээс ашгийн бус байх шаардлагатай. Хуульд зааснаар ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн ба орон нутгийн өмчид байх зохицуулалттай хэрэгжээгүйн улмаас энэ салбарт хувийн хэвшлийн болон дундын өмчлөлийн асуудал үүсгээд 20 гаруй жил болж байгаа боловч хувийн хэвшлийн ААН-үүдийн үйл ажиллагааг төрийн бодлогод нийцүүлэх, төр, хувийн хэвшлийн хоорондын харилцаа зохицуулах асуудал орхигдсон байна.

УХАТ-ын салбарын нэгдсэн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх төрийн захиргааны байгууллага байхгүйгээс шалтгаалан улсын төсөв, олон улсын болон гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжаар хийгдэж буй өргөтгөл, шинэчлэлийн хүрээнд хийгдэж буй төсөл, хөтөлбөрт хамрагдах эсэх нь орон нутгийн удирдах байгууллагуудын өөрсдийн авхаалж самбаанаас шалтгаалдаг ерөнхий байдал үүссэн байна. Энэ нь хуулийн 6.1.2-д заасан хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, өргөтгөх, төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах зохицуулалт хэрэгжихгүй, чиг үүрэг эзэнгүй байгааг харуулж байна.

Иргэдийн хувийн хэрэгцээндээ зориулан гаргасан усны эх үүсвэрийн тухайд

Манай Улсын хэмжээнд 2017 оны байдлаар тусгай зөвшөөрөл бүхий 200 гаруй ААН худаг гаргах үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд худаг гаргах үйлчилгээний хөлс хотод 110000-160000 төгрөг/метр, хөдөө орон нутагт байршлаас хамааран үнэ тарифаа харилцан тохиролцох байдлаар тогтоодог байна. Иргэдийн зүгээс худаг гаргуулах эрэлт хэрэгцээ нэмэгдсэн нь эдгээр ААН-ийн тоо өсөхөд нөлөөлсөн байх магадлалтай.

Улсын болон орон нутгийн хэмжээнд гаргаж буй худгийн тоо мэдээллүүд зөрүүтэй байна. Энэ нь нэг талаас зөвшөөрөлгүй гаргасан худгийн тоо их байгаатай холбоотой байх магадлалтай. Ерөнхийдөө холбогдох төрийн байгууллагуудын зүгээс худгийн тооллогын дүнг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар гаргах чадваргүй байгаа нь тэдгээрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж буй байдлыг тогтоох, хууль дүрэм зөрчигчид хариуцлага хүлээлгэх тогтолцоо, орчин нөхцөл бүрдээгүйгээс, мөн усны асуудал хэт олон байгууллагад хамаарч байгаагаас, тэдгээрийн бодлого, үйл ажиллагаа уялдаа холбоогүй байгааг харуулж байна.

Иргэд хууль тогтоомжид заасан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг иргэний хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэрт мөн адил хэрэгжүүлснээр усны чанар, стандартад нийцсэн ус хэрэглэх нөхцөлийг бүрдүүлэх, мөн ус хангамжийн эх үүсвэрийг бохирдлоос хамгаалах зорилго бүхий ХСУХАТАТХ-ийн 7.11-д заасан иргэн хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэрийг ашиглах болон бусад хэрэглэгчийг усаар хангах нөхцөлд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх эрх зүйн зохицуулалт хэрэгжих боломжгүй байна.

Учир нь МУ иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу хот, суурин газарт 0,07-0,35 га хүртэлх хэмжээтэй газрыг иргэний өмчлөлд олгож байна. Гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлэх газрын байршил хэмжээг м2-аар илэрхийлбэл нийслэлд 0.07 хүртэл га 20х35 м2, аймгийн төвд 0.35 хүртэл га 35х100 м2, сумын төв, тосгонд 0.5 хүртэл га 50х100 м2 байгаа нь ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох наад захын зай хэмжээг хангахгүй байгаа нь иргэд хууль тогтоомж зөрчигч болох нөхцөлийг бүрдүүлжээ. Мөн гэр бүлийн хэрэгцээнд зориулан иргэнд олгох хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, таримал ургамал тарих зориулалтаар 0,1 га-гаас илүүгүй, тариалангийн газрыг 5 га хүртэлх хэмжээтэй олгох тохиолдолд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг тухайн газар мөрдөх боломжтой боловч уг газарт ямар бордоо, химийн бодис ашиглаж буйг бүрэн хянах боломжгүй байна.

Үүнээс харахад Усны тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулиудад иргэн аймаг, нийслэлийн байгаль орчны албанаас олгосон зөвшөөрлийн дагуу гэр бүлийнхээ хэрэгцээнд ашиглах, уг газарт худаг гаргаж усыг нь ашиглах боломж олгосон зохицуулалт нь Усны тухай хууль, ХСУХАТАТХ болон Бүсийн дэглэмд заасан хамгаалалтын болон эрүүл ахуйн дэглэм дэх хуулийн шаардлагыг хангах боломжгүй байдлыг харгалзаагүй, уялдаа холбоогүй зохицуулалтыг бий болгосон байна. Иймд ус хангамжийн эх үүсвэр, түүний хамгаалалтын асуудал нь газрын харилцааны асуудалтай салшгүй холбоотой байхыг харгалзан үзэж газар, хөрсний бохирдлоос хамгаалах, газар төлөвлөх, хот төлөвлөх, УХАТ-ын асуудлын уялдаа холбоог сайжруулах шаардлага байна.

Практикт тулгамдаж буй асуудлаас гадна хууль тогтоомжийн төвшинд зөрүүтэй зохицуулалт бас байна. Тухайлбал, ХСУХАТАТХ-ийн 17.4.1-д хот, суурины төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд тогтоохоор заасан бол Бүсийн дэглэмд төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн хувьд 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүсийг, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг, онцгой

хамгаалалтын бүсийг ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хориглолтын бүсэд тогтооно гэж зөрүүтэй байдлаар зохицуулжээ.

Технологийн хэрэглээний усыг дахин ашиглах тухайд

ХСУХАТАТХ-ийн 17.13-ын “Уул уурхай, эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглана” гэх зохицуулалт бий. Гэвч энэ зохицуулалтаар шийдвэрлэхийг зорьсон харилцаа нь хот, суурины ус хангамжийн асуудалд хамаарахгүй байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлж байна гэж үзлээ.

Хуулийн зохицуулалтын зорилгыг хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүргийн хүрээнд уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүд технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашигласаа замаар усны нөөц, ус хангамжийн эх үүсвэрийг хамгаалах, үйлдвэрлэлд усны зохистой хэрэглээг бий болгох, ус хэмнэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн нь ус ашиглалтын байгаль орчинд үзүүлэх үр дагавар, эргэх холбоонд ач холбогдол өгсөн байгаа нь сайшаалтай ч иргэдийн хувийн унд, ахуйн хэрэгцээндээ гаргасан ус хангамжийн эх үүсвэр, ариун цэврийн байгууламжийн асуудлыг ХСУХАТАТХ-сар бус Усны тухай хуулиар зохицуулж байгаа энэ тохиолдолд уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүдэд хэрэглээний усаа эргүүлэх ашиглах үүрэг хүлээлгэх асуудлыг ХСУХАТАТХ-д оруулах нь илүүц байна гэж үзлээ.

ҮСХ-оос гаргасан мэдээллээс харахад манай улс 2015 онд нийт 493,4 сая м³ ус ашигласнаас уул уурхайд 81,1 сая м³, цахилгаан станцууд 44,7 сая м³ ус хэрэглэсэн нь нийт усны хэрэглээний 25 гаруй хувийг дангаараа эзэлжээ. Мөн 2017 оны эхний улиралд газрын доорх усны 0,8%-ийг хүн амын унд, ахуйн хэрэглээнд, 99,2%-ийг үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглажээ.

Манай улсад ашигт малтмал ашиглалтын 1676 хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл эзэмшигч бий. Эдгээр ТЗЭ нь Усны тухай хуулийн дагуу ус ашиглах гэрээ байгуулан, уг хуульд заасан шаардлага ханган ажиллах үүрэг хүлээлгэсэн нь БАОЖЯ, БХБЯ-ны чиг үүрэгт давхардал бий болгосон, ХСУХАТАТХ-ийн 17.13-д уул уурхай ... нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглана гэсэн заалтын хэрэгжилтийг тайлагнадаг уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй ААН байхгүй, хуулийг хэрэгжүүлэгч БХБЯ энэ асуудалд төдийлөн анхаарал хандуулдаггүй учраас уул уурхай, эрчим хүчний үйлдвэрүүд тайлангаа ирүүлдэггүй, түүнийг нэгтгэх, дүгнэх ажиллагаа хийгдээгүй зэрэг нь хэрэгжилт хангалтгүй байхад нөлөөлснөөс гадна ХСУХАТАТХ-д заасан технологийн хэрэглээний усыг дахин ашиглах үүргийг уул уурхайн компаниуд зөвхөн нийгмийн хариуцлагын хүрээнд, сайн дурын үндсэн дээр хэрэгжүүлэх нөхцөлийг бий болгосон байна.

Ерөнхийдөө ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн компаниуд ус ашиглалт, дахин ашиглаж буй усны хувь хэмжээний талаарх мэдээллээ ил тод байршуулахгүй байгаа нь олон нийтийн болон төрийн хяналтыг хэрэгжүүлэх боломжгүй байдлыг бий болгосон гэж үзэж болох юм. Судалгааны ажлын хүрээнд санамсаргүй түүврийн аргаар 7 ААН-ын олон нийтэд ил тод байршуулсан мэдээллийг судалж үзэхэд уурхайн үйл ажиллагааны усны нийт хэрэглээний хэдэн хувийг дахин ашигласан усаар хангаж байгаа талаар тоо мэдээлэл гаргасан компани ховор байна.

Харин “Өмнийн говь дахь уул, уурхайн компаниудын усны удирдлагын сайн дурын кодекс”-т нэгдэн орсон 10 компани усны талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тодорхой хэмжээнд мэдээллээ ил тод байршуулдаг бол дийлэнх компаниудын хувьд цахим хуудасгүй, байгаа нь зөвхөн компаний танилцуулга төдийхнөөр хязгаарлагдсан мэдээлэлтэй байна.

Үүнээс харахад уул уурхайн компаниуд үйл ажиллагаандаа хэрэглэж буй усны талаарх мэдээллийг “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” боловсруулах, биелэлтийг тайлагнах ажлын хүрээнд БОАЖЯ, АМГ, УУЯ зэрэг байгууллагуудад мэдээлэл хүргүүлдэг бол ХСУХАТАТХ-ийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий БХБЯ-нд энэ талаар мэдээлэл хүргүүлдэггүй, яам энэ талаар тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс мэдээлэл авдаггүй, энэ үүргийг нарийвчлан зохицуулсан дүрэм, журам боловсруулагдаагүй, хуулийн хэрэгжилтийг хариуцах байгууллага, нэгж тодорхойгүй, хуулийн хэрэгжилтийн талаар тайлан мэдээ авдаггүйтэй холбоотой байна. Энэ нь уул уурхайн компаниудын дахин ашигласан усны талаар нэгдсэн тоо, статистик байхгүй, энэ чиглэлээр ямар ахиц гарсныг тодорхойлох боломжгүй байдалд хүргэсэн байна.

Уул уурхай, эрчим хүчний салбарт усыг дахин ашиглах, хэмнэх технологийг түлхүү нэвтрүүлэх, түүнийг хөхиүлэн дэмжих эрх зүйн зохицуулалтуудыг бий болгох шаардлага үүссэн байна. Манайд технологийн хэрэглээний ус, хэрэглээнээс гарсан ус, саарал ус, хаягдал ус гэж хэд хэдэн янзаар нэрлэгддэг усыг ашиглахгүй байх гол шалтгаанд усыг эргүүлэн ашиглахад гаргах зардал цэвэр усыг ашиглахаас илүү үнэтэй, мөн дээрх салбаруудад ашиглагдаж буй худгууд бүрэн тоолууржаагүйтэй холбоотой байх магадлалтай. Иймээс МУ-ын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн стратегийн үнэлгээнд дурдсан усны үр ашигтай хэрэглээ, дахин ашиглах технологийг дэмжиж, санхүүгийн урамшуулал нэвтрүүлэх, бүх уурхайн худаг тус бүрийг усны тоолууржуулах, усны хяналт шинжилгээнд иргэдийг оролцуулах зэрэг арга хэмжээ авах замаар дахин ашиглах усны хэмжээг нэмэгдүүлэх боломжтой гэж үзэж байна. .

Уул уурхайн салбарт технологийн хэрэглээний усыг дахин ашиглах асуудал хэдийгээр хангалтгүй, тодорхойгүй байгаа ч эрчим хүчний байгууллагуудаас харьцангуй дээр байна гэж үнэлж болох юм. Эрчим хүчний салбар нь нийт усны хэрэглээний хамгийн өндөр хувийг буюу 25%-ийг дангаараа хэрэглэж, гүний усыг станцуудын цамхаг хөргөх, үнс зайлуулах, угаалга хийхийн ашигладаг буюу хамгийн өндөр усны хэрэглээтэй салбар юм.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Байгаль орчны мэдээллийн төвөөс хөтөлдөг Мэдээллийн санд байршуулсан тооллогын мэдээллээс харахад УБ хотын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 4 ДЦС-д нийт 35 гүний худгийн сайн чанарын буюу унд, ахуйн хэрэглээнд хэрэглэж болох усыг нийслэл хотын ДЦС-ын дотоод хэрэгцээнд турбин цехийн техникийн усан хангамж, техникийн усаар хангах зорилгоор ашигладаг бол орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ДЦС-уудын мэдээлэл байхгүй байна. Эрчим хүчний салбарт хэрэгжиж буй үйл ажиллагааны талаарх нарийн мэдээ, мэдээлэл олон нийтэд ил тод бус, олон нийтийн зүгээс мэдээлэл авах боломжтой эх сурвалжуудад цахилгааны үнэ тариф, тус салбарт оруулах хөрөнгө оруулалт зэрэг хэдэн ерөнхий сэдвээр мэдээлэл түгээгддэг бол ус ашиглалтын талаар албан ёсны мэдээлэл байршуулдаггүй нийтлэг дутагдал байна.

ХСУХАТАтХ-ийн 17.13-д заасан хэрэглээний усаа эргүүлэн ашиглахтай холбоотой харилцаа, хэмжээ, хязгаарыг нарийвчлан зохицуулсан дүрэм, журам боловсруулагдаагүй, хуулийн хэрэгжилтийг хариуцах байгууллага, нэгж тодорхойгүй, хуулийн хэрэгжилтийн талаар тайлан мэдээ авдаггүй байдал нь мөн адил эрчим хүчний байгууллагуудын дахин ашигласан усны талаар нэгдсэн тоо, статистикгүй, энэ чиглэлээр ямар ахиц гарсныг тодорхойлох боломжгүй байдалд хүргэсэн байна.

Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт үйлчилгээн зохицуулах зөвлөлийн тухайд

ХСУХАТАтХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.11 дэх хэсэгт заасан Зохицуулах зөвлөл нь санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж, нийтэд мэдээлэх үйл ажиллагааг практикт хэрэгжихгүй байна. ХСУХАТАҮЗЗ нь байгуулагдсанаас хойших 6 жилийн хугацаанд 1 удаа буюу 2015 онд санхүүгийн тайлангаа аудитаар баталгаажуулан цахим хуудсаараа дамжуулан нийтэд мэдээлсэн бол энэ үүргээ сүүлийн 2 жил хэрэгжүүлээгүй байна. Харин ТЗЭ-чдээс авч буй зохицуулалт үйлчилгээний хөлс болон бусад санхүүгийн тайланг шилэн дансанд байршуулдаг байна.

ХСУХАТАтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.7 дахь хэсэгт заасан тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчээс холбогдох мэдээллийг гаргуулах үйл ажиллагааг тодорхой хэмжээнд хэрэгжүүлж байна.

УХАТ-ын ашиглалт, засвар, үйлчилгээ эрхлэгч ТЗЭ-дийн Мэдээллийн сангийн программ хангамжийг хүлээн авч, салбарын хүний нөөц, техник технологи, санхүү, эдийн засгийн үзүүлэлтийн нэгдсэн мэдээллийн санг байгуулснаар усны үйлчилгээний мэдээллийн урсгалыг оновчтой зохион байгуулах, салбарыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын бодлогыг дэмжих, улмаар түүний өгөөжийг зөв тооцох, удирдлагын менежментийн бүх төвшний ухаалаг бодлого явуулж ажиллах суурь нөхцөл тавигдсан байна. Тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, хүний нөөц, техник технологи, эдийн засгийн үзүүлэлтийн талаар мэдээллийн нэгдсэн сан бий болгосноор ТЗЭ-дийн боловсон хүчний давхардал, эдийн засгийн чадавх зэргийн мэдээллийг нэг дороос харах боломж бий болсон байна.

Гэхдээ энэхүү санг хариуцан ажиллах мэргэжлийн боловсон хүчний дутагдал зэрэг хүчин зүйлсээс шалтгаалан уг мэдээллийн санг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгааг анхаарах шаардлагатай. Тус мэдээллийн санг ашиглах боломж, нэвтрэх эрхийг НАА салбарын бодлого хариуцсан БХБЯ-ны холбогдох газарт олгох нь төрийн захиргааны төв байгууллагаас хэрэгжүүлэх хяналт-шинжилгээ, хяналт шалгалт, үнэлгээг гүйцэтгэх, нэгдсэн тоо мэдээлэл үнэн бодитоор гарахад чухал нөлөөтэй болохыг анхаарах шаардлагатай байна.

ХСУХАТАтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах болон түүний ашиглалт, засвар, үйлчилгээг Зохицуулах зөвлөлөөс олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэдэг. ХСУХАТАтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан 14 төрлийн тусгай зөвшөөрлийг багцаар нь авахад ч, 1 төрлийн тусгай зөвшөөрөл авахад ч ялгаагүй ижил үнийн дүн бүхий тэмдэгтийн хураамж төлж буй нь учир дутагдалтай

байна. Түүнчлэн бүртгэл мэдээлэл нь тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрийн дагуу явуулж буй үйл ажиллагааны тайлан мэдээлэл гаргуулах, мөн тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрийн дагуу хяналт шинжилгээ, үнэлгээ хийх боломж хязгаарлагдах эрсдэлийг үүсгэж байна.

Хэрэглэгчийн эрх, үүрэгтэй холбогдох зохицуулалт, түүний хэрэгжилт

ХСУХАТАТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь хэсэгт заасан цэвэр усаар хангах, бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх хэрэглэгчийн үүрэг хүлээлгэсэн зохицуулалт практикт хэрэгжихгүй байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 16 дугаар зүйлд зааснаар хангагч нь ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжид эрчим хүчний гэнэтийн тасалдал гарсан, гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэний улмаас усны хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай болсон, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжид ноцтой гэмтэл гарсан тохиолдолд цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох эрх зүйн үндэслэл байна. Тухайлбал, ХСУХАТАТХ-ийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасны дагуу хангагч нь хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд аюултай нөхцөл байдал үүссэн, ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээнд төлөвлөгөөт урсгал болон их засвар хийх болсон,... цэвэр усны алдагдал, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн гэмтлийг тогтоосон хугацаанд засварлаагүй, ус хангамжийн байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд хангагчийн зөвшөөрөлгүйгээр холбосон, усны тоолуурын битүүмжлэл, байрлал, холболтыг дураараа өөрчилсөн, энэ хуулийн 18.1-д заасны дагуу тогтоосон бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг хангаагүй бохир ус нийлүүлсэн нөхцөлд хэрэглэгчид урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагааг хязгаарлах буюу зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй байна. Эдгээрээс бусад нөхцөлд хэрэглэгчийн цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагааг хязгаарлах буюу зогсоох боломжгүй юм. Гэсэн хэдий ч хангагч байгууллагаас авсан үйлчилгээний төлбөрөө төлөөгүй хэрэглэгчийг хангагч байгууллагаас хязгаарлах явдал практикт цөөнгүй тохиолддог бөгөөд энэ үйлдлийнхээ төлөө хангагч байгууллага Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээдэг. Гэтэл Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэгт Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль зөрчих буюу хангагч, эсхүл хэрэглэгч ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаарх хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэх зохицуулалттай. Үүнийг ХСУХАТАТХ-ийн 15 дугаар зүйлд заасан хэрэглэгчийн эрх, үүрэгт усны хэрэглээний төлбөрөө тоолуурын заалтын дагуу төлөх үүрэг буюу хэрэглэгч гэрээнд заасны дагуу үйлчилгээний төлбөрөө төлөх үүрэгт мөн хамаатуулж болох юм. Харин нь тоолуургүй хэрэглэгчдийн хувьд ямар эрх зүйн зохицуулалт үйлчлэх нь тодорхойгүй болж хуулийн хийдэл үүсгэжээ.

Судалгаанд хамрагдсан ТЗЭ байгууллагуудын зүгээс хэрэглэгчтэй холбоотойгоор дундын эзэмшлийн шугам хоолой цоорсон, гэмтсэн тохиолдолд засвар үйлчилгээ хийх ажил удаашралтай, гэмтэл гарсан үед СӨХ засвар хийхэд шаардлагатай материалыг авч өгч чаддаггүйгээс хэрэглэгч хохирох асуудал гардаг, зарим хэрэглэгчид тоолуурын заалт өгдөггүй, тоолуураа албаар гацаах, хэрэглэсэн усаа нууж ухраах гэх мэт асуудал үүсгэдэг, тоолуургүй хэрэглэгчдийн хувьд хаяг дээрээ 1-2 хүнээр тооцож усны төлбөр хийдэг боловч үнэндээ олон хүнд түрээслэх, нийтийн орон сууц хэлбэрээр ашиглах асуудал их гардаг, төлбөрөө төлөөгүй хэрэглэгчид ямар ч арга хэмжээ авч чаддаггүй зэрэг асуудал гардаг бөгөөд түүнчлэн дундын өмчлөлийн шугам сүлжээг мэргэжлийн байгууллагад, ОСК-т хариуцуулах хууль эрх зүйн орчин бий болгох, дундын өмчлөлийн шугам сүлжээний засвар үйлчилгээний зардлыг ТЗ эзэмшигч байгууллагууд, тухайлбал ОСК, УСУГ засвар үйлчилгээ хийсэн хувь хэмжээгээрээ зардлыг хуваадаг байх шаардлагатай байгаа тухай санал, гомдол гаргадаг байна.

Түүнчлэн УХАТ-ийн ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй ТЗ бүхий аж ахуйн нэгжүүд нь ус хангамжийн үйлчилгээг дамжуулах үйлчилгээ үзүүлж байгаа нь тэднийг нэг талаас хангагч, нөгөө талаас хэрэглэгчийн статустай байгаа нь хүндрэл үүсгэж байна.

Цэвэрлэх байгууламж, түүний үйл ажиллагааны тухайд

УХАТ салбар нь өөрөө ус түгээгчээс гадна ус бохирдуулагч субъект болохын хувьд УХАТ-ын үйлчилгээ нь ус олборлолтоос, цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал ус, лагийн ашиглалт хүртэлх бүхий л шатанд хамаарах цогц үйл ажиллагаа юм.

Хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, ЦБ-аас гарсан усыг стандартын шаардлагын төвшинд хүргэн цэвэршүүлэх, түүнийг байгальд эргүүлэн нийлүүлэх зэрэг асуудлаар мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачдын зүгээс тодорхой санал, зөвлөмжүүдийг гаргадаг боловч ашгийн бус энэ салбарын хөрөнгө оруулалт, санхүүжилтийн асуудлаас шалтгаалан хэрэгждэггүй.

ХСУХАТАТХ-ийн 18 дугаар зүйлд цэвэрлэх байгууламжийн байршил тогтоох, цэвэрлэх байгууламж саарал усыг эргүүлэн ашиглах, цэвэрлэх байгууламжийн бохир усны найрлага, технологийн горимд хяналт тавих, үйлдвэрлэлийн усыг урьдчилсан цэвэрлэх байгууламжаар дамжуулах зэрэг харилцааг зохицуулахаар тусгасан нь хүн амын хэрэглээнээс гарсан бохир усыг стандартын шаардлагад нийцтэл цэвэрлэн байгальд нийлүүлэх замаар иргэдийн орчны бохирдлоос хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад зорилготой гэж үзсэн.

Өнөөдрийн байдлаар үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарч буй бохир ус анхан шатны цэвэрлэгээгүйгээр их хэмжээгээр ариутгах татуургын системд шууд нийлүүлэгдэж байгаа, мөн гэр хорооллын нүхэн жорлон, авто угаалга, мал нядалгааны газраас соруулсан бохирыг ариутгах татуургын шугам, сүлжээнд шууд нийлүүлж байгаа зэргээс шалтгаалан ЦБ-ийн бохир ус цэвэршүүлэх төвшин буурч, эдийн засгийн өндөр алдагдалд хүргэж, байгаль орчныг бохирдуулах томоохон хүчин зүйлийн нэг болж байна. Түүнчлэн уул уурхайн компаниуд ЦБ-гүй тул технологийн хэрэглээний усаа байгальд шууд нийлүүлж, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах эрхийг зөрчих, байгаль экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах,

үндэсний болон хүнсний аюулгүй байдалд нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулж байгаа байдал өөрчлөгдөхгүй байна.

Улсын хэмжээнд 130 гаруй бохир ус цэвэрлэх байгууламж байгаагаас хэвийн ажиллагаатай 51, хагас ажиллагаатай 27, огт ажиллагаагүй 47 байгаа ба ЦБ-ийн талаас илүү хувь нь үйл ажиллагааны доголдол, эвдрэлтэй байгаагаас үүдэн жилд 120 сая гаруй м3 бохир ус байгальд шууд хаягдаж байгаль орчныг бохирдуулдаг. Энэ нь хуулийн 18.3-т заасан цэвэрлэх байгууламж нь саарал усыг цэвэршүүлэн эргүүлэн ашиглах технологи бүхий тоног төхөөрөмжтэй байх шаардлагыг хангахгүй байгааг илтгэж байна.

ЦБ-ийн талаарх судалгаа, тоо баримтууд зөрүүтэй, ЦБ-ийн асуудал бодлогын төвшинд хаана харьяалагдаж буй нь тодорхойгүй, түүний бүртгэл, мэдээллийг шинэчлэх ажил удаашралтай байна.

Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттай ЦБ-ийн хувьд ХСУХАТАТХ-ийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох, өргөтгөх боломжийг харгалзах, саарал усыг эргүүлэн ашиглах технологи бүхий тоног төхөөрөмжид тавигдах шаардлага хангах, хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах зэрэг асуудал хэрэгжихгүй байна. Үүний шалтгааныг хувийн компаниудын хувьд өөрийн өмчлөл, эзэмшлийн газарт ЦБ барих шаардлагатай тулгардаг, энэ нь хот төлөвлөлт гэхээсээ илүү үйлдвэрийн байршил, газрын хэмжээнээс илүү хамаардагтай холбоотой.

Улсын хэмжээнд ЦБ, ариун цэврийн байгууламжид хамаарах маш олон эрх зүйн акт хүчин төгөлдөр мөрдөгддөг боловч түүнийг мэддэг хүн, ААН цөөн байгаа нь хуулийн хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан болж байна. Түүнчлэн урьдчилсан ЦБ-аар зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл цэвэрлэсний дараа татан зайлуулах шугам сүлжээнд нийлүүлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд үйл ажиллагааг нь зогсоох хүртэл арга хэмжээ авч байгаа боловч энэ нь үр дүн муутай байдаг.

Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, БОАЖЯ-наас Ахуйн хэрэгцээнээс гарч байгаа хаягдал уснаас төлбөр авах журам зэрэг холбогдох дүрэм журмыг боловсруулаагүй, усны бохирдлын хэмжээг ямар байгууллага хэрхэн тогтоох нь тодорхойгүй зэрэг шалтгаан нь ус бохирдуулсны төлбөрийг бодитойгоор тооцох, төлбөр тооцоо хийх зэрэг асуудлыг хүндрүүлдэг, түүнчлэн хот төлөвлөлт, зам, талбай, барилга байгууламжийн усны хаялгын асуудлыг шийддэггүй, түүнд тавих хяналт, хүлээлгэх хариуцлага сул байгаа нь хөрсний ус татан зайлуулах шугам сүлжээгүй барилга, байгууламжийн тоо ихсэх, замын хажуугийн хаялга, ус зайлуулах суваг, шуудууг хийхгүй орхиход нөлөөлж үүний улмаас ТЦБ-ийн ачаалал хэт ихсэж цэвэрлэсэн ус стандартын шаардлага хангахгүй байх, бохир усны төлбөр тооцоо хариуцах эзэнгүй үлдэх, улмаар алдагдалтай ажиллах гол шалтгаан болж байна.

Хуулийн энэ заалтын хүрээнд ЦБ-аас гарч буй 2 төрлийн бүтээгдэхүүний 1 болох бохир усыг цэвэршүүлэхтэй холбоотой эрх зүйн зохицуулалт хангалттай байгаа бол 2 дахь бүтээгдэхүүн болох лагийн ашиглалт, халдваргүйжүүлэлт, хоргүйжүүлэлтийн тухайд эрх зүйн зохицуулалтгүй байна.

Ариутгах татуургын төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй, холбох ажиллагаа ихээхэн төсөв хөрөнгө шаардагдах тохиолдолд аймаг, орон нутагт болон хотын алслагдсан хэсгүүд, гэр хороололд бага оврын цэвэрлэх байгууламж барьж, ашиглах боломжийг дэмжих замаар ус хангамжийн болон хөрсний бохирдлоос хамгаалах арга хэмжээ дутмаг байгаа нь хуулийн заалт практикт хэрэгжихгүй байна гэж үнэлэх үндэслэл болжээ.

ЦБ-ийн үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, норм, дүрэм, журамд хуулийн нэр томьёо ихээхэн зөрүүтэй хэрэглэгдэж байгаа нь хуулийн нэр томьёоны нэгдмэл байдлыг алдагдуулахаас гадна хууль хэрэглэгчдийн төөрөгдүүлэх эрсдэл үүсгэжээ. Тухайлбал, хаягдал ус, бохир ус, саарал ус, хэрэглээнээс гарсан, ЦБ-ийн цэвэрлэсэн ус гэх зэрэг олон байдлаар тусгасан, түүнийг тайлбарласан, ялгаа заагийн тогтоосон зүйл байхгүй байгааг анхаарах шаардлагатай байна гэж үзлээ.

Эцэст нь нэгтгэн дүгнэвэл ХСУХАТАтХ-ийн зорилт болох “хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэх зохицуулалт дээрх үндэслэл, шалтгаанаас үүдэн хэрэгжихгүй, зорилгодоо хүрэхгүй гэж үнэлэгдсэн нь уг хуулийг шинэчлэн найруулах, сайжруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж өгсөн гэж үзэж болох юм.

Хуулийн зүйл, заалтын хэрэгжилт тус бүрт хийсэн үнэлгээ, зөвлөмжийг холбогдох хэсгээс дэлгэрүүлэн үзэж боломжтойг энд дурдъя.

ДӨРӨВ. ЗӨВЛӨМЖ

УИХ-аас 2011 онд баталсан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний үр дүнд суурилан дараахь асуудлуудыг шийдвэрлэхийг зөвлөмжилж байна.

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг хуулийн хүрээнд зохицуулж буй нь иргэдийн амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдлоос хамгаалуулах зэрэг Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан суурь эрхийг хангахад чиглэгдсэн билээ. Мөн хүн бүрийн амин чухал суурь хэрэглээний нэг болох унд, ахуйн усаар хангагдах эрхийг хүн бүхэн тэгш, хүртээмжтэй эдлэх ёстой гэдгийг анхаарах шаардлагатай юм.

Бодлогын төвшинд анхаарах асуудал

4. Өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар стандартын шаардлага хангасан баталгаат унд, ахуйн усаар хангах үйлчилгээг “хот, суурины инженерийн барилга байгууламжид холбогдсон иргэд”-ээр хязгаарлах нь тэгш эрхийн зарчмыг зөрчсөн төдийгүй нийгмийн суурь үйлчилгээг хөдөөгийн иргэд, суурин газар амьдарч байгаа боловч орон сууц худалдан авах чадваргүй, орлого багатай, ядуу иргэдийг ялгаварлан гадуурхсан байдлаар хуульчилсан нь Үндсэн хууль болон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчиж байх тул хүн бүрийг стандартын шаардлага хангасан баталгаат унд, ахуйн усаар хангах нөхцөлийг бүрдүүлсэн эрх зүйн орчныг бий болгох, Тухайлбал ХСУХАТАТХ-ийн 1.1-д энэ хуулийн зорилт нь хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж заасан боловч 12.2.12-т хот, суурины ус түгээх байрны ашиглалт, засвар, үйлчилгээ, 12.2.13-т зөөврийн ус хангамжийн үйлчилгээ, 12.2.14-т бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ эрхлэхэд тусгай зөвшөөрөл олгохоор тусгасан нь энэ хууль зөвхөн инженерийн барилга байгууламжаар хязгаарлагдах боломжгүйг харуулж байна.
5. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын тухай хуулийн нэр хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуультай зөрчилдсөн, түүнчлэн суурин газарт тооцогдохгүй хэдий ч УХАТ-ын барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ бүхий газрын болон бүртгэлтэй иргэдийн тоогоор суурин газарт тооцогдохгүй боловч түр оршин суугч, дамжин өнгөрөх хүний тоо тогтмол 500-аас дээш байх газруудын асуудал хуулиас гадуур орхигдсон зэргээс шалтгаалан хуулийн нэрийг өөрчлөх, тухайлбал Усны нийтийн үйлчилгээний тухай гэж,
6. УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ нь ус олборлолтоос эхлээд цэвэрлэх байгууламжаас гарсан бүтээгдэхүүн болох хаягдал ус, лагийг байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр ашиглах, устгах, хадгалах, зайлуулах хүртэлх бүхий л шатанд хамаарах цогц үйл ажиллагаа болохын хувьд ЦБ-аас гарч, байгальд эргэн нийлүүлэгдэж буй бохир ус, лагийн асуудлыг хуульчлах замаар УХАТ-ын ашиглалт үйлчилгээний эргэх холбоог бэхжүүлэх, УХАТ өөрөө бохирдуулагч субъект болохоос зайлсхийх, лагийг дахин ашиглах эрх зүйн орчныг бий болгох,
7. Хүн амыг стандартын шаардлага хангасан унд, ахуйн хэрэглээний усаар хангах, орчны бохирдлоос хамгаалах төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангах, хууль

- тогтоомжийн хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зэрэг асуудлыг хариуцан ажиллах төрийн захиргааны байгууллагыг байгуулах замаар УХАТ-ын салбарыг нэгдсэн удирдлагатай, хариуцах эзэнтэй болгох
8. Үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгаа болсон усны асуудал /хангамжийн эх үүсвэр, ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний ашиглалт, үйлчилгээ, технологийн хэрэглээний усыг эргүүлэн ашиглах зэрэг/ нь олон яам, агентлагийн эрхлэх асуудалд хамаарч байгаагаас үүдэн салбар дундын бодлого, хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авах,
 9. Төрийн захиргааны төв байгууллага болон түүний харьяа байгууллагад нийт 4 мэргэжилтэн ажиллаж төрийн бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлж байна. Иймд хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний орон тоог нэмэгдүүлэх, улмаар БХБЯ ХСУХАТАтХ-иар хүлээсэн эрх, үүргээ улсын хэмжээнд тэгш, хүртээмжтэй, үр дүнтэй, чанартай хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх,
 10. ХСУХАТАтХ-иар байгуулагдсан Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл нь уг хуулийн хүрээнд хариуцсан “тухайн нутаг дэвсгэрт усны үйлчилгээний төлбөр, ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээний тарифыг тогтоох, хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах” чиг үүргээ хангалттай хэрэгжүүлж байгаа боловч уг байгууллагын эрх зүйн байдал, статус тодорхойгүй байгаа тул салбарын хэмжээнд үл ойлголцлыг бий болгож байна. Иймд Зөвлөлийн статус, эрх зүйн байдлыг тодорхой болгох шаардлагатай байна. Түүнчлэн нийтийн аж ахуй, түүн дотроо нийгмийн чухал асуудлын нэг болох ус хангамж, ариутгах татуургын тухай салбарын хуулиар байгуулагдсан зөвлөл уг хуулийн зөвхөн 3 асуудлыг хариуцаж байгаа нь хангалтгүй байх тул цаашид хэрхэн ажиллах, ямар асуудлыг харьяалуулах тухайд шийдвэрлэх,
 11. Хүн амыг стандартын шаардлагад нийцсэн унд, ахуйн хэрэглээний усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах замаар иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах, амьдралын наад захын хэрэгцээг хангах зорилго бүхий хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээтэй холбогдох төрийн бодлого төлөвлөлт тогтвортой, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээ тасралтгүй, үр дүнтэй байхад уг асуудлыг хариуцсан чиглэлийн яам, түүний харьяа байгууллагуудын тогтвортой байдал нэн чухал байгааг анхаарах. Тухайлбал, БХБЯ нь Хот, суурины УХАТ-ын барилга, байгууламж, инженерийн шугам, сүлжээний өмчлөл, ашиглалт, үйлчилгээтэй холбогдох асуудлыг Нийтийн аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт 2 хуваах шаардлага бий эсэхийг судлах,
 12. Үндэсний аюулгүй байдал, иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан эрхийн хүрээнд хөндөгдөх ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээг төрийн болон орон нутгийн өмчид байлгах, харин төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бүтээн байгуулагдсан ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээг хувийн хэвшлийн өмчид гэрээний хугацаанд байлгах асуудлыг судлах,

1. Ус хангамжийн эх үүсвэр, усны барилга байгууламж, шугам сүлжээний хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг Газрын тухай хуулийн зам, шугам сүлжээний газарт хамааруулах, газрын төлбөрөөс чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгох замаар ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд хууль бусаар газар олгох, суурьших, үйл ажиллагаа явуулах үйлдлийг таслан зогсоох,
2. Хуулийн нэр томъёоны нэгдмэл байх шаардлагыг хангах үүднээс, тухайлбал, үйлдвэрийн газрын технологийн хэрэглээний ус, бохир ус, үйлдвэрлэлийн хэрэглээний ус, саарал ус, хаягдал ус, мөн усан хангамж, ус хангамж, ундны усны эх үүсвэр, ус хангамжийн эх үүсвэр зэргээр ялгаатай байдлаар тусгасан байгааг цэгцлэх.
3. Газрын тухай, МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн дагуу гэр бүлийн хэрэгцээнд зориулан өмчлүүлж буй газрын хэмжээ, Газрын тухай, Усны тухай хуулиар олгогдсон худаг гаргаж ашиглах эрх, Усны тухай хууль, ХСУХАТАтХ, Бүсийн дэглэмд заасан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоосон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохицуулалтууд нь харилцан шүтэлцээгүй байгаа нь өөрийн эзэмшлийн худаг бүхий иргэд байнга хууль зөрчигч болох, зөрчлийн арга хэмжээ авахуулах нөхцөлийг бий болгосон байх тул бодит нөхцөл байдалд илүү тохирсон, хэрэгжих боломжтой эрх зүйн зохицуулалт бий болгох,
4. Энэ хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д заасан “ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламж, цэвэр ус дамжуулах, түгээх, бохир ус цуглуулах, татан зайлуулах шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж нь төрийн болон орон нутгийн өмчид байна” гэх зохицуулалт нь зөвхөн магистрал шугам, сүлжээ болон ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжаар хязгаарлагдахгүй салбар шугам сүлжээнд мөн адил хамааралтай байгааг анхаарах,
5. НАА, УХАТ-ын салбарын бодлого, алсын хараа, стратегийг хэрэгжүүлэх асуудал БХБЯ-нд, салбарын хуулийн хэрэгжилт, норм, дүрэм, стандартыг мөрдүүлэх ажил төрийн захиргааны байгууллагад, УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг хариуцах байгууллагууд нь орон нутгийн өмчит болон хувийн хэвшлийн тусгай зөвшөөрлийн болзол хангасан ААН байхаар зохицуулах боломжийг судлах
6. УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ хариуцдаг ОСК-ууд УХАТ-ын барилга байгууламж, шугам, сүлжээний гамшиг, ослын улмаас үүсч болзошгүй засвар, үйлчилгээ, их засвар, ашиглалтын хугацаа дуусах тохиолдолд шугам, сүлжээг шинээр солих зэрэгт зориулсан хуримтлал үүсгэхийн тулд даатгалд хамруулах, эсхүл элэгдэл хорогдлын тусгай сантай болгох зэрэг асуудлыг судалж үзэх,
7. ХСУХАТАтХ-ийн 17.13-ын “Уул уурхай, эрчим хүчний үйлдвэр нь технологийн хэрэглээний усаа эргүүлэн ашиглана” гэх заалт энэ хуулийн зорилт болох “хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг өмчлөх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах” харилцаанд хамаарахгүй байгаа тул хуулийн дээрх заалтыг хасах,
8. ТХХТ болон концессын гэрээгээр баригдсанаас бусад шинээр баригдаж буй орон сууцны хороолол, хотхонуудын хэрэгцээнд зориулан барьж суурилуулсан УХАТ-ын барилга байгууламж, шугам, сүлжээний өртөг ихэнх тохиолдолд тухайн орон сууцыг борлуулах үнэд шингэсэн байдагтай холбогдуулан тухайн УХАТ-ын барилга

- байгууламж, шугам, сүлжээг төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэх асуудлыг орон сууц өмчлөгчдийн саналд үндэслэдэг байх нөхцөлийг бүрдүүлэх,
9. ХСУХАТАтХ-ийг хэрэгжүүлэгч байгууллагууд Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах,
 10. Хот, суурины ус хангамж ариутгах татуургын барилга, байгууламжийн ашиглалт, өмчлөл, үйлчилгээнд төрийн байгууллагаас гадна хувийн хэвшлийн оролцоо нэмэгдэж байгаатай холбогдуулан УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн удирдах болон гүйцэтгэх ажилтнуудын албан үүргээ гүйцэтгэх явцад хүлээх хариуцлагын асуудлыг тодорхой болгох,
 11. ХСУХАТАтХ-ийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, хариуцлага хүлээлгэх асуудлыг хангагч, хэрэглэгч тус бүрээр тодорхойлох замаар хуулийн хэрэгжилтийг сайжруулах, мөн хууль тогтоомж зөрчсөний улмаас үүссэн хохирлын үнэлгээг байгаль орчны экологийн бодит үнэлгээнд нийцүүлэхэд анхаарах,
 12. ХСУХАТАтХ-д заасан 1/аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын хэрэглээний халуун, хүйтэн ус, ариутгах татуургын норм, дүрэм, журмыг, 2/гамшиг болон аюул үүссэн тохиолдолд ус хангамжийн талаар мөрдөх журмыг, 3/үйлдвэрийн газрын технологийн хэрэглээний усыг дахин ашиглахтай холбогдсон норм, дүрэм, журмыг тус тус баталж мөрдүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулах,
 13. УХАТ-ын барилга байгууламж, шугам сүлжээний өмчлөл, ашиглалттай холбоотой мэдээллийн нэгдсэн санд нэвтрэх эрхийг тодорхой хязгаарлалттайгаар ХСУХАТАҮЗЗ, БХТ УСУГ зэрэг шугам сүлжээний техникийн нөхцөл олгох, хяналт шинжилгээ, ашиглалт, засвар үйлчилгээ хийх чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад олгох замаар энэ салбарын ажлын уялдааг холбоог сайжруулах,
 14. УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй ААН, байгууллагууд урт /15 жил/, дунд /10 жил/, богино /5 жил/ хугацааны үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, батлуулдаг байх. /Үүнд өмчилж, ашиглаж, үйлчилгээ үзүүлж буй УХАТ-ын барилга байгууламж, шугам сүлжээний элэгдэл хорогдол, засвар үйлчилгээний зардал, хугацаа, байгууллагын орло бизнес төлөвлөгөө, албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаа зэрэг асуудлыг тусгах/
 15. УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг практикт олгож буй төрлөөр багцлах, хураамжийн төлбөрийг тусгай зөвшөөрөл авч буй төрөл, түүний тоотой уялдуулан тогтоох,
 16. Үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, батлуулсан УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ эрхлэх ТЗЭ-ийн ТЗ-ийн хугацааг 5 жилээр сунгах боломж олгох,
 17. Хэрэглэгчдийн тоолууржилтыг жил бүр тодорхой хувиар өсөн нэмэгдүүлэх замаар ОБУ-ны хувийг бууруулах, үүний тоолуургүй хэрэглэгчдийг төрөөс эргэн төлөх нөхцөлтэйгөөр, хөнгөлөлттэй үнээр тоолууржуулах арга хэмжээ зохион байгуулах,
 18. Усны алдагдлыг бууруулах, усны төлбөр төлөхөөс зайлсхийгчдийн зүй бус үйлдлийг таслан зогсоох үүднээс төлбөрөө гэрээнд заасан хугацаанд төлөөгүй төлбөрийн чадваргүй нь тогтоогдсоноос бусад хэрэглэгчийн, мөн хаягийн бүртгэлээр нотолсон албан ёсоор оршин суух иргэдийн тооноос илүү хүн амьдарч буй тоолуургүй орон сууцны цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээг хязгаарлах эрх зүйн орчныг бүрдүүлэх,

19. УХАТ-ын хангагч байгууллага, түгээгч байгууллага, эцсийн хэрэглэгчдийн ялгааг тодорхой болгох замаар эцсийн хэрэглэгчийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх
20. УХАТ-ын үйл ажиллагаа, ашиглалт, үйлчилгээтэй холбоотой судалгаа, тоо баримтуудыг улсын хэмжээнд нэгдсэн байдлаар гаргаж олон нийтэд танилцуулдаг байх, үр дүнд суурилсан үнэлгээ хийж, түүнд суурилсан урамшуулал, дэмжлэгийг төр, хувийн хэвшлийн гэж ялгалгүйгээр үзүүлдэг байх,
21. Төвлөрсөн шугам, сүлжээнд холбогдоогүй хот, хөдөөгийн гэр хорооллын өрх, ААН-ийн ЦБ-ийн ашиглалт, үйлчилгээнд хамаарах, эрх зүйн зохицуулалтыг бий болгох, мөн төвлөрсөн шугам, сүлжээнд холбогдоогүй өрх, ААН-ээс гарч буй бохирдол өндөртэй хаягдал усыг урьдчилан цэвэрлэх байгууламжаар дамжуулах хуулийн шаардлага, эрх зүйн орчныг бий болгох, бага оврын ЦБ-ийн ашиглалтыг бодлогоор дэмжих замаар хуулийн 18.5 дахь заалтын хэрэгжилтийг хангуулах,
22. Усны үнийг бодит зардалд нийцүүлэх, олон улсын жишигт дөхүүлэх алхам хийх замаар УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын алдагдлыг бууруулах, тухайлбал 2 шатлалт тарифын тогтолцоог нэвтрүүлэх, шатлалын хэмжээг тогтоохдоо цэвэр усны нөөцөөр хомс байдлаа харгалзан усны хэмжээг тогтоох,
23. Иргэдийн хандлага, хэрэглээнд нөлөөлөхүйц арга хэмжээ, сургалт, сурталчилгааны ажил гүйцэтгэх. Гэхдээ ус хэмнэх асуудлыг бүх сувгаар сурталчилж байгаа боловч тодорхой үр дүнд хүрээгүй тул эдийн засгийн хөшүүрэг хэрэглэх нь илүү үр дүнтэй байх боломжтой, тухайлбал утаагүй зуух гэдэг шиг ус хэмнэдэг төхөөрөмжийг төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон өрхөд, ус дахин ашиглах боломж олгох тоног төхөөрөмжийг төвлөрсөн шугам сүлжээнд холбогдоогүй айл өрхөд хөнгөлөлттэй үнээр худалдаалах, хөнгөлөлттэй зээлд хамруулах гэх зэргээр дэмжих.

Ооо О ооО

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж

1. Агаарын тухай хууль
2. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
4. Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулга
5. Газрын тухай хууль.
6. Жижиг, дунд уйлдвэрийн тухай хууль
7. Засгийн газрын 2013 оны 389 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөө”
8. Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
9. Захиргааны ерөнхий хууль
10. Зөрчлийн тухай хууль
11. Иргэний хууль
12. Концессийн тухай хууль
13. Монгол Улсын Үндсэн хууль
14. МУ иргэнд газар өмчлүүлэх тухай хууль
15. МУ-ын Дээд шүүхийн 2011 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн №1 зөвлөмж
16. МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
17. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
18. Нийслэлийн өмчид үнэ төлбөргүйгээр шилжин ирж буй нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэн авах тухай журам
19. Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль
20. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого. УИХ-ын 2009 оны 64 дүгээр тогтоолын хавсралт
21. Төрийн албаны тухай хууль
22. УИХ-ын 2008 оны 12 тоот тогтоолоор баталсан “Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндэсний хөгжлийн цогц бодлого”
23. УИХ-ын 2010 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Ус” үндэсний хөтөлбөр
24. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”
25. УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлого”
26. УИХ-ын 2016 оны 12 дугаар тогтоол “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”
27. УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
28. Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага” баримт бичиг. УИХ-ын 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 23 дугаар тогтоол.
29. Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүс, тэжээгдлийн мужийн заагийг тогтоох тухай БОАЖСайд, БХБСайдын хамтарсан тушаал
30. Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм
31. Усны тухай хууль
32. Уул уурхайн салбарын усны норм. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаал
33. Харилцаа холбооны тухай хууль
34. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тооцох аргачлал

35. Хаягдал усны эзлэхүүн болон бохирдуулах бодисын агууламжийг үндэслэн хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээг тогтоох журам
36. Хот байгуулалтын тухай хууль
37. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль
38. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль
39. Хот, тосгоны эрх зүйн байдлыг тухай хууль
40. Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
41. Эрүүгийн хууль
42. Эрүүл мэнд, спортын сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 74/37 дугаар “Заавар батлах тухай” тушаал
43. Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай ЗГ-ын 3 дугаар тогтоол болон бусад холбогдох хууль тогтоомж

Стандарт, дүрэм, журам

1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн дүрэм батлах тухай . Засгийн газрын 2012 оны 02 сарын 15-ны өдрийн 46 дугаар тогтоол
2. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн бүтэц, орон тоо батлах тухай. Засгийн газрын 2012 оны 05 сарын 30-ны өдрийн 183 дугаар тогтоол
3. Ус хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжид хамаарах стандартын жагсаалтыг хавсралтаас дэлгэрэнгүй үзнэ үү

Ном, гарын авлага

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал. ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралт
2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гарын авлага 2013 он
3. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн танилцуулга
4. Уул уурхай ба газрын доорх усны менежмент, хяналт шинжилгээ сургалтын гарын авлага
5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар дахь усны хэрэглээний өнөөгийн байдал, хэтийн төлөв, төлөвлөлт илтгэл
6. ШӨХТГ-ын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах газрын дарга Ц.Лхагвасүрэнгийн илтгэлээс.
7. ХСУХАТАҮЗЗ-өөс Зөвлөх үйлчилгээний багт ирүүлсэн мэдээлэл
8. Усны хуулийн эмхэтгэл
9. Ус хангамж, ариун цэврийн байгууламжтай холбоотой эрх зүйн актын эмхэтгэл
10. Чадавхийн үргэвчилсэн үнэлгээний аргачлал. БХБЯ, НҮБХХ, КОЙКА. 2015 он
11. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын хууль, эрх зүйн орчин ба тогтолцоо, өнөөгийн байдал” судалгааны тайлан. БХБЯ, НҮБХХ, КОЙКА. 2015 он
12. Монгол Улсын Мянганы хөгжлийг зорилтуудын хэрэгжилт. ЗГ. 2015 он.
13. Барилгын мэдээлэл” Барилга, НАА-н сар тутмын мэдээллийн эмхэтгэл. 2015N^o4
14. Needs assessment on institutional capacity for water governance in Mongolia. Governrnt of Mongolia, UNDP Mongolia.
15. Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээний салбарын санхүүжилтэд тэгш байдлыг хангах нь. НҮБ-ын Хүүхдийн сан. 2015 он
16. Water supply, sunitation and hygiene in Mongolia. ACF International. 2014.

Нийтлэл

1. А.Сүхбат: Туул голыг гольдролоор нь улсын тусгай хамгаалалтад авах шаардлагатай.

2. Аж ахуйн нэгж байгууллагуудтай “Экологийн хариуцлагын гэрээ” байгуулж эхлэв. 2018.05.03.
3. Зөвшөөрөлгүй худаг гаргавал 12 сая хүртэлх төгрөгөөр торгоно. 2017 он.
4. М.Оюунчимэг: Туул голын асуудал дээр МАН, АН гэж талцах шаардлага байхгүй.
5. МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүх Усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэдээлэл хийлээ. Өдрийн сонин. 2018.05.05.
6. МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн МУ-ын усны нөөц, ус ашиглалтын өнөөгийн байдал, тулгамдаж байгаа асуудал, цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар 2018.05.04-ний өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанд хийсэн мэдээлэл.
7. Онцгой хамгаалалтын бүсийг 35 метр давжээ. 2014 он.
8. С.Батболд: Туул гол дагуу олгогдсон газруудын зөвшөөрлийг цуцлах шаардлагатай.
9. Т.Батсүх: “Эрдэнэт” үйлдвэр усыг зохистой ашигладаг.
10. төв цэвэрлэх байгууламж 50 гаруй жилийн дараа шинэчлэгдэж байна
11. Туул гол дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар ашиглах зөвшөөрөл олгосон асуудлаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.
12. Туулыг цэвэрлэхэд 1,7 тэрбумыг зарцуулсан ч бохир хэвээрээ.
13. Улаанбаатар хотын ус хангамжийн асуудлыг таван жилийн хугацаанд иж бүрэн шийднэ
14. Ундны усны аюулгүй байдал алдагдвал хэн хариуцлагыг нь хүлээх вэ.2008 он.
15. Ус стратегийн үнэт баялаг.
16. Хувийн орон сууцанд байгаа дундын өмчлөлийн өмч хөрөнгийг засварлах, ашиглах боломж бололцоо нээгдэнэ 2018.09.07
17. Я.Болдбаатар: Хамгаалалтын бүсэд худаг гаргахыг хориглосон байдаг. 2018.05.28

Судалгааны тайлан, экспертийн ярилцлага

1. 2014-2017 оны ус, рашаан ашигласны төлбөрийн ногдуулалт, төвлөрүүлэлтийн байдал аудитын тайлан
2. 2017 оны Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа.
3. Усны Нөөцийн Нэгдсэн Менежмент – Загвар Бүс Нутаг Монгол –Бодлогын хураангуй. 2018
4. АХБ-ны “ТА9100-МОН: Төвлөрсөн бус ариун цэврийн байгууламжууд болон бохир ус цэвэрлэх байгууламжаас гарах лагийг дахин ашиглах, менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх төслийн багийн гишүүдтэй хийсэн уулзалтаас
1. Ахуйн бохир ус цэвэрлэх бага оврын цэвэрлэх байгууламжийн гарын авлага 2017.
2. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийн 2016 оны үйл ажиллагааны хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгийн тайлан 2017 он
3. Барилга, хот байгуулалтын яамны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн 2016, 2017 оны нэгдсэн тайлангуудаас
4. БХБЯ-ны хэрэглэгчийн үнэлгээний тайлан 2015, 2016, 2017
5. Гадаргын усны нөөц ба уул уурхайн ус ашиглалт
6. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ судалгааны тайлан. 2018.
7. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2013-2014 он
8. Монгол орны байгаль орчны төлөв байдлын тайлан 2015-2016 он
9. Монгол Улсын нийслэлийн нийгэм, эдийн засгийн байдал 2016 он
10. Монгол Улсын усны нөөц ашиглалт. ҮСХ. 2017 он.
11. МУ-ын ЗГХЭГ-ын 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн ХЭГ/1565 тоот “Асуулгын хариу хүргүүлэх тухай” албан бичиг, түүний хавсралт

12. Нийслэлийн гүний худгийн тайлан. 2013 он
13. Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарын хууль, эрх зүйн орчин ба тогтолцоо, өнөөгийн байдал” судалгааны тайлан. 2015 он.
14. Нүхэн жорлонгоос 150-250 метрт гүний худаг гаргах ёстой.2018.05.29.
15. Тогтвортой хөгжил ба баялгийн нөөцийн хариуцлагатай ашиглалт
16. Ус” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан. 2016 он.
17. Усны статистикийн өнөөгийн байдал судалгааны тайлан
18. ХСУХАТАҮЗЗ, Тусгай зөвшөөрлийн албаны мэдээлэл, Орон сууцны айл өрхийн судалгаа, 2018 он
19. ХСУХАТАҮЗЗ, Хүний нөөцийн судалгаа, 2018 он
20. хот суурин газрын агаарын бохирдлын хүн амын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийн судалгаа. 2014 он
21. Эрдэс баялгийн салбарын статистик мэдээ. 2017 он.

Цахим эх сурвалж

1. <http://audit.gov.mn/>
2. <http://erdenestt.mn>
3. <http://esd.mn>
4. <http://medee.mn/>
5. <http://montsame.mn/>
6. <http://nda.gov.mn>
7. <http://news.barilga.mn/>
8. <http://opendata.burtgel.gov.mn/>
9. <http://tavantolgoi.mn/>
10. <http://ub.inspection.gov.mn/>
11. <http://umch.ub.gov.mn/>
12. <http://undesten.mn>
13. <http://vip76.mn/>
14. <http://www.1212.mn/>
15. <http://www.eic.mn/>
16. <http://www.gazar.gov.mn/>
17. <http://www.mmhi.gov.mn/>
18. <http://www.mongolianminingjournal.com/>
19. <http://www.parliament.mn/>
20. <http://www.supremecourt.mn>
21. <http://www.ulaanbaatar.mn/>
22. <http://www.wsrc.mn/>
23. <https://asmhub.mn/>
24. <https://asmhub.mn/>
25. <https://dnn.mn/>
26. <https://enorm.gov.mn>
27. <https://mcud.gov.mn/>
28. <https://www.mrpam.gov.mn/>
29. <https://www.nso.mn/>
30. <https://www.switch-asia.eu/>
31. www.iwrm-momo.de/publications

Мэдээллийн сан

1. Барилгын норматив баримт бичгийн сан <https://enorm.gov.mn/>
2. Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан <http://www.shuukh.mn/>
3. Стандартын нэгдсэн сан <http://www.estandart.gov.mn/>
4. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан <http://www.1212.mn>
5. Улсын усны мэдээллийн нэгдсэн сан <http://water.eic.mn/>
32. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан <http://www.legalinfo.mn/>

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Зөрчлийн тухай хуульд тусгагдсан УХАТ-ын барилга, байгууламж, үйл ажиллагаа, ашиглалт, хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс зэрэг асуудалд холбогдох зөрчлүүд

Зөрчлийн тухай хуульд ХСУХАТAtX-иас гадна УХАТ-ын барилга байгууламж, хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд хамаарах асуудлын хүрээнд дараахь зөрчлүүдэд хуулийн дагуу арга хэмжээ авахаар хуульчилж өгсөн байдаг. Үүнд:

- **дүгээр зүйлд Хог хаягдлын тухай хууль зөрчих:** 3.Хүн амын төвлөрсөн суурьшлын бүс, усны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, эрүүл ахуйн бүс, ашигт малтмалын нөөц тогтоогдсон газарт зөвшөөрөлгүйгээр, эсхүл хуулиар хориглосон бусад газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- **5.16 дугаар зүйл.Энгийн харуул, манааны журам зөрчих:** 1.Энгийн харуул хамгаалалт, манааны талаар төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон журам зөрчсөн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.,
- **5.13 дугаар зүйл.Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих** 3.Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул, гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор байгуулсан барилга байгууламжийг эвдэж гэмтээсэн, эсхүл зориулалтыг дур мэдэн өөрчилсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- **6.17 дугаар зүйл.Эрүүл ахуйн тухай хууль зөрчих:** 1.Хүн амыг хуульд заасан ундны болон ахуйн нөхцөл, шаардлагыг хангасан усаар хангаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2.Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд холбогдох хяналтын байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулаагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- **12.2 дугаар зүйл.Геодези, зураг зүйн тухай хууль зөрчих:** 7.Геодезийн байнгын цэг, тэмдэгт байрлаж байгаа газар, барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нь геодезийн үйл ажиллагааг саадгүй явуулах нөхцөлийг бүрдүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.,
- **12.4 дүгээр зүйл.Орон сууцны тухай хууль зөрчих:** 1.Орон сууцны төлөвлөлт, барилгын үндсэн бүтэц, хийц, инженерийн шугам сүлжээг зөвшөөрөлгүйгээр

анхны зураг төслөөс өөрчилсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Ус алдах, эсхүл цахилгаан таслах зэргээр орон сууц ашиглалтын журам зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Орон сууцны байшингийн инженерийн гадна шугам сүлжээ, дэд өртөө, ус, дулаан дамжуулах төв, бусад үйлчилгээний газарт зарцуулсан хөрөнгийг орон сууцны өртөгт оруулж тооцсон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

➤ **12.5 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хууль зөрчих:** 1. Хот байгуулалтын тухай хуульд заасан: 1.3. барилга байгууламжийн зураг төсөл нь хот, тосгоны батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний шийдлүүд, олгогдсон газрын хэмжээ, зориулалттай уялдсан байх; хуульд заасан журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

➤ **12.6 дугаар зүйл. Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль зөрчих:** 1. Төсөл хэрэгжүүлэх талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэр гарснаас хойш төсөл хэрэгжүүлэхээр сонгосон талбайд, эсхүл хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн бэлтгэл ажил, инженерийн, нийгмийн дэд бүтэц, нийтээр ашиглах барилга байгууламж барихаар төлөвлөсөн газарт: 1.1. шинээр барилга байгууламж барих; 1.2. газар өмчлөх, эзэмших, ашиглах эрх олгосон, эсхүл эрх шилжүүлсэн; 1.3. барилга байгууламжид дураараа өргөтгөл, шинэчлэл хийсэн; 1.4. эрхийг бусдад шилжүүлсэн; 1.5. түрээсэлсэн; 1.6. нүүн ирж суурьшсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Хотыг дахин хөгжүүлэх төсөл хэрэгжүүлэхээр сонгосон талбайд газрыг чөлөөлөөгүй, эсхүл газар чөлөөлөх үйл ажиллагаанд саад учруулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

➤ **12.10 дугаар зүйл. Нийтийн зориулалттай инженерийн байгууламжид хууль бусаар холбогдох хэрэгсэл хэрэглэх журам зөрчих:** 1. Нийтийн зориулалттай инженерийн байгууламжид хууль бусаар холбогдох хэрэгсэл хэрэглэсэн, эсхүл холбогдох дүрэм, журам зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

➤ **7.15 дугаар зүйл. Усны тухай хууль зөрчих:** 1. Хуульд заасны дагуу: 1.1. усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан; 1.2. цооног өрөмдөх зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан; 1.3. ус ашиглахад тавигдах

нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй; 1.4.ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй; 1.5.усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн; 1.6.ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан, эсхүл бусдад шилжүүлсэн, эсхүл усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Хуульд заасан: 5.1.усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүс тогтоох шаардлага биелүүлэх; журам зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл машин техник, бохир зүйл угаасан, эсхүл усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- **7.16 дугаар зүйл.Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих:** 1.Ус бохирдуулагчийн тухай болон хаягдал усны хэмжээ, найрлага, бохирдуулах бодисын тухай мэдээллийг нуун дарагдуулсан, эсхүл худал мэдээлэл өгсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлгүй цэгт хаягдал ус нийлүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Ус бохирдуулсны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- **7.17 дугаар зүйл.Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах:** 1.Тусгай хамгаалалттай газар нутагт: 1.1.хууль, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, дэглэм, горим зөрчсөн; 1.2.менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол,

нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- **8.1 дүгээр зүйл.Газрын тухай хууль зөрчих:** 9.Хуульд заасныг зөрчиж: 9.3.иргэн, хуулийн этгээд нь байгаль орчны тэнцвэрт байдал, хүн амын эрүүл мэнд, мал, амьтан, агаар, ой, ус, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, эсхүл тоног төхөөрөмж байршуулах, эсхүл үйлдвэрийн хаягдал, бохир ус, хортой, бусад бодисыг газрын доор хадгалах, эсхүл булаах ажлыг мэргэжлийн эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр гүйцэтгэсэн;

9.4.газрыг бохирдуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- **8.2 дугаар зүйл.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль зөрчих:** 5.Өмчийнхөө газрыг ашиглах явцад барилгын, экологийн, ариун цэврийн, эрүүл ахуйн, галын аюулгүй байдлын болон бусад холбогдох стандарт, дүрэм, журам, шаардлагыг сахиж мөрдөх, эсхүл өмчийн газрынхаа газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг өөрийн зардлаар 5 жил тутамд эрх бүхий байгууллагаар хийлгүүлж байх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- **14.1 дүгээр зүйл.Харилцаа холбооны тухай хууль зөрчих:** 7.Барилга байгууламж, инженерийн шугам, сүлжээний хайгуул хийх, зураг төсөл зохиох, барилга байгууламж, шугам сүлжээ байгуулахдаа тэдгээрийн талбайд орсон харилцаа холбооны шугам, сүлжээг зохих зөвшөөрөлгүйгээр тасалсан, эсхүл зөөсөн, эсхүл үүний улмаас тухайн шугам сүлжээ /холбооны кабель, агаарын баганат шугам, хэрэглэгчийн кабелийн хайрцаг, шүүгээ, оруулгын утас, трансформатор, сувагчлал, шуудангийн хайрцаг зэрэг/-г гэмтээсэн, эсхүл ашиглалтгүй болгосон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

- **14.5 дугаар зүйл.Авто зам, замын байгууламж, тэмдэг, тэмдэглэлийг гэмтээх, өөрчлөх, бохирдуулах:** 7.Инженерийн шугам сүлжээ хийх, эсхүл өргөтгөх зорилгоор зөвшөөрөлгүй авто зам эвдэж сэтлэх, орц, гарц гаргах, зогсоолын талбай, хурд сааруулагч хийх зэргээр замын хөдөлгөөний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хавсралт 2. Удирдамж

БАТЛАВ:

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН

“ХОТ, СУУРИНЫ УХАТ-ЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ” ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

2018 оны 9 дүгээр сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Нэг. Зорилго.

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр бүлгийн **Зургадугаар зүйлийн** 1-д “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.”, 2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.” гэж, 4-д “Төр ... газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.” гэж, Хоёрдугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 2-т хүн 2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй гэж тус тус заасан байдаг.

Дээрх Үндсэн хуулийн баталгаажсан хүний эрхийг хангах, мөн улс орны үндэсний аюулгүй байдал, хүн амын эрүүл мэндийг хамгаалах, орчны бохирдлоос хамгаалахад чиглэгдсэн суурь зохицуулалтын хүрээнд хэрэгжүүлэх онцгой үйл ажиллагааны нэг бол хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээ юм.

Монгол Улсын Их хурлаас анх 2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуулийг баталснаар хэрэглэгчдийг стандартын шаардлагад нийцсэн усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг ашиглах, хангагч, хэрэглэгч хоорондын харилцааг зохицуулах эрх зүйн үндэс бүрдсэн байна.

Анхдагч хуулийн зохицуулалт бий болсноор хот, суурин газар оршин суугаа иргэдийг цэвэр усаар хангах, хэрэглээний бохир усыг стандартад нийцүүлэн зайлуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн.

Гэвч энэхүү зохицуулалт нь нийгэм, эдийн засгийн хөгжил, хотжилт, үйлдвэржилтийн үйл явцтай хөл нийлүүлж, тэдгээрээс урган гарч буй асуудлыг бүрэн зохицуулах чадваргүй, хариуцлагын тогтолцоо бүрэлдээгүй, инженерийн барилга, байгууламжийн ашиглалт, хэрэглэгч, түгээгчийн хоорондын харилцаа тодорхойгүй, мөн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах байгууллагуудын чиг үүргийн асуудлыг цэгцлэх

шаардлагатай гэж үзэн Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2011 онд баталсан ба өнөөг хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталснаас хойш хуульд нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан ба эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь гол төлөв шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжтой холбоотой байсан бөгөөд үндсэн асуудлыг хөндөөгүй байна.

Хэдийгээр Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь харьцангуй шинэ хууль мэт боловч хуулийн хүрээнд зохицуулах шаардлагатай харилцааг бүрэн шийдвэрлэж чадахгүй байгаа нь энэ хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, улмаар үнэлгээний үр дүнд суурилан зохист нэмэлт, өөрчлөлтийг оруулах хэрэгцээ, шаардлагыг бий болгож байна.

УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.90.-д “Хот, суурин газруудад шинээр баригдах орон сууцны хорооллын инженерийн хангамжийн шугам сүлжээний техникийн шийдлийг хонгилын системээр төлөвлөн, үе шаттай хэрэгжүүлнэ.” гэж 2.94-д “Улаанбаатар хотод шинээр төлөвлөж байгаа орон сууцны хорооллын унд-ахуйн хэрэглээний цэвэр усыг тусад нь төлөвлөх, гарсан бохир усыг саарал усны стандартын шаардлагад нийцүүлэн дахин боловсруулж, ариутгах татуургын системд технологийн зориулалтаар болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зэрэг техникийн шийдлийг зураг төсөлд тусгаж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлнэ.” гэж, 2.96-д “Цэвэрлэх байгууламжаар цэвэрлэсэн ус болон хөрсний усыг үйлдвэрийн технологийн хэрэгцээнд ашиглах боломжийг бүрдүүлнэ.” гэж, 2.98-д “Улаанбаатар хотын цэвэр усны хангамжийг сайжруулах ажлын хүрээнд Туул, Сэлбэ, Дунд голын урсцыг нэмэгдүүлж, эргийн дагуу олон нийтийн соёл, амралтад зориулсан тохилог орчныг бүрдүүлнэ.” гэж, 4.2.3-т Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлэх нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, хаягдал бохир усыг цэвэрлэн дахин ашиглах технологи нэвтрүүлэхийг дэмжинэ.” гэж тус тус заасан, түүнчлэн УИХ-ын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 44-т “Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай тус тус тусгасан нь хуулийн төсөл боловсруулах эрх зүйн үндэслэл болж байна.

Түүнчлэн Хот суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуулийн хүрээнд төрийн захиргааны, төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, Иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг байгууллагуудын чиг үүрэг, бүрэн эрх, хариуцлагын асуудал өнөөг хүртэл тодорхой, үр дүнтэй зохицуулагдаагүй, хууль дахь Зөвлөлийн үйл ажиллагаа болон техникийн нөхцөл, тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой зохицуулалтаас бусад зүйл заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, ундны усны эх үүсвэр, шугам сүлжээний хамгаалалтын бүсэд хууль бусаар барилга байгууламж барих, аж ахуйн үйл ажиллагааг зөвшөөрөлгүй эрхлэх, байгаль орчин, усны эх үүсвэрийг бохирдуулах зэрэг зөрчил газар авч байгаа боловч түүнийг таслан зогсооход чиглэсэн эрх зүйн зохицуулалт хүчгүйдэж байгаа бол шинээр баригдаж байгаа орон сууцны хороолол, барилга байгууламжийн инженерийн шугам, сүлжээний ашиглалт, өмчлөлтэй холбоотой эрх зүйн зохицуулалт энэ төрлийн харилцааг бүрэн зохицуулах чадваргүй байна.

Иймд Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, гаргаж буй шийдвэр, тэдгээрийг хүчгүйдүүлж буй сул орон зай, хариуцлагын тогтолцоо зэрэг хуулийн хэрэгжилтийн явцад гарж буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэх нь цаашид шинэчлэн боловсруулах хуулийн төсөлд нэмж зохицуулах, засаж сайжруулах шаардлагатай асуудлыг тодорхойлоход чухал үр нөлөөтэй гэж үзсэний үндсэн дээр 2011 онд батлагдсан “Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай” хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээ хийх шаардлагатай гэж үзсэн.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээний зорилго нь хуулийг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэх, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөг тогтоох замаар цаашид уг хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ашиглаж болохуйц шийдлийн хувилбаруудыг дэвшүүлэхэд оршино

Хоёр. Зорилт

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны ажлын хүрээнд “Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай” хуулийн зарим зүйл заалтад үнэлгээ хийж, хуулийн хэрэгжилт болон хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар судалж бодит нөхцөл байдлыг илрүүлэх, эдгээрт үндэслэсэн санал, зөвлөмж боловсруулах зорилт тавьж ажиллана.

Гурав. Судалгааны ажил гүйцэтгэх хугацаа

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг 2018 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс 9 дүгээр сарын 24-ний өдөрт багтаан гүйцэтгэж, үнэлгээний тайланг 2018 оны 9 дүгээр сарын 25-ны дотор БХБЯ-ны холбогдох удирдах албан тушаалтанд хүргүүлнэ.

Дөрөв. Судалгаа явуулахад баримтлах зарчим

Судалгааг хараат бус, бие даасан байдлаар шинжлэх ухааны арга зүйг баримтлан явуулах бөгөөд судалгааны дүгнэлтийг зөвхөн тухайн судалгаагаар тогтоогдсон үр дүнд үндэслэн бодитой гаргах;

Тав. Судалгааны арга

“Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай” хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтлан баримт бичгийн судалгааны арга, харьцуулалтын арга, задлан шинжлэх, нэгтгэх аргыг ашиглан гүйцэтгэнэ.

Зургаа. Судалгааны үр дүн:

“Хот, суурины УХАТ-ын ашиглалтын тухай” хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилтийн бодит байдалд дүн шинжилгээ хийж замаар уг хуулийг хэрэгжүүлэх явцад гарч буй хүндрэл бэрхшээлийг илрүүлэх, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөг

тогтоох замаар цаашид уг хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд ашиглаж болохуйц шийдлийн хувилбаруудыг дэвшүүлсэн байна.

Долоо. Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хүрээг тогтоох:

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх хүрээг тогтоохдоо 2011 онд батлагдсан Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийг хэрэгжүүлэхэд агуулгын хувьд чухал ач холбогдолтой гэж үзсэн хуулийн **1, 3.1.12, 3.1.19, 5.1.1, 5.1.6, 6.1.4, 7.1.2, 8.1.3, 9.3, 9.10, 10.2.1-10.2.3, 12.1, 16.2.6, 17.2, 17.3, 17.4.1-17.4.4, 17.5-17.7, 17.8.4, 17.11-17.14, 18.2, 18.6, 21.1, 21.2, 23** дугаар зүйл, заалтыг сонгон судлах ба эдгээрийн **хэрэгжилтийг 1/зорилгод хүрсэн төвшин, 2/ практикт нийцэж буй байдал, 3/ бусад үр дагавар гэсэн 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлнэ.**

Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийх үнэлгээний ажлыг хэрэгжүүлэх үе шатанд холбогдох байгууллага, албан тушаалтан болон судалгааны бусад эх сурвалжаас шаардлагатай мэдээ, мэдээлэл цуглуулах ажлыг гүйцэтгэнэ. /Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх явцад шаардлагатай тохиолдолд дээр дурдсан зүйл заалтаас хасах, дурдагдаагүй зүйл заалт нэмэгдэх зэрэг өөрчлөлт орох магадлалтайг энд дурдах нь зүйтэй юм./

Эцэст нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хийх үнэлгээний ажлын хэрэгжүүлэх үе шатанд цуглуулсан мэдээ, мэдээллийг боловсруулах, харьцуулах, нэгтгэн дүгнэх зэрэг ажлыг гүйцэтгэж үнэлгээ үр дүнг гаргах ба энэхүү үнэлгээний үр дүнд суурилсан санал, зөвлөмж боловсруулна.

Хавсралт 3. УХАТ, ЦБ-д хамааралтай стандартын жагсаалт

Ус, ус хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламж зэрэгт холбогдох Монгол Улсын стандартаас²⁵⁴

1. MNS 3239 : 2014 14 х. Барилга доторх ус хангамж, ариутгах татуургын системийн ажлын зураг,
- 13.060 Усны чанар 13.060.01 Усны чанарын нийтлэг асуудал
 2. MNS 0017-1-1-14 : 1980 3 х. Усан мандал. Ус ашиглалтын ангилал
 3. MNS 2570 : 1978 1 х. Усны тунгалагийг тодорхойлох арга
 4. MNS 4047 : 1988 18 х. Усан мандал. Гадаргуугийн усны чанарыг хянах журам.
 5. MNS 4079 : 2016 42 х. Усны аж ахуй. Усны чанар. Нэр томьёо, тодорхойлолт.
 6. MNS 4586 : 1998 3 х. Усан орчны чанарын үзүүлэлт
 7. MNS 5789 : 2007 4 х. Усны чанар. Нийт цианид тодорхойлох титриметрийн арга.
 8. MNS 5790 : 2007 5 х. Усны чанар. Мангани (Mn)-ийн агууламжийг тодорхойлох арга
 9. MNS 5791 : 2007 7 х. Усны чанар. Биндэр (Be)-ийн агууламжийг тодорхойлох арга
 10. MNS 6694 : 2017 69х. Хүрээлэн байгаа орчин. Усны нөөц, ус ашиглалт, хамгаалалт. Нэр томьёо, тодорхойлолт
- 13.060.20 Ундны ус
 11. MNS 0899 : 1992 14 х. Унд ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам ба эрүүл ахуйн шаардлага
 12. MNS 0900 : 2018 12 х. Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ
 13. MNS 1097 : 1970 20 х. Гэр ахуй, ундны усны физик-химийн шинжилгээний арга
 14. MNS ISO 10359-1 : 2002 7 х Усны чанар. Фторидийг тодорхойлох. 1-р хэсэг
 15. MNS ISO 24512:2012 52х Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ – Ус хангамжийн барилга, байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт үйлчилгээний түвшинг үнэлэх аргачлал
- 13.060.10 Байгалийн ус
 16. MNS 3342 : 1982 4 х. Усан мандал. Газар доорхи усыг бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.
 17. MNS 3597 : 1983 2 х. Монгол Улсын стандартын жагсаалт
 18. 2018 80 Усан мандал. Гадаргуугийн ба газрын доорхи усыг эрдэс бордооны бохирдлоос хамгаалах ерөнхий шаардлага.
 19. MNS 6148 : 2010 5 х. Усны чанар. Газрын доорхи усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ 13.060.20 Ундны ус
 20. MNS 6546 : 2015 6 х. Усны чанар. Ундны усанд ялтаст шүүлтүүрийн аргаар *Pseudomonas aeruginosa* бактерийг илрүүлэх
- 13.060.25 Үйлдвэрлэлийн хэрэглээний ус
 21. MNS 5582:2006 4х. Арьс шир боловсруулах үйлдвэрлэл төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх ус
 22. MNS 6734 : 2018 6 х. Дахин ашиглах цэвэрлэсэн ус. Техникийн ерөнхий шаардлага.
- 13.060.30 Бохир ус
 23. MNS 4288 : 1995 6 х. Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний технологи. Түвшинд тавих үндсэн шаардлага
 24. MNS 4943 : 2015 4 х. Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
 25. MNS 5667 : 2006 2 х. Бохир ус. Лагийн чийглэг ба үнслэгийг тодорхойлох арга.
 26. MNS 5668 : 2006 12х. Усны биологийн шинж чанарын шинжилгээ. Бохир усны микробиологийн шинжилгээний арга

²⁵⁴ <http://www.estandard.gov.mn/admin/editors/spaw2/uploads/files/MON-CAT2018.10.25.pdf>

27. MNS 6390 : 2013 3х Ноос, ноолуур боловсруулах үйлдвэрүүдээс ариутгах татуургын төвлөрсөн сүлжээнд нийлүүлэх урьдчилан цэвэршүүлсэн бохир ус. Техникийн шаардлага
28. MNS 6561 : 2015 6 х. Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага
29. MNS ISO 24511 : 2012 57 х Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээ. Ариутгах татуургын барилга, байгууламжийн ашиглалтын менежмент болон ашиглалт үйлчилгээний түвшинг үнэлэх аргачлал.
30. MNS EN 12255-1:2012 23 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 1-р хэсэг: Байгууламжийн ерөнхий зарчмууд
31. MNS EN 12255-3 : 2015 8 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 3-р хэсэг: Урьдчилсан цэвэрлэгээ
32. MNS EN 12255-4 : 2012 8 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 4-р хэсэг: Анхдагч тунгаалт
33. MNS EN 12255-5 : 2015 5 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 5-р хэсэг: Цөөрмийн процесс
34. MNS EN 12255-6 : 2012 13 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 6-р хэсэг: Идэвхт лагийн процесс
35. MNS EN 12255-7 : 2012 16 х Бохир ус цэвэрлэх байгууламж. 7-р хэсэг: Бэхлэгдсэн хальс бүхий биологийн реактор
36. MNS EN 12255-8 : 2015 17 х. Монгол Улсын стандартын жагсаалт 2018 Бохир ус цэвэрлэх байгууламж. 8-р хэсэг: Лагийн боловсруулалт ба хадгалалт
37. MNS EN 12255-9 : 2015 14 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 9-р хэсэг: Үнэрийн хяналт ба агааржуулалт
38. MNS EN 12255-10 : 2012 19 х Бохир ус цэвэрлэх байгууламж. 10-р хэсэг: Аюулгүй ажиллагааны зарчмууд
39. MNS EN 12255-11 : 2012 14 х Бохир ус цэвэрлэх байгууламж. 11-р хэсэг: Шаардлагатай ерөнхий өгөгдлүүд
40. MNS EN 12255-12 : 2015 14 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 12-р хэсэг: Хяналт ба автоматжуулалт
41. MNS EN 12255-13 : 2015 13 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 13-р хэсэг: Химийн цэвэрлэгээ. Тунадасжуулах болон флокуляцийн аргаар бохир ус цэвэрлэх
42. MNS EN 12255-14 : 2015 17 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 14-р хэсэг: Халдваргүйжүүлэлт
- 13.060.45 Усны шинжилгээний нийтлэг асуудал
43. MNS ISO 5663 : 2001 7 х. Усны чанар. Кьелдалийн азотыг тодорхойлох. Селений оролцоотойгоор эрдэсжүүлсний дараах арга
44. MNS ISO 5667-1 : 2002 21 х. Усны чанар. Дээж авах. 1-р хэсэг: Дээж авах хөтөлбөр боловсруулах заавар
45. MNS ISO 5667-3 : 1999 29 х. Усны чанар. Дээж авах 3-р хэсэг : Дээжийг боловсруулах ба хадгалах зөвлөмж
46. MNS ISO 5667-4 : 2001 8 х. Усны чанар. Дээж авах. 4-р хэсэг. Байгалийн ба хиймэл нуураас усны дээж авах заавар
47. MNS ISO 5667-5 : 2001 11 х. Усны чанар. Дээж авах. 5-р хэсэг. Ундны ус, хүнс болон ундаа үйлдвэрлэхэд хэрэглэх уснаас дээж авах заавар
48. MNS ISO 5667-6 : 2001 13 х. Усны чанар. Дээж авах. 6-р хэсэг: Гол горхины уснаас дээж авах заавар
49. MNS ISO 5667-7 : 2002 18 х. Усны чанар. Дээж авах. 7-р хэсэг: Уурын зуухны ус болон уураас дээж авах заавар
50. MNS ISO 5667-8:2000 4 х. Усны чанар. Дээж авах. 08-р бүлэг. Нойтон хур тунадасны дээж авах заавар

51. MNS ISO 5667-10 : 2001 17 х. Усны чанар. Дээж авах. 10-р бүлэг: Хаягдал уснаас дээж авах заавар
52. MNS ISO 5667-11 : 2000 13 х Усны чанар. Дээж авах. 11-р бүлэг. Гүний уснаас дээж авах зөвлөмж
53. MNS ISO 5667-13:2000 23 х. Усны чанар. Дээж авах. 13-р бүлэг. Ус болон цэвэрлэх байгууламжаас лагийн дээж авах заавар
54. MNS ISO 5667-14 : 2000 21х. Усны чанар. Дээж авах. 14-р бүлэг. Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж
- 91.140.60 Усан хангамжийн тогтолцоо
55. MNS 6279 : 2011 33 х. Ус хангамж, ариун цэврийн байгууламж.Нэр томьёо, тодорхойлолт – Тайлбар толь
56. MNS ISO 4064-1:2016 43 х. Ундны хүйтэн ус ба халуун усны тоолуур -1-р хэсэг: Хэмжил зүйн ба техникийн шаардлага
57. MNS ISO 4064-2 : 2013 12 х. Битүү шугам хоолой дахь усны зарцуулалтын хэмжилт. Ундны хүйтэн ба халуун усны тоолуур. 2-р хэсэг: Суурилуулахад тавих шаардлага
58. MNS ISO 4427 : 2007 14 х. Ус дамжуулахад зориулсан полиэтилен хоолой /PE/. Ерөнхий шаардлага
59. MNS ISO 15874-1 : 2007 8 х. Халуун ба хүйтэн ус дамжуулах хуванцар хоолойн систем - Полипропилен /PP/ 1-р хэсэг: Ерөнхий шаардлага
60. MNS ISO 15874-2 : 2007 14 х. Халуун ба хүйтэн ус дамжуулах хуванцар хоолойн систем-Полипропилен /PP/ 2-р хэсэг: Шугам хоолой
61. MNS ISO 15874-3 : 2007 14 х. Халуун ба хүйтэн ус дамжуулах хуванцар хоолойн систем - Полипропилен /PP/ 3-р хэсэг: Холбох хэрэгсэл
62. MNS ISO 15874-5 : 2007 8 х. Халуун ба хүйтэн ус дамжуулах хуванцар хоолойн систем-Полипропилен /PP/ 5-р хэсэг: Системийн зориулалтад нийцсэн байдал
63. MNS ISO 15876-1 : 2008 8 х. Халуун ба хүйтэн ус дамжуулах хуванцар хоолойн систем – Полибутилен (PB).1-р хэсэг: Ерөнхий шаардлага
64. MNS ISO 15876-2 : 2008 12 х. Халуун ба хүйтэн ус дамжуулах хуванцар хоолойн систем – Полибутилен (PB).2-р хэсэг: Дамжуулах хоолой
65. MNS ISO 15876-3 : 2008 14 х. Халуун ба хүйтэн ус дамжуулах хуванцар хоолойн систем – Полибутилен (PB).3-р хэсэг: Холбох хэрэгсэл
66. MNS ISO 15876-5 : 2008 8 х. Халуун ба хүйтэн ус дамжуулах хуванцар хоолойн систем – Полибутилен (PB).5-р хэсэг: Системийн зориулалтад нийцэх байдал (тохирол)
67. MNS EN 12255-1:2012 23 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 1-р хэсэг: Байгууламжийн ерөнхий зарчмууд
68. MNS EN 12255-3 : 2015 8 х. Монгол Улсын стандартын жагсаалт 2018 Бохир ус цэвэрлэх байгууламж. 3-р хэсэг: Урьдчилсан цэвэрлэгээ
69. MNS EN 12255-4 : 2012 8 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 4-р хэсэг: Анхдагч тунгаалт
70. MNS EN 12255-5 : 2015 5 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 5-р хэсэг: Цөөрмийн процесс
71. MNS EN 12255-6 : 2012 13 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 6-р хэсэг: Идэвхт лагийн процесс
72. MNS EN 12255-7 : 2012 16 х Бохир ус цэвэрлэх байгууламж. 7-р хэсэг: Бэхлэгдсэн хальс бүхий биологийн реактор
73. MNS EN 12255-8 : 2015 17 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 8-р хэсэг: Лагийн боловсруулалт ба хадгалалт
74. MNS EN 12255-9 : 2015 14 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 9-р хэсэг: Үнэрийн хяналт ба агааржуулалт
75. MNS EN 12255-10 : 2012 19 х Бохир ус цэвэрлэх байгууламж. 10-р хэсэг: Аюулгүй ажиллагааны зарчмууд

76. MNS EN 12255-11 : 2012 14 х Бохир ус цэвэрлэх байгууламж. 11-р хэсэг: Шаардлагатай ерөнхий өгөгдлүүд
77. MNS EN 12255-12 : 2015 14 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 12-р хэсэг: Хяналт ба автоматжуулалт
78. MNS EN 12255-13 : 2015 13 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 13-р хэсэг: Химийн цэвэрлэгээ. Тунадасжуулах болон флокуляцийн аргаар бохир ус цэвэрлэх
79. MNS EN 12255-14 : 2015 17 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 14-р хэсэг: Халдваргүйжүүлэлт
80. MNS EN 12255-15 : 2015 17 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 15-р хэсэг: Идэвхт лагийн системийн агааржуулах санд цэвэрлэгдсэн усанд ууссан хүчилтөрөгчийг хэмжих
81. MNS EN 12255-16: 2015 12 х. Бохир ус цэвэрлэх байгууламж. 16-р хэсэг: Механик шүүлтүүр
- 91.140.80 Бохирын шугамын тогтолцоо
82. MNS 5924 : 2015 17 х. Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага
83. MNS 6230 : 2010 5 х. Бохир ус зайлуулах цэг тогтоох. Ерөнхий шаардлага
84. MNS ISO 6594 : 2001 16 х. Ариутгах татуургын ширмэн хоолой ба тэдгээрийг холбох хэрэгсэл. Техникийн шаардлага
85. MNS ISO 8772 : 2008 18х. Бохир ус зайлуулах болон дренажийн системд зориулсан өндөр нягттай полиэтилен (HD-PE) хуванцар хоолой, холбох хэрэгсэл-Шаардлагууд
86. MNS EN 1091-1 : 2016 68 х. Барилгын гадна ариутгах татуургын вакуум систем ба ариутгах татуургын тусгай систем 1-р хэсэг: Барилгын гадна ариутгах татуургын вакуум систем
87. MNS EN 12566-1 : 2011 23 х. 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 1-р хэсэг: Угсармал септик
88. MNS EN 12566-2 : 2011 40 х. 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 2-р хэсэг: Хөрсөөр шүүрүүлэх систем
89. MNS EN 12566-3 : 2011 32 х. 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 3-р хэсэг: Угсармал болон газар дээр нь угсарсан ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж
90. MNS EN 12566-4 : 2011 8 х. 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 4-р хэсэг: Угсардаг иж бүрдлийг ашиглан газар дээр нь угсарсан септик
91. MNS EN 12566-5 : 2011 41 х. 50 хүртэл хүн амд зориулсан бага хүч чадлын ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж. 5-р хэсэг: Урьдчилсан цэвэрлэгээ хийсэн бохирыг шүүх шүүлтүүрийн систем Монгол Улсын стандартын жагсаалт 2018 288
92. MNS BS 8525-1 : 2015 40 х. Саарал усны систем. Ерөнхий шаардлага

4. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ИНЖЕНЕРИЙН ТОНОГЛОЛ БА ГАДНА ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ НОРМАТИВ БАРИМТ БИЧИГ

Цогцолбор 40. Ус хангамж ба ариутгах татуурга, Гол (магистральные) үйлдвэрийн шугам хоолой

1. БНбД 40-01-14 Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж Sewage. Outdoor pipelines and facilities БХБСайдын 2014 оны 90 дүгээр тушаал
2. БНбД 40-02-16 Ус хангамж, гадна сүлжээ ба байгууламж Water supply, outdoor pipelines and facilities БХБСайдын 2016 оны 116 дугаар тушаал
3. БНбД 40-04-16 Ус хангамж, ариутгах татуургын гадна сүлжээ, барилга байгууламж Water supply, sewerage, outdoor pipelines and facilities БХБСайдын 2016 оны 116 дугаар тушаал

4. БНбД 40-05-16 Барилга доторхи ус хангамж, ариутгах татуурга Indoor water supply and sewerage pipelines БХБСайдын 2016 оны 116 дугаар тушаал
5. БНбД 40-06-16 Дотор сантехникийн систем Indoor plumbing system БХБСайдын 2016 оны 116 дугаар тушаал
6. БД 40-101-05 Жуулчны баазын инженерийн хангамжийн төлөвлөлтийн ерөнхий шийдэл, /General design on water supply and sewerage pipelines for tourist camps/ БНААХДТ-ийн даргын 2005 оны 65 дугаар тушаал
7. БД 40-102-06 Ус хангамж. Ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төлөвлөх ба угсрах. Үндсэн журам /Planning and installing polymer pipelines for water supply and sewage. Basic principle/ БХБСайдын 2006 оны 120 дугаар тушаал
8. БНбД 44-01-08 Төв дамжуулах (Магистраль) хоолой Main pipelines ЗТБХБСайдын 2008 оны 35 дугаар тушаал
9. БНбД 44-02-08 Төв дамжуулах (магистраль) хоолойн угсралт /Construction of main pipelines/ ЗТБХБСайдын 2008 оны 35 дугаар тушаал
10. БНбД 44-03-11 Ган хоолойн бат бэхийн тооцоо /Strength analysis of steel pipes/ ЗТБХБСайдын 2011 оны 305 дугаар тушаал
11. БНбД 81-87-16 Ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн тохируулга, зүгшрүүлэлтийн ажлын төсвийн норм БХБС-ын 2016 оны 75 дугаар тушаал
12. БД 11-105-06 Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил БХБСайдын 2006 оны 116 дугаар тушаал БХБСайдын 2006 оны 116 дугаар тушаал
13. БД 11-115-16 Ус, дулаан хангамж, ариутгах татуургын сүлжээ, үерийн усны байгууламжийн геодезийн ажил БХБСайдын 2016 оны 25 дүгээр тушаал
14. БНбД 83-10-06 Гадна холболт, ус түгээгүүр, бохир усны татуургын ажлын хөдөлмөр зарцуулалтын жишиг норм БХБСайдын 2006 оны 142 дугаар тушаал
15. УББ 81-202-15 Орон сууц, олон нийтийн барилгын нэгж талбай, гадна инженерийн шугам сүлжээний нэгж уртын төсөвт өртөг тооцох аргачлал БХБСайдын 2015 оны 112 дугаар тушаал
16. БНбД 33-06-09 Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээц ЗТБХБСайдын 2010 оны 107 дугаар тушаал
17. БНбД 33-05-09 Усны барилга байгууламжийн ачаалал ба үйлчлэл ЗТБХБСайдын 2010 оны 107 дугаар тушаал
18. БНбД 33-04-09 Усны барилга байгууламжийн буурь ЗТБХБСайдын 2010 оны 107 дугаар тушаал
19. БНбД 33-01-03 Усны барилга, байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам ДБСайдын 2003 оны 134 дугаар тушаал Decree
20. БНбД 41-04-13 Тоног төхөөрөмж, дамжуулах хоолойн дулаан тусгаарлалт БХБСайдын 2014 оны 136 дугаар тушаал

Хавсралт 4. Төлөвлөгөө

ХОТ СУУРИНЫ УХАТ-ЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН СУДАЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго

Хот суурины УХАТ-ын ашиглалтын тухай хуулийн хэрэгжилтийг үнэлж, хот, суурины УХАТ-ын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааг чанаржуулах ба үр өгөөжтэй явуулахад тулгарч буй доголдол, бэрхшээлийг илрүүлж хуулийн хэрэгжилтийг сайжруулах бодлогын зөвлөмж дэвшүүлэхэд оршино.

Зорилт

- ✓ Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бүрэн эрхийн хэрэгжилт, тулгардаг асуудал бэрхшээлийг тодруулах
- ✓ Хангагчийн бүрэн эрхийн хэрэгжилт, Зохицуулах зөвлөл болон хангагч хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог тодруулах
- ✓ Хэрэглэгчийн бүрэн эрхийн хэрэгжилт, хэрэглэгчийн хуулийн талаарх мэдлэг, ус ашигласны төлбөр, тариф тогтоож буй өнөөгийн байдлын талаарх байр суурийг тодруулах
- ✓ Зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд тулгардаг асуудал бэрхшээл, сайжруулах арга замыг тодруулах

Хугацаа: 2018.09.10-2018.09.14-ыг дуустал

Хамрах хүрээ

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч, ханган нийлүүлэгч, болон хэрэглэгчдээс байршлыг шалгуур үзүүлэлт болгон сонгоно.

Судалгааны аргачлал

Анкетын арга: Судалгааны анхдагч мэдээлэл цуглуулалт анкетын аргын хүрээнд хийгдэх бөгөөд хот, суурины УХАТ-ын ашиглалттай холбогдох оролцогч талуудын санал бодол, хуулийн хэрэгжилтийн байдалтай холбогдох мэдээллүүдийг цуглуулна.

Судалгаанд хэрэглэгч, хангагч, тусгай зөвшөөрөл эзэмшигч зэрэг үндсэн 3 бүлгээс мэдээлэл цуглуулалтыг /РАPI/ буюу судлаач судалгаанд оролцогчтой нүүр тулж, ярилцлага хийн мэдээллийг авна.

Судалгаанд 2 төрлийн анкетын асуулга хэрэглэнэ. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хангагчаас мэдээлэл цуглуулах анкет;
- Хэрэглэгчээс мэдээлэл цуглуулах анкет;

Ганцаарчилсан ярилцлагын арга: Энэхүү судалгаанд ганцаарчилсан ярилцлагын аргаар анкетын судалгааны мэдээллийг гүнзгийрүүлэн шалгах, учир шалтгааныг нь тодорхойлох мэдээллүүдийг цуглуулна. Дараах субъектүүдээс ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулна. Үүнд:

- i. Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хангагч

- ii. Хэрэглэгч
- iii. Зохицуулах зөвлөлийн төлөөлөл

Баримт бичгийн шинжилгээний арга: Баримт бичиг судлах буюу шинжлэх арга нь объектив шинжтэй учраас судлаачдад илүү бодитой мэдээлэл өгдөг. Энэхүү судалгаанд холбогдох баримт бичгүүдийг дараах ангилалд оруулан шинжилгээ хийхээр төлөвлөж байна. Үүнд:

- I. Зохицуулах зөвлөлд хэрэглэгчдээс гаргаж байгаа гомдол шийдвэрлэх ажиллагааны статистик, үндэслэл
- II. Хот суурины ус хангамж, ариутгах татуургатай холбогдох эрх зүйн маргааны төрөл, статистик тоо баримт

Судалгааны түүвэр

Улаанбаатар хотод 2017 оны эцэст 380,828 өрх бүртгэгджээ. Үүнээс түүврийн зохист хэмжээг 95 хувийн итгэх төвшинтэйгээр, +/- 5 хувийн алдаатайгаар тооцоход 363 өрхийн төлөөллийг судалгаанд хамруулахад практик шаардлагыг бүрэн хангахаар байна.

2018 оны 4 сарын байдлаар Зохицуулах зөвлөлөөс тусгай зөвшөөрөл авсан 173 аж ахуй нэгж бүртгэлтэй байгаагаас түүврийн зохист хэмжээг тооцоход 119 аж ахуй нэгжийг хамруулахаар байна.

Түүврийн нарийвчлал

	Түүврийн хэмжээ	Дүнд эзлэх хувь
Хэрэглэгч	363	20%
Тусгай зөвшөөрөл эзэмшигч болон хангагч	119	40%
Нийт	482	100%

Судалгааны төсөв

	Зардлын утга	Тоо ширхэг	Нэгжийн үнэлгээ	Нийт үнэ
1	Мэдээлэл цуглуулах ажилтны цалин хөлс	482	1000	482,000
2	Мэдээлэл шивэх ажилтны цалин хөлс	482	200	100,000
3	Анкет хэвлэх зардал	482	100	48,200
	Нийт			630,200

Хугацаа

	Ажлын нэрс	Хугацаа	Зарцуулагдах өдрийн тоо /ажлын өдөр/
1	Судалгааны хэрэглэгдэхүүн батлах	2018.09.09	1
2	Цагийн ажилтныг сонгон шалгаруулж сургалт явуулах	2018.09.09	1
3	Судалгааны анхдагч мэдээлэл цуглуулах	2018.09.10-09.14	5
4	Судалгааны мэдээлэл шивж оруулах	2018.09.15	1
4	Судалгааны мэдээлэл боловсруулж тайланг хүлээлгэн өгөх	2018.09.16-09.20	5
	Нийт		13

Хавсралт 5. Үнэлгээнд ашиглах асуумжийн маягт №1

Огноо: 2018/09/...

Хаяг:.....

Судлаачийн код:

МАЯГТ А ХЭРЭГЛЭГЧИЙН АСУУЛГА

Танд энэ өдрийн мэнд хүргэе. Энэхүү судалгааны зорилго нь цэвэр, бохир усны үнэ тариф, хэрэглээний усаар хангаж буй ААНБ-ын үйлчилгээний чанар, үйлчилгээг сайжруулах санал хүсэлтийг авахад оршино.

1. Таны нас
2. Таны хүйс
 1. Эр
 2. Эм
3. Өрхийн орлогын хэмжээ
 1. 250,000-аас бага
 2. 251,000-500,000
 3. 500,001-1,000,000
 4. 1,000,001-1,500,000
 5. 1,500,001-2,000,000
 6. 2,000,001-2,500,000
 7. 2,500,001-3,000,000
 8. 3,000,001-ээс дээш
4. Ам бүлийн тоо
5. Ажил эрхлэлтийн байдал
 1. Төрийн байгууллагад
 2. Хувийн байгууллагад
 3. Хувиараа хөдөлмөр эрхлэгч
 4. Оюутан, сурагч
 5. Тэтгэвэрт
 6. Ажилгүй
 7. Группт
 8. Бусад /бичнэ үү/.....
6. Танай байрны/барилгын цэвэр, бохир усны ашиглалтыг хариуцдаг орон сууцны конторийн нэр юу вэ?
.....
7. ... компани танай байранд/барилгад дараах ажиллагааг хийдэг үү?

		Тийм	Үгүй	Мэдэхгүй
1	стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангадаг	1	2	3
2	хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулдаг	1	2	3
3	технологийн дагуу цэвэрлэдэг	1	2	3
4	чанар, аюулгүй байдлын шаардлагад хяналт тавьдаг	1	2	3
5	хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулахад зориулсан тоног төхөөрөмж суурилуулсан	1	2	3
6	туршилт тохируулга хийж, аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөөгөөр хангадаг	1	2	3
7	барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжид технологийн шаардлагын дагуу засвар, үйлчилгээ, шинэчлэлтийг тогтоосон хугацаанд нь хийдэг	1	2	3

8	гэнэтийн осол, аваар гарсан болон зайлшгүй урьдчилан сэргийлэх, засвар, үйлчилгээ хийх үед энэ тухай танд мэдэгддэг	1	2	3
9	үйлдвэрлэлийн осол, аваар гаргасан, эд хөрөнгийн хохирол учруулсан, техникийн гэмтэл гарсан тохиолдолд зөрчлийг арилгадаг	1	2	3
10	Үйлчилгээний тарифт орох өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 30 хоногийн өмнө мэдэгддэг	1	2	3
11	төлөвлөгөөт засвар хийх үед цэвэр усаар хангах үйл ажиллагааг түр зогсоох тухай хэрэглэгчид урьдчилан мэдэгдэх буюу хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарладаг	1	2	3

8. Та цэвэр, бохир усны үнэ тарифыг хаанаас тогтоодог болохыг мэдэх үү?

1. Мэднэ
2. Мэдэхгүй

9. Цэвэр, бохир усны үнэ тарифын талаарх мэдээллийг авч чаддаг уу?

1. Тийм
2. Үгүй

10. Та сард усны хэрэглээний зардалд дунджаар хэдэн төгрөг төлдөг вэ?

.....

11. Таны бодлоор цэвэр усны төлбөр, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөр зохистой хэмжээнд байдаг уу?

1. Их гардаг
2. Зохист хэмжээнд
3. Бага гардаг

12. Танай орон сууцны шугам сүлжээтэй холбоотойгоор танд аливаа асуудал гарч байсан уу?

1. Тийм
2. Үгүй

13. Хэрэв тийм бол ямар асуудал тулгарсан бэ? Хэрхэн шийдвэрлэсэн бэ?

.....



.....

Судалгаанд хамрагдсанд баярлалаа

Хавсралт 6. Үнэлгээнд ашиглах асуумжийн маягт №2

МАЯГТ Б. ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧ БУЮУ ХАНГАГЧААС АВАХ АСУУЛГЫН ҮР ДҮН

Судалгаанд хамрагдсан бүс нутгийн байршил



Нэг. Байгууллагын ерөнхий мэдээлэл

1. Тусгай зөвшөөрлийн төрөл (тохирохыг дугуйлна уу)

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Хувь	Тохиолдлын %
1	хот, суурины ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ;	6.9%	56.5%
2	ус олборлох, цэвэршүүлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ;	6.1%	50.0%
3	цэвэр ус дамжуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ;	9.2%	76.1%
4	цэвэр ус түгээх шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ;	9.2%	76.1%
5	орон сууцны доторх цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ;	9.8%	80.4%
6	ус дамжуулах төвийн ашиглалт, засвар, үйлчилгээ;	7.4%	60.9%
7	.бохир усны гаргалгааны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ;	8.4%	69.6%
8	бохир ус цуглуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ;	7.9%	65.2%
9	бохир ус татан зайлуулах шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ;	9.2%	76.1%
10	бохир ус цэвэрлэх байгууламжийн ашиглалт, засвар, үйлчилгээ;	6.3%	52.2%
11	ус хангамж, ариутгах татуургын тоног төхөөрөмжид туршилт, тохируулга хийх үйлчилгээ;	4.0%	32.6%
12	хот, суурины ус түгээх байрны ашиглалт, засвар, үйлчилгээ;	5.0%	41.3%
13	зөөврийн ус хангамжийн үйлчилгээ;	5.5%	45.7%
14	бохир усыг тусгай зориулалтын машинаар зөөвөрлөх үйлчилгээ	5.0%	41.3%

2. Авсан тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа юу?

№		Тоо	Хувь
1	Тийм	47	100.0
2	Үгүй		

3. Дээрх тусгай зөвшөөрлийг багцлах хэрэгцээ, шаардлага бий юу?

№		Тоо	Хувь
1	Тийм	32	76.2
2	Үгүй	10	23.8

4. Тусгай зөвшөөрлийн жилийн хураамжийн хэмжээ хэр тохиромжтой вэ?

№		Тоо	Хувь
1	Тохиромжтой	29	61.7
2	Тохиромжгүй	18	38.3

5. Тусгай зөвшөөрлийг сунгаж буй хугацаа хэр тохиромжтой вэ?

№		Тоо	Хувь
1	Тохиромжтой	19	40.4
2	Тохиромжгүй	28	59.6

6. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд заасан дараах эрх хэрэгждэг үү?

		Тийм	Үгүй
1	хэрэглэгчийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид үзлэг, шалгалт хийж заавар, зөвлөгөө өгөх;	95.7	4.3
2	хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, учирсан хохирлоо төлүүлэхийг шаардах.	76.6	23.4

- Айл өрхийн усыг хязгаарлах боломжгүй тул гэрээнд заасан заалт хэрэгжих боломжгүй.
- Жил, олон сар дамнасан хэрэглэгчдийн тоолуурыг салгах эрхгүй байдаг нь хүндрэлтэй байдаг.
- ОНӨХК Эрдэнэт-Ус 2-н гэрээний үүргийн биелэлтэнд аймгийн ИТХ, ЗДТГ-с Эрдэнэт үйлдвэрт шахалт үзүүлдэг.
- Төлбөр төлөөгүй 1 жилээс дээш өртэй хэрэглэгчийг шүүхээр шийдвэрлүүлж байна. Бусад тал дээр эрх зүйн орчин сул байдгаас хэрэглэгчдэд шаардлага мэдэгдэх хуудас өгөхөөс өөр арга хэмжээ авч чаддаггүй.
- Хариуцсан байцаагч, хууль зүйн орчин байхгүй дутмаг.
- Хэдийгээр хуулинд заасан байгаа ч хэрэгждэггүй, механизм нь бүрхэг.
- Хэрэглэгч тус бүрийн усны шугамыг хаах, хязгаарлах боломжгүй. Нийтийн эрх ашиг хөндөгдөх тул гэрээг цуцлах боломж байхгүй.

7. Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд заасан дараах үүргээ хэрэгжүүлж чаддаг уу?

	асуулт	Тийм	Үгүй	Хэрэгжихгүй байгаа шалтгаан
1	гэрээний нөхцөлд тохирсон тоо, хэмжээ, стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах, технологийн дагуу цэвэрлэх, чанар, аюулгүй байдлын шаардлагад хяналт тавих	93.6	6.4	Боломжгүй Зэв их гарч байгаа Улсын байцаагчийн эрхтэй хяналт хийх
2	хууль болон гэрээнд өөрөөр заагаагүй бол цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулахад зориулсан тоног төхөөрөмж суурилуулах, туршилт тохируулга хийж, аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөөгөөр хангах;	95.7	4.3	Төвлөрсөн бохирын шугам байхгүй. Зөөврийн машинаар бохир усыг зайлуулдаг. Цэвэрлэх байгууламжийн хүчин чадлын 40-50%-г ашигладаг. Бохирын нэгдсэн төв шугамтай болох шаардлагатай. Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал багадаж байгаа.
3	ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаарх хууль тогтоомж, норм, стандарт, дүрэм, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөх;	97.8	2.2	гэрээний үүргээ биелүүлээгүй хэрэглэгчийг усаар хангахгүй байх заалтыг хэрэглэх боломжгүй

4	өөрийн ашиглалт, өмчлөлд байгаа инженерийн барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжид технологийн шаардлагын дагуу засвар, үйлчилгээ, шинэчлэлтийг тогтоосон хугацаанд нь хийх;	91.3	8.7	норм дүрэм зааж өгөх солих шаардлагатай шугам сүлжээг 100% солих санхүүгийн боломж байхгүй
5	гэнэтийн осол, аваар гарсан болон зайлшгүй урьдчилан сэргийлэх, засвар, үйлчилгээ хийх үед энэ тухай хэрэглэгчид мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээ авах;	97.8	2.2	Зарим тохиолдолд үгүй-учир нь мэдэгдсэн тохиолдолд хэрэглэгчид ус их хэмжээгээр нөөцөлж байгаад бидний ажилд хүндрэл учруулдаг
6	үйлчилгээний тарифын хэмжээ тогтоох саналыг боловсруулж, Зохицуулах зөвлөлөөр батлуулж, мөрдөх.	100.0		

8. Хэрэглэгчийн зүгээс ямар асуудлаар гомдол санал их гаргадаг вэ?

- Амралтын өдрүүдэд өндөр давхруудад ус хүрэхгүй болдог, өндөр барилгад дээд давхарт ус хүрэхгүй, УСУГ даралт хагас бүтэн сайнд их муу хүрэхгүй байна
- Голдуу угаалтуур бөглөрөх
- Дундын эзэмшлийн шугам сүлжээ
- Зэвтэй ус байнга гарч шугам хоолой хурдан цоорч байна. Төвийн бохирын шугам хэвийн ажиллахгүй байгаа нь эрүүл мэндэд хортой. Зэвтэй ус, УСУГ эх үүсвэр муудсан. Ус зэвтэй байна, шугам сүлжээг ПВС хийх
- Техник нэмэх, ажилтан нэмэх, шаардлагатай орон тоогоор ажиллах
- Тоолуур үнэн зөв зааж байгаа эсэх дээр
- Тоолуурын заалтаа цаг хугацаандаа өгдөггүйгээс үүссэн төлбөрийг их байна гэдэг гомдол ихэвчлэн гардаг
- усны тоолуур үнэн зөв тоолж байгаа эсэх, усны суурь үнэ авах нь зөв эсэх
- Усны хатуулга
- Халаалт цэвэр бохир усны талаар
- Хөрсний устай холбоотой асуудал
- Цэвэр усгүй хэрэглээ ихтэй үед ус сувгаас даралт унаж шугам хоосордог

9. Таны бодлоор цэвэр усны төлбөр, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөр зохистой хэмжээнд байдаг уу?

№		Тоо	Хувь
1	Их гардаг	6	14.6
2	Зохист хэмжээнд	19	48.7
3	Бага гардаг	15	36.6

10. Зохицуулах зөвлөлтэй хамтран ажиллахад танай байгууллагад аливаа асуудал тулгарч байсан уу?

№		Тоо	Хувь
1	Тийм	3	6.8
2	Үгүй	41	93.2

11. Хэрэв тийм бол ямар асуудал тулгарсан бэ? Хэрхэн шийдвэрлэсэн бэ?

- Авлага нэмэгдэх асуудал тулгардаг, барагдуулах талаар ямар нэг ажил хийх
- Төлбөрөө хугацаандаа төлөхгүй асуудлаас болж алдангитай холбоотой байнга маргаан гарч байгаа
- Үнэ тарифын
- Хүнд сурталтай

12. Бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй холбоотой асуудал тулгарч байсан уу?

- Адил эрхтэй ажилладаг боловч нэгнийхээ эзэмшдэг эд хөрөнгө рүү дайрч булааж авдаг
 - Зэвтэй усыг хөнгөлөх
 - Спирт бал бурам ХХК-тай бохир усны төлбөрийн асуудалтай тулгарч байсан
 - Тоолуурын маргаан тулгардаг
 - УСУГ-аас ирсэн нэхэмжлэлийн дагуу сар бүр төлж өргүй гардаг ч 25-аас хойш тоолуур салгаж байрыг нийтээр нь усыг хааж байсан
 - Цемент шохой ХК-тай холбоотой усны тоолуурын заалт зөрүүтэй гарч асуудал тулгарсан
 - Цэвэр усаар хангах асуудал нь МУ-ын үндэсний аюулгүй байдалтай шууд холбоотой учир өндөр нөхцөл шаардлагаар бусад байгууллагад тусгай зөвшөөрөл олгох ёстой байтал тусгай зөвшөөрлийн шаардлага доогуур байна
 - Эрдэнэт ус компанитай цэвэр усыг хангах бохир усыг татан зайлуулж цэвэрлэх гэрээг хийж чадахгүй байгаа
 - Эрдэнэт хотод ус дамжуулах шугам сүлжээний газар байхгүй
 - ЭХЗХ болон дулааны тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай байнга маргаантай байгаа
 - ЭХЗХ-той байнга асуудал тулгардаг
13. Хэрэглэгчтэй холбоотой ямар асуудал тулгардаг вэ? Хэрхэн шийдвэрлэдэг вэ?
- Айл өрхүүд хувийн гүний худаг их гаргаж байгаа нь ундны усны аюулгүй байдалд нөлөөлнө гэдгийг анхаарах.
 - Дундын эзэмшлийн шугам хоолой цоорсон, эсвэл шугам сүлжээ рүү тамхины иш хийж шугам хоолойг шатаасан гэх мэт явдал гэмтэл гарсан үед СӨХ засвар хийхэд шаардлагатай материалыг авч өгч чаддаггүйгээс хэрэглэгч хохирох асуудал байнга гардаг. Иймд энэ дундын өмчлөлийг мэргэжлийн байгууллагад ОСКонторд хариуцуулах хууль эрх зүйн орчин шаардлагатай байна. Мөн дундын байгууллагуудын шугам хоолой цоорох, бохир бөглөрөх үед УСУГ тухайн гэмтлийг болон бөглөрлийг засварт хамрагдах байгууллагууд ижил хэмжээгээр зардлыг хувиар нэхэмжилж авах хэрэгтэй. Ихэнх тохиолдолд контор дангаараа хийдэг.
 - Зарим хэрэглэгчид тоолуурын заалт өгдөггүй, тоолуур эвдэх гацаах.
 - Тоолуураа албаар гацаах, хэрэглэсэн усаа нууж ухраах гэх мэт асуудал үүсдэг. Үүнд арга хэмжээ авахад дургүйцдэг. Мэргэжлийн хяналт гэх мэт гомдол гаргадаг.
 - Төлбөрөө төлдөггүй.
 - Түр ус хаах, бохир шингэн бөглөрөх үед бухимдал хэрэглэгчээс ирдэг. Хэрэглэгч хаан гэсэн байдлаар хангах.
 - Хууль зөрчих, ус алдуулах, тоолуур гэмтээх асуудлуудыг хуулийн дагуу шийдвэрлэдэг.
 - Хэрэглэгч ОСНААУГ, хувийн контор, УСУГ-ийн ялгаа тус тусдаа бие даасан газар гэдгийг мэддэггүй.
 - Хэрэглэгч усыг хулгайгаар хэрэглэх, лацыг таслах.
 - Хэрэглэгчдэд гарсан асуудлыг шийдвэрлэх эрх мэдэл (торгох арга хэмжээ) байхгүй
 - Шугам засварлах үед тодорхой хугацаанд зэвтэй ус гардаг. Зарим өндөрлөг газарт усны даралт багасдаг.

Хавсралт 6. Үнэлгээний хүрээнд хийсэн уулзалт, ярилцлагын жагсаалт

№	Хугацаа	Байгууллага	Оролцогчийн нэр
1	2018.07.27	БХБЯ-ны ХСУХАТАТХ-ийн шинэчилсэн найруулга боловсруулах ажлын хэсгийн гишүүн	Болд
2	2018.09.18	ОСНААУГ Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга	Пүрэвжамц
3	2018.09.18	ОСНААУГ Гэрээ эрх зүйн мэргэжилтэн	Жамьяанжав
4	2018.09.28	Барилгын хөгжлийн төв Норм, нормативын хэлтсийн дарга	Алтанхуяг
5	2018.09.28	УСУГ Ерөнхий инженер	Дагвасүрэн
6	2018.10.01	ХСУХАТАУЗЗ-ын албаны дарга нар	Гэрэлчулуун Доржбат Нарантуяа
7	2018.10.02	Нийслэлийн ус, шугам сүлжээ, ариутгах татуургын асуудал хариуцсан мэргэжилтэн	Алтангэрэл
8	2018.10.02	Барилгын хөгжлийн төв Нийтийн аж ахуйн хэлтсийн дарга	Ганбаатар
9	2018.10.04	Азийн хөгжлийн банк Лагийн төслийн баг	Туул
10	2018.10.05	УСУГ Цэвэрлэх байгууламжийн дарга	Болд
11	2018.10.10	УБ хотын ТЗЭ-дийн хурал	
12	2018.10.11	Ажлын хэсгийн хурал	
13	2018.10.15-16	Төвийн бүсийн ТЗЭ-дийн хурал	
14	2018.10.19	ОСНААУГ-ын ажилтан, албан хаагчдын хурал	
15		Бусад	

СУДАЛГААНЫ ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ
ТАТУУРГЫН АШИГЛАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Ж.БАТСУУРЬ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
НИЙТИЙН АЖ АХУЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДАРГА

О.ЛХАГВАЦЭДЭН

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

Б.НЯМДОРЖ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
НИЙТИЙН АЖ АХУЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ
ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

Б.ОЮУНЧИМЭГ

БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ХУУЛИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.МОНГОЛЖИНГОО